



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

нэгдсэн хуралдааны тэмдэглэл
2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА 2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-116
1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдээгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжлэв/	6-116

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
9 дүгээр сарын 17-ны өдөр /Лхагва гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 83 гишүүн хүрэлцэн ирж, 65.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Д.Ганмаа, Л.Мөнхбаатар, Д.Пүрэвдаваа, С.Цэнгүүн;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, С.Одонтуяа;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Ц.Идэрбат, Ч.Лодойсамбуу, Э.Одбаяр;

Тасалсан: Л.Гантөмөр;

Хоцорсон: Н.Алтаншагай -21 минут, О.Амгаланбаатар -06 минут, Э.Бат-Амгалан -01 минут, Х.Баттулга -05 минут, Ж.Баярмаа -08 минут, Х.Болормаа -01 минут, Г.Ганбаатар -27 минут, Д.Ганбат -2 цаг 30 минут, Ц.Даваасүрэн -2 цаг 56 минут, Г.Дамдинням -17 минут, Т.Доржханд -02 минут, Б.Жавхлан -05 минут, Д.Жаргалсайхан -05 минут, Т.Мөнхсайхан -05 минут, З.Мэндсайхан -09 минут, О.Номинчимэг -04 минут, Н.Номтойбаяр -02 минут, Б.Пунсалмаа -17 минут, Ц.Сандаг-Очир -42 минут, О.Саранчулуун -13 минут, Н.Учрал -08 минут, Г.Уянгахишиг -44 минут, Г.Хосбаяр -13 минут, Д.Цогтбаатар -28 минут, Ж.Энхбаяр -02 минут, Р.Эрдэнэбүрэн -12 минут.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссан тухай мэдэгдэв./10:03/

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан,

Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Н.Ууганбаатар, А.Энхбат, Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх Г.Ганболд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Б.Энх-Амгалан, мөн газрын Захиргаа, санхүүгийн газрын дарга Б.Батцэцэг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Бизнесийн орчны бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдээгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг Улсын Их Хурлын гишүүдийн асуултаар үргэлжлэв.

Ерөнхий сайдын илтгэл болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Бейсен, М.Нарантуяа-Нара, С.Эрдэнэболд, Д.Үүрийнтуяа, Ж.Баясгалан, Х.Жангабыл, Г.Очирбат, Ц.Туваан, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, С.Зулпхар, Ц.Мөнхтуяа, Да.Цогтбаатар, С.Ганбаатар, Ө.Шижир нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Монгол Улсын

сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Боловсролын сайд П.Наранбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 56 минут үргэлжилж, 12 цаг 56 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 05 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа үдээс хойших хуралдааныг даргалав.

Ерөнхий сайдын илтгэл болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин, О.Алтангэрэл, Х.Баасанжаргал, Х.Тэмүүжин, О.Батнайрамдал, А.Ариунзаяа, Л.Соронзонболд, Б.Уянга, Ч.Номин, Д.Батбаяр, А.Ганбаатар, Д.Энхтүвшин, М.Мандхай, Ц.Баатархүү, Ж.Галбадрах, Э.Болормаа, З.Мэндсайхан, Д.Ганбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Боловсролын сайд П.Наранбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Ажлын цаг дууссан тул хуралдаан 17 цаг 59 минутад өндөрлөв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 50 минут үргэлжилж, 126 гишүүнээс 114 гишүүн хүрэлцэн ирж, 90.5 хувийн ирцтэйгээр 17 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтгая. Ирц 83 гишүүн бүртгэгдэж, 65,9 хувьтай байна. 2025 оны намрын ээлжит чуулганы 9 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Энэ Засгийн газрын гишүүдийг дуудъя. Төсвийн хүрээ, төсөв хэлэлцэнэ. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. 2 дугаарт, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 9 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс 2 өдрийн завсарлага авсан байгаа. Завсарлагатай холбогдуулан Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга үг хэлнэ. Цогтгэрэл даргын микрофоныг өгье.

О.Цогтгэрэл: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. АН-ын бүлгээс төсвийн төсөлтэй холбоод, Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдуулан завсарлага авсан. Тэгээд ажлын хэсэг байгуулагдаад өчигдөр Эдийн засгийн хөгжлийн сайд бөгөөд Тэргүүн шадар сайд, Сангийн сайд нараас төсвийн төсөлтэй холбоотой мэдээллүүдийг авч хуралдсан, ажлын хэсэг хуралдсан. Тэгээд эхний байдлаар төсөв дээр гарч байгаа завсарлага авсан үндэслэлийн нэг нь төсөв өргөн барихдаа нэг жилийн төсвийг өргөн барихдаа ирэх 5 жилийн дунд хугацааны төлөвлөлтийг өнөөдөр Монгол Улсын Их Хурлаас батлаагүй байгаа гэдэг шалтгааныг бид үндэслэл болгож байсан. Энэ маань үндэслэлтэй. Тэгэхээр энийг энэ төсвийн хэлэлцүүлгийн явцад энэ 5 жилийн төлөвлөлтийг заавал хамтатган батлах, нэгтгэн дүгнэх шаардлагатай гэдэг ийм байр суурь ингээд батлагдаж байна.

2 дугаарт нь энэ төсвийг урсгал зардлыг бууруулах замаар төсвийн алдагдлыг эрс бууруулах ийм боломж байна гэдэг урьдчилсан дүгнэлт гарч байгаа.

Сая 6 дугаар сард батлагдсан төсвийн тодотголоос одоо урсгал зардал 500 тэрбумаар нэмэгдчихээд байгаа. Зөвхөн 3, 4 сарын хугацаанд урсгал зардал 500 гаруй тэрбумаар нэмэгдчихсэн. Энэний цаана төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардлын харьцаа өнөөдөр 75:25 байгааг 70:30 болгох зэрэг ажлын хэсгийн саналууд ингээд олон, олон саналууд, мөн бидний баримталж байгаа бодлого, сүүлийн сонгуулийн тогтолцоо, олон зүйл чинь бүсчилсэн хөгжил гэдэг зүйл рүү асуудал бодлогын өөрчлөлт гараад явж байгаа гэж үзэж байгаа. Гэтэл бүсчилсэн хөгжил гэдэг зүйлтэй холбоотой хөрөнгө оруулалтын болоод бодлогын өөрчлөлт, шинэчлэлт энэ төсөв дээр ерөөсөө зүйл харагдахгүй байна гээд маш олон ийм байр сууриуд, зарчмын байр сууриуд, үндэслэл бүхий байр сууриуд гарч ажлын хэсэг дээр ингээд яригдсаныг мэдээлье.

Тэгэхдээ төсөв дөнгөж хэлэлцэгдэж эхэлж байна. Өнөөдрөөс төсвийн хэлэлцүүлгээ үргэлжлүүлээд, тэгээд явцын дунд тодорхой зарчмын байр сууриудаар АН-ын бүлгээс дахиж нэгтгэж, зарчмын байр сууриудаа үе шат бүхэнд тодорхой илэрхийлээд явна гэдгийг хэлье. Тэгээд төсвийн хэлэлцүүлэг завсарлага зогсоод төсвийн хэлэлцүүлгээ ингээд үргэлжлүүлье.

Д.Амарбаясгалан: Завсарлага дууслаа. Хэлэлцүүлгээ үргэлжлүүлэн явуулна. Бямбацогт сайд энэ Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайдууд орж ирэхгүй юм уу? Энэ чуулган эхэлчхээд байхад чинь энэ Учрал, Жавхлан зэрэг сайд орж ирмээр байх юм. Шууд асуулт, хариулт явах ёстой. Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх илтгэлийг Ерөнхий сайд болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг зөвлөлийн дарга тус тус танилцуулсан байгаа. Илтгэл дүгнэлттэй холбогдуулан Ерөнхий сайд, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн даргаас болон холбогдох ажил хариуцаж байгаа сайд нараас асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 35 гишүүн, 36 гишүүн асуулт асуухаар нэр ирлээ. 36 гишүүнээр тасаллаа. Даваагийн Цогтбаатар гишүүний нэрийг нэмж оруулъя. Асуулт. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Монголын ард түмэнд болон Улсын Их Хурлын гишүүддээ намрын чуулганы мэндийг дэвшүүлье. Чуулганы завсарлагаар хэд хэдэн аймгийн сумдаар явсан. Тэгэхлээр Өмнөдэлгэр сумын Баянзүрх багийн Ядамсүрэнгийн Цэвээн гэдэг хүн энэ хүн Гомбожав гуайтай Занданшатар гуайн аав Гомбожав гуайтай хамт ажиллаж байсан Чандмань сум, Чандманийн сангийн аж ахуйд ажиллаж байсан хүн байна лээ. Тэгээд тэр хүн юу гэж захиж байна вэ гэхээр төсвийг ард түмнээр хэлэлцүүлчхээд далд хийчхэв, тэгээд өөрсдийнхөө юмыг хийгээд явчхав гэж захиж байна лээ. Тэгээд бараг л тэрүүгээр явчих шиг боллоо.

Тэгэхээр энэ ахмадуудын тэтгэврийг 6 хувиар нэмэхээр орж ирсэн байгаа. Тэгэх дээр 2021 оны, 21 онд өргөн барьсан Тэтгэврийг индексжүүлэх тухай хууль 24 онд төсөв хэлэлцэхтэй хамтатгаж хэлэлцэгдээд батлагдсан. Энэ хуулиар энэ жил хэдэн хувийн инфляцтай байна, ирэх оны 1 сарын 1-нээс тэдэн хувиар тэтгэвэр нэмэх тухай хууль юм. Тэгээд өнгөрсөн жил 10 хувьтай байж байхад 6 хувиар тэтгэвэр нэмсэн. Энд ахмадууд маш их гомдолтой байгаа. Тийм учраас энэ жилийн 8 сарын байдлаар хөдөөд 8,9 хувийн инфляцтай, хотод 9,9 хувийн инфляцтай байж байгаа юм. Тийм учраас энэ оны эцэс гэхэд 10 гарахаар байна. Тийм учраас 10-аар 10 хувиар тэтгэврийг нэмэгдүүлэх энэ шаардлагыг би тавина гэдгийг хэлье.

Сүүлийн үед манай Туваан сайдыг янз янзаар дайрч байх шиг байна. Тэгээд Уул уурхайн сайдын хувьд тодорхой хэмжээгээр энэ бодлого гаргаж, бодлогынхоо

дагуу яавал их нүүрс гаргах вэ, яаж хил холболтоо хийх вэ гэдэг энэ бодлогын үндсэн дээр ажиллаж тэр ерөнхий гэрээн дээр гарын үсэг зурсан. Тэр үнэ тогтоох, тэр ямар нүүрс гаргахыг чинь Эрдэнэс Монгол компанийн захирал Наранцогт, түүний доор байдаг Эрдэнэс Тавантолгой компанийн захирлууд л шийддэг байхгүй юу даа. 5 компанийн үнэ чинь ерөөсөө хэдхэн центийн зөрөөтэй юм байна лээ шүү дээ, 3-тай нь адилхан үнэтэй. Тэгээд янз янзаар дайрдаг ийм юмаа болих хэрэгтэй шүү дээ. Яагаад тэр үнэ, нүүрсний үнэ бусад нь ингээд өндөр байхгүй байгаа юм бэ? Хилийн цаана та нар бүгдэнг нь зөрөөг нь авчхаад, нүүрсний тээврийн үнийг нь тээврийн компаниудаар дамжуулж оруулж ирж авлигалаа авдаг биз дээ. Тэгээд тэрэнд нь Наранцогтыг Эрдэнэс Тавантолгойн захирлыг Туваан мэддэг юм гэнэ, ёстой гонжийнжоо байлгүй. Өөрсдийнхөө хулгайг энэ АН-ын 8 сайд руу янз янзын байдлаар хийнэ гэвэл ёстой тийм юм байхгүй шүү. Манай бүлэг бол ясаа зайтал хамгаална шүү. Энд ажлаа л хийсэн, Монголын төлөө л ажилласан. Хил холболтыг ингээд зөрүүлээд хаячихсан тэр зөрүүлснийг л холбохын төлөө л явсан. Монголын бусад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

М.Нарантуяа-Нара: Сайн байцгаана уу, намрын чуулганы мэндийг хүргэе нийт гишүүд, Их хурлын дарга, иргэд, олон нийтдээ. Ингээд төсөв хэлэлцэнэ тэртээ тэргүй төсвийг маш сайн олон талаас нь, 126 талаас нь маш сайн мөлжиж, шүүмжилж маш сайн ажилладаг. Тэгэхдээ би төсвөөс гадна яг энэ нийгэм цаг үед үүсчихсэн байгаа асуудлаар дуу хоолой илэрхийлмээр байна. Яагаад гэвэл иргэд маань ч гэсэн яг одоо энэ талаар сайн хэлж өгөөсэй гэж Улсын Их Хурлын гишүүн болгож томилсон өөрсдийнхөө гишүүдээс үг хүлээж байгаа байх гэж бодож байна. Тэгэхээр яг одоо энэ нийгэм цаг үед маш эмзэг, аймшигтай хэрэг гараад байгаа. Би Улсын Их Хурлын дарга Амарбаясгаланд нэг зүйлийг санаачлаад хийж өгөөсэй гэж бодож байгаа. Учир нь гэвэл манай парламент чинь энэ нийгэм цаг үеийн шаардлагад нийцсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар голлон чиглэж ажиллаж байгаа.

Тэгэхээр зэрэг энэ цаазын ялын тухай маш олон иргэд аргаа барсан иргэд шүү дээ. Тэгээд би ч гэсэн аргаа бараад гээд энэ талаар дуугарч байна. Тэгээд захаасаа гишүүд хууль тогтоогчид хүн алах тухай яриад явж байна гээд ингээд ингэж байгаа. Энэ чинь зүгээр явж байгаа хүн алах тухай биш. Хүний амь насыг онц хэрцгийгээр бүрэлгэж байгаа, удаа дараа олон ноцтой ийм аллага үйлдэж байгаа, тэр дундаа хүүхэд, эмэгтэйчүүдийг харгислан хядаж байгаа ийм асуудал дээр бид яг ямар арга хэмжээ авах вэ, ард иргэд биднээс өөр хэнд хандах вэ, хэнийг хүлээх вэ гэдэг ийм асуудлууд ирчихсэн байна. Тэгэхээр зэрэг би таныг энэ ажлын хэсэг байгуулаад, энэ ажлын хэсэгтээ энэ хуульч, эрх зүйч, мундаг мэргэжлийн энэ гишүүдээрээ баг бүрдүүлээд энэ цаазын ялын тухайд болох юм уу, болохгүй юм уу, болохгүй бол яагаад юм, болох яагаад юм гэдэг энэ үндэслэлүүдийг гаргаж ирэх ажлын хэсгийг байгуулж өгөөч гэсэн ийм хүсэл саналд тавья гэж бодож байгаа юм.

Тэгээд жишээлбэл зарим нэгэн гишүүд маань жишээлбэл Тэмүүжин гишүүн хэлж байна л даа. Цаазын ялаар попорч болохгүй гээд. Попороод байсан юм байхгүй. Гэхдээ бид өнгөрсөн хугацаанд ер нь энэ хүүхэд, эмэгтэйчүүд энэ нийгэм дэх хүний амь насыг бид хэрхэн, яаж хамгаалж байгаа юм бэ? Цаазын ялгүй байлаа гээд өөр бидэнд энэ иргэнээ хамгаалах, амь насыг нь хамгаалах ийм арга, гарц байгаа юм уу? Ийм асуудлыг та нар мэргэжлийн ийм мундаг хуульчид, дээрээс нь

парламентад олон удаа сууж байгаа ийм дадлага туршлагатай хүмүүс. Тэгэхээр ийм зүйлийг санаж сэдэх нь бидний ажил болохоос биш, ард иргэд бол аргаа бараад, аргаа барсан хүмүүс л ингээд мэдэх чадах юмаа л ярьж байгаа. Даргаа 1 минутаа үргэлжлүүлээд авчихъя нэгмөсөн.

Тэгээд энэ хууль шүүх, шүүх засаглалын асуудлыг яах вэ? Энэ иргэд чинь ер нь үнэхээр аргагүй шүү дээ шүүх засаглалд итгэхгүй байхаас өөр аргагүй байдал үүсчхээд байгаа. Яагаад гэвэл тэртээ тэргүй хууль шүүх засаглал өөрөө иргэн болон эрх мэдэлтнүүдэд ялгавартай үйлчилдэг энэ байдал нийгэмд газар аваад, олон жилийн нүүрийг үзэж байгаа учраас иргэд өнөөдөр шүүх засаглалд итгэх итгэл, улмаар төр засагтаа итгэх итгэл алдарчихсан байж байгаа. Тэгэхээр зэрэг энэ асуудлыг бүгдээрээ яаж шийдэх юм бэ? Шүүх засаглалыг прокурорыг тийм ээ, үнэхээр нөгөө хохирогчийн талд баян, ядуу хамаагүй үйлчилж чаддаг тийм ээ, яллах дүгнэлтийг гаргаж чаддаг, хэргийг зөв шүүн тунгаадаг ийм ажлыг бид шууд хянах боломжгүй ч гэсэн энэ ХЗБХ-гоороо дамжуулаад ч байдаг юм уу, энэ иргэдийнхээ итгэлийг сэргээх энэ асуудлыг төлөөлөл нь болсон бид л хийхгүй юм бол хэн хийх юм бэ ер нь тийм биз дээ дарга аа? Тэгэхээр та тэр ажлын хэсэг дээр сайн анхаарч өгөөч гэж хүсэлт тавих гэсэн юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энэ сүүлийн үед энэ хууль хяналтын байгууллага, шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл маш дундуур байгаа. Яг нийгэмд ийм сэртийлгэсэн айхтар, айхтар гэмт хэргүүдийн асуудал хөндөгдөөд яригдаад байдаг, асуудлыг үнэн мөнөөр нь шийдэх тийм боломж нөхцөлийг хуулийн байгууллагын түвшинд хангалттай бий болгохгүй байна гэж Улсын Их Хурлын гишүүд олноороо үзэж байгаа. Ер нь манай хуульч гишүүд энэ дээр санаачилгатай ажиллах хэрэгтэй. Олон саналуудыг гаргаж, энэ хуулийн тодорхой өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай бол цаг хугацаанд нь өөрчлөлтүүдийг хийх хэрэгтэй. Хууль шүүхийн байгууллага бол шударга ёс тогтоохын төлөө ажилладаг байх ёстой болохоос дохиур хэлбэрээр ажилладаг огт байж болохгүй.

Бид нийгэмд өрнөж байгаа олон зүйлүүдийг их сайн харах хэрэгтэй. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж хүн яллаад, араас нь шүүхийн тогтоол унших гээд явж байдаг тохиолдол хүртэл илт бий боллоо гэж манай Улсын Их Хурлын гишүүд мэдэгдэл хийж байгаа. Олон талаар зарим зүйл дээр санал нийлж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй. Тэгээд нийгэмд шударга ёс тогтох эсэх асуудал бол энэ шүүхийн байгууллага, ялангуяа энэ хууль хяналтын байгууллагуудын цэвэр ажиллагаанаас л хамаарах ёстой зүйл. Энийг онцгой анхааралдаа авч Их Хурал ажиллах ёстой. Их Хуралд хийж болохгүй гэдэг зүйл бол ойлголт байж болохгүй. Яаж хийх вэ гэдэг арга замаа зөв олж, энэ олон нийтийн бухимдлыг арилгах үүднээс зарчмын шийдвэрүүдийг гаргаж ажиллах нь зөв гэсэн ийм байр суурьтай байна. Тэгээд би энэ дээр анхаарч ажиллана гэдгийг Нарантуяа гишүүнд хэлье. Буланы Бейсен гишүүн асуулт асууя.

Б.Бейсен: Гишүүддээ өглөөний мэндийг хүргээд, намрын чуулгандаа амжилт хүсье. Эрүүл мэндийн салбарын Эрүүл мэндийн даатгалын сан дампуурлаа. Эмнэлгүүд дээр эм байхгүй, эм, эмнэлгийн хэрэгсэл байхгүй, эмнэлгийн ажилчид нь цалин нэм гэдэг ийм асуудал байгаа. Энийг 2026 оны төсөвт тусгасан уу ер нь? Ялангуяа одоогийн байдлаар эмнэлгүүдийн квот тогтоочихсон зарим юун дээр чинь эм, эмнэлгийн хэрэгсэл нь байхгүй, ард иргэд гаднаас авч ирж байна. Энэ талаар тодорхой тусгасан уу? Энэ Сангийн сайд, Эрүүл мэндийн сайд 2-оос асууя. Эрүүл мэндийн салбарынхан туйлдаж байна шүү энэ талаар?

Дараа нь энэ би Баян-Өлгий аймгаас сонгогдсон төлөөлөгч юм байгаа юм. Их Хурлын гишүүн байгаа. Тэгээд энэ Цэнгэл сумын 3 дугаар сургуулийн спорт заал гээд энэ жил 3 дахь жилдээ гадаа биеийн тамирын хичээл орох гэж байна. Төсвийг нь гаргуулаад, Барилгын хөгжлийн төвийн дүгнэлт гарсан, спорт заалны төсвийг хассан байх юм. Миний бүх юмыг хасаад хаячихсан байна. Энэ Төсвийн байнгын хороонд байдаг манай Аубакир гишүүн энэ талаар анхаараагүй юм уу та? Очихдоо, Цэнгэл сум дээр очихдоо ярина даа энэ асуудлыг, би таны урдаас ярина шүү.

Нөгөө талаар Улаанхад, Ховд багийн 2 эмнэлэг баригдаад 2 жил болж байна. Эрүүл мэндийн сайд энэ 2 эмнэлгийн нэг эмч, нэг сувилагч, жолооч, галчийн төсөв батлагдсан уу? Хоосон байж байна шүү дээ энэ эмнэлэг чинь, сумын дайтай багууд байж байгаа. Том 1800 хүнтэй ийм сургууль, цэцэрлэгтэй тийм баг байгаа уурхайтай. Тэгээд аймгийн төвийн 150 ортой Оношилгоо, эмчилгээний төвийн тоног, төхөөрөмж ашиглалтад өгөх гэж байна. Энийг хасаад хаячихсан байх юм. Хоосон эмнэлэг дээр орох юм уу? Энийг Эрүүл мэнд сайд тавиулж чадсан уу, тэрийг манай Аубакир гишүүн бид хэд санал өгсөн, тэгээд өчигдөр Аубакир гишүүнээс асуусан хассан байна гээд яриад байх юм.

Мөн түргэн тусламжийн машиныг 26 онд оруулсан. Алслагдсан байдалтай хүнд өнөөдөр гэхэд харвалттай улсуудыг аваарт орсныг замаар авч гарч байна шүү дээ. Онгоцоор хүн тээвэрлэхээ больсон. Ийм төсвүүд хассан байна. Энийг яагаад хассан бол, хариулт авъя?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Бейсен гишүүний хөндөж байгаа асуудал дээр Сангийн сайд Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Их Хурлын даргаа одоо бид чинь нөгөө хүрээ ярьж байгаа төсвийн асуултуудаа төсөв дээрээ ярих уу, нэгмөсөн ингээд цуг явчих юм уу?

Д.Амарбаясгалан: Гишүүний асуултад хариулах үүрэгтэй, төсөв яригдаж байгаа, төсвийн хүрээ яригдаж байгаа. Мэдээж гишүүд төсвийн хүрээтэй холбогдуулаад төсвийн талаар их хөндөж ярьдаг, өмнөх жилүүдэд ч ийм байдлаар ярьсан. Тэгэхээр энэ дээр нь тохирсон хариултыг цаг хугацаанд нь өгөөд явбал төсвийн хэлэлцүүлэг ч гэсэн тодорхой хувиар хөнгөрөөд явна гэж бодож байна. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Бейсен гишүүний асуултад хариулъя. Тойргоос сонгогдсон гишүүд тойргийн ард иргэдийн санал хүсэлтийг ямар ч түвшинд, ямар ч цаг хугацаанд Засгийн газарт, Улсын Их Хурал дээр хүргүүлэх, санал бодлоо хэлэх бүрэн эрхтэй. Тэр ч хүрээнд гишүүдээс тойрогтоо бүтээн байгуулалт хийх төсөл арга хэмжээний саналууд ирдэг. Гэхдээ зарчмаараа явах ёстой. Тэр нь юу вэ гэхээр чиглэл чиглэлийн төсөл арга хэмжээнүүд нь яамнуудаараа очих ёстой, яамнууд маань хуульд заасан хүрээнд 1 дүгээрт 5 жилийн төлөвлөгөө, ирэх жилийн төлөвлөгөө, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, тэгээд төсвийн шаардлагууд, тэгээд яамдын өөрсдийнх нь бодлогын эрэмбэ дараалал, тэгээд эцэст нь төсвийн хязгаартаа багтсан ийм дүрмүүдээр хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүд төсөвт өргөн баригдсан байгаа.

Тэгэхээр таны хэлж байгаа 2 санал бол яг л ийм зарчмаар явсан байгаа. Ялангуяа Баян-Өлгий аймаг сургууль, цэцэрлэг. Энэ жил бид анх удаа Боловсролын

яаман дээр их өгөгдлөөр өөрсдийнхөө хэмжээнд хиймэл оюун ухаанаар энэ хөрөнгө оруулалтуудыг эрэмбэлсэн байгаа. Энэ эрэмбээр манай Боловсролын сайд давхар хариулах болов уу гэж бодож байна. Баян-Өлгий аймагт ирэх жил шинэ сургууль барих шаардлагагүй, бусад аймгуудтай харьцуулбал хамрагдалтын коэффициент, ээлжийн коэффициент бол зохих түвшинд байна. Аймгуудын орон нутгийн дунджаас өндөр байна гэж гарсан байгаа. Тийм учраас шинэ сургууль, цэцэрлэг байхгүй байгаа.

Таны ярьж байгаа бол би их засвар гэж ойлгосон тийм ээ, спорт заалны дээвэр нь нурчихсан их засвар юм байна гэж ойлгосон байгаа тийм. Тэгэхээр энэ асуудал нь яамнаас нь ирсэн үү, үгүй юү энэ дээр ажлын хэсгээс хариулчих. Бусад өөр тэр ямар зарчим бариад эдгээр асуудлууд нь орж ирээгүй юм бэ гэдэг дээр чиглэлийн сайд нь нэмж хариулбал сайн байна. Яамнаас санал нь ирсэн эсэх дээр ажлын хэсгээс нэмээд хариулчих уу?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгээс нэмж хариулт өгөх хүн байна уу? Жигжидсүрэнгийн Чинбүрэн сайд хариулт өгье.

Ж.Чинбүрэн: Бейсен гишүүний асуултад хариулъя. Нэгэнт төсвийн хүрээнээс гадна төсөв ярьж байгаа учраас нэлээн дэлгэрэнгүй мэдээлэл өгчихье. Эхлээд ямар ч байсан нөгөө эрүүл мэндийн төвийн барилга, Баян-Өлгий, Өлгий сум, Хотгор багт баригдаж дууссан тоног, төхөөрөмж гэсэн төсөв орчихсон байгаа шүү. Энэ орчихсон тийм. Нөгөө талаасаа Эрүүл мэндийн даатгалын асуудал хүнд байгаа талаар сая ярилаа. Мөн өнөөдөр Засгийн газрын хуралдаанаар Эрүүл мэндийн даатгалын нөхцөл байдлын талаарх танилцуулга хийлээ. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх даргаар ахлуулсан Эрүүл мэндийн даатгалын холбогдолтой энэ ажлын хэсэг гараад хяналт шалгалт хийж байгаа. Үүний дүгнэлт гарна. Ер нь эрүүл мэндийн даатгал бол өнгөрсөн хугацааны гүйлгээнүүдийг ингээд зөвхөн 25 оны гүйлгээг аваад үзэхэд 316 тэрбум төгрөгөөр өр барагдуулсан. Үүний дараагаар үйл ажиллагаа явуулахдаа хязгаарлалт тавьж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя. Буланы Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Тэр спорт заалны барилга байгаа 3 жил спорт заалгүй гадаа хичээллэж байгаа. Өчигдөр тэр Дэлгэржаргалд би гараараа аваачиж өгсөн, тэр төсөв, Барилга хөгжлийн төвийн дүгнэлтийг Наранбаяр сайдад өг гээд би Наранбаяр сайдын гарт нь өгсөн. Тэгсэн чинь сургууль гээд хассан байгаа юм. Сургууль биш, тэр сургуулийн спорт заал нь байхгүй асуудал байхгүй юу төсөв нь гарчихсан юм, тэрийг нэг гадаа хичээллэж байна өвлийн хүйтэнд тэрийг нэг анхаарч үзээч гэж хэлмээр байх юм.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Бейсен гишүүнээ энэ таны хэлж байгаа энэ санал чинь яг заалны их засвар гэсэн тийм эдийн засгийн ангиллаараа санал нь яамнаасаа ирээгүй юм байна шүү. Тэгэхээр яаман дээрээ шалгуур даваагүй гэсэн үг. Зураг төсөв нь дутуу байсан уу, эсвэл хуучин зураг төсөвтэй байсан уу, эсвэл тэр эрэмбээрээ судлагдаж гарч ирээгүй юу, санал ирээгүй юм байна шүү.

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд нэмж хариулт өгье.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын сургуулийн спорт заалыг 3 дахь жилдээ бариулах ийм саналыг оруулж ирсэн. Тэгээд энэ дээр энэ Төсвийн тухай хуулийнхаа шаардлагын дагуу батлагдсан магадлагдсан ийм зурагтай байх ёстой, энэ шаардлагыг бол хангасан. Харин бүлэг дүүргэлт ачаалалт хэрэгцээ шаардлага одоо байгаа байрны даац ачааллыг тооцох ёстой. Тэгээд энэ дээр бол дан спорт заал байгаа учраас энэ бол эрэмбийн дээгүүр орж ирж чадаагүй хасагдсан. Бид саналаа явуулсан боловч энэ чинь нөгөө ажлын хэсэг дээр яригдаад, ингээд эрэмбийн дээгүүр дан спорт заал гэдэг утгаараа ороогүй, бид 3 ээлж рүү орох эрсдэлийг бууруулах сургууль, цэцэрлэгийн барилгыг түрүүлж барих гэсэн ийм шалгуур үзүүлэлтээр ингээд явсан учраас энэ ороогүй байна. Энэ цаашдаа ярилцаад энийг хэрхэн томьёолох вэ гэдэг асуудлыг ярих боломж бий гэж харж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Сайн байцаана уу. Төсөв, төсвийн хүрээ 2 салгаж хэлэлцэж байгаа учраас би төсвийн хүрээтэй холбоотой хэд хэдэн асуулт тодруулалт байна. 1 Засгийн газрын өсөлтийн таамаглалын эрсдэлтэй холбогдуулаад 26-аас 28 онд эдийн засаг 6-аас 6,5 хувь тогтвортой өснө гэж тооцсон нь хэт өөдрөг байж болзошгүй харагдаж байна. Уул уурхайн төслүүдийн гадаад зах зээл энэ геополитикийн нөхцөл байдал эрсдэлтэй холбогдуулаад энийг хангалттай ер нь тооцох ёстой, олон талаас нь тооцох ёстой гэж харж байна. Энэ дээр юу гэж бодож байна вэ?

2-т нь болохоор тэр түүхий эдийн савлагааны нөлөө тал дээр төсвийн орлогын томоохон хувийг эзэлж байгаа энэ уул уурхайн бүтээгдэхүүний үнэ эргэлтийн энэ огцом савлагааг бага үнэ багц хэмжээний хувилбараар стресс тест хийх шаардлагатай гэж харагдаж байгаа. Энэ дээр би хараагүй юу, эсхүл хийсэн юм уу энэ дээр тодруулга авъя. Тэгэхгүй энэ дээр тодорхой биш бол энэ орлогын төлөвлөлтийг эмзэг болгож байж болзошгүй юм гэж харж байгаа.

3 дугаар асуулт болохоор энэ зардлын бүтэц ба хязгаарлалтын асуудал дээр урсгал зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 24, хувийн түвшинд хүргэсэн ч төсвийн үр ашиг, институт хоорондын үр дүнтэй хуваарилалтыг хангах талаар тодорхой тийм зохицуулалтын механизм сул харагдаж байна, дутмаг харагдаж байна гэж үзэж байгаа. Тэгээд энэ дээр яг тандалтын задаргаа нь тодорхой бус байгаа учраас энэ дээр тайлбар тодруулга авмаар байна.

4 дүгээрт болохлоороо энэ өрийн удирдлагын сорилттой холбогдуулаад 26 онд ДНБ 50, 27 оноос 45 хувийн түвшинд барина гээд төлөвлөсөн байна. Энд нуугдмал өр, төрийн өмчит компаниудын баталгаа, концессын эрсдэл зэргийг бүрэн тусгагдаагүй байх ийм магадлалтай харагдаад байна. Энэ дээр Учрал сайд мэдээлэл авъя.

Хөрөнгө оруулалтын эрэмбэ тогтоох аргачлалын хувьд энэ төсвийн төсөл дэх 9,6 их наяд төгрөгийн хүрээнд 1200 гаруй хөрөнгө оруулалтын саналд яг энэ олон улсын жишиг шалгууруудыг яг юу юуг баримталсан юм бэ? Энэ өрийн тогтвортой байдлын шалгуур маань бүрэн хэрэглэгдэхгүй бол төсвийн хөрөнгө үр ашиггүй хуваарилагдах ийм эрсдэлтэй байна.

6 дахь нь болохлоороо нийгмийн халамжийн тогтолцоо дээр халамжийн зардлыг Дотоодын нийт бүтээгдэхүүний 2,5-аас 2,2 хувь хүртэл буурна гэж тооцсон. Гэхдээ энэ нь ингээд яг зоримог энэ бүтцийн шинэчлэл хийхгүйгээр хэлбэртэй ноцолдоод, агуулга руу нь гүнзгий орохгүй бол энэ түр хойшлуулсан, аргацаасан байдал руугаа орчих вий дээ. Тийм учраас энэ нь эргээд дунд хугацаандаа ингээд дахин өсөх эрсдэлтэй харагдаж байгаа энэ дээр тодруулга авъя.

Сүүлд нь энэ 7 иргэдийн ил тод байдал, олон нийтийн оролцоог хангасан олон хэлэлцүүлэг зохион байгуулсан, иргэд, хувийн хэвшлээс санал авсан гээд байгаа ч гэсэн энэ их тийм хязгаарлагдмал хүрээнд явчхав уу даа гэсэн ийм хардалт байна. Одоо ч гэсэн иргэдэд янз бүрийн асуудал, саналууд зөндөө гараад байдаг. Их Хурлын гишүүд ч гэсэн зарим талаар мэдээлэл дутмаг байгаад байна. Энэ дээр тодруулга авъя.

Ер нь эцэст нь гэж хэлэхэд энэ төсвийн эрэмбэ тогтооход нөгөө үндэсний аюул аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн шалгуур гарсан юм уу, гараагүй юм уу, хэзээ гарах юм бэ?

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Эдийн засгийн өсөлтийг 2024 оны эцэст 5,1 хувь, 2025 оны эхний хагас жилд 5,3 хувиар гарсан байсантай дүйцүүлж тооцож байгаа. Яах вэ ХАА-н салбарт эдийн засгийн өсөлтийг ХАА-н салбар харьцангуй дэмжиж байгаа бол уул уурхайн салбарын өсөлт удааширсан. Үүнийг дагаад тээвэр худалдааны салбарууд агшиж, өсөлтийг удаашруулж байгаа. Гэхдээ уул уурхайн салбарт бол жонш, зэсийн баяжмалаас бусад бүтээгдэхүүний олборлолт мөн үеэс буурч байгаа хэдий ч зэс дээр, алтан дээр, жонш дээр эрэлт харьцангуй нэмэгдэж байгаа. Тэгэхээр бид 2026 оны эдийн засгийн хүлээгдэж байгаа өсөлтийг 5,7 хувь гэж тооцохдоо салбар бүрээр нэгж хувийг нарийвчлан тооцсон. Сая хэлсэн зэсийн баяжмал үйлдвэрлэл, нүүрс, төмрийн хүдэр болон алтны олборлолтуудыг яг энэ 5,7 хувийг тооцохдоо нэгж хувиар нь нэмж тооцож байгаа. Оюу толгойн зэсийн баяжмал үйлдвэрлэл өсөхийн зэрэгцээ алтны, зэсний агуулга нэмэгдэх ийм хүлээлт байгаа. Түүнийг энэ эдийн засгийн өсөлтөөр тооцсон. Эрэлт талаасаа төрийн хэрэглээ 6 хувиар буурч, өсөлтийг яг 1,2 нэгж хувиар нэмэгдэнэ гэсэн ийм тооцоололтойгоор эдийн засгийн өсөлтийг тооцож гаргаж байгаа.

Дунд хугацааны төсөөлөл, дунд хугацааны төсөөлөлд анхаарах асуудлуудыг салбарын яам болгоноор эдийн засгийн өсөлтөд ямар хувь нэмэр оруулах вэ гэдэг чиглэлээр төсвийн хүрээтэй холбогдуулаад чиглэлүүдийг өгсөн. Дунд хугацааны төсөөлөл бол 2025 онд 5.5, 26 онд 5.7, 27 онд 6.3, 28 онд 6.5 байна гэдэг ийм тооцооллыг гаргасан байгаа. Тэгэхээр бид тээврийн салбартаа хил боомтуудын бүтээн байгуулалтуудын ажлыг эрчимжүүлнэ. Уул уурхайн ба уул уурхайн бус бүтээгдэхүүний ачаа тээврийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээнүүдийг шат дараатай аваад явж байна. ХАА-н салбарт Хүнсний хувьсгал, Цагаан алт, Атрын 4 дүгээр аяны нөлөөгөөр дунд хугацаанд тогтвортой энэ өсөлт хадгалагдах төлөвтэй байгаа. Тэгэхээр салбар болгон дээр энэ чиглэлүүдээр ажлуудаа эрчимжүүлээд явж байна.

Засгийн газрын нийт өрийн хэмжээ 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 35,5 их наяд төгрөг буюу нийт Дотоодын нийт бүтээгдэхүүний 39 аравны хувьтай тэнцэж байгаа. Бид төсвийн хүрээтэй холбогдуулаад хуулийн төсөлд өрийн дээд хязгаарыг

шат дараатай бууруулахаар оруулж ирсэн. Тэгэхээр 26 онд бид Дотоодын нийт бүтээгдэхүүний 50 хувь, 27-гоос 28 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувь байхаар тооцсон. Энэ нь мэдээж цаашлаад зээлжих зэрэглэлийгээ тогтворжуулна гэдэг ийм зорилготой. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яамны тооцоо бол Засгийн газрын нийт өрийн хязгаарыг тооцдог. Тэгээд энэ өрийн хязгаар дотроо өрийн гүйцэтгэлийн мэдээллийг Сангийн яам хариуцаад явдаг гэдгийг хэлье.

Түрүүн хэлсэн энэ Өрийн удирдлагын хуулиа бид чанд барьж байгаа 2026 онд GDP-ийн 50, 27 онд 45 хувийн түвшинд барина гэдэг тооцсон. Жилийн төлөвлөгөөнд туссан төслүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр яамнууд дээр байсан 149 төслийг эрэмбэлээд, тэргүүн ээлжид хэрэгжүүлэх 40 төсөл, 4 бүлэг, 15 зүйл аргачлалаар үнэлгээг нь хийлгээд ЗГ-аар батлуулсан. 14 мега төслийг олон улсын аргачлалаар үнэлсэн. Ингээд 5 жилийн чиглэлд тусгаад явна гэсэн ийм төлөвлөгөөтэй байна.

Д.Амарбаясгалан: Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Учрал сайдаас хэд хэдэн асуултад хариулт авлаа. Тэр зардлын бүтцэд ба хязгаарт тал дээр та тодруулаач? Ингээд өөрийн чинь ингээд мэдэгдлээс харахад аягүй олон газрыг татан буулгалаа. Дээрээс нь тэр ТӨК, ААН-үүдийн захирлуудыг сайдын статус руу 3 сая болголоо гээд хэлэх юм. Тэгэнгүүт нэг тэр байгууллагын дарга нь гарч ирэнгүүтээ 3 сая төгрөг байвал бүгдээрээ авлига авна шүү дээ гээд. Энэ Монгол төр гэдэг чинь энэ нөгөө хэмнэхийн тулд хэмнээд байгаа биш энэ чинь ухаалгаар энэ зарцуулалтаа ил тод, нээлттэй, хяналттай үр ашигтай байлгаж иргэдийн нуруун дээр байгаа энэ дарамтыг бууруулах гээд байгаа шүү дээ. Засаг нь ингээд байнгуут доороо очоод яаж байна гэсэн чинь тэгээд юу гэсэн үг юм бэ энэ чинь ТӨК-удын компаниудын захирлыг 3 сая төгрөг болгочихоор нэг авлига авна шүү гээд тийм аргумент дэвшүүлээд байж байдаг. Тэгээд энийг тэр зардлын бүтэц ба хязгаарлалттайгаа холбогдуулаад та нэг хариулт өгмөөр байна.

2 дугаарт тэр нэг хөрөнгө оруулалтын эрэмбэ тогтоох тэр асуусан асуултад хариулж өгөхгүй юу?

Д.Амарбаясгалан: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Их Хуралд ТӨК-ийн Бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулийг өргөн мэдүүлчихсэн, хэлэлцэх эсэхийг дэмжсэн байгаа. Нийтийн өмчийн хуультай хамтатгаад батлаад явбал ТӨК-ийн ангилал ойлгомжтой болно, шалгуурууд тодорхой болно. Хууль батлагдсаны дараа ЗГ-т баримтлах чиглэлийг хуулиараа оруулж ирэх ёстой. Сая Занданшатар даргын Засгийн газар байгуулагдсанаас хойш 109 компаниас энэ удаа төсөв дээр нийтдээ компанийг эхний байдлаар 70 хүргэнэ гэдэг ийм зорилттой. Засгийн газар өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд 20 ТӨК-ийг нь нэгтгэж нийлүүлж, өөрчлөн зохион байгуулсан шийдвэрийг Хэрэг эрхлэх газар Бямбацогт сайд дээр гаргаад, Засгийн газраар оруулаад шийдвэрлэсэн.

Хөрөнгө оруулалтын хөгжлийн төслүүдийг бид макро эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, төсөв, төслийн бэлэн байдлын үнэлгээ, санхүүжилтийн эх үүсвэрийн нөлөөллийн үнэлгээ, нийгмийн нөлөөллийн үнэлгээ гээд 1-ээс 5 оноогоор олон улсын аргачлал 4 бүлэг, 14 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн. Тэгээд энэ үнэлгээ албажсан.

Д.Амарбаясгалан: Учрал сайдад нэг минут нэмж өгье.

Н.Учрал: Тэгэхээр үүнтэй холбогдуулаад бид 5 жилийн Үндсэн чиглэл хуулиараа 10 сарын 31-ний өмнө орж ирэх ёстой. 5 жилийн үндсэн чиглэл дотор 8 зорилт, хөтөлбөр байгаа. Үүнтэй уялдуулаад жилийн төлөвлөгөө боловсруулагдана. Тэгэхээр энэ олон төсөл, хөтөлбөрүүдийг саяын 4 чиглэлээр үнэлээд эхлэхээрээ дотор нь ангилалтай болж байгаа. Тэргүүн ээлжид хэрэгжүүлэх ач холбогдол өндөр төслүүдээ эрэмбэлсэн гэдгийг хэлэх ёстой.

Зарлагын дээд хэмжээг Төсвийн тогтвортой байдлын хууль, дээрээс нь та бүхний баталсан жилийн төлөвлөгөөнд урсгал зардлыг 24 хувиас хэтрүүлэхгүй байх. Уг нь Төсвийн тогтвортой байдлын хуулиар 30 хувь, бид жилийн төлөвлөгөөнд туссан 24 хувийг чанд барьж байгаа. Урсгал бол 24 хувиас хэтрэхгүй байна, хэрэглээгээ хумина. Ирэх жил 23, түүний дараа жил 22 гээд урсгал шат дараатай буурна. Тэгэхээр зөвхөн хууль биш, жилийн төлөвлөгөөгөө барьсан, урсгал зардлыг яг 24 хувьдаа чанд бариад орж ирж байгаа гэдгийг хэлье. Тэгэхээр зардлын реформд анхаарна.

Д.Амарбаясгалан: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууна.

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе. Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой надад 3 асуулт байна. 1 дүгээрт, бид энэ төсөв дагаж төсвийн хүрээгээ өөрчилдөг асуудлыг ер нь хэдийнээс эхлээд болих юм бэ? Энэ 2 хуулийн уялдаа холбоог бид хэзээнээс хангаж ажиллах юм бэ? Өөрчлөх шаардлагатай юу, үгүй юү? Өнгөрсөн 10 жилийн судалгаа харахад бид Төсвийн тухай хуулиа 21 удаа, 71 удаа, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа 21 удаа өөрчилжээ. Төсөв өөрчлөгдөх болгонд Тогтвортой байдлын тухай хууль дагаж өөрчлөгддөг. 2027 он гэхэд, 2027 онд ирэх жилийн дараагийн төсөв хэлэлцэх үед сүүлийн 10 жилийн урсгал зардлын өсөлтийн tendency хурдаар бол бид төсвийн тусгай шаардлагуудаа хангаж чадахгүй хэмжээнд хүрэх нь. Тэгтэл бид одоо энэ хүрээ өөдрөгөөр орж ирж байгаа. Дахиад ирэх онд өөрчлөх үү? Энэ 2 хуулийн уялдаа холбоог ер нь хэзээнээс хангадаг болох юм бэ, энэ дээр тодорхой хариулт өгөөч? Энэ бүх судалгаа бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хийсэн судалгааны дүнгээс авсан мэдээллүүдийг хэлж байгаа юм.

2 дугаарт бид энэ онд 2025 онд төлөвлөсөн нүүрсний биет хэмжээ, олборлолтын хувьд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11 хувиар гүйцэтгэлээр бага гарсан байгаа. Тэгэхээр нүүрсний экспорт энэ оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр ер нь биет хэмжээ ямар байх юм бэ? Бид энэ 2026 оны төсөв дээр 90 сая тонноор төлөвлөж байна. Энэ бодит хэмжээ мөн үү? Хэр үндэслэлтэй биет хэмжээг төлөвлөж байгаа юм бэ?

3 дугаарт макро эдийн засгийн асуудлуудыг тодотгож оруулахдаа үндсэн хөрөнгийн өсөлт болоод инфляцын өсөлтийг тайлбарласан 2 тайлбар дээр нэг жишээг 2 эсрэг талаар нь авчхаж л дээ. Тухайлбал үндсэн хөрөнгийн өсөлтөд юу нөлөөлсөн бэ гэхээр малын зүй бус хорогдол өнгөрсөн оны мөн үеэс 7,9 сая тоо толгойгоор буураад, төлийг сайн авсан учраас биологийн хөрөнгөөр үндсэн хөрөнгийн өсөлт өсчихсөн гээд дүгнэчихсэн байгаа юм. Гэтэл хэрэглээний инфляц өсөхөд нөлөөлсөн хүчин зүйл нь цахилгааны үнийн өсөлт болон махны үнийн өсөлт. Мах яагаад өссөн бэ гэсэн чинь малын зүй бус хорогдол өндөр байснаас гээд. Инфляц өсөх болохоор малын зүй бус хорогдол нь өндөр болчихдог. Үндсэн хөрөнгө

өсөөд ирэхээрээ малын зүй бус хорогдол нь бага болчихдог. Энэ ямар дүгнэлт ороод ирэв? Энийг тодруулж өгөөч?

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгөх нь үү? Энэ яах вэ Үүрийнтуяа гишүүний асуусан асуулт дээр энэ санал асуулга явуулаад төсвийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлттэй холбоотой хэдэн график ирүүлсэн байна л даа. Тэгээд иргэдээс таны бодлоор ирэх онуудад эдийн засгийн өсөлт хэд байх вэ гэж асуусан байх юм. Таны бодлоор ирэх онуудад үнийн өсөлт хэд байх вэ гэж асуулт асуугаад байх юм. Тэгээд энийг чинь иргэд мэддэг юм уу, бодлого гаргаж байгаа, бодлого барьж байгаа газар нь мэдэж зохицуулалтаа хийдэг юм уу гээд энэ асуумаар юмнууд их байна. Энийгээ нэг жоохон мэргэжлийн хүмүүс нэг тайлбар хийгээч. Эндээс гишүүн сууж байгаад ирэх жилийн эдийн засгийн өсөлт 7 хувь байна гээд таамаг дэвшүүлж байгаа нь иргэдийн амьдралыг хөтлөх жолоодох бодлого болох юм уу? Ийм байдал ийм байж болдог юм уу? Учрал сайд энэ дээр хариулт өг дөө.

Н.Учрал: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Төсвийн хүрээ төсвийг ингэж ойр ойрхон өөрчилдөг байдал маш эмзэг байдалтай нь болсон нь үнэн. Төсвийн тогтвортой байдлын хуулийг чанд бариад явсан бол одоо бидний яриад байгаа мөчлөг сөрсөн бодлого амжилттай хэрэгжиж, төсөв зөв бодлоготой байх байсан. Тэгээд төсвийн хүрээний мэдэгдэлд төсвийг нөгөө гаргаж байгаа зарлагадаа нийцүүлсэн орлого тавьдаг, ДНБ-ээ нэмж урсгалаа нэмдэг, жилийн төлөвлөгөөнд туссан шаардлага, Төсвийн тогтвортой байдлын хуулийн шаардлагаа барьдаггүйгээс болоод өнөөдөр ийм эмзэг байдалтай болсон. Тэгэхээр бид нийт эдийн засгийн 38 хувьтай тэнцэх төсвийн зардалтай болсон. Түүний ихэнхийг нь автоматаар жил бүр томруулдаг нь маш эмзэг байдал.

Тийм ч учраас бид энэ удаа төсвийн хүрээний мэдэгдэл дээр эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, хувийн хэвшилд илүү орон зай бий болгох чиглэлээр төсвийн тэнцвэржүүлсэн орлого Дотоодын нийт бүтээгдэхүүний харьцааг үе шаттай бууруулж, 28 хувь болгохоор оруулж ирсэн. Төсвийн хүрээний бидний баталсан мэдэгдэл дээр бид ээлжит бус чуулганаар өөрчлөлт хийхдээ орлого, зарлага 2 хэрвээ нэгэн зэрэг буурсан тохиолдолд төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилж болно гэдэг нэг удаагийн шинжтэй хуулийг баталсан. Тэгэхээр цаашдаа энэ асуудал давтагдахгүй байхын төлөө Эдийн засаг, хөгжлийн сайдын хувьд би анхаарч ажиллана. Тийм учраас энэ удаа Төсвийн тогтвортой байдлын хуулийн тусгай шаардлагуудыг бүрэн барьсан урсгал жилийн төлөвлөгөөнд туссан, тусгай шаардлага дээрээ харьцааг эдийн засгийн харьцаагаа сайн барьсан, орлого зарлагыг аль алиныг нь бууруулсан гэдгийг хэлэх ёстой.

Тэгээд мэдээж түрүүн асууж байна. Тэр ирэх жил бид тэр нүүрсний тоон хэмжээ биет тоон хэмжээг нэмэгдүүлэх ийм зорилтыг тавьж байгаа юм. Тэгээд яах вэ бид жишээ нь Эрдэнэс Тавантолгой дээр менежментийн баг ажиллаад харьцангуй нүүрс олборлож байгаагүй хэмжээний тоо хэмжээний нүүрсийг өнгөрсөн хугацаанд олборлосон. Тэгээд зохих арга хэмжээнүүдийг авсны үр дүнд 25 онд 85 сая тоннд хүрэх гэж байгаа, ирэх жил 90 сая тоннд хүрнэ. Үнийг ямар нэгэн өндөр үнээр огт тавиагүй яг Блүүмбергийн терминал дээр байгаа тэр 14, 5 байгууллагын үнийг харьцуулаад, дээрээс нь дотоодын компаниудтайгаа хэд хэдэн удаагийн уулзалт хийсний үндсэн дээр тоо хэмжээгээ ч гэсэн, үнэ дээрээ ч гэсэн бодит тоонуудыг тавьсан гэдгийг хэлэх ёстой.

Тэгээд цаашдаа мэдээж төрийн эдийн засаг дахь оролцоо сүүлийн жилүүдэд огцом нэмэгдсэнийг засаж, энэ эдийн засгийн харьцааг нь 26 онд 30,9 рүү буулгая, 27 онд 29 хувь руу, 28 онд 28,2 болгож үе шаттай бууруулахаар тооцсон. Тэгээд Эдийн засгийн хөгжлийн яам энэ тусгай шаардлагаа барих, тоондоо хатуу байх энэ зарчмаа л барьдаг. Тэгэхээр энэ зарчмаа бариад л энэ төсвийн хүрээгээ боловсруулсан. Тэгээд л ирэх жилээс бид дахиж төсөвтэй холбогдуулж төсвийн хүрээ өөрчилдөг байдлыг бол хална гэдгийг хариуцлагатайгаар хэлье.

Тэгээд Их Хурлын дарга асууж байна. Тэгээд бид иргэдээс мэдээж энэ эдийн засгийн өсөлтийн тоо хэмжээг асууна гэдэг утгагүй зүйл. Тэгэхээр бид ЗГ өөрөө жишээ нь инфляцад тооцохдоо ч тэр Монголбанктай, Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, бусад байгууллагуудтай хамтарч ажиллаад л яг энэ хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд бид эдийн засгийн өсөлт, инфляц, бусад энэ төсвийн хүрээний эдийн засгийн энэ 9 тоог хуулийнхаа хүрээнд өөрсдөө гаргаад ингээд тусгай шаардлагуудыгаа бариад оруулж ирж байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Дутуу байна аа? Үүрийнтуяа гишүүний асуултад хариулт дутуу авлаа гэж байна. Тодруулж асууя, Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: 1 дүгээрт, би 3 асуулт асуусан. 3 дахь асуултдаа хариулт авсангүй. 2 дугаарт хариулсан асуултууд дээр тодруулахад би хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг нүүрсний биет хэмжээг хэлээд өгөөч л гээд байгаа юм. Яагаад гэхээр гишүүдэд ирсэн мэдээлэл дээр эхний хагас жилийн гүйцэтгэл ирсэн, хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр мэдээлэл ирээгүй байна. Эхний хагас жилийн гүйцэтгэлээс харахад бид 85 сая тонн нүүрсээ энэ жил экспортолж чадах уу, үгүй юү гэдэг эргэлзээтэй харагдаад байгаа юм. Гэтэл энийг нэмчихлээ. Тэгэхээр энд ямар боломж гарцыг харж ингэж төлөвлөж байгаа юм бэ гэдгийг тодруулмаар байгаа юм л даа? 3 дахь асуултынхаа хариултыг авъя.

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Өнөөдрийн байдлаар нүүрсний биет тоо хэмжээ 56 сая тоннд хүрсэн. Тэгэхээр бид гүйцэтгэлийг 85 сая тоннд хүргэнэ гэдэг зорилтыг тавьж байгаа. Зөвхөн Эрдэнэс Тавантолгой гэхэд одоо 18 сая болсон байна. Тэгээд үүнтэй холбогдуулаад Уул уурхайн яамны зүгээс зохих арга хэмжээг авч байгаа, экспортыг дэмжих ажлын хэсэг ажиллаж байгаа. Бид тэр гааль дээр үүсээд байсан асуудлыг хилээр бараа, үйлчилгээ нэвтрүүлэхэд саад тотгор учруулаад байсан журмуудыг өөрчилсөн. Одоо ямар нэгэн саад тотгоргүйгээр явж байгаа. Мөн биржийг дэмжиж байгаа, биржийн тээврийн, биржээр зарагдсан нүүрсийг тэр AGB-н терминал дээр явуулах арга хэмжээнүүдийг авсан. Сая Өвөрмонголын өөртөө засах орон болоод БНХАУ-ын Ерөнхий сайдтай ч гэсэн Хятадад уулзсан. Тэгээд энэ үеэрээ 2 талаас үүсээд байгаа тэр м... асуудал, мэдээлэл солилцох асуудал, тодорхой бүх хүлээгдэж байгаа асуудлуудыг шийдвэрлэсэн. Энэ гүйцэтгэлд хүрнэ.

Д.Амарбаясгалан: Учрал сайдад минут нэмж өгье.

Н.Учрал: Тэгэхээр боомтууд дээр нэвтрүүлэлтийг нэмэгдүүлэхээр тохиролцох ажил хөрш орнуудтай харилцан тохиролцсон. Гашуунсухайтаар зөвхөн 40 сая тонн гарах ёстой шүү дээ. Тэгэхээр энэ зорилтдоо бид хүрнэ. Ирэх онд болбол, жишээ нь сая тэр Ганцмод Гашуунсухайтын хил холболтын төмөр зам дээр явж байгаа тэр Чайна Энержигийн нүүрс гэхэд л 2 цуваа вагон явдаг байсан одоо 8

явдаг ингээд л болсон. Тэгээд ер нь энэ ажлууд эрчимтэй явж байгаа. Дээрээс нь Хятад, Монголын комисс энэ намар хуралдана. Ингээд ерөнхийдөө экспортыг нэлээдгүй сайн дэмжинэ. Тэгээд ер нь 90 сая тоннд хүрнэ гэж тооцсон гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Үүрийнтуяа гишүүний 3 дахь асуултад л хариулт авъя гээд байх юм. Учрал сайд 3 дахь асуултыг нь ойлгоогүй юм уу? Дахин тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: 3 дахь асуултаа би дахиад хэлье. Үндсэн хөрөнгийн өсөлт инфляцын өсөлт 2-ыг тооцож гаргасан макро эдийн засгийн үзүүлэлтүүд дээр чинь малын зүй бус хорогдлыг 2 өөр янзаар ашиглаад байна. Үндсэн хөрөнгийн өсөлт нэмэгдсэн нь малын зүй бус хорогдол буурсантай холбоотой. Мал 7,9 саяар зүй бус хорогдол нь буурсан гээд нэг талд нь тайлагначихсан. Нөгөө талд нь хэрэглээний инфляц өсөхөд эрчим хүчний үнийн өсөлт болон махны үнийн өсөлт нөлөөлчихсөн. Махны үнэ өсөхөд юу нөлөөлсөн гэхээр малын зүй бус хорогдлын өсөлт нөлөөлөөд байна гээд тайлбарлаад байгаа байхгүй. Яахаараа инфляц өсөхөөрөө малын зүй бус хорогдол нь өсөөд байдаг, үндсэн хөрөнгийн өсөлт нь өсөхөөрөө малын зүй бус хорогдол нь буураад байдаг юм бэ энийг тайлбарлаад өгөөч л гээд байгаа юм?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгээс хариулъя. Хэн хариулах вэ? Эдийн засаг, хөгжлийн яамны, 4 дүгээр индэр. Эдийн засаг, хөгжлийн яамны газрын дарга. 4 дүгээр индэр микрофон өгье.

Л.Энх-Амгалан: Гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Энх-Амгалан. Үндсэн хөрөнгийн хуримтлал энэ юу энэ малын тооны өсөлт, ялангуяа нөгөө хээлтэгч насны малын тоог бүртгэдэг. Тэгэхээр өнгөрсөн оны тухайд, өнгөрсөн 2 жилийн тухайд өвөлжилт нэлээн тааруу байсантай холбоотойгоор манай улсын малын тоо толгой нэлээн хорогдсон. Энэ агуулгаараа ХАА-н салбарт гол үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн потенциал явуулдаг тэр хээлтэгч малын тоо хорогдсонтой холбоотойгоор хөрөнгө оруулалтын эх үүсвэр буурсан гэж ингэж статистик бүртгэдэг. Энэ нь энэ жилийн тухайд зуншлага сайн, өнгөрсөн жил өвөлжилт гайгүй байсантай холбоотойгоор манай үндсэн хөрөнгө нэмэгдэх ийм хандлагатай байна. Энэ бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулах уу? 4 дүгээр микрофон.

Л.Энх-Амгалан: Энэ эдийн засгийн өсөлт талдаа таатай байгаа юм. Гэтэл 2 жилийн өмнө төл хүлээн авалт нэлээн муу байсантай холбоотойгоор энэ жилийн тухайд яг мах бэлтгэлд ашиглах хэмжээний том малынх нь тоо толгой харьцангуй бага байна. Тэгэхээр намартаа, магадгүй ирэх хавартаа махны үнийн инфляц дарамттай байх магадлалтай. Зудын нөлөө инфляц руу яг ингэж 2 жилийн дараа орж ирдэг. Энэ бол яг нөгөө мах бэлтгэлтэй холбоотой төлгөөс, ялангуяа 2 наснаас дээш малаа гаргадагтай холбоотойгоор ингэж орж ирдэг юм. Энэ жилийн тухайд GDP талдаа сайн нөлөөтэй, инфляц талдаа 2 жилийн хоцрогдлоороо муу нөлөөтэй ийм л зүй тогтолтой явж байгаа.

Д.Амарбаясгалан: Энх-Амгалангийн хариулт амьдралаас жоохон хол хариулт болчих шиг л болох юм. Зуншлага хаана сайн байсан юм бэ? Энэ жил 21 аймгийн 8 аймаг нь зуншлага тааруу байна. Газар тариалангийн голлох аймгуудын ургацын байдал тааруу байна. Яг өнөөдрийн байдлаар жишээлбэл баруун 5 аймгийн, ялангуяа Баян-Өлгий, Ховд, Увс гээд аймгуудад малчид малаа маш их

хэмжээгээр зах зээлд нийлүүлэх бодлогыг барьж ажиллаад эхэлчихсэн байж байх жишээтэй байна шүү дээ. Хүнсний ногоо, ургац хураалт тааруу байна үнэ өсөх нөхцөл рүү орж байна гэдэг ийм төлөвтэй болчихсон байж байгаа шүү дээ. Тэгэхээр өөрийн чинь хариулт дээр болохоор зуншлага сайн байсан, ер нь гайгүй гэсэн тийм хариулт өгчих юм. Энэ дээр нэг тодруулаад хариулаач?

Л.Энх-Амгалан: Тийм, эдийн засгийн өсөлт талаасаа тайлбарлахаар өнгөрсөн 2 жилийн тухайд ХАА-н салбар дээр суурь нь нэлээн муудчихсан. Тэгээд өнгөрсөн хавар, өвлийн байдлаар том малын зүй бус хорогдол болон төллөх, том малын зүй бус хорогдол бага байсан. Энэ сайн мэдээ. Төл хүлээн авалт сайн байсан. Энэнтэй холбоотойгоор бид үндсэн хөрөнгийн хуримтлалыг өндрөөр тооцож аваад байгаа юм. Энэ зуны тухайд тийм, зуншлага олон аймаг, сумдад муу байна. Тийм болохоор ирэх хавартаа инфляц дээр дарамт учирч магадгүй гэсэн ийм төсөөлөлтэй байгаа. Өвөлжилт сайн байсан гэж би өмнө нь хэлэх байсныг зуншлага гэж магадгүй андуурсан шиг байна.

Д.Амарбаясгалан: Болсон, Үүрийнтуяа гишүүн 2 удаа тодруулгаа авчихсан, дэгээрээ 2 тодруулга авах боломжтой. Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууя.

Ж.Баясгалан: Энэ өдрийн мэнд хүргэе. 2026 оны улсын төсвийн төсөлд инфляцыг 6 хувь байхаар тооцсон байгаа. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод үйлчилгээний бүлгийн үнэ 18,2 хувиар, хүнсний бүлгийн үнэ 7,4, хүнсний бус бүлгийн үнэ 10,1 хувиар өссөн байгаа. Одоогийн байдлаар 330 сумаас 220 сум нь гантай, ургац тааруу, малын тарга тэвээрэг сайнгүй байгаа гэж үзэж байгаа. Тэгээд дээр нь өнөөдөр статистикийн газраас гаргасан мэдээгээр 25 оны 9 сарын байдлаар үхрийн ястай мах 19920, цул мах 23900, 1кг төмс 2614, алтан тариан савласан гурил 3400, талхны үнэ ч гэсэн өссөн байгаа. Тэгэхлээр энэ олон өсөлтүүдийг тооцож үзсэн үү? Энийгээ 6 хувьд барьж чадах уу? 26 оны нэг сараас эхлээд дулааны тариф 73, айл өрхийн дулаан 100 хувь, халуун, хүйтэн бохирын ус бүгд нэмэгдэж байгаа. Эд нараа тооцсон уу? Дээр нь нэмэгдээд валютын ханшийн өдөр ирэх тусам өсөж байгаа энийгээ тооцож үзсэн үү гэж 1 дүгээр асуулт?

2 дугаар асуулт нь сая Ерөнхий сайд хэлсэн. Энэ тэтгэвэр нэмэхтэй холбоотой асуудал дээр. Тэтгэврийг бага хэмжээний тэтгэвэртэй хүмүүст илүү нэмээд, өндөр тэтгэвэртэй хүмүүст бага хэмжээгээр нэмье гэж. Үгүй ээ энэ чинь тэтгэвэр шүү дээ, тэтгэвэр, тэр хүмүүс өөрсдөө цагтаа ажилласан мөнгөө хураагаад, хураалгаад ямар ч хүүгүйгээр хадгалуулаад, сүүлд нь өөрөө авах болохлоороо сар болгон хүү төлж зээлж авдаг. Энэ мөнгөндөө ингээд эргээгээд тэр өндөр төлсөн хүн нь хохироод байж болох ийм шударга ёс байх юм уу, энэ чинь хүн төлсөн мөнгөө л авах гэж байгаа. Тэгэхлээр нэмбэл бүгдийг нь нэмэх ёстой. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 10 хувиар нэмье гэсэн санал оруулсан гэж Аубакир сайдыг ойлгож байгаа. Тэгэхлээр энэ сайд саналаа оруулсан уу, эсвэл энэ санал ороод 6 хувь болсон юм уу? Энэ эсвэл тэр Ерөнхий сайдын энэ дээр Сангийн сайд хариулаад өгөөч. Энэ намын сонгуультай холбоотой сурталчилгаа яваад байгаа юм уу, энэ чинь ийм байж болохгүй шүү дээ. Эсвэл энэ Засгийн яг бодлого юм уу? Энэ дээр Сангийн сайдаас бүүр тодорхой асуумаар байна. 1 минутаа нэмээд авчихъя.

Тэтгэвэр, тэтгэмжийн асуудал ярьсантай холбогдуулаад Монгол Улсад байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ талаар ярихгүй бол болохгүй. Нийгмийн халамжийн сангийн 73,6 хувь нь хүүхдийн мөнгө, цалинтай ээж, жирэмсэн, одон,

ихэр, насны хишиг гээд явдаг. Ерөөсөө 26,4 хувь нь л нийгмийн халамжийн зорилтот бүлэгт зориулагдаж ирсэн юм. Тэгээд өнөөдрийн байдлаар энэ чинь 6 хувь нэмээд, нэмээд халамжийн тэтгэврийн хэмжээ 397500 болно. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхийн мөнгө 471 мянга болно, асаргааны тэтгэмж 302600 болж байна. Ингэхлээр чинь энэ мөнгөөр энэ их өсөж байгаа инфляцын үед амьдарч чадах уу? Энэ дээрээ анхаарч болдоггүй юм уу? Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн энэ тэтгэвэр, тэтгэмжийн асуудал маш хүнд байгаа шүү дээ. Өвчтэй эм, тариа хэрэглэдэг, ажил хөдөлмөр эрхэлж чаддаггүй тэгсэн хэр нь тэтгэврийн хэмжээнээс дахин бага ийм мөнгөөр яаж амьдрах юм бэ?

Тэгээд энэ бидний санал болгоод оруулсан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр орон сууцын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 30 тэрбумын тусгуулах санал.../минут дуусав

Д.Амарбаясгалан: Төсөв дээр мэдээж тодорхой хариултууд явах байх гэж бодож байна. Эхлээд Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Мэдээж макро эдийн засгийн тогтвортой байдлыг сайжруулж, иргэдийн энэ бодит орлогыг хамгаалахад инфляцыг бид зайлшгүй бууруулах шаардлага үүсэж байгаа. Тэгэхээр Үндэсний статистикийн хороо бол 8 дугаар сард инфляцыг яг зарладаг. Тэгэхээр 8 дугаар сард инфляц улсын хэмжээнд 8,8 хувь байна гэдэг тооцоог Статистикийн хороо өөрсдийн батлагдсан аргачлалынхаа дагуу нөгөө ерөнхий үнийн өсөлтийг гаргасан. Үүнд бол нөгөө тодорхой хэд хэдэн асуудлууд нөлөөлж байгаа. Тэгээд бид макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, инфляцыг тогтвортой барихад энэ ХАА-н салбарт хэрэгжүүлэх аян хөтөлбөрүүд эцсийн зорилт үр дүнд хүрэх ёстой учраас шахуу арга хэмжээнүүдийг авч байна. Хүнсний нийлүүлэлт нэмэгдэх, тээвэр логистикийн саатлаас урьдчилан сэргийлэх, нийлүүлэлтийн хомсдол үүсгэхгүй байх, Төв банкнаас оновчтой мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтраад ажиллаад явж байгаа.

Ингээд инфляц 25 оны 8 дугаар сард 8,8 хувьд хүрээд өмнөх оны мөн үеэс 2,7 нэгж хувиар энэ өссөн үзүүлэлттэй байсан. Тэгээд үүнд мэдээж нөгөө цахилгааны төлбөр, мах, хүнсний ногоо, түрээсийн зардал, суудлын автомашин гээд гол нөлөө үзүүлж байгаа зүйлүүд байна. Хүнсний ногоо, тэгээд л нийтийн тээврийн үйлчилгээ гээд. Тэгэхээр бид нөгөө өрхийн цахилгааны тариф 24 оны 11 сарын дунд, 11 дүгээр сард бараг дунджаар 65 хувиар өссөн. Энэ өөрөө шууд 1,2 нэгж хувиар өсгөхөд гол нөлөөг үзүүлсэн. Автобусны үнэ 25 оны 2 дугаар сард мянган төгрөг болсон. Тэгээд 1100 хувиар энэ өсөж байгаа үзүүлэлт инфляцад 0,3 нэгж хувийн үзүүлэлттэй байгаа. Зүгээр бид 2026 онд дунджаар 7 хувь байхаар тооцож байна. Тэгэхээр Статистикийн хороо яг нэг ийм инфляцыг хэрхэн тооцдог талаараа Статистикийн хорооноос нэмэлт мэдээлэл хийх нь зөв байх гэж бодож байна.

Тэгээд бид яг энэ инфляцыг 7 хувь барина гэж тооцохдоо саяын хүнсний салбарт хэрэгжих тэр дундаа тэр хүнсний хувьсгал, Атрын аян гээд аянуудыг, тэр Шинэ хоршоо, бусад ХАА-н салбарт хийж байгаа бодлогын үйл ажиллагаануудыгаа эрчимжүүлэх зорилтыг тавьсан. Инфляц мэдээж тэр нөгөө хүлээлтээр удирдагдаж явдаг тул инфляцыг хэт өндрөөр төсөөлөх нь ирэх жил барааны үнэ өсөх эрсдэлд хүргэдэг. Тийм учраас Засгийн газрын зүгээс Төв банкны зорилтот түвшин, инфляцын хүрээтэй нь мөнгөний бодлогоо нийлүүлж, зорилтот түвшинд илүү хүргэж ажиллахаар ярилцаад ингээд ажиллаж байгаа. Тэгэхээр энэ яг Монголбанкнаас

гаргаж байгаа интервалд, интервалтай нийцээд ингээд явж байгаа. Тийм учраас Засгийн газрын зүгээс яг нэг ийм бодитойгоор 7 хувьд хүргэнэ л гэдэг ийм зорилтыг тавьж байгаа. Тэгээд инфляцыг яг тэр нөгөө хэрхэн бодох аргачлалын талаар нөгөө хэрэглээний сагсанд байгаа бүтээгдэхүүн, нөгөө сум, аймаг, нийслэлийн худалдаа үйлчилгээний цэгүүдээс цуглуулж байгаа нийт мэдээллүүдийг аваад л бид Статистикийн хороо нөгөө инфляцыг гаргадаг. Тэгэхээр үүнийг Статистикийн хороо нэмж мэдээлэл хийх байх. Сангийн яам.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулт өгье.

Б.Жавхлан: Баясгалан гишүүний асуултад хариулъя. Тантай би бүүр 200 хувь санал нийлж байна. Өндөр тэтгэвэр авч байгаа иргэд маань тухайн, тухайн үедээ өндөр шимтгэл төлсөн. Өөрөөр хэлбэл тэр өндөр шимтгэлээр нь тухайн, тухайн үед төр тухайн үеийн тэтгэвэр авагч нарт тэр эх үүсвэрээр тэтгэврийг нь тавьсан байдаг байхгүй юу. Ингэж бодохоор нэг талаараа энэ чинь аягүй том нийгмийн хариуцлага юм байгаа юм. Тэгээд тэтгэвэрт гарсан хойно нь торгоод чи өндөр авч байгаа учраас чамд бага нэмнэ, энд чинь олон бага авдаг улсууд байна тэнд өндөр нэмнэ гэж болохгүй. Тийм учраас энэ удаа, энэ удаа ч юу байх вэ сүүлийн жилүүдэд ижил яг хувиар нэмж байгаа. Одоо 6 хувиар, өндөр улсуудад 6 хувь өндөр гарна, бага дээр нь 6 хувь бага л гарна.

Харин халамжийн тэтгэвэр өөр. Халамжийн тэтгэвэр дээр өөр бодлого явах ёстой. Энэ талаар чиглэлийн сайд нь хариулах байх гэж ингэж бодож байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орон сууцтай холбоотой ямар нэг асуудал, юу санал ирээгүй учраас төсөв дээр тусгагдаагүй.

Д.Амарбаясгалан: Тилеуханы Аубакир гишүүн, сайд хариулт өгье.

Т.Аубакир: Баясгалан гишүүний асуултад хариулъя. Тэтгэвэртэй холбоотой асуудлыг сая Сангийн сайд ерөнхийдөө хэллээ. Тэтгэврийг 1,5 сая төгрөг болгоё гэсэн шаардлагыг, хүсэлтийг тавьж байгаа иргэд. 1,5 сая төгрөг болгоход улсын төсөв дээр 4,1 их наяд төгрөгийн ачаалал ирнэ. Тэгээд иргэд утсаар болон бичгээр холбогдож байгаа. Яг таны хэлж байгааг хэлж байгаа юм Баясгалан гишүүнээ. Бид шударгаар 20, 30 жил нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөд явж байдаг. Гэтэл ажил хөдөлмөр эрхлэхгүй явж байгаад ингээд халамжийн тэтгэвэрт хамрагдаад тэтгэвэр аваад явж байгаа хүмүүстэй бид адилхан тэтгэвэр авна гэж бол байхгүй шүү. Бид тэгвэл шударгаар хөдөлмөрлөсний давуу тал буюу энэ тэгвэл хаана байх юм бэ энэ шударга явдал чинь гэдэг асуудал ярьж байгаа. Тэтгэвэр нэмэх бодлогыг инфляцтай уялдуулаад байнга нэмээд явах хууль батлагдсан. Та сая асуулаа 26 оны улсын төсөвт өгсөн санал дээр манай.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Аубакир сайдад нэг минут нэмж өгье.

Т.Аубакир: Тэгээд бид 10,3 хувиар нэмүүлэх саналаа өгсөн. Гэхдээ мэдээж хэрэг санхүү төсөвтэй холбоотой 6 хувь дээр тогтож байна 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн энэ хүний хөгжлийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн салбар дээр бид тодорхой хэмжээний төсвүүдийг тусгаад явж байгаа. 25 онд 238 тэрбум төгрөг байсан бол 2026 онд 245,7 тэрбум төгрөг болгож өсгөсөн. Үүн дотор таны асуусан хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр 165,9 тэрбум төгрөгөөр суусан байж байгаа. Хөгжлийн

бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн хөнгөлөлт 15,6 тэрбум төгрөг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой төсөл, хөтөлбөрүүд байнга явж байгаа. Сүүлийн жилүүдэд бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж байгаа энэ ажил, үйлчилгээг байнга төсвийг нь нэмэгдүүлээд явж байна. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төв жишээлбэл Баянзүрх дээр шинээр барилга нь эхлээд явж байгаа гэх зэрэг маш олон зардлууд суугаад явж байгаа. Энэ цаг аягүй бага болохоор дараа дараагийн юман дээр дахиад нэмээд дэлгэрэнгүй.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хажекберийн, Баясгалан гишүүн тодруулж асууя.

Ж.Баясгалан: Аубакир сайдаас яг саяынхаа асуудлыг тодруулчихъя. Энэ би юу асуусан бэ гэхлээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний орон сууцын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай 30 тэрбумыг тусгуулах саналаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд гаргасан. Энэ саналыг Сангийн яаманд хүргүүлсэн үү, эсвэл та нар хүргүүлээгүй юү гэдэг асуудлыг л гол нь асуух гээд байгаа юм л даа. Сая Сангийн сайд хүргүүлээгүй гэдгээ илэрхийлсэн тийм ээ? Тэгэхлээр тийм Аубакир сайд хүргүүлсэн юм уу, хүргүүлээгүй бол яагаад хүргүүлээгүй юм бэ? Энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон сууцад хамрагдах асуудал хамгийн том асуудал шүү дээ. Байгаа дээр нь сайдуудыг байгаа дээр нь яг асуучихсан нь дээр, тодорхой.

Д.Амарбаясгалан: Тилеуханы Аубакир сайд хариулт өгье.

Т.Аубакир: Төсөв хэлэлцэж байхад бүх сайдууд байнга байж байгаа шүү Баясгалан гишүүнээ. Тэгээд бид энэ 30 тэрбум төгрөг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг орон сууцжуулахын хүрээнд бид саналаа хүргүүлсэн. Энэ маань яг Засаг дээр яригдаад явж байгаа Орон сууцжуулалтын банктэй болгохтой холбоотой том, том зүйлүүдийг яригдаад явж байгаа юм. Энэ хүрээнд магадгүй Сангийн яамнаас энэ удаадаа жоохон хүлээх гэдэг ч юм уу, түүнээс мэдээж хэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тавьдаг хамгийн нэг номерын асуудал энэ орон сууцтай болмоор байна, жирийн хүмүүсээс илүү жоохон хөнгөлөлттэйгөөр орон сууцтай болмоор байна гэсэн асуудлыг байнга тавьдаг учраас бид 26 оны улсын төсөвт саналаа хүргүүлсэн.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Аубакир сайдаа энэ санал маань системээрээ албан ёсоор хүргэж ирэх ёстой шүү дээ. Тэгэхээр 7 сарын 25-нд системээр ирсэн үү, ирээгүй юү гэдгээ та эргээд нэг хараадхаарай. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон сууц барих төсөл өмнө нь хэзээ ч ер нь хэрэгжиж байгаагүй, тийм төслүүд явж байгаагүй. Миний бодлоор танай яаман дээр энийг хэрэгжүүлэхээр тийм төсөл бэлэн байдалтай байхгүй гэдгийг би маш сайн мэдэж байна. Ийм зураг төсвөөр, ийм хөрөнгөтэй, ажлын зураг нь ийм бэлэн болчихсон юм гээд та нар хүргүүлэх зураг одоо та нарт бэлтгэл ажил байхгүй шүү дээ. Тэгэхээр та нар хүргүүлэх юм байхгүй байхгүй юу. Тэгэхээр системээр яг хүргүүлсэн үү, үгүй юү гэдгийгээ ажилчдаасаа дахиад нэг эргүүлээд шалгаадхаарай.

Д.Амарбаясгалан: Энийг ер нь их тодорхой болгохгүй бол их олон жил хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг орон сууцаар хангана, хөнгөлөлттэй орон сууц барьж өгнө л гээд л нэг ийм, яг үнэндээ бодит амьдрал дээр хэрэгжиж чадахааргүй

тийм амлалт ингээд л жил болгон ярьдаг, жил болгоны төсөв дээр ярьдаг л болчхоод байгаа байхгүй юу. Яг бодит амьдрал дээр төр байшин бариад хямдхан, хөнгөлөлттэй нөхцөлөөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгоно гэдэг үндсэндээ бүтэхгүй зүйл шүү дээ. Энийгээ тодорхой Засгийн газар хэлэх нь зүйтэй.

Харин орон сууцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тодорхой хэмжээний хөнгөлөлт үзүүлээд оруулах тэр хувийн хэвшлийн барьж байгуулж байгаа орон сууцад яаж бодлогоор дэмжлэг үзүүлэх юм бэ гэдэг дээр нэг жоохон тодотгож ярих нь л зөв байх. Түүнээс биш хөгжлийн бэрхшээлтэй иргэд заавал төр барьж өг, тэр төрийн барьсан орон сууцад орно гэдэг зүйлийг ярихгүй байгаа байх гэж бодож байгаа юм. Би сая энэ 15-ны чуулганы нээлт дээр хэлсэн үгэндээ төр энэ хувийн хэвшлийн хийж чаддаг аж ахуй, үйлчилгээний бизнес рүү ордгоо л больчихооч гэдэг зүйлийг хэлээд байгаа шүү дээ. Улсын Их Хурал тогтоол баталж, энэ оролцоод байгаа зүйлийг таслан зогсоолгох хэрэгтэй. Зам цэвэрлэхийг төр хийхээ болих хэрэгтэй, хоол хийдгийг төр хийх энэ ажлаа болих хэрэгтэй, амралт сувиллын газар ажиллуулдгийг төр хийдгээ болих хэрэгтэй. Хувийн хэвшилдээ орон зай гаргаж өгөөч л гэдэг зүйлийг хэлээд байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр зоригтой шийдвэр гаргаад Засгийн газар шийдчихэд болохгүй юм ерөөсөө байхгүй шүү.

Зарим салбарын сайдууд ч гэсэн энэ зүйлээсээ татгалзах хэрэгтэй. Салбарын сайд заавал аж ахуй удирдах гээд байх тэр сонирхлыг таслан одоо зогсоох цаг нь нэгэнт болчхоод байна шүү дээ. Тэр мэргэжлийн байгууллагууд нь байгуулагдаад төрийн нийгмийн хариуцлагын хүрээнд авч явах ёстой бизнес байдаг бол тэр хувийн хэвшлийн сонирхоод эсхүл хөрөнгө оруулалтаа хийж чадахгүй байгаа тэр хэсэг дээрээ төр үйл ажиллагаа явуулаад, бусдыг нь ингээд энэ хувийн хэвшилдээ бүрэн өгөх хэрэгтэй. Хажекберийн Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би Монгол Улсын нэгдсэн төсвийн талаар асуулт асууна Сангийн сайдаас. Баян-Өлгий аймагт орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, дээрээс нь Орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүжилтийг 2025 оны төсвийн тодотголоор хасагдсан. Дээрээс нь энэ жилийн 2026 оны төсвөөс хасагдсан байна. Өөрөөр хэлбэл орон нутгийн төсөвт олгох санхүүжилтийн дэмжлэг 2 удаа дараалан хасагдсанаас болж Баян-Өлгий аймагт 164 албан хаагч цомхотголд орохоор байна. Яагаад энэ орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг хасаад байдаг юм бэ? Миний бодлоор тодорхой шалгууртай байх ёстой. Төвийн бүсээс алслагдсан байдал, дээрээс нь хүн амын тоо, газар нутгийн хэмжээ гэх мэт. Баян-Өлгий аймаг хүн амын тоогоор хамгийн их нь, төвийн бүсээс алслагдсан. Тэгсэн мөртөө та энийг зориуд албаар хасчихсан биш үү? Тодорхой тайлбар авмаар байна.

Боловсролын сайдаас Монгол Улсын Засгийн газар энэ жилийг боловсролыг дэмжих жил болгон зарласан. Ерөнхий сайд маань хүний хөгжил манай Засгийн газрын хамгийн том мега төсөл гэж зарлачихсан. Боловсролын хөрөнгө оруулалт энэ жил 2 дахин нэмэгдсэн. Тэгсэн мөртөө Баян-Өлгий аймгийн боловсролын салбарт шинээр нэг ч төгрөг хөрөнгө оруулалт тавигдаагүй байна. Энэ яагаад юм бэ нэг?

2 дугаарт Баян-Өлгий аймгийн Боловсролын газрын даргаар төрийн албан шаардлагыг хангаагүй ХҮН намын 1 нөхрийг та томилуулан ажиллуулж байгаа. Энэ нөхөр цэцэрлэг, сургуулийн захирал, эрхлэгч нарыг очоод ХҮН намын гишүүнчлэлийг ав, ХҮН намын гишүүнчлэлийг авахгүй бол ажлаас чөлөөлнө гээд

дарамталдаг. Төрийн албаны зөвлөлөөс энэ нөхрийг шалгаад, ямар ч шалгуур хангахгүй гэсэн дүгнэлт гарсан. Та энийг хэрэгжүүлэхгүй байгаа, тэр нөхрийг хэд хоногийн өмнө тушаал гаргаад ажлаас нь чөлөөлөөд, буцаад томилсон сурагтай. Энэ үнэн юм уу? Энэ үнэн бол ер нь та ХҮН намын Хүний нөөцийн сайд юм уу, Монгол Улсын сайд юм уу? Та бол энэ хуулиа хэрэгжүүлэх хэрэгтэй. Хуулийн хангалтыг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Жангабыл гишүүнийхээ асуултад хариулъя. Орон нутгийн хөгжлийн сан ер нь аймгууд дээр жигд хасагдсан байгаа. Энэ дээр аймаг аймгийн, тойрог тойргийн төлөөллүүд гишүүд буруугүй. Жангабыл гишүүн та энд буруугүй шүү. Орон нутагт тиймэрхүү улс төржсөн асуудлууд яригдсан байна лээ, манай дээр ч хүртэл бичиг ирсэн. Тэгэхээр энэ ямар асуудал болсон бэ гэхээр энэ жил төсвийн орлого буурахад нөлөөлж байгаа зүйл маань энэ нүүрсний үнэ юм байгаа юм шүү дээ. Тэгэхээр нөгөө Амнат маань төсөвт ордог Амнат маань бүхэлдээ дүн нь буурчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр буурсан дүнгээс чинь 10 хувийг нь аваад, Орон нутгийн хөгжлийн сан дээр тавиад аймгуудад хуваагаад өгөхөөр чинь энэ дүн буурна даа. Тийм учраас тодотголоор ч буурсан. Тодотголоор буурсан дүнгээс ирэх жилийн Амнатын дүн мөн дахиад тодорхой хэмжээнд буурч байгаа. Тэгэхээр дахиад буурч байгаа юм, тийм ингэж хуваарилагдаж байгаа учраас гишүүдэд энд ямар нэг буруу байхгүй гэдгийг би тодруулж хэлье.

9 хувиар хэдүүлээ төрийн албаны тоог бууруулна гэдгийг өнгөрсөн 5 сард хөгжлийн төлөвлөгөөндөө оруулчихсан 2026 оны. Энийг сая тодотголоор хэрэгжүүлж эхэлсэн байгаа. Энийг хэрэгжүүлэхдээ орон нутагт төсвийн ерөнхийлөн захирагч нар, аймгийн дарга нар, аймгийн удирдлагууд энэ дээр нэг жоохон улс төржсөн тийм өнгө аяс гаргаад байгаа байна лээ. Бидэн рүү бичиг ирсэн. Баян-Өлгий аймгийн Засаг даргаас ийм бичиг ирнэ лээ. Түүн дээр харин 9 хувиар цомхотгол тэнд өртөх төрийн албан хаагч нараас сонголт хийхдээ улс төржсөн маягаар ингэж хийж байгаа бол энэ буруу. Ингэж болохгүй. Энэ дээр Засгийн газрын Хэрэг эрхлэхээс аймгуудад, яамнуудад маш тодорхой чиглэлүүд өгсөн байгаа. Хамгийн 1 дүгээрт төрийн албан хаагч нараас нас нь болоод тэтгэвэрт гарч байгаа бол аль болох тухайн орон тоон дээр нэмж хүн авахгүй байх. Мөн нэмэлт орон тоо сул байгаа бол энэ дээрээ мөн нэмж хүн авахгүй байх. Энэ дээрээ хэмнэлт хийх гээд. Цахим хэлбэрээр хийж болох өөр бусад технологи ашиглаж хийж болох ийм орон тоонуудыгаа цомхотгох гээд ийм аль болох ажлын байран дээр илүү их тийм дарамт үүсгэхгүй байхаар, төрийн албан хаагч нарт өрхийн орлогод нь хүчтэй цохилт өгөхгүй байхаар ийм зохицуулалтуудыг хийх ийм боломжууд байгаа. Тэгж байхад ингэж улс төржсөн байдлаар ингэж хийх нь мушгиж гуйвуулж төрийн бодлогыг хэрэгжүүлэх нь маш буруу шүү гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд нэмж хариулт өгье.

П.Наранбаяр: Жангабыл гишүүний асуултад хариулъя. Баян-Өлгий аймагт нийтдээ 4 төсөл, арга хэмжээ цэцэрлэг, сургуулийн барилга энэ жил хэрэгжихээр заагдсан байгаа. Энэ дээр 2 цэцэрлэг, 2 сургууль, үүнээс 3 нь шилжин хэрэгжихээр цэцэрлэгийн барилга 100 ортой Баян-Өлгийн Өлгий сум 12 дугаар баг, бага сургуулийн барилга 160 суудалтай Баян-Өлгийн Ногооннуур сумын 6 дугаар баг, сургуулийн барилга 320 суудалтай Баян-Өлгийн Цэнгэл сум гэсэн байгаа. Мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр цэцэрлэгийн барилга 100 ортой Баян-

Өлгийн Өлгий сумд шинээр хэрэгжүүлэхээр ингээд туссан байгаа юм. Тэгэхээр зэрэг огт шинэ хэрэгжүүлэх ийм төсөл байхгүй гэж хэлж болохгүй ийм байдлаар. Бид ер нь ээлжийн коэффициент, хүн амын нягтшил, түрүүнд ярьсан тэр ухаалаг энэ газрын зургийн системээр хөрөнгө оруулалтыг ингээд шийдээд явж байгаа. Боловсролын газрын даргын томилгооны.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд гүйцээж хариулъя.

Д.Амарбаясгалан: Бид Төрийн албаны зөвлөлөөс шаардлага ирүүлсэн бидэнд. Бид тэр шаардлагыг хангаад чөлөөлсөн тушаал гаргасан нь үнэн. Цаашдаа энэ дээр түр томилгоогоор ажиллуулах шаардлага гарсан учраас түр томилсон байгаа. Цаашдаа яг энэ хуулийнхаа хүрээнд бид томилгоог ингээд хийгээд явна. Зүгээр танд хэлэхэд Баян-Өлгий аймагт яг энэ сургууль, цэцэрлэгийн асуудал дээр улс төржсөн ямар нэгэн тийм юм явуулахыг яамны зүгээс ч зөвшөөрөхгүй байгаа. Зүгээр зарим нэгэн ирсэн мэдээллээр мөнгө төгрөг өгч ажлын байрыг зардаг, олж авдаг иймэрхүү зохисгүй юмнууд байгаа нь үнэн шүү. Энийг нь дэлгээд ингээд, ингээд явбал өнөөдөр тэнд байж байгаа нөхцөл байдал нэлээн энэ тал дээрээ нэлээн ужгирсан ийм байдалтай. Өөрсдийнхөө тэр боловсон хүчнийг хэтрүүлж хэрэглэсэн, авсан, ажилд авсан энэ тэр гээд асуудлууд нэлээн хурсан байдаг юм байна лээ шүү. Тэгээд энэ дээр бид шинэчлэлийг хийх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жангабыл гишүүн тодруулж асууя.

Х.Жангабыл: Боловсролын салбарт таны яриад байгаа нь урьд өмнө жил хэрэгжиж байгаа төслүүд л дээ. Гэхдээ сая 1 цэцэрлэг шинээр 100 ортой гээд хэлчихлээ та. Би энэ номоос олохгүй байх юм. Хаана бичээстэй байгаа бол 1 дүгээрт?

2 дугаарт та буцаад томилдог нь ямар учиртай юм бэ? Энэ хуулиа биелүүлж, хуулийн хэрэгжилтийг хангах ёстой юм биш үү? Чөлөөлсөн тушаал гаргачхаад хууль зөрчсөн гээд буцаагаад нөгөө хүндээ томилдог нь ямар учиртай юм бэ? Тодорхой хариу өгөөч та? Та тэгээд байвал энэ Төрийн албаны зөвлөл бас наад хүнийг чинь чөлөөлөх тийм хуультай шүү, хуулийн дагуу л ажиллах хэрэгтэй байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. 2024 оны намрын чуулган дээр хэлж байсан үгээ л давъя даа. Энэ төсөв ерөөсөө утгагүй, төсвийн хүрээний мэдэгдэл ямар ч ийм дунд хугацааны төлөвлөгөөндөө уягдаагүй, жилийн төлөвлөгөөгөө үгүйсгэсэн ийм л төсөв байна. Загас толгойноосоо өтдөг. Монгол Улсын Ерөнхий сайд өөрийнхөө төсвийг 1,5 хувиар нэмээд оруулаад ирчихсэн байгаа, 1,5 тэрбум төгрөгөөр. Улсын Их Хурлын, Их Хурлын дарга, Тамгын газар энэ оных яах вэ дээ 3,1 тэрбумаар буурсан байгаа. Түүнээс 2020, 2019 онтой харьцуулбал 5, 6 дахин өсгөчихсөн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар 2019 онд 4,6 тэрбум байсан, 20 онд 6,6 тэрбум байсан бол энэ жил 33,6 тэрбум. Үгүй ээ тэгээд энэ ард иргэд бол шударга ёсыг хүсээд байгаа юм. Энэ төлсөн татварыг зөв зарцуулаач гээд байгаа юм.

Тэгээд хэдэн дарга нар нь өөрсдийнхөө энэ зардлыг хэмнэж чадахгүй ийм байдалтай л байгаа шүү дээ. ЗГХЭГ 14,4 тэрбум төгрөгөөр зардлаа нэмэгдүүлж орж ирсэн. Эндээс би ганц хоёрхон юм тодруулчихмаар байгаа юм. Энэ Эдийн засгийн

хөгжлийн төв гээд 2025 онд 3 тэрбум төгрөг тавьж байсан бол 26 онд 7,8 болгоод оруулаад ирсэн. Хархорин хотын захиргааны алба гээд 4 тэрбум байсан бол 7 тэрбум болгоод оруулаад ирсэн. Эрчим хүчний реформ гээд 2,7 тэрбум байсан бол 2,6 тэрбум маань яг бараг хэвээр нь ингээд оруулаад ирсэн. Мөн дээрээс нь энэ Шинэ хоршоо хөгжлийн нэгж гээд шинээр 4 тэрбум 400 төгрөг тавьчихсан. Үгүй ээ тэгээд энэ шударга ёс юм уу? Нөгөө баахан нэгж хороо янз бүрийн юмнуудаа болиулъя, буулгая, ард иргэдийнхээ төлж байгаа татварыг хэмнээ гээд байсан тэр бодлого чинь энэ төсөв дээр ерөөсөө орж ирээгүй байна гэж харагдаж байгаа юм нэг, энэ дээр нэг хариулт авчихъя?

2 дугаарт бид энэ алдагдалгүй төсөв ярьсан, өчнөөн олон жил ярьж байгаад түрүү жил Ерөнхийлөгч хориг тавьж байж нэг юм алдагдалгүй төсөв баталсан. Тэгээд одоо 1,3 их наядын дахиад л алдагдалтай, баахан зээл нэмнэ. Тэгээд тэр зээлийнхээ мэдээллүүдийг сонсчихмоор байна. Яг улсын хэмжээнд хэдий хэмжээний өртэй байгаа юм, тэр зээлийг иргэддээ хуваавал хэдэн төгрөгийн өртэй байгаа юм энийг нэг сонсчихъё?

Дараагийнх нь ахмадтай холбоотой асуудал. Ахмадуудаа бид харж хүндэлж, хайрлаж явахгүй бол энэ улс ер нь цаашаа яах юм бэ? Ахмадууд чинь энэ залгамж халааг бэлдээд, бэлтгээд, сургаад явж байгаа шүү дээ. Тэгэхэд ахмадуудынхаа тэтгэврийг зургаахан хувиар нэмчихсэн. Хуулийг нь судлаад үзэхээр болохоор өмнөх жилийн дунджаар гэж байгаа юм инфляцын дунджаар. Дунджаар бол 6,8 байгаа, жилийн эцсээрээ 9 хувь байгаа, 1.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Очирбат гишүүнд нэг минут нэмж өгье.

Г.Очирбат: Тэгээд ядаж энэ хуулиа мөрдөөд энэ тэтгэврээ бодитойгоор нэмчих л дээ гэж байгаа юм. Дараа нь энэ төсвийн хүрээтэй холбоотой бүгдээрээ нүүрс ярьдаг, экспортод ганц гарч байгаа бараа бүтээгдэхүүн гэж ярьдаг. Энэ БНХАУ-ын чинь 5 жилийн төлөвлөгөө одоо хэлэлцэж байна. Энэнтэй хэр уясан юм бэ? Энийг нэг асуучихмаар байгаад байгаа юм.

Хамгийн сүүлийнх нь АН-ын хэдэн сайдууд луу нээрээ үнэхээр дайрч байна шүү. Энэ хуучин Ерөнхийлөгч байсан хүн нь хүртэл гарч ирээд л илүү, дутуугаар нь ярих юм. Үгүй ээ тэгээд тийм сайн байсан бол тэр үедээ хөгжүүлчихгүй яасан юм бэ? Бүх л албан тушаал дээр байсан шүү дээ. Тэгээд араас нь гарч ирээд л олон долоон юм ярьдаг. Өнөөдөр хүүхэд нь Батшугар гишүүн тэнд сууж л байна шүү дээ. Аавдаа хэлэх хэрэгтэй. Зарим нэг юмнаас хол бай л даа. Батшугар гишүүнээ нээрээ. Тэгээд л хэвлэлээр гарч ирээд л өөрийнхөө телевизээр нэвтрүүлэг хийгээд л баахан цацах юм. Энэ 8 сайд ажил хийх гэж ороод л ажил хийсэн шүү дээ. Тэгээд одоо харлуулахаар бол бид ийм юу харлуулчихсан нөхцөл байдлын чинь хариу ирнэ шүү гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ням-Осорын Учрал сайд.

Н.Учрал: Эдийн засаг, хөгжлийн яаманд нэг эрх байдаг. Тэр юу вэ гэвэл төсөв өөрөө улсын жилийн төлөвлөгөө, урт хугацааны бодлого, дунд хугацааны бодлого баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэх, нөгөө Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, хөтөлбөрүүд тусгагдсан эсэх дээр зөвшөөрөл өгдөг. Үүнтэй холбогдуулаад энэ оны, ирэх оны төсөв дээр зөвшөөрөл өгсөн. Энэ удаагийн улсын төсвийн төсөл нь Алсын хараа Монгол Улсын урт

хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцсэн, Шинэ сэргэлтийн бодлоготой 91,5 хувь дүйцсэн, Монгол Улсын Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр болон улсын жилийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлтэй уялдаж байгаа гэж. Гэхдээ жишээ нь жилийн төлөвлөгөө дээр 126 төсөл байсан төсөл, арга хэмжээ. Үүний 76 нь тусгагдсан. Гэтэл 50 нь өөрөө төсөв нь шийдэгдэх бололцоогүй байсан. Үүнийг шийдэхгүй бол бид зөвшөөрөхөд бэрхшээлтэй.

Тийм учраас энэ санхүүжилт нь тодорхойгүй төслүүдийг бид төр, хувийн хэвшлийн түншлэлээр явуулъя гэдэг зорилгоор төсвийг дагуулаад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг оруулж ирж байгаа юм. 21 аймаг, нийслэлийн 9, нийслэл өөрөө төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг нутгийн өөрөө удирдах байгууллагатайгаа хамтраад өөрөө шийдвэрлэж явах бололцоог нь бүрдүүлээд багадаа жил 3, 4 сар болдог байсан энэ төслийн хугацааг 6 сард эхлүүлэх бололцоог олгоод, хуучин Эдийн засаг, хөгжлийн яаман дээр жагсаалтад оруулаад, тэгээд бичиг аваад, тэгээд урьдчилсан шинжилгээ, бүрэн оношилгоо гэдэг юм хийлгээд, тэгээд түүн дээр нь хамгийн сүүлд нээлттэй сонгон шалгаруулдаг байсан процессыг хөнгөвчилсөн. Ингээд төр, хувийн хэвшлийн түншлэлээр энэ үлдсэн 50 төслүүдийг явуулна гэдэг ийм зорилттой байгаа.

Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн төслийг 10 сарын 31-нээс өмнө Их Хуралд өргөн мэдүүлнэ. 8 зорилт, хөтөлбөрийг дагалдуулна. Үүнийг бид урт хугацааны бодлоготойгоо уялдуулна гэж байгаа юм. Яг таны хэлж байгаа экспортолж байгаа манай уул уурхайн бүтээгдэхүүн тэр дундаа нүүрсээ экспортолчхож байгаа БНХАУ 15 дугаар 5 жилийн төлөвлөгөөг үндсэндээ 10 дугаар сард Намын төв хорооны гишүүдийн хурлаар эх нь батлагдаад, ингээд саналуудаа авдаг юм байна. Үүнтэй холбогдуулаад энэ зун БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайдад энэ албан хүсэлтээ илэрхийлсэн. Сая Монгол Хятадын экспогийн үеэр ӨМӨЗО-д парламентын дэд даргатай нь уулзсан. Ингээд 5 жилийн чиглэлд манай энэ хил холболтын ажлууд, төмөр замын бүтээн байгуулалтын ажлуудыг эрчимжүүлэх, биржийн, биржийг дэмжих, дээрээс нь 2 орны хооронд үүсээд байдаг мэдээлэл солилцох энэ асуудал бэрхшээлүүдийг хамтдаа шийдвэрлэе гэдэг зорилгоор асуудал зарчимд хүрсэн. Ингээд 9 дүгээр сарын 28-нд ӨМӨЗО-ны яг энэ асуудлыг хариуцсан удирдлагуудтай Ганцмод дээр уулзалт хийе гэж байгаа юм. Тэгэхээр энэ ажлууд урагшилж байна гэж хэлж болно.

Түрүүн алдагдал гэдэг дээр би нэг зүйлийг хэлэхэд ер нь өөрөө нөгөө зарлагаа нэмээд, түүндээ тохирсон орлого төлөвлөдөг, тэгээд Төсвийн тогтвортой байдлын хуулиа бүрэн хэрэгжүүлдэггүй байснаасаа болоод өнөөдөр ийм байдалд хүрчихжээ. Зөв үедээ, зөв цагтаа мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж чадаагүй учраас буюу эдийн засаг тэлж байх үед, халж байх үед хумих, хуримтлуулах бодлого огт бариагүй. Тэгээд үүнээсээ болоод ийм байдалд хүрчихсэн. Тэгэхээр одоо эдийн засгийн мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж байж хувийн хэвшилд байгаа ажлын байраа хадгалж үлдэнэ. Тэгж байж энэ төгрөгийн ханшаа хадгална. Тэрнээс биш одоо бол бид шууд орлого, зарлага тэнцүү төсвөө явуулна энэ эдийн засгаа дэмжих ямар ч бодлого хэрэгжихгүй, хувийн хэвшилд орон зай үлдэхгүй л гэдэг зорилгоор тодорхой алдагдал төлөвлөсөн.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Очирбат гишүүний асуултад хариулъя. 2026 оны төсөв, бид хүрээ ярьж байна, хүрээний тоонуудыг та харж байгаа байх. 2025 оны анхны

тооноос зардал жишээ нь 2,8 их наядаар буурсан байгаа, 2,8 их наядаар шүү. Тэгэхээр төсвийн ерөнхийлөн захирагч бүр дээр харвал бүгд тодорхой хэмжээнд буурсан байгаа. ЗГХЭГ-ын төсөв бага хэмжээгээр нэмэгдсэн, тэр нь бүтэцтэй холбоотой маш олон жижиг нэгжүүд өөр, өөр сайдууд дээр, Шадар сайдууд дээр байсныг татан буулгаж, Хэрэг эрхлэхийн бүтэц рүү оруулсантай холбоотойгоор зардал нь өссөн тийм тодорхой шилжилт байгаа. Тэрнээс биш бусад төсвийн ерөнхийлөн захирагчид, тухайлбал Ерөнхийлөгчийн Тамгын газрынх 40, энэ чинь 43-аас 36 болж буурч орж ирж байх жишээтэй. Хэрвээ бүх юмыг 19, 18 оныхтой харьцуулбал энэ чинь тэнгэр, газар шиг өөр шүү дээ. Тэрнээс хойш.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Очирбат гишүүн тодруулж асууя.

Г.Очирбат: Ойлголоо. Тэгээд бүх юмыг 19, 20 он гэхээс илүүтэйгээр 4 жилийн өмнө авч байсан, ажил хийгээд авч байсан орлого өнөөдрийн энэ төсвийн энэ дарга нарын нэмэгдсэнтэй адилхан иргэдийн авч байгаа цалин нь нэмэгдэж чадсан юм болов уу даа Жавхлан сайд аа? Бидний үрж байгаа мөнгө 4 дахин нэмэгдээд байдаг, ажил хийгээд цалин авч байгаа иргэдийн маань орлого 4 дахин нэмэгдэж чадсан уу? Энийг л би асуугаад байгаа юм 1-д.

2-т гэвэл бидэнд энийг танах боломж байна уу гэсэн байгаа. 10-аас 15 хувь танах бүрэн боломжтой. Та түрүүн тэр баахан хороо нэгжийг нэг газраас нь аваад л нэг газар луу өгчхөж байгаа байхгүй юу. Тэгээд яаж зардал буурах юм бэ? Тэгээд татан буулгавал буулгасан шиг л буулга л даа. Тэгж л зардлаа хэмнэнэ шүү дээ тийм биз дээ Жавхлан сайд аа? Тэгээд ахмадууддаа асуултынхаа хариултыг авчихъя. Яагаад энэ түрүү жилийн хуулийн дагуу түрүү жилийн инфляцтай уялдуулж нэмээгүй юм бэ? Яагаад бага нэмсэн юм бэ, зургаахан хувиар?

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Нэг талаар 24 хувьд барих ёстой шүү урсгал зардлаа, нэмж болохгүй шүү гээд та хязгаарлачихсан. Нөгөө талдаа нэм, нэм гээд байхаар энэ 2 чинь ингээд хайч болчхож байгаа юм. Ирэх жил бид төрийн албан хаагч нарынхаа цалинг нэмэх боломж гарсангүй, төсөв маш хязгаарлагдмал байна. Дээрээс нь дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувьдаа хязгаарлах ёстой шүү гээд ингээд жилийн төлөвлөгөөндөө оруулаад, Засгийн газарт үүрэг өгчихсөн. Ганц бид бүх боломжоо дайчилж нэмж чадсан нь тэтгэвэр байгаа, тэтгэвэр 6 хувь 378 тэрбум төгрөг. Энэ маань яг саяын энэ хязгаартаа багтаад энэ хайчин дундаа нэмж чадсан хэмжээ нь л энэ юм байгаа юм. Дараа дараагийн жилүүдэд төсөв мөнгөний бодлого зөв явж, мөн гадаад талд бидний эрсдэл буурах иймэрхүү төлөвүүд гараасай билээ. Эндээ тохирсон.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дахиад нэг тодруулга авах уу? Очирбат гишүүн тодруулга өгье.

Г.Очирбат: Дараагийнх нь Ерөнхий сайд байсан бол асуух байсан юм. Яах вэ Сангийн сайд хариулчих байлгүй дээ, Шадар сайд 2 сууж байгаа юм чинь. Энэ танай нам нэг бүлэг дотроо ярьж байгаад манай намынхан руу энэ ажил хийсэн хүмүүс рүү дайрдгаа хэзээ зогсох юм бэ? Түүн дээр нэг тодорхой хариулчхаач? Тогоон дотроо юмаа яриад, танай намыг чинь их гоё л ярьдаг юм байна лээ шүү дээ. Дотроо бүх асуудлаа шийдээд, гадагшаа болохоор аягүй гоё эв нэгдэлтэй байдаг гээд л иргэн болгон ойлгож байгаа. Тэгээд ингээд юм ярихаараа дандаа гарч

ирээд л АН-ын ажил хийсэн хүмүүс рүү дайраад байдаг. Жавхлан сайдаа та цуг кабинетад нь байсан хүн энэ дээр нэг сайхан тодорхой хэлчхээч. Ажил хийсэн юм бид, тэгээд үр дүн нь одоо гарч байна гээд хэлэхгүй бол наад бүлэг дотроо гэдэг юм уу, танай намын хуучин байсан дарга цэрэг чинь буцаж оргож босгоод байдаг юм уу төвөгтэй байна шүү дээ. Тэгээд нийгмийг 2 хуваачих юм. Тэгээд яасан ч их мөнгөтэй юм. Түүн дээр Жавхлан сайд та нэг тодорхой хариулчхаач тэгэх үү?

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя. Өчигдөр АН-ын бүлэг дээр төсөв танилцуулж байхад мөн энэ асуулт байсан. Гишүүд ч асууж байна лээ би маш тодорхой хэлсэн. Ийм асуудлаар Засгийн газрын албан ёсны байр суурь илэрхийлсэн зүйл огт байхгүй шүү. Огт байхгүй. Өмнө нь хийгдсэн ажлууд бүгд үргэлжлээд явж байгаа. Ганцмод-Гашуунсухайтын гэрээ 5 сарын сүүлээр Их Хурлаар ороод ингээд хийгдээд явсан. Сая 8 сард дахиж баталгаажаад төгрөгөөр хийгдсэн гэрээ нь юаниар хийгдээд салбарын сайд нь энэ гэрээгээ хийгээд ингээд л явж байгаа шүү дээ. Хаанаас ямар саналууд, ямар санал бодол шүүмж гарч ирэхийг Засгийн газар удирдахгүй. Тийм учраас тийм Засгийн газар энэ дээр ийм л байр суурьтай байна. Өөр юу хэлэх вэ дээ.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд, Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Баярлалаа. Төсвийн хүрээ хэлэлцэж байна. Тэгэхээр түрүүн Үүрийнтуяа гишүүн дурдана лээ. Төсвийн хүрээний мэдэгдэл бол энэ төсвөө дагаад өөрчлөгддөг ийм нэг тийм бэлгэ тэмдгийн чанартай хэзээ ч өөрчилж болдог л зүйл болчихоод байна л даа. Алдагдалгүй төсөв гээд саяхан бид гэгээн минь гээд л алгаа ташаад л алдагдалгүй баталж болдог юм байна, үүнээс хойш алдагдалгүй явъя гээд 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл миний санаж байгаагаар алдагдалгүй байхаар л явж байсан. Тэр үнэн үү, эсхүл би буруу бодоод байна уу? Тэгсэн одоо дахиад өөрчлөөд ингээд 1,4 их наядын алдагдал гээд явж байна. Энэ дээр байр суурь ямар байгаа юм бэ? Яагаад ингээд төрийн байр суурь ийм амархан өөрчлөгдөөд байгаа юм бэ? Ямар үед нь алдагдалтай, ямар үед нь алдагдалгүй болчихоод байгаа юм бэ? Энэ дээр нэг тодорхой хариулт авъя.

Тэгээд төсвийн хүрээн дээр болон төсөөлөл дээр, төсөв дээр саналууд авсан, хэр туссан юм доо, би эргэлзэж байгаа. Санал авлаа, хаалаа, нөгөөдөр нь өргөөд барьж байх жишээтэй. Төрийн байгууллагуудаар кампанит ажил явж байна лээ саналаа өгөөрэй. Тэр хүмүүс юу санал өгч тоогоо нэмэгдүүлээрэй гээд. Тэгэхээр энэ нэг жоохон үр дүнгүй ажил болчихож байгаа юм биш биз дээ. Бид 15 хоногийн өмнө ороод нэг хэлэлцүүлэг нэмээд ингээд явж байгаа энэ ажил маань үр дүнтэй болоосой гэж.

Дараагаар нь энэ тэтгэвэр дээр сая орон нутагт тойргоор ажилласан энэ ахмад болгон дуугарч байна лээ шүү. Тэтгэвэр нэм гэж. 1 сая 500 гэж байна лээ. Би нэртэй нь хэлж чадна, 1 сая 500-гаар биш 1 саяар ядаж нэмчхээч гээд. Сая Их Хурлын дэд дарга Пүрэвдорж дарга үгүй ядаж та тэр 10 хувь руугаа гээд. Аубакир сайд 10 хувиар саналаа өгсөн л юм байна. Хуультай юм байна, энийгээ ядаж нэмчихмээр байна. Тэр тэтгэврээр авч чаддаг юм гэдэг бүүр маш багассан байна шүү. Юмны үнэ аягүй өндөр байна. Энийг тэгэхээр 10 хувь руу гэдэг дээр бид ингээд шахаад явна.

Инфляц, үгүй ээ саяхан энэ Батдаваа дарга гишүүдийн утсанд ирүүлж байна лээ. Одоогоор 8,8 гээд. Тэгээд энэ чинь одоо 6-гаар нэмнэ гээд ингээд энэ тоонууд чинь яагаад энэ бүхэл бүтэн 2, 3 хувиар ингээд зөрөөд байгаа юм бэ? Бусад энэ урсгал зардлуудаа танаад, энэ ахмадууддаа хэдүүлээ нэг тэртээ тэргүй амьдралд нь хүрэхгүй байгаа тэтгэвэр дээр нь асуудлыг нь яривал яасан юм бэ гэж.

Нөгөө муу хэлээд байгаа Чайна энерги одоо орохоос өөр яах вэ, 85 саяыг олборлоно, дээр нь нөгөө нэг Чайна энергийн 5-ыг нэмэхийгээ оруулчихсан л байна, 90 гээд тооцсон байна. Тэгээд л нөгөө муу бол арын хар овоохой гэдэг шиг Дэлгэрсайхан сайд бид хэд рүү ингээд дайраад. Энэ 5 саяыг чинь нэмэхэд төмөр замын хил холболт чухал шүү. Дэлгэрсайхан сайдын ажлыг нь хийлгэмээр байна. 1 минутаа нэмээд авчихъя. Тэгж байж энэ 5 сая чинь нэмэгдэнэ шүү. Манай авто тээвэр бүүр чардайгаад чинээндээ тулчихсан гаргахад 83 сая тонн байсан. Тэгэхээр энэ хэрвээ нэмж байгаа бол энэ Зам, тээврийн сайдынхаа ажлыг нь хийлгэж, тэр төмөр замын холболтоо улс төржөөд зогсоогоод байлгүй энийгээ хий. Туршлагатай хүн учраас Пүрэвдорж гишүүн оноод хэлчихнэ лээ. Би бас хэлэхгүй жоохон жудаг заагаад байсан юм. Яг яс юман дээр энэ Улсын Их Хурлын 100 шахам гишүүн Засгийн газар чинь ерөнхий хэлэлцээр дээр л зурсан юм. Тэр доллар мэдэхгүй, хэдээр өгч байгаа энэ тэр чинь тэр Эрдэнэс Монгол, Эрдэнэс Тавантолгой дээр л явдаг шүү дээ. Тэгээд энийг хэлэхгүй л байсан, тэгээд ингээд шахацгаагаад улс төржөөд байхаар чинь хэлж байгаа юм.

Дээр нь төсөв дээр энэ аж үйлдвэр, эрдэс баялгийн салбар дээрээ хамгийн бага төсөв, морин тэргэн дээр бүгдээрээ гараад суучихсан морио ташуурдаад байдаг, 70 хэдхэн тэрбум төгрөгтэй, улсын төсвийн 30 хувь, экспортын 90 гаруй хувийг олж ир л гээд байгаа юм. Энэ дээр ер нь яагаад ийм бага байгаад байгаа юм бэ гэдэг ийм асуултуудад хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Өмнө батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэл дээр орлого 33,4 их наяд, зарлага 33,4 их наяд гэж алдагдалгүйгээр баталсан. Тухайн үед эдийн засгийн нөхцөл байдал өөр байсан. Өнөөдөр тодорхой бус байдал индекс түүхэн дээд түвшиндээ хүрлээ, тооцож болзошгүй ийм асуудлууд үүсэж байна. Эдийн засаг гадаад нөхцөл тухайн үед сайн байсан, сүүлийн саруудад дотоод нөхцөл байдал ч гэсэн ийм идэвхгүй байдалд орж байгаа. Тэгэхээр ийм тохиолдолд бид нөгөө мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэхээс өөр замгүй. Тэгэхээр төсвийг ер нь алдагдалтай батална гэдэг өөрөө бид зөв үедээ зөв бодлого хэрэгжүүлж чадаагүй болохоос биш, төсөв дээр тодорхой алдагдалтай байлгах нь ер нь эдийн засгийг тогтворжуулахад хэрэглэдэг бас нэг ийм эдийн засгийн тохируулга. Нэг ёсондоо төсвийн тэнцлийг алдагдалтай байлгах, ашигтай байлгахыг тохируулахдаа тэр эдийн засгийн мөчлөг хаана байгаа вэ гэдгээс нь хамааруулж тодорхойлдог. Жишээ нь нөгөө мөчлөгийн нөгөө output гар гэж нэрлэдэг. Ер нь нөгөө потенциал түвшин, гүйцэтгэл 2-ын хоорондын харилцаанаас хамааруулна.

Тэгэхээр энэ бол юу вэ гэхээр одоогийн энэ output гар буюу потенциал, түвшин зорилтот түвшин эдгээрийн харьцаа тэг хэмжээнд оччихоод байна л даа. Тэгэхээр хувийн хэвшилд байгаа ажлын байрыг хэрхэн хадгалж үлдэх вэ гэдэг бодлого хэрэгжүүлж, эргээд төр хэмнэлт хийх буюу сая хэмнэлтийн тодотголоор 2 их наяд орчмыг хэмнэсэн. Одоо зөвхөн хоосон хэмнээд байвал шинэ ажлын байр бий болгож чадахгүй, дэвшилтэт технологи нэвтрүүлж чадахгүй. Дээрээс нь хэрхэн

тэр зээлжих зэрэглэлээ хадгалж үлдэх вэ, зээлжих зэрэглээ хадгалж үлдэхгүй бол гадаадын зээл, тусламж, энэ дотоодын компаниуд ч гэсэн гаднын хөрөнгө оруулалт татахад маш их бэрхшээлтэй болно. Тэгээд төгрөгийн ханшаа яаж хадгалах вэ гэдэг ийм л зовлонгийн өмнө бид байгаа юм л даа. Тийм учраас зүгээр ингээд орлого, зарлага тэнцүү аваад ороод ирж болно. Гэтэл үүний чинь цаана байгаа нөгөө Азийн хөгжлийн банкаар хэрэгжүүлэх гэж байгаа сургуулиуд, нөгөө газрын тос боловсруулах үйлдвэрүүд, тэр Эрдэнэбүрэний УЦС, ингээд өнгөрсөн хугацаанд энэ авсан зээл, хөнгөлөлттэй зээл чинь бараг 12, 3 их наяд юм байна лээ шүү дээ. Тэгээд байгаа санхүүжилт нь тодорхой юмыг хэрэгжүүлж чаддаггүй. Нэг ёсондоо гадаадын зээлүүд чинь зарлага талд бичигдээд, орлого талдаа бүртгэгддэггүй.

Тэгээд Төсвийн тогтвортой байдлын хуулиа хадгалж барина шүү гэдэг ийм бодлого л жишээ нь Эдийн засаг, хөгжлийн яамнаас барьсан. Ерөнхий сайд ч гэсэн энэ тусгай шаардлагаа бариарай л гэсэн. Тэгэхээр нь урсгал нэмэхгүй 24 хувиас урсгалыг огт хэтрүүлж болохгүй. Дээрээс нь тэнцвэржүүлсэн орлого GDP харьцааг тогтмол бууруулна, 28 онд 28 руу авчирна гээд энэ ингээд шаардлагуудаа бариад явахаар 1,9 их наяд төгрөгийн зээл бол ирэх жил байгаа байхгүй юу 1,9. Гэтэл түүний 1,3-ыг нь тодорхой алдагдал тавивал заавал алдагдал дээр эх үүсвэр бичдэг. Энийг юугаар санхүүжүүлэх юм бэ, Засгийн газрын бонд гаргах юм уу, үнэт цаас гаргах юм уу? Тэгвэл энэ удаагийн 1,3-ын алдагдал чинь статистик л алдагдал байхгүй юу. Яагаад гэвэл эх үүсвэр нь өөрөө нөгөө хөнгөлөлттэй зээлүүд нь ард нь явж байгаа гэсэн. Тэрнээс бонд гаргаж, үнэт цаас гаргаж санхүүжүүлэх шаардлага байхгүй.

Ингэснээрээ үүний ард тэр олон сургууль, цэцэрлэгийн барилга байшинг бариулахад хувийн хэвшлээ дэмжинэ. Тэр олон бүтээн байгуулалтууд явахад гаднын хөрөнгө оруулалтууд нь нэмэгдэнэ, ингэснээрээ зээлжих зэрэглэлээ барина, төгрөгийн ханшаа барина гэдэг зорилгоор энэ бол яах вэ зүгээр ер нь мөчлөг сөрсөн бодлого. Гэхдээ төр хэмнэх ёстой, давхар хэмнэлтээ хийж байгаа гэдэг ийм зорилгоор оруулж ирсэн юм шүү л гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Туваан сайдын асуултад хариулъя. Сая Учрал сайд маань макро талаас нь тайлбарлалчлаа. Би төсөв талаас нь тэр алдагдал гэдгийг тайлбарлая. Төсвийн хүрээнээсээ орлого маань 1,6-гаар ирэх жил багасах нь, багасах нь. Энийг дагаад хэрвээ зардлаа 1,6-гаар багасгаад алдагдалгүй хийчихвэл бүртгэл талаасаа их амархан. Тэгвэл эдийн засгийн өсөлтөө бид байхгүй болгоно. Эдийн засгийн өсөлт байхгүй болно гэдэг маань хувийн хэвшлээ татаж унагана гэсэн үг. Тэгэхээр мөчлөг сөрнө гэдэг маань энийгээ хэлээд байгаа юм. Ноднин төсвөө бид баталж амжаагүй байхад орлого унах нь тодорхой болж ирсэн. Тийм тохиолдолд бид төлбөрийн тэнцлээ хамгаалахаас өөр арга байхгүй. 2,3 их наядаар зардлаа бууруулсан. Өөрөөр хэлбэл 500-гаад сая доллароор төлбөрийн тэнцлийнхээ ачааллыг бууруулсан гэсэн үг.

Энэ жилийн хувьд бид 9 сар хүртэл 3 улирал эдийн засгаа хамгаалах нэлээдгүй арга хэмжээнүүдийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тийм учраас эдийн засгийнхаа өсөлтөө дэмжихээр ингэж зорьж байгаа. Туваан сайдаа би таны асуултад хариулаад байгаа юм. Төсвийн хүрээн дээр 2 тоо та хараарай. Тэнцвэржүүлсэн тэнцэл, суурь тэнцэл гээд. Суурь тэнцэл буюу татварын орлогоороо санхүүждэг цалин, тэтгэвэр тэтгэмж, хүүхдийн мөнгө энэ бүгдийгээ бүрэн санхүүжүүлээд, цаана нь 2 хувийн ашигтай байгаа. Зөрөө алдагдал маань зөвхөн гадаад зээлийн ашиглалт л байгаа. Гадаад зээлийн ашиглалт дотор дандаа мега төслүүд байгаа. Таны ажиллаж байсан нефть боловсруулах үйлдвэр байна, Эрдэнэбүрэнгийн УЦС, нийслэлийн цэвэр усны хангамжийн Мянганы сорилтын сангийн төсөл байна, нийслэл хотын цэвэрлэх байгууламж байна, 17 аймгийн анхан шатны эмнэлгүүд байна гэх мэт. Энэ дандаа мега төслүүд тулгамдчихсан ийм санхүүжилтүүдээ хийж байгаа ийм гадаад зээлүүдээр л энэ алдагдал бий болж байгаа. Тэгэхдээ энийг санхүүжүүлэх өөр эх үүсвэр хайх бид ямар ч шаардлага.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Яах вэ тайлбар байгаа, байгаа. Тэгэхдээ саяхан алдагдалгүй төсөв ямар гоё вэ гээд алгаа ташицгааж байгаад баталж байсан. Ард иргэддээ алдагдалгүй төсөв баталж болдог юм шүү гээд ярьж байсан хүмүүс нь ийм юм ярьж байгааг нь л би асуугаад байгаа юм. Энэ яачхав гээд, энэ болохгүй юу гээд? Алдагдалгүй баталж болно шүү дээ, урсгал зардлаа хасаж болно, өөр тэгээд бүтээн байгуулалтууд гээд л тэгж байна. Тэгээд бүтээн байгуулалтууд дээр хамгаалж байгаа юм байгаа юм уу тэгээд, тэртээ тэргүй эд нар хийсэн гээд л муулцаагаад л байгаа. Тэгэхээр эдийн засаг өөр байсан гээд Учрал сайд хэлж байна. Эдийн засгийн өсөлт байхгүй болно л гэж байна. Өнгөрсөн Засгийн газрын үед алдагдалгүй төсөв батлаад, эдийн засгийн тоонуудаа бүүр тодотгол хийхээргүй хэмжээнд байлгаж л байсан. Тийм ч муу байгаагүй, тийм муу тоонууд өгөөгүй, үлдээгээгүй. Тэгэхээр нэг өнгөрсөн рүүгээ ингээд байгаад нь л би ямар ялгаа байгаа юм бэ л гэж асуух зорилготой энэ асуултыг асуусан юм.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Туваан сайдын асуултад үргэлжлүүлж хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам яагаад бага төсөвтэй юм бэ гээд. Манай эдийн засгийн гол boost болдог 2 яам байгаа. Манай уламжлалт бүтэц буюу ХХААХҮЯ, манай мэдээж Эрдэс баялгийн яам. Энэ 2 яам маань ер нь их том хувийн хэвшлийн бүтэц дээр, хүчирхэг хувийн хэвшлийн эдийн засгийн хөшүүрэг дээр бодлогын яамнууд байхгүй юу. Ялангуяа Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам маань энэ нэрнийхээ дагуу үйлдвэр эрхлэх, аж ахуй эрхлэх, бизнес эрхлэх яам биш, цэвэр бодлогын яам. Тийм учраас яг зардлууд нь голцуу энэ удирдлагын бүтцийн ийм зардлууд байдаг. Өмнөх жилээс тодорхой хэмжээнд нэмэгдэж байгаа, энэ мөн л бодлогын зардал. Тэр нь эрэл хайгуул шүү, Х лицензийн ажлынх биш, эрлийн түвшинд хийх ийм зардлуудыг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Бүгдийнх нь өглөөний амрыг айлтгая. Тэгээд яг Монгол Улсын тэнцвэржүүлсэн нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн тухай, Төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай хэлэлцэж байна. Тэгэхээр энэ хүрээндээ асуултаа асууя. Дараа нь 26 оны төсвийн тухай хууль хэлэлцэгдэх учраас. Юуны өмнө би нэг өмнөхөн нэг

яриа өгсөн юм. Тэгсэн яриан завсар нэг үг хэлсэн нь төсөв бол улс төрийн хэрэгсэл болох ёсгүй гээд. Яагаад тэгж хэлсэн бэ, гол санаа нь юу вэ гэхээр аль нам, улс төр, улс төрийн намаас нэр дэвшиж, ялж гарсан нь үл хамааран төсөв бол бодлогын хэрэгсэл юм, төсвөөрөө дамжуулаад бид хөгжлийн бодлогодоо тухайн жилийнхээ Засгийн газрын хөтөлбөртөө тусгасан үйл ажиллагаануудаа хэрэгжүүлэх ёстой. Тэр утгаар нь хэлсэн юм.

2 дугаарт нь гадаа ахмадууд мэдээж жагсаад байна, тэтгэврийнхээ хэмжээг өсгөхийг хүсэж байна. Энэ дотор байгаа бүх хүмүүс тэр ахмадуудын тэтгэвэр, тэтгэмжийг өсгөхийг хүсэж байгаа гэдэг дээр итгэл байна гэдгийг зориуд хэлмээр байна. Тэгээд гол нэг юман дээр л төвлөрье гэж бодож байна. Яагаад гэвэл энэ төсвийн хүрээний мэдэгдэл учраас. Бид яагаад байн, байн өөрчлөөд байна. Нааштай зүйл нь юу вэ гэхээр өмнөх онуудын төсвийн энэ баримт бичгүүдийг бодвол харьцангуй чамбай төсөв, төсөл орж ирсэн, ажилласан байна гэж харж байгаа юм. Эдийн засгийн өсөлтийг тодорхой хэмжээгээр 0,2-оос 0,4 хувь нэгжээр бууруулсан байна. Мөн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон төсвийн тэнцвэржүүлсэн зарлага ба тусламжийн дүн хэмжээг 1-ээс 2 их наяд төгрөгөөр бууруулсан байна. Гэвч, гэхдээ юу вэ гэхээр бусад гишүүд хэлээд байна. Төсвийн орлого эерэг, хэт өөдрөг хэвээр байна тооцоолсон хэвээр байна.

Хамгийн наад зах нь гишүүд хамгийн жирийн 10 жилийн сурагчид хүртэл хардаг болчихсон тоо юу вэ гэхээр нөгөө нүүрс. Нүүрсний гаргах гээд байгаа 90 сая дээр хүн болгон акцент өгөөд байна шүү дээ. Энийг эргэж хараасай. Яагаад заавал 90 сая тонн гэж, 75-аар ч юм уу тооцчихоод, бодит амьдрал дээр энэ нь үнэхээр 90-д хүрчихвэл тэр илүү гарч байгаа зардлаа нийгмийн нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмжээ зорилтот бүлэг рүүгээ чиглүүлээд оновчтой болгоход зарцуулбал яасан юм бэ гэдэг ийм горимын санал байна. Яагаад ингэж хэлэх болов, энэ оны эхний 7 сарын байдлаар төсвийн орлого буурсан, 6,1 их наядаар буурсан буюу 16,58 их наяд байгаа. Эхний 7 сарын байдлаар зарлага өссөн, 10,7 хувиар өссөн буюу 16 зууны хэд байна вэ 87 хувь их наяд хүрсэн. Энэ дотроо орлогоо бүрдүүлж байгаа нөгөө татварын хувь хэмжээгээ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье. Ер нь гишүүд маань минут бол тодруулгад зориулагддаг юм шүү. 1 минутаа авчихъя гээд бүгдээрээ хэдүүлээ ингэвэл 70, 80-уулаа асуулт асууж, үг хэлнэ. Асуудлаа хэзээ хэлэлцээд дуусах вэ тэрийгээ бодоорой. Мөнхсоёл гишүүнд нэг минут нэмж өгье.

Б.Мөнхсоёл: Энэ тоонууд маш чухал учраас хэлчихье гэж бодлоо. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар өмнөх тооцоолсон дүнгээс буурчихсан байгаа 1,13 их наядаар, Амнат болохоор 1,19 их наяд төгрөгөөр буурчихсан байна. Гэтэл ирэх онд 2026 онд энийгээ өсгөнө гээд оруулаад ирчихсэн энэ дээр санаа зовж байна. Товчхон базаад хэлэхэд бид төсвийн тэнцвэржүүлсэн орлогынхоо доод хэмжээг батлах биш, дээд хэмжээгээ баталчхаад байна. Хэт өөдрөг тооцчихоод байна. Дахиад нөгөө тодотгол хийх, өөрчлөх асуудлууд гарна. Тэгэхээр бие биеэ хуурахгүй, иргэдээ хэт хүлээлтэд би оруулахгүйн тулд бодитой ажиллая гэсэн л товч, тодорхой саналыг хэлж байна. Баярлалаа. Өр дээр ч гэсэн өссөн хэмжээтэй Засгийн газрын өр. ДНБ-ийхээ хэмжээг эдийн засгаа эергээр бодоод хэт өсөлттэй тооцохоор арифметик тоо өндөр гарна. Төсвийн тогтвортой байдлынхаа хуульд заасан шалгуураа хангачихна шүү дээ, энэ бол тоо. Бүгдээрээ цаана нь эдийн засгийнхаа утгыг энэ тоо.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Засгийн газар дээр энэ макро тоонуудаа төсвийн хүрээний мэдэгдлүүдээ танилцуулсан. Тэгээд танилцуулах үеэрээ салбарын яамнуудад тухайн салбар өсөлтөд ямар нэгж хувийн хувь нэмэр оруулах вэ, энэ ямар, ямар ажлаа илүү голлож ажиллах вэ гэдэг дээр яг ингээд чиглэл өгсөн. Яагаад гэхээр бид тооцоолохдоо тэр чинь салбаруудын оролцоог ямар түвшинд байх вэ гэдэг дээр нь тооцоолол гаргаж байгаа шүү дээ.

Дээрээс нь түрүүн асуугаад байсан. Ер нь бид эрсдэлийн үнэлгээг хийх, тэр стресс менежмент дээр ажиллах чиглэлээр тогтмол ажилладаг юм байна. Нэг ёсондоо Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдаад түүнээс хойш тогтмол бид ажиллаад, ажлын хэсэг байгуулаад түүн дээр ажиллаад ирсэн. Тэгэхээр цаашдаа ч энэ ажлаа бид эрчимжүүлнэ. Тэгэхээр энэ макро тоонуудыг гаргахад бид үнэнээ ярих ёстой. 2-т төсөөлөл өөдрөг байх ёстой, орлогыг хэт багаар төлөвлөнө гэдэг бас өөрөө эрсдэл. Тэгэхээр энэ чинь target тавиад, түүндээ хүрэх зорилтуудыг салбарууд дэвшүүлдэг. Жишээ нь нүүрс дээр гэхэд 90 сая тонн гээд биет хэмжээг тавьчихсан байгаа. Үүнээс 40 сая нь гэрээгээр баталгаажихсан байхгүй юу. Биржийн гэрээнүүдийг бид бүгдийг нь бүртгэж явдаг ийм Засгийн газрын тогтоолтой байхгүй юу. Бирж дээр байгуулагдсан гэрээг бүртгэлжүүлдэг энэ хоосон зүйл биш. Тэгэхээр би 90 сая бол бидний хийж чадах ажил мөн.

Тэгэхээр энд юу хийх вэ, Зам, тээврийн сайд ямар оролцоотой байх вэ тэр хил холболтуудаа эрчимжүүлэх нь байна. Жишээ нь Аж үйлдвэрийн сайд ямар оролцоотой байх вэ гээд нэгж хувиудыг нь бүгд дээр нь тооцсон. 2-т Төсвийн тогтвортой байдлын хуулиа бүүр чанд барьсан, орлого 1,8 орчим их наяд, зарлага 500-гаар буурч байгаа юм. Ингээд үзэхээр урсгал 24-төө багтана. Түрүүн Жавхлан сайдын хэлээд байгаа тэнцвэржүүлсэн орлогоос бид суурь зарлагыг хасах буюу нөгөө гадаад зээл, тусламж биш, бусад юугаа хассан суурь зарлагаа хасахаар тэр суурь тэнцэл нь өөрөө эерэг буюу 2-оос дээш байх ёстой. Ингэхээр татвараар бүрдүүлж байгаа орлогоор цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжээ тавьсны дараа 2 хувийн ашигтай гарна гэж. Тэгэхээр нөгөө 1,3 их наядын алдагдал чинь өөрөө эх үүсвэр нь ойлгомжтой гэж тайлбарлаад байгаагийн шалтгаан нь энэ. Хэрвээ алдагдал тавиад тэр алдагдлаараа тэтгэвэр, тэтгэмжээ тавина, цалингаа тавина гэхэд үүгээр Засгийн газрын бонд гаргах гэж байгаа юм уу гэвэл энэ харин эрсдэл.

Тэгэхээр эдийн засгийн эрэлтээ дэмжье гэвэл энэ зарлага талд бичигдчихээд байгаа, орлого тал бүртгэхгүй байгаа гадаадын энэ хөнгөлөлттэй зээлүүдээс тодорхой хувийг нь явуулснаараа хувийн хэвшлийн ажлын байр хадгалагдах нөхцөл бүрдэхээр нөгөө зээлжих зэрэглэл, валютын ханшинд эергээр нөлөөлнө гэж ингэж үзэх ёстой. Тийм учраас бидний энэ тоо ер нь бодитой гэдгийг хэлэх ёстой. Жишээ нь нүүрсний үнийг хоосон өөдрөгөөр төсөөлөөд, жишээ нь өмнө батлагдсан төсвийн хүрээ яагаад өөрчилсөн юм бэ гэж 80 доллар гээд хэрвээ тооцсон байвал тэрүүгээр зарж чадахгүй юм байж тийм тооцоолол гаргаад, түүнд тохирсон төсөв боловсруулчихвал нөгөө мянга хөрөнгө оруулалтын ажил чинь хийгдэхгүй шүү дээ.

Тэгэхээр үнэнээ хэлье. Харин тоо хэмжээг 85-аас энэ жил бол 85 саяын тооны хүлээлттэй байна. Гэтэл энийг 90 болгох үүрэг чинь энэ Засгийн газрын гишүүдэд байгаа шүү дээ. Ажлаа хийх ёстой, 5 сая тонн нэмэгдүүлэх ажлаа хийх ёстой шүү дээ. Үнийг бол зохиомлоор үүсгэж болохгүй. Тийм учраас орлогыг ч бай, зарлагыг ч бай аль алиныг нь бууруулаад, хэрэглээгээ хумиад, тэгээд тэр гадаад зээлийн эх

үүсвэртэй алдагдлаараа эдийн засгийнхаа эрэлтийг дэмжээд, тэгээд явбал энэ төсвийн бодлого цаашдаа зөв явна. Дээрээс нь нийт ДНБ, орлого 2-ын харьцаа одоо 37 хувь байгааг 28 онд 28 болгож чадвал эдийн засаг эрүүлжинэ л гэж харж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Баатаржавын Мөнхсоёл гишүүн тодруулж асууя.

Б.Мөнхсоёл: Олон юм яриад яах вэ, энэ бичлэгийг хадгалаад, бодит байдал дээр үнэхээр биеллээ олбол талархъя. Тоог бол харчхаад асуугаад байгаа юмыг эргээд баахан тайлбарлачихлаа, харчхаад асуугаад байгаа гэдгийг сайтар ойлгоорой, тооцчихоод. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Бүх гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Ер нь зүгээр тухайн жилийн төсвийг хэлэлцэхээс өмнө төсвийн хүрээний мэдэгдэл, түүний дараачийн 2 жилийн төсвийн төсөөллийг өөрчилдөг энэ зарчим гэдэг юм уу нэг соёл угаасаа энэ танхимд тогтчихсон байна. Тэгэхээр энэ бодлогын бичиг баримтын нэг тодорхой тоонуудын буюу энэ макро эдийн засгийн 9 үзүүлэлтийг л яаж байгаа шүү дээ. Энэ үзүүлэлт нэг дээш, доош 15-аас 20 хувийн хэлбэлзэл байвал уг нь бид гар хүрэхээ болимоор байна. Тэгээд төсөв гэдэг юм уу, тухайн жилийнхээ Төсвийн хуулийн энэ үзэл баримтлал, танилцуулга дээрээ энэнийхээ учир шалтгааныг тайлбарлаад бичээд, энэ үзүүлэлтээр явахгүй бол ингээд нэг тохируулга хийгээд ерөөсөө ямар ч нэг ийм үр дүнгүй бичиг баримт батлаад баахан өдөржингөө сууж байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь энэ тал дээрээ боломж, тийм бололцоо байдаг юм уу, үгүй юу бас нэг анхаарчихмаар байгаа юм.

Дээрээс нь яах вэ зүгээр магадгүй тэр хэлбэлзлийг тодорхой интервалтайгаар хийж болно. Дээрээс нь энэ дэлхийн тодорхой бус байдлын индексээ бариад энэ асуудлыг хэлэлцэх үү, үгүй юу ч гэдэг юм уу, өөрчлөлт оруулах уу, үгүй юу гэдэг тэр үзүүлэлт шалгууруудаа тавиад явчихмаар байна. Тэгээд л ерөөсөө ингээд нэг тааруулж тоо тавьдаг, бид хэд өөрсдөө төлөвлөж, төсөөлж чадахгүй байна л гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энэ дээр нэг ийм өөрчлөлт хийж болох юм уу, үгүй юу энийг нэг хэлж өгөөч гэж хүсэж байгаа юм.

Дэлхий нийтээрээ энэ тодорхой бус байдлын индекс өндөр байна. Гэтэл бид хэд энэ төсөв дээр ч байна, манай нөхцөл байдал дээр бүх зүйл тодорхой бус байна. Ахмадынхаа тэтгэврийг нэммээр байна, багш нарынх нь цалинг нэммээр байна. Харин нэмэхийн тулд бид мөнгөтэй болох хэрэгтэй. Мөнгөтэй болох ганцхан салбар уул уурхайн салбар. Өнөөдөр уул уурхайн салбар дээр ерөөсөө байгаа хэдийгээ ерөнхийдөө барьж авч зодож байна. Тэгээд цаашдаа ерөнхийдөө энэ уул уурхайн салбарын хөгжлийг дэмжих энэ геологийн хайгуулыг байхгүй. Газрын хэвлийн хайгуул, судалгаан дээр бид хэд ерөөсөө юу ч зарахаа болилоо. Магадгүй өнөөдөр зөвхөн эрдэс баялгийн асуудал биш, газрын гүний дулааныг бид судалмаар байгаа байхгүй юу. Тэгвэл бид өнөөдөр бүх суурин газрууд утаагүй болох магадлал байна. Энэ Архангай дээр жишээ нь халуун рашаан байна гэдэг бол цаана нь газрын гүний дулаан байна л гэсэн үг. Тэгээд бид энийг ашиглаж чадахгүй байна. Нордик орнууд болон тэр яг энэ газрын гүний дулааныг ашиглаж байгаа орнууд чинь өнөөдөр эдийн засгийн ДНБ өсөөд, эдийн засгийг нь өдөөгөөд байгаа чинь ерөөсөө энэ юм байна лээ шүү дээ. Бүх юм нь үнэгүй болчихсон. Энэ чинь өөрөө эргээд мөнхийн эрчим хүч болчихоод байгаа байхгүй юу, мөнхийн дулаан.

Тэгээд гол юм руугаа бид юу ч хийхгүй байж ингээд баахан юм яриад л байдаг, баахан өөдрөг юм ярьдаг. Дараа нь дараа жил нь орж ирээд л нөхцөл байдал өөрчлөгдлөө гээд шилээ маажаад л, ерөөсөө ингээд л нэг бие биеийгээ хуурсан үзэгдэл ерөөсөө энд явж байна. Хэн ч төсөөлж чадахгүй байна. Нэг жилийнхээ төсвийг төсөөлж чадахгүй байгаа юм чинь 3 жилийн юмыг юугаараа яах вэ дээ ер нь, үнэндээ хэлэхэд ийм л байгаа. Тэгэхээр ийм зүйлүүд байх юм. Тэгээд ер нь зүгээр ирэх жилүүдэд энэ геологийн хайгуул, судалгаа, газрын гүний дулааны чиглэл дээр ямар хөрөнгө оруулалт, бодлогын асуудлууд байгаа юм бэ гэдэг зүйл байна.

2 дугаарт бид хэд энэ тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэх энэ чиг үүргийн хуваарилалт үнэхээр буруу байна. Жишээ нь би Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам байна, хөдөлмөрийн асуудлыг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд хариулах уу? Тэгвэл хэн, Дамдинням сайд хариулт өгье.

Г.Дамдинням: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Сайнзориг гишүүн бол яг яалт ч үгүй л энэ манай салбарын нэг томоохон уурхай дээр ажиллаж байсан хүн туршлагатай яг л хэлж байна. Бид татвар, мөнгөний бодлого эд нар юмнуудаараа энэ нээрээ үнэхээр байгаа хэдээ л мөлжих рүүгээ яваад байна. 800 тэрбумын зах зээлтэй нүүрсний зах зээлд Монгол орон бол том, том тоглогч болж чадаж байгаа. Гэтэл 450 тэрбумын зах зээлтэй зэсийн зах зээлд бид тоглож чадахгүй байгаа. Гол шалтгаан бол Амнатыг 21,6 хувь хүргээд тавьчихсан байгаа. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ганцаараа төлдөг. Дараачийн зэсийн төслүүд хийгдэх гэхээр энд ерөөсөө явахгүй, хэн ч орж ирэхгүй ийм нөхцөл рүү орчихсон. Тэгэхээр энэ Амнаттай холбоотой, тэгээд л энэ бүх л өөр төрлийн эх үүсвэрүүд, газрын овор элемент ч гэдэг юм уу, урантай холбоотой асуудлууд дээр хууль, эрх зүйн өөрчлөлтийг бэлтгэж байна. Ойрын үед Засгийн газраар оруулаад Улсын Их Хурал руу оруулж ирнэ. Ашигт малтмалын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлын дагуу энэ орж ирнэ.

2 дугаар асуулт энэ эрэл судалгааны ажлын зардал муу байгаа, үнэхээр үнэн. Эрэл судалгааны ажил гэдэг бол дэлхийн бүх улс орон өөрийн хөрөнгөөрөө улсын төсвийн хөрөнгө оруулалтаараа геологи хайгуулын ажлын өмнөх суурь судалгааны ажлыг хийдэг. Энд үндэсний аюулгүй байдлын асуудлууд, барилга байгууламжуудын асуудлууд, гамшгийн асуудлууд, газар тариалантай холбоотой асуудлууд гээд энэ хөрсөө болон газрын хэвлийгээ тэр чигт нь ерөнхий судалгаа хийдэг ийм зардал гаргах ёстой байдаг. Харамсалтай нь энэ зардлууд жилээс жилд их муу байсан. Харин энэ жил Сангийн яамныхантайгаа бид ярилцаж байгаад өнгөрсөн жилээс 2 дахин их эрэл судалгааны ажлын зардлыг тавьж байгаа. Болж өгвөл уг нь бараг 10, 100 дахин их тавьж байж Монгол орныхоо газрын хэвлийн аль хэсэгт нь ямар минерал байгаагаа тодорхойлж, хаана нь, энэ эрэл судалгааны ажил гэдэг зөвхөн ашигт малтмал дээр суурилж хийгддэг ажил биш. Хаана нь газар тариалангаа явуулах юм, хаана нь энэ газрын дулаантай холбоотой асуудлаа судлах юм, хөгжүүлэх юм, хаана нь аялал жуулчлалаа явуулах юм гээд энэ маш ач холбогдолтой ийм судалгаа бүх улс хийх ёстой. Энэ судалгаа ирэх жил нэлээн эрчимтэй 2 дахин өсөж явна. Энийг илүү дахиад нэмүүлэх ёстой гэдэг зарчмын байр суурьтай байгаа.

3 дугаар асуудал энэ газрын гүний дулааны асуудал, бас л манайд эрх зүйн орчин дутагдалтай байгаад байгаа. Скандинавын орнууд ялангуяа хойшоо тэр Iceland гэж орон бий, Исланд гэж орон. Энэ оронд бидний яриад байдаг том хэмжээний цахилгаан станцууд, дулааны эх үүсвэрүүд ерөөсөө шууд тэндээсээ хийгдэж байдаг. Манай Монгол орны урьдчилсан таамгаар бид дунд хэмжээний дулаантай орон гэсэн ийм тооцооллуудыг Исландууд хийдэг юм байна лээ. Манай дулааны бараг 20 гаруй инженерүүд тэр оронд очиж судалгаа тооцоо хийгдсэн ийм тоо баримт бид авсан. Тэгээд энэ эрх зүйн орчныг бүрдүүлэх тал дээр анхаарч ажиллая.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд нэмж хариулт өгье.

Б.Жавхлан: Төсвийн хүрээг би хариулъя тэгвэл. Ер нь манайх цаашдаа бид энэ GFS 86 гэдэг системтэй яваад байгаа юм. Government Finance Statistics гээд Олон улсын валютын сан, OECD улсууд баримталдаг. Өөрөөр хэлбэл аль өнгөрсөн зууны сүүлийн үед хэрэглэж байсан энэ системтэйгээ явж байгаа. Манайтай ижил төстэй, ижил зэрэглэлтэй улсуудын хувьд бид арай урд нь явж байгаа арай прогрессив явж байгаа. Манай хувийн секторынхон GFS 14 гээд арай шинэ ийм систем рүү яваад орчихсон. Тэгэхээр энэ төсвийн хүрээтэй очиж яаж уягдах юм бэ гэж та асуух байх. Энэ бол бүртгэлийн асуудал байгаа, бүртгэлийн асуудал. Хувийн сектор маань ашгүй ингээд биднээс хамаагүй түрүүлээд ингээд явчихсан. Төр, төрийн санхүүгийн удирдлагын систем маань энэ орчин үеийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Маш энгийнээр л уг нь хэлчихмээр байгаа юм. Тэгээд сүүлийн үед нэг ийм байна. Хуулийг ер нь үгүйсгэх, төсөвт ачаалал өгч байгаа 280 хуулийн 1060-аад заалтыг хүчингүй болгох байдлаар ч юм уу асуудлыг шийднэ гээд байгаа юм. Гэтэл тэр хууль болгоны ар талын заалт дээр чинь нийгэмд зайлшгүй хөрөнгө оруулалт хийж байх, тодорхой эрх ашиг, нийгмийн харилцаанууд байгаа байхгүй юу. Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр энийг Сангийн яам хийж байгаа нь зөв байна. Би энийг шууд үгүйсгээгүй. Зөв.

Ер нь зүгээр Ерөнхий сайдын буюу Засгийн газрын газрын ганц юм бол Үндсэн хууль болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэрэгжилтийг орон даяар зохион байгуулах. Энийг байнгын тогтвортой судалж байдаг law review commission буюу энэ загварыг бид Ерөнхий сайд дэргэдээ авч энэ хууль тогтоомжийн агентлагийг байгуулах ёстой юм. Ингэж байж энэ аль хууль ямар ачаалал өгөөд байгаа юм, нийгэмд ямар үр дүн үүсгээд байгаа юм, ийм их зардал гарчхаад шударга ёс тогтоож чадаж байгаа юм уу, ийм их зардал гаргачхаад яг тэр эдийн засгийг өсгөж чадаж байгаа юм уу гэдэг дээр дүгнэлт өгөхгүй бол юу юугүй зүгээр бүгдийг нь үгүйсгээд, ер нь хуулиас болж энэ төсөв чинь өсчхөөд байгаа шүү гэдэг юм сүүлийн үед ярих хандлага руу орлоо шүү. Тэгээд энийг чинь бидний л популист маягийн хуулиуд баталсны л хор шүү дээ. Тэгээд энийг чинь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Сайнзориг гишүүнтэй санал нэг байна. Тэр хуулиудыг өөрчлөөд, бид тэгэхдээ их хүнд даваа шүү энэ. Яг үнэхээр болдог бол тэр хуулиудыг өөрчлөөд энэ төсөв дээр ирж байгаа энэ хуваарилалт, төсвийн хуваарилалтуудыг нь зогсоочих, тэгвэл энэ нэг удаагийн арга хэмжээ. Тийм нэг урт настай арга хэмжээ

болж чадахгүй. Магадгүй дахиад 4 жилийн дараа, 8 жилийн дараа дахиж ямар улс төрийн зорилтууд байгаа юм, ямар популист зорилгууд тавиад дахиад хуулиа эргэж өөрчлөх юм бүү мэд. Харин саяын миний ярьж байгаа энэ системийг өөрчилбөл энэ нэлээн хамаагүй урт настай. Магадгүй дахиад 50 жил явах ч ийм урт настай. Тэгэхээр энэ нөгөө нэг системийн бүртгэл маань өөр болоод ирэхээр уул уурхайгаас хамааралтай энэ хэт савлагаанууд маань энэ төсөв дээр, төсвийн хүрээн дээр нөлөөллүүд нь хамаагүй багасаад ирэх юм байгаа юм. Энийг бүртгэл талаас нь ойлгуулахын тулд нэлээн тийм цаг хугацаа хэрэгтэй.

Тэгэхдээ ер нь энэ эхлээд бид урт настай системүүдээ зоригтой барьж авах хэрэгтэй. Ойрын хугацаандаа шийдлүүд нь бол таны ярьж байгаа одоо энэ бид татварын шинэчлэл гээд байна, маш өндөр өртөгтэй. Энийг богино хугацаанд хийхийн тулд төсөв дээр ирж байгаа энэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сархадын Зулпхар гишүүн асуулт асууя.

С.Зулпхар: Их Хурлын дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөлтэй уялдуулаад мэргэжлийн түвшинд дүгнэлт, санал, зөвлөмж гаргадаг бүтэц нь их тодорхой Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Өнгөрсөн жилийн бид санал, дүгнэлтийг уншиж байсан. Энэ жилийнх харьцангуй эерэг гарсан байна. Тэр битгий хэл бараг өнгөрсөн жилийн тэр санал, зөвлөмжүүдийг 60-аас 70 хувийг нь бараг авчихсан байна. Тэгэхээр энэ бол мэргэшсэн түвшинд төсвөө оруулж ирэх ийм хандлага гарч байгаа юм байна гэсэн ийм ойлголт байна. Нэг талаар энэ сайн юм. Би төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн бодлоготой холбогдуулаад 2 сайдаас асууя.

Эхнийх нь Аубакир сайдаас. Бид энэ эдийн засгийн үзүүлэлтүүдээ яриад байна. Эдийн засгийн үзүүлэлтээс гадна төсвийн бодлогын нөлөөлөл бол нийгмийн нөлөөлөлтэй байх ёстой, үр дүнтэй байх ёстой. Энэ өнгөрсөн жилийн манай төсвийн бодлого оруулж байсан, одоо хэрэгжиж байгаа энэ төсвийн бодлого чинь 25 онд ажил эрхлэлт, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр энэ ямар нөлөөлөл үзүүлсэн юм бэ? Энийг та бидэнд тайлбарлаж хэлж өгөөч гэж байгаа юм?

Наранбаяр сайдаас. Ирэх жилийг буюу 2026 оныг бид Боловсролын хөгжлийг дэмжих жил болгоод ингээд зарлачихсан. Энэтэй холбогдуулаад төсөв дээр 198 ийм төсөл, арга хэмжээ байхаар байгаа юм бүтээн байгуулалтын, 180 нь цэвэр барилга байгууламж байна л даа. Сургуулиуд дээр бүлэг дүүргэлт жишээ нь 35 хувь нь давчихсан гэсэн ийм тооцоолол статистик байж байгаа. 8 сарын 28-ны өдрийн бидний ажил хэргийн уулзалт дээр энийг манай дэд хороон дээр ярьж байсан. Тэгэхээр одоо энэ бүтээн байгуулалтууд хийгдсэнээр өмнө байсангууд нь үргэлжилснээр саяын бүлэг дүүргэлтэд ямар сайн үр дүн гарах юм бэ? Энэ 8 мянга гаруй бүлэг дүүргэлт нь хэтэрсэн гэж байгаа шүү дээ, энэ дээр ямар үр дүн гарах юм бэ гэсэн ийм асуулт байна?

2 дахь зүйл бид нийгмээрээ ярьж байна. Багш нарын цалин хөлсний асуудал. Ерөнхий сайд зарлачихсан хамгийн том бүтээн байгуулалт бол хүний хөгжил, цаашлаад боловсролын салбар гээд ингээд зарлачихсан байгаа шүү дээ. Энэтэй уялдсан байдлаар багш нарынхаа жишээ нь цалин хөлсний бодлого дээр, аргачлал дээр, арга зүй дээр, бүтэц дээр, тэрнээс гадна цалингийн зөрөө хот, хөдөөгөөс шалтгаалаад бидний урьд нь гаргасан шийдвэртэй холбоотойгоор ялгаатай байгаа

шүү дээ. Энэ дээр ямар та бүхэн санал, эсвэл тооцоолол, тэрнээс гадна үр дүн хүлээсэн байдлаар оруулж ирсэн бэ гэсэн ийм асуулт байна.

Төгсгөлд нь түрүүн Бейсен гишүүний хэлж байсан санал л даа. Газар дээр нь та бүхэн ажилласан уу? Газар дээр нь бид ажиллахад энэ сургууль дээр бол спорт заал байхгүй байгаа шүү дээ. Та бол анги дүүргэлт нь сайн байна гэж хэлж байна. Анги дүүргэлт бол өөр, энэ бол хөтөлбөр өөр хэрэгжиж байгаа юм. Хувь хүний, сурагчдын бие бялдрын хөгжлийг хангах гол жишээ нь арга хэрэгсэл чинь биеийн тамирын хичээл юм бол биеийн тамирынхаа хичээлийг орж чадахгүй боллоо л гэсэн үг. Тэр сумд биеийн тамирын заал байхгүй байна. Тэгэхээр та хэд өөр шалгуур тавьж байна энийг та бүхэн тодорхой хариулаач гэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Тилеуханы Аубакир сайд хариулт өгье.

Т.Аубакир: 2025 оны төсвийн бодлого ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшинд хэрхэн нөлөөлсөн бэ гэж асуулаа гэж ойлгож байна. Ажилчдын тоо 2025 онд 33 мянгаар буюу 2,4 хувь орчмоор нэмэгдэж, нийт ажиллагсад 1 сая 388 мянган ажиллагсдын тоонд хүрэх ийм төлөвтэй байгаа. Ер нь аливаа энэ баталж байгаа улсын төсөв, төсөл, хөтөлбөрүүд бол ажлын байр нэмэгдүүлэхэд гол чухал үзүүлэлтүүд болдог шүү дээ. Хөдөлмөр эрхлэлтийн өсөлт, хөдөлмөр эрхлэх хандлага нэмэгдсэнтэй холбоотойгоор ажиллах хүч 33 мянган хүнээр буюу 2 орчим хувиар нэмэгдээд 1,4 саяд хүрэх төлөвтэй харагдаж байгаа. Оны эцэс рүү яг тоо гарах байх. Үүний үр дүнд ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос 0,5 нэгж хувиар өсөж байгаа юм.

Яах вэ мэдээж хэрэг энэ ажилгүйдлийн шалтгааныг бид заавал хэлэх ёстой. Ажилгүйдлийн шалтгааныг авч үзэхэд гол зонхилох ийм шалтгаанууд нь 34,2 хувь нь ажил хайгаад олдохгүй байгаа, 10,9 хувь нь мэргэжил, дадлага, туршлага байхгүй, 9 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа гэх зэрэг маш олон шалтгаануудыг дурдаж болж байгаа юм. Эрэлт, нийлүүлэлт буюу энэ хөдөлмөрийн зах зээл дээрх ажил олгогч, ажилтан хоёрын эрэлт, нийлүүлэлт ерөөсөө огтлолцож өгдөггүй. Бид гаднын ажиллах хүчний асуудлуудыг өнөөдөр Засгийн газрын хуралдаан дээр авч үзлээ гэх зэрэг маш олон зүйлүүд байна. Тэгээд ажилгүйдэлтэй холбоотой, энэ хөдөлмөр эрхлэлттэй холбоотой, ирэх жилийн буюу 2026 оны батлах бидний одоо яриад сууж байгаа төсөв, төсөл, хөтөлбөрүүд маань тодорхой хэмжээний ажилгүйдлүүдийг шийдэхэд нэмэр болох байх гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууя. Уучлаарай, Наранбаяр сайд нэмж хариулт өгөх юм байна.

П.Наранбаяр: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 198 төсөл, арга хэмжээн дээр нэмэх нь АХБ-ны зээлийн шугамаар 41 сургууль, цэцэрлэгийг нэмж бариулахаар ингээд оруулж ирж байгаа. Эдгээр нь ингээд баригдсан тохиолдолд бид ээлжийн коэффициент нь өнөөдөр улсын дундаж 1,48 байгаа бол 1,34 рүү буурах ийм бид тооцоо хийсэн. Ингэснээрээ сурлагын чанар 2 функтээр өсөх ийм тооцоолол хийсэн байгаа.

Мөн тэр Баян-Өлгий аймагт сая ярьсан, Бейсен гишүүний яриад байгаа Цэнгэл сумын спортын заалны биеийн тамирын заалны барилгын тухайд бид судалж үзэхэд энэ тухайн үедээ яг хуульд заасан хугацаандаа энэ санал нь ирээгүй, нэмэлтээр Сангийн яам руу бид саналыг нь дэмжиж явуулсан байгаа, дэмжиж

явуулсан. Энэ дээр бид ингээд юу яахад таны хэлдэг яг үнэн, энэ спорт заалгүй тэр хүүхдүүд чинь өнөөдөр гадаа хичээллэж байгаа юм. Тэгээд нийт хөрөнгө оруулалт нь нийтдээ 2 тэрбум төгрөг, энэ жил.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Энэ жил санхүүжих дүн нь 1 тэрбум төгрөг байгаа. Энийг энэ бүлгийн хуралдаан болон энэ яг энэ үеэр ярилцаад, энэ хөрөнгө оруулалтынхаа ийм жагсаалт руу оруулах боломжийг эрэлхийлж үзнэ гэсэн ийм байр суурьтай байна.

Цалингийн тухайд 8 дугаар сарын 31 хүртэл бид судалгаа хийж үзсэн. Үндсэн цалин болоод нэмэлт цалингуудын энэ бүх бүтцийг нь судлаад ингээд үзэхэд өнөөдөр орон зай болон цаг хугацаагаар хамаарсан ийм цалингийн зөрөө энэ салбарт нэлээд их байна ийм дүгнэлтэд хүрсэн. Дөнгөж ажилд орж байгаа нийслэлд ажилд орж байгаа залуу багш хүн үндсэн цалин 1,4 саятайгаар эхэлж байгаа. Энэ бол ямар нэгэн нэмэгдэл эхний 5 жилд ямар нэгэн нэмэгдэл байхгүй ийм байгаа нь маш их энэ залуу хүмүүс энэ багшлах энэ хөдөлмөрийн зах зээлд орж ирэхийг бол ихээхэн хэмжээгээр хааж байгаа нь харагдаж байгаа. Тийм учраас цалинг нэмэгдүүлэх ийм саналыг гаргасан. Бид 25 хувиар нэмэгдүүлье гэсэн бидний.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Зулпхар гишүүн тодруулж асууя.

С.Зулпхар: Ажлын хэсэг их тодорхой түвшинд ажиллаж байгаа байх. Энэ багш нарын цалинтай холбогдуулаад нэг зүйл тодорхой яригдсан шүү дээ. Үндсэн цалин болон гүйцэтгэлийн жишээ нь цалин хөлсний энэ балансыг бид тэнцвэржүүлбэ гэсэн. Нэг бол энийг зохистой харьцааг нь хангая гэсэн. Энэ дээр ер нь ямар тооцоо хийгдсэн бэ? Зарим талаар багш нар гүйцэтгэлийг тэр чигт нь үндсэн цалин руу оруулчих гэж байна. Нөгөө хэсэг нь бол хэрвээ энэ гүйцэтгэл байхгүй болбол сүүлдээ бүтээмжээр цалинжуулдаг энэ жишээ нь тогтолцоо чинь эвдэрчихнэ, энэнээс шалтгаалаад сурлагын чанарт ч нөлөөлж магадгүй гэдэг ийм зүйл ярьж байгаа юм л даа. Тэгэхээр энэ дээр яам ямар байр суурьтай байгаа юм бэ? Цалин хөлсний бодлого их тодорхой байх ёстой. Нөгөө нэг зүйл тодорхой асуумаар байна.

Ер нь энэ жишээ нь төрийн албан хаагчид чинь 226 мянган албан хаагч байгаа юм. Би Сангийн сайдаас зориуд асууж байна л даа. Цалин хөлсний бодлого нэгдмэл байх ёстой. Гэхдээ салбарын онцлогтой байх ёстой байх. Энэ нэгдмэл болон онцлог байх нөхцөл байдлыг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд нэмэлт хариулт өгье.

П.Наранбаяр: Тэгэхээрээ зөв, 2022 оноос эхлээд гүйцэтгэлд суурилсан ийм цалингийн систем рүү орсон. Энэ гүйцэтгэлд суурилсан энэ цалин бол нэвтэрсэн явдал ололттой талууд олон бий. Тийм учраас энийг 100 хувь үгүйсгэж хэрхэвч болохгүй. Өнөөдөр 70 орчим тэрбум төгрөгийг гүйцэтгэлийн үнэлгээ дээр тавиад ингээд багш болон сургуульд нь очиж байгаа, тэр нь яг багш болон сургууль дээрээ очиж байгаа ийм зүйл байгаа. Гэхдээ энэ цалингийн ялгааг үүсгээд байгаа нь 40 хүртэл хувиар үүсгээд байгаа юм, зөвхөн гүйцэтгэлийн үнэлгээ гэхээр ийм байгаа юм. Тэгэхээр энэ нөхцөл байдалд Боловсролын яамны зүгээс бид гүйцэтгэлийн үнэлгээнийх нь өнөөдөр байж байгаа нийт дүнгийн 50 хувийг нь үндсэн цалинд нь

шингээж өгье гэсэн ийм байр суурьтай байгаа. Ингэснээр багш нарынхаа цалинг нэлээдгүй хувиар нэмэх ийм боломжтой болж байгаа. Харин 50 хувийг нь үлдээж яг хөтөлбөрөө сайн хэрэгжүүлж байгаа, хүүхдүүдээ, сурагчдаа сайн сургаж байгаа ийм багш нар бол цалин урамшуулал авах ийм боломжийг хангах ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Занданшатар сайдаас 3 асуулт, Наранбаяр сайдаас 2 асуулт байсан. Тэгээд Занданшатар сайд хаачсан юм бол? Төсөв хэлэлцэхээр ингээд бүгдээрээ алга болдог, сайд болох болохоороо бүгдээрээ бөөндөө чихэлдээд сууж байдаг ийм байж болохгүй. Албан тушаал болохоор гүйлдээд байдаг, ард түмний төлөө төсөв болохоор ингээд хэдхэн хүн сууж байж болохгүй. Монгол Улсын Их Хурал 25 оны 5 сарын 30-ны өдөр Монгол Улсын нэгдсэн төсвийн 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг баталсан.

Миний хувьд энэ баталсан хуульдаа өөрчлөлт оруулахыг дэмжихгүй байгаа. Төлөвлөж, төлөвлөж, шөнөжин өдөржин хэлэлцэж баталчхаад, дөрөвхөн сарын дараа өөрчлөх гээд ингээд сууж байгаа нь үнэхээрийн утгагүй санагдаж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээг 6 хувь байсныг 5,7 хувь болгоод, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг 105,6 их наяд төгрөгт хүрэх байсныг 102,2 их наяд болгож 3,3 их наяд төгрөгөөр бууруулахаар тооцсон байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын иргэн бүрд очих 1 сая төгрөгийг зүгээр л нэг хуулийн өөрчлөлтөөр хасаад хаячихлаа ингэж болох уу? Ер нь ингээд хүрнэ гээд баталсан төлөвлөгөө, тооцоотой зүйлээсээ ухраад байж болох юм уу? Харин ч үүнийг өсгөөд нэмэгдүүлэх талаар Засгийн газрын зүгээс хамаг хүч чадлаа шавхаад ажиллах ёстой юм биш үү сайдуудаа, Засгийн газрын сайдуудаа, Ерөнхий сайд аа.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 33 их наяд 479 тэрбум байсныг 31 их наяд 600 тэрбум болгон 1 их наяд 879 тэрбум төгрөгөөр бууруулсан хэр нь нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 32 их наяд 980 тэрбум төгрөг болгож 499,5 тэрбум төгрөгөөр бууруулсан байна. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, төсвийн алдагдал 1,3 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэ 1,3 их наяд төгрөгийн алдагдлаа юунд зарцуулах гэж байгаа вэ? Эсвэл алдагдалгүй баталж болохгүй юм уу? Өнгөрсөн жил төсөв алдагдалтай баталлаа гээд Ерөнхийлөгч хориг тавиад, Их Хурлын гишүүд нь дэмжээд хүлээж аваад, алдагдалгүй төсөв баталсан асуудал юу болж хувирав?

3 дугаарт Монгол Улсын 26 оны төсвийн тухай хуулийн төслөөс үзэхэд ирэх онд боловсролын салбарт дотоодын нийт бүтээгдэхүүний 4,2 хувийг л зарцуулах юм байна. Уг нь Монголын төр 23 онд боловсролын салбарт 5,1 хувь, 24 онд 5,2 хувийг зарцуулж байсан. Гэтэл өнөөдөр харамсалтай нь 25 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 4.7, 26 онд 4.2 гээд ингээд буугаад явж байна.

Д.Амарбаясгалан: Мөнхтуяа гишүүнд нэг минут нэмж өгье.

Ц.Мөнхтуяа: 2026 оныг боловсролыг дэмжих жил гэж зарлачхаад өнөөдөр ингээд боловсролын салбарт оногдож байгаа төсөв нь өмнөх онуудынхаасаа 5,2 байсныг 4,2 болгоод ингээд буулгаж байна шүү дээ. Ингээд алдагдсан боломжийн өртөг 1 их наяд төгрөгөөр хэмжигдэж байна. Нэгэнт төсвийг алдагдалтай баталж

болоод байгаа юм чинь төсвийн тухай шаардлагуудаа зөрчихгүйгээр Засгийн газраас ирэх 26 оныг боловсролыг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан боловсролын салбарт зарцуулах төсвөө дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувийн босгыг давуулж болох уу, ийм боломж байна уу гэдгийг асуумаар байна?

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Их Хурлаар батлагдсан төсвийн хүрээг эргээд харахад тухайн үед эдийн засгийн нөхцөл байдал их өөр байсан. Гадаад орчин их өөр байсан. Тийм учраас тухайн үед нүүрсний үнийг 80 доллароор тооцож байсан. Тэгээд тэр төсвийн хүрээ батлагдсаны дараа сар хүрэхгүй хугацаанд энэ худалдааны дайн, тарифын бодлогууд, Хятадын үл хөдлөхийн салбарын уналт, гангийн хэрэгцээ буурсан гээд ийм нөлөөллүүдээс болоод нүүрсний үнэ унасан. Тухайн үед жишээ нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөнтэй бид ажиллаж байхад 88 доллар гэдэг үнэ өгч байсан. Тэгээд үнэхээр тийм үе байсан. Тэгэхээр одоо бидний экспортолж байгаа гол бүтээгдэхүүний маань үнэ уначхаад байхад энд худлаа ярьж суух утгагүй л дээ. Угаасаа 80 доллароор нүүрсээ заръя гэвэл хэн авах вэ дээ ийм л болчихоод байна.

Тийм учраас дэлхийн зах зээл дээрх үнийн хөдөлгөөн, Хятадын эдийн засгийн талаар олон улсын шинжээчдийн анализ, төсөөллийг байнга авч ашигладаг. Тэгээд энэ хүрээндээ бид 4 сард төсөөлөл боловсруулах үед нүүрсний зах зээлийн үнийн төсөөлөл 80 орчим байсныг нь энэ удаагийн төсвийн хүрээний мэдэгдэл дээр 70 доллар болгож бууруулж байгаа. Гэхдээ биет тоон хэмжээгээ нэмэгдүүлэх үүргийг өгч байгаа яг таны хэлснээр энэ Засгийн газрын ажил. Тоон хэмжээгээ нэмэгдүүлэх ёстой, боломжтой тоонд нь хүргэх ёстой, сайн ажиллах ёстой гэсэн үг шүү дээ. Ингэж байж энэ цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжээ нэмэх асуудлуудаа шийдвэрлэнэ. Тэгэхээр үнэнээ хэлэх ёстой гэдэг утгаараа тоогоо хатуу барья гэдэг зорилгоор л энэ удаагийн төсвийн хүрээ орж ирж байгаа.

Тэгэхдээ нэг удаагийн өөрчлөлтийг та бүхэн маань Төсвийн тогтвортой байдлын хуулиар өөрчилж өгсөн. Орлого, зарлага аль аль нь буурсан тохиолдолд нэгэн зэрэг буурсан тохиолдолд нэг удаа өөрчлөх, нэг удаагийн өөрчлөлт энэ хууль батлагдсантай холбогдуулаад энэ удаа бид нөгөө зарлага нэмэх зорилготой биш, худлаа хоосон орлого төлөвлөх зорилготой биш, аль алиныг нь бууруулж орж ирж байгаа юм.

Дээрээс нь тусгай шаардлагуудыг биелүүлж байна гэдэг бол цаашаа эдийн засаг ийм эрүүлжих бололцоо байгаа байхгүй юу. Жишээ нь нүүрсний үнэ, дээрээс нь зэс, алтны үнэ өсөх хандлага байлаа гэвэл салбар болгон дээр нь яг үүргүүдийг нь хүлээлгээд, салбар болгон дээр хийх ажлуудаа тооцоолоод, эдийн засгийн өсөлтийг 5,7 гэж ингэж оруулж ирсэн. Тэгээд энэ яах вэ Азийн орнууд, манайх шиг хөгжиж байгаа орнуудын хувьд ер нь жишиг ийм түвшин байдаг. Тэгэхээр бид энэ 5.7-д хүргэнэ. Гол экспортолж байгаа улс жишээ нь Хятад гэхэд ер нь өсөлт 5 хувьтай байдаг. Тэр 5 хувьдаа хүрэхээргүй хэмжээнд одоо оччихоод байна л даа. Тийм учраас ийм давагдашгүй хүчин зүйлүүд тулгарсан.

Ер нь манайх шиг хөгжиж байгаа оронд яах вэ төсвийн хүрээ бол өөрөө тэр голлож байгаа бүтээгдэхүүний зах зээлийн үнэ өсөлт, тэр төсөөллөөсөө шалтгаалаад харьцангуй уян хатан байх нь илүү зохимжтой ер нь бол. Өмнө нь бид хиймэл өндөр зарлага тавиад, түүндээ тохирсон адилхан зарлага гаргадаг байсан. Хэрвээ 33,4 их наядын орлого олох гэж байсан бол зарлагаа бууруулаад 30 их

наядын ч юм уу зарлага бууруулчихсан бол харин эндээс эдийн засаг буцаад эрүүлжинэ шүү дээ. Тэгэхээр орлого, зарлага тэнцүүлнэ гэдэг тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдлаасаа шалтгаалдаг гэдгийг хэлэх ёстой. Өнөөдөр энэ урсгалыг 24 хувиас хэтрүүлж угаасаа л болохгүй, тусгай шаардлагаа барих ёстой. Гэтэл цалин хөлсөө нэмье гээд оруулаад ирэхээр 24 хувь нь даваад явчихаад байдаг. Нэг иймэрхүү хайчинд л байгаа шүү гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Мөнхтуяа гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхтуяа: Наранбаяр сайд 8 сарын 19-ний өдөр багш нарын цалинг 20 хувь нэмнэ гээд амлалт өгсөн тийм ээ, өөрөө амаараа хэлсэн байгаа шүү дээ. Энэ 20 хувь чинь хаана байна вэ, хэзээ нэмэх вэ? Ер нь энэ боловсролын салбарын багш, ажилчдын нийгмийн асуудлыг бид үргэлж хөндөж шаардаж яваа. Тэгээд энэ зөвхөн хэдэн багш нарын цалинг нэмэх гээд байгаа асуудал биш л дээ. Энэ Монголын ирээдүйн төлөө хийх гэж байгаа хөрөнгө оруулалт юм. Хэдэн багш нарыг баяжуулаад, хэдэн багш нарын цалинг нэмэх гээд байна гэсэн буруу, нийгэмд ийм буруу ойлголт яваад байна. Өнөөдөр сайн хүүхдүүд багшийн сургуулийг сонгохоо больсон. Алдаатай бичдэг, нэрээ бичиж чадахгүй юмнууд бараг багшийн сургуульд орж байгаа 400 оноогоор. Тэгээд ийм байж өнөөдөр гүйцэтгэлийн үнэлгээ гэж попрохоо одоо боль. Гүйцэтгэлийн үнэлгээг чинь 98 хувь нь эсэргүүцэж байгаа, багш нарын тэр групп рүү ороод хараарай, гоё байна гэж хэлсэн нэг ч багш байхгүй байгаа шүү, битгий худлаа яриад байгаарай энэ танхим дотор. Ер нь үнэнийг ярьж гэж байгаа бол бүгдээрээ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд хариулт өгье.

П.Наранбаяр: Энэ Монгол улс энэ Инчоны тунхаглал гээд олон улсын баримт бичигт зөвлөмж хэлбэрээр байдаг. Энд элсэж орсон. Энэ дээр ДНБ-ийхээ 20 хувь, төсвийнхөө зарлагын гээд ингээд юунууд байдаг, нөгөө амлалтууд. Тийм, 7 хувь. Төсвийнхөө зарлагын 20 хувь, уучлаарай. Тэгэхээр энэ амлалтыг биелүүлэхэд би тантай адилхан байр суурьтай байдаг, адилхан. Бид энэ жил хэдийгээр 4,1 хувьд нь төсвийнхөө зарлагын 4,1 хувьд хүрч байгаа ч гэсэн АХБ-ны шугамаар зээллэгийн шугамаар сургууль, цэцэрлэг барихад зориулаад 150 сая долларын зээллэг бол энэ дээр яригдаж орж ирж байгаа. Гэхдээ энэ нь нөгөө бичилт дээрээ Сангийн яамны, Сангийн сайдын багцад орж байгаа, боловсролын салбар дээр бичигдэхгүй. Тэгэхээр тооны хувьд ингэж харагдаад байгааг хэлье. 2 дугаарт цалингийн асуудал байна. Түрүүнд би хэлсэн.

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд гүйцээж хариулъя.

П.Наранбаяр: 8 дугаар сарын 19-нд та бүхэнтэй уулзахад бид энэ боломжоо харж энэ цалинг 20 хүртэл хувиар нэмэхэд энэ чиглэлээр ажиллахад бэлэн байна гэдгээ хэлсэн. Бид яамнаас боловсруулсан санал 25 хувь нэмэхэд 560 тэрбум төгрөг шинээр шаардлагатай юм байна гэсэн тооцоог гаргаж явуулсан байгаа. Гүйцэтгэлийн үнэлгээг ч гэсэн өнөөдөр энэ хүлээн зөвшөөрч байгаа, хүлээн зөвшөөрөхгүй байгаа ийм багш нар байгаа шүү дээ. 2 хувь тийм биш шүү дээ, 98 хувь нь эсэргүүцэж байна гэдэг энэ бол тийм бодитой тоо биш. Зүгээр бид энэ сайн ажиллаж байгаа хүнд нь түлхүү өгдөг. Харин гэхдээ үндсэн цалин нь өөрөө амьдралын баталгаа болдог энэ л бодлого руу явах ёстой л гэсэн хатуу байр суурьтай байгаа юм. Энэнийхээ төлөө л бид явна. Ийм учраас тэр ДНБ-д болоод төсвийн зарлагад эзлэх энэ боловсролд зориулах энэ зардал мөнгийг бол улс орны

эдийн засгийн өсөлт энэ болгонтой харьцуулж харж байгаад боломжоороо бид нэмээд ингээд явах ёстой. Боловсролд оруулсан хөрөнгө оруулалт болгон ирээдүйд энэ чинь 4 дахин өсөж орж ирж байдаг ийм л зүйл шүү дээ.

Д.Амарбаясгалан: Мөнхтуяа гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхтуяа: АХБ-ны 150 сая доллароор сургууль, цэцэрлэг барина л гээд байгаа юм. Тэгээд тэр сургууль, цэцэрлэгт чинь ажиллах багш байхгүй байгаа шүү дээ. Өнөөдөр 5 мянган багшийн дутагдалд орчхоод, багш нарынхаа цалин хөлсийг нэмж чадахгүй ингээд сууж байхаасаа ичих хэрэгтэй, ичих хэрэгтэй. Тэгээд өөрийгөө хамгаалаад 98 хувь нь худлаа гээд юу яриад байгаа юм бэ? Би бодитой судалгаа ярьж байна. Та багш нарынхаа өмнө очоод асуу л даа өөрөө, гүйцэтгэлийн үнэлгээ хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу, хэрэггүй гээд бүгд хэлээд байхад чинь хэрэгтэй гээд энд яриад, нөгөө тэмээ гэхээр ямаа гээд суух юм. Битгий ийм муухай хариуцлагагүй, ёс зүйгүй байгаач. Та нарын тэр байшин барилга барьж мөнгө угаах чинь өөр асуудал, Боловсролын яам бодлогоо ярь. Монголын боловсрол өнөөдөр аль түвшинд яваагаа ярь. Бодлогын чанар, бодлогын алдаа, чанар тэр юунууд чинь бүгд алдагдчихсан байгаа шүү дээ. PISA-ийн үнэлгээгээ хар, өнөөдөр хувийн сургууль төгссөн хүүхдүүд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Өдрийн мэнд хүргэе. Баянхонгор аймагт тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн асуудал шийдсэн Энх-Амгалан сайд, Аубакир сайд 2-т юуны өмнө баярлалаа гэдгээ илэрхийлье. Гэхдээ энэ Аубакир сайд байж байгаад гараад явчихлаа. Дунд шатанд яаж ажлыг завхруулж болдог вэ гэдгийг зун 6 сараас хойш Аубакир сайд уг нь яс махандаа шингэтэл ойлгосон. Тэгээд энэ дунд шатанд байгаа энэ хариуцлагынхаа асуудлыг ярих хэрэгтэй шүү гэдгийг өөрт нь хэлмээр байна, захичихъя.

Тэгээд энэ 24 оны Засгийн газрын санхүүгийн аудитаар төсвийн болон төрийн өмчит ААН-үүдийн төсвийн ерөнхийлөн захирагчид дээр 15 их наяд төгрөгийн алдаа дутагдал гарсан гэдгийг аудитын байгууллага Улсын Их Хуралд танилцуулсан. Тэгээд энэ хэнд, ямар хариуцлага тооцсон бэ гэдгийг энэ Хэрэг эрхлэх газрын дарга, Ерөнхий аудит 2 энд хэлж өгмөөр байна. Тэгээд жишээ энэ 2024 онд Баянхонгор аймагт 24-өөс 25 онд 7 хүнийг хууль бусаар томилчихсон байгаа юм. Энэ Төрийн албаны зөвлөл байвал энэ дээр энэ тэр ТАЗ-өөс гаргасан тогтоолын дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангаа нэг яриад өгвөл сайн байгаа юм.

Хэрэг эрхлэхийн дарга Бямбацогт сайд хаврын чуулганы хаалт дээр хэлж байсан юм. Бид намар гэхэд энэ хариуцлагатай холбоотой энэ данхар төрийг хязгаарлах тал дээр хууль өргөн барина гэсэн, хуулиа өргөн барьсан уу, хууль чинь хаана явж байгаа вэ гэж? Тэгээд энэ Баянхонгор аймаг, Өвөрхангай аймгийн дулааны станцын энэ барилгын ажлыг явуулна гэдэг мэдээллийг Сангийн яам энэ хаврын чуулган дээр бас мэдэгдсэн. Гэтэл энэ өргөн барьсан төсөв дээр нь алга болчихсон. Энэ Баянхонгор аймаг, Өвөрхангай аймаг бол яг энэ Улаанбаатар хот шиг утаандаа живж эхэлж байгаа гэдгийг энд дуулгая.

Тэгээд 24 оны төсөв тэр чигтээ сонгуулийн төсөв байсан. Сангийн сайд энэ нөгөө төсөв дээр асуудлуудаа энэ хөрөнгө оруулалтуудыг шийдье гэхээр маш их тийм шаардлага, шалгуур өндрөөр тавьдаг. Тэгтэл 24 онд Өвөрхангай аймагт

жишээлэхэд 10 ширхэг зураг, төсөвгүй сургууль, цэцэрлэгийн барилга орчихсон байгаа. Одоо тэгээд тал барилга хүлээж авах уу, яах вэ гэдэг дээрээ, хэн хариуцлага хүлээх вэ, яах вэ, ийх вэ гэдэг асуудлаа тэр зарчим нь хаана байна, хариуцлага нь хаана байна гэдгийг энд яривал зүгээр байна. Тэгээд энэ сургуулийн барилга ингээд энд, тэндгүй нөгөө мөнгөгүй болоод гацаад байхад Засгийн газар боловсролын жил л гэж зарлаад байх юм. Тал сургуультай боловсролын жил болчих гээд байна шүү дээ.

Тэгээд энэ Бичигтийн боомтоос Дарьгангын тэр орох зам маш их тийм зарчимтай ажил хэрэгч ажил болж орж ирээд байх шиг байгаа юм. Гэтэл Засгийн газар чинь бүсчилсэн хөгжил гэж нэг юм яриад энэ Өвөрхангай-Мандалговь-Чойрыг холбосон засмал зам тавина гээд явж байсан, аймгийг аймагтай, бүсийг бүстэй холбох зам тавина гээд явж байсан ийм Бичигт боомтыг Дарьгангатай холбох замаас юугаараа дутуу болоод хасагдчихаад байгаа юм бэ? Энэ дээр нэг тайлбар. Тэгээд энэ Засгийн газрын ажил уг нь тасралтгүй байх ёстой. Хангайн бүсийн нөгөө Засгийн газрын хурал дээрээс гарсан ажлууд энэ төсөв дээр орж ирээгүй. Тэгээд тодруулга дээрээ нэмэлт мэдээлэл авна.

Д.Амарбаясгалан: Бямбацогт сайд хариулт өгье.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны шинэчлэл, төсвийн хэмнэлтийг дээрээсээ эхлүүлнэ гэж Монгол Улсын Ерөнхий сайд Занданшатар хэлсэн. Үүний хүрээнд тодорхой ажлууд хийгдээд явж байгаа. Тухайлбал яамдын газар, хэлтсийн дарга нарын тоог цөөлөх энэ ажлуудыг зохион байгуулж, нийтдээ 28 газар, 53 хэлтсийг татан буулгасан, 81 яамны газар, хэлтсийн даргаар цөөрсөн гэсэн үг. Мөн агентлагуудтай холбоотой, агентлагууд дээр 300 орчим дарга, ажлын хэлтсийн дарга, албаны даргыг цөөлж, ингэж орон тоог цөөлсөн байгаа. Энэ хүрээндээ нийтдээ 20 орчим тэрбум төгрөгөөр төсвийн хэмнэлт хийсэн. 57 үндэсний хороо, зөвлөл байсан үүнийг 29-өөр цөөлсөн. Энэ хүрээндээ төсвийн 40 орчим, 40 гаруй тэрбум төгрөгийн хэмнэлтүүд хийгдсэн. Иймэрхүү байдлаар тодорхой хэмжээнд төсвийн зардлыг бууруулах, данхар төрийг цомхон, чадварлаг, бүтээмжтэй болгох ийм ажлууд хийгдэж байна. ТӨК-удтай холбоотой 109 ТӨК-ийг 70 болгож цөөлөх тодорхой бодлогын ажлууд хийгдэж байгаа.

Мөн цаашдаа бид бүхэн Төрийн албаны хуулийн шинэчлэлийг хийж хэрэгжүүлэх Улсын Их Хуралд өргөн барьж боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барих энэ бэлтгэл ажлыг хийгээд явж байна. Энэ намрын чуулгандаа багтаагаад Төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулгыг өргөн барьчих ийм бодолтой ажиллаж байгаа.

Ер нь төсвийн урсгал зардалтай холбоотой, төсвийн данхайгаад байгаа, бүтэц нэмэгдээд байгаатай холбоотой асуудал дээр төрийн албаны энэ томссон байдал байгаад байгаа. Гэхдээ энийг төрийн захиргаа, төрийн тусгай, төрийн үйлчилгээ гээд аваад үзвэл яах аргагүй хүн амын өсөлт, үүнтэй холбоотойгоор эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, бусад үйлчилгээнүүд нэмэгдэж байгаа тохиолдолд төрийн үйлчилгээ дээр илүү их нэмэгдэж байгаа юм байна лээ. Яг төрийн захиргаан дээр харьцангуй юу гэдэг юм нэмэгдэж байгаа байдал харьцангуй бага, данхайж байгаа байдал нь. Гэхдээ илүү цомхон, чадварлаг, илүү бүтээмжтэй болох, төрийн албан хаагчдын бүтээмжийг гүйцэтгэлийг нь тийм бодитой үнэлэх энэ талд томоохон өөрчлөлтүүд хийнэ. Иргэдийн оролцоотойгоор, иргэдийн хяналт доор, иргэдээр үнэлүүлж төрийн албыг илүү цомхон, чадварлаг, хүнд сурталгүй

болгох ийм ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллаж байгаа, ажиллаж байгаа. Урьд нь төрийн албан хаагчдын үнэлгээ гээд, үнэлгээ аваад үзэхээр дарга нар нь үнэлдэг 99 хувь нь хангалттай сайн ажлаа хийж байна гэж үнэлэгддэг, 1 хүрэхгүй хувь нь хангалтгүй гэж үнэлэгддэг ийм байдалтай.

Улсын Их Хурлаас бас төрийн алба, Засгийн газрын үйл ажиллагааг үнэлэхээр 60 гаруй хувьтай байна гэж үнэлдэг. Иргэд болохоор ерөөсөө хангалттай нь 40 хувьтай байна, хангалтгүй нь 60 хувьтай байна гэж үнэлдэг. Ийм үнэлгээнүүд өөр, өөр байгаад байгаа. Тэгээд үүнийг л ерөөсөө иргэдийн оролцоотой, иргэдийн хяналттайгаар, иргэдээр бодитой үнэлүүлдэг байх ийм тогтолцоонд ил тод, нээлттэй болбол илүү төрийн алба чадамжтай, илүү бүтээмжтэй, хариуцлагатай болох юм болов уу. Энэ тогтолцоонд шилжих асуудлыг Төрийн албаны хуулийн өөрчлөлтөө өргөн барих, үүнээс наана шийдэх асуудлыг шийдээд явна.

Д.Амарбаясгалан: Хэн байна вэ нэмж, 4 дүгээр индэр дээрээс нэмж хариулт өгье.

Ж.Дэлгэржаргал: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Хөрөнгө оруулалттай холбоотой 3 асуудал, асуулт асуусан. 10 аймгийн ДЦС-ын хувьд Солонгосын Эксим банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжээд явж байгаа. Гүйцэтгэгч буюу хэлэлцээрийн хүрээнд Солонгос гүйцэтгэгч Солонгосын компани байсан, дампуурлаа зарлаад, шүүхийн шийдвэр Солонгосын шүүхээр гарсан. Энэ дээр яг Монголын Засгийн газар Эксим банкттай хэлэлцээрүүд хийгээд ирэх долоо хоногт Солонгосын Сангийн яамтай энэ хэлэлцээрийг үргэлжлүүлээд нийтдээ 10 аймаг дээр үлдсэн зээлийн ашиглалт 73 сая ам.доллар дээр цааш нь энэ төслийг хэрхэн үргэлжлүүлэх вэ гэдэг шийдэл ингээд хэлэлцээрийн түвшинд явж байгаа. Зээл, тусламжийн ашиглалт 1,5 их наядын хүрээнд энэ хэлэлцээр үргэлжлээд энэ төсөл цаашаа явбал ашиглалтад гараад явах боломжтой буюу санхүүжилт нь тусгагдсан. Сургууль, цэцэрлэгийн хувьд Өвөрхангай аймаг дээр нийтдээ шинээр сургууль, цэцэрлэг төлөвлөгдөөгүй, нийтдээ боловсролын салбарын 10 төсөл.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж минут өгье.

Ж.Дэлгэржаргал: Энэ 10 төслийн хувьд таны хэлснээр яг 2024 онд бүгд эхэлсэн, 26 онд дуусах ийм үлдэгдлүүд нь явж байгаа. Ирэх оны төсөв дээр бид шинээр хөрөнгө оруулалтуудыг сургууль, цэцэрлэгийг төлөвлөхдөө нэг маягийн зургаар төлөвлөх, цаашдаа ч гэсэн нэг маягийн зургаар төлөвлөхгүй яг бие даасан зургаар явах ийм зарчим барьсан. 24 онд эхэлсэн энэ зарим төслүүдийн хувьд тухайн үед нэг маягийн зургаар төлөвлөснөөс үүдэлтэй өртгийн нэмэгдэл гарсан. Энэ дээр гарсан нэмэгдэл магадлалын дүгнэлтээр аудитын дүгнэлтийг хийж ингэж шийдвэрлээд явж байгаа.

Авто замуудын хувьд 25 оны шинэ хөрөнгө оруулалт дээр бид бүсчилсэн хөгжлийн хүрээнд авто замын салбарт шинээр хөрөнгө оруулалтуудыг төлөвлөсөн. Ирэх оны төсвийн төсөл дээр нийтдээ авто замын салбарт 902 тэрбум төгрөгийн санхүүжилт тусгагдсаны 800 тэрбум нь яг шилжих хөрөнгө оруулалтуудын үлдэгдэл байгаа. Тэгэхээр ирэх жил шинээр эхлүүлсэн 4 авто замын төслийн хувьд эрэмбийн хувьд Бичигт Дарьгангатай.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бүх тайланг чинь сонсох цаг Их Хурал дээр байхгүй. Тэгэхээр товчхон, тодорхой хариулж байхгүй бол болохгүй. Ер нь энэ авто замтай холбоотой асуудал хөндөгдсөнтэй холбоод хэлэхэд өмнөх жилүүдэд тавьсан зам дээрээ төсвөө тавихгүй мөртөө шинээр замууд оруулж ирж төсөв тавьж эхэлж байгаа байдал Засгийн газар 2 өөр бодлого гаргаж ажиллаж байгаагийн л жишээ харагдаж байгаа шүү дээ. Жишээ нь Завхан аймгийг Арцсуурь боомттой холбох замын төслийг өнгөрсөн жил эхлүүлчхээд, энэ жил төсөвгүй, үргэлжлүүлэх төсөвгүй. Тэгсэн мөртөө ахиад шинээр зам тавих гээд явж байдаг. Тэгээд энэнд чинь ард иргэд битгий хэл энд сууж байгаа Улсын Их Хурлын гишүүд итгэхгүй болж эхэлж байна шүү дээ.

Тэгээд л нэг дарга, сайд нарын нөлөө ордог юм уу, өмнөх бодлогоо үгүйсгээд л, өмнө нь явж байсан хөрөнгө оруулалтаа удаашруулаад л, тэрний чинь хор гайгаар жилдээ 3, 4 зуун тэрбумын өртөг нэмэгдэж байгаа алдагдалд улс өөрөө ороод байгаа гэдгийг л бодмоор байгаа байхгүй юу. Барилгын төсөвт өртөг. Энэ 10 аймгийн дулааны станцын асуудал ярьж байгаа. Энэ 10 аймгаас сонгогдсон гишүүд ч гэсэн энэ дээр онцгой анхаарах хэрэгтэй. Энэ жилийн, ирэх жилийн төсөвт энэ жил өргөн баригдахад нэмэгдсэн төсөвт өртгийг засаж залруулах бодлого орж ирээгүй л гэж байгаа юм. Тэгэхээр 10 аймгийн дулааны станц ирэх жил үргэлжлэхгүй гэсэн үг байхгүй юу. Тэгээд бүр дампуурна, баахан хөрөнгө оруулалт ороод хаягдана, эсхүл Засгийн газар хурдан шийдээд тэр Солонгосынхоо зээлийг зогсоогоод байгаа бүтээн байгуулалтыг нь үнэлээд, хувийн хэвшилд зарлаад, хувийн хэвшилд хөрөнгө оруулалтаа хийгээд дуусгах боломжийг нь олгох ёстой. Төр нь ч хийдэггүй, хувь нь ч хийдэггүй, ахиад гадных нь зээл нь өртөг нэмэгдээд цаашаа үргэлжилж чаддаггүй. Тэгээд одоо хэдүүлээ энд худлаа ярьж суугаад яах юм бэ, иргэдэд худлаа мэдээлэл өгөөд яах юм бэ, одоо бодитой, дорвитой алхам авах цаг нь ирсэн л гэж бодох хэрэгтэй. Даваагийн Цогтбаатар гишүүн тодруулж асууя.

Да.Цогтбаатар: Тэгээд нэг асуусан болох юм, хариулсан болох юм. Энд саяын Сангийн яамнаас яригдаж байгаа асуудал хаврын чуулган хаахад яг л энэ нөхцөл байдал хэвээрээ байсан, ямар ч ажил урагшлаагүй байгаа. Тэгээд тэр нэг хэдэн угсарчихсан төмөр чинь тэгээд зэврээд дууслаа. Энэ дээр нэг дорвитой ажил хийгээрэй Эрчим хүчний яам, энэ Сангийн яам 2-т онцгой анхааруулж хэлье. Гадаадад амьдарч байгаа залуучууд ээж, аав эх орноо гээд Монголдоо ирж байна, одоо бол харамсаж байна. Татвар төлж байгаа хувийн хэвслүүд бол энэ татварын өндөр байгаа дээр үнэхээр харамсаж байна. Тэгээд энэ Учрал сайд энэ сая Засгийн газар төсвөө нийтэд ил тод ярилцаад саналыг нь авсан гэсэн энэ дээр нэг хариулт хэлэх байх. Би бол Засгийн газрын нэрийн өмнөөс тэр гадаадад амьдарч байгаад ирсэн мундаг, мундаг залуучууд, энэ хувийн хэвслээс Засгийн газрын нэрийн өмнөөс уучлалт хүсэж байна. Тэгээд энэ Авлигатай тэмцэх газар саяхан хэд хоногийн өмнө МАН-ын цагаан байр луу орж нэгжлэг хийлээ. Энэ дээр бид нэг төсөв гээд, төсвийн хүрээ гээд 30, 40 их наядын асуудал ярьж байгаа. Уг нь дахиад цаашаа нэг даргын өрөө рүү орсон бол энэ авлигын загалмайлсан.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Асуулт асууя. Би 3 асуулт байна. 1 дүгээрт, төсөв алдагдалтай батлах ёстой бараг л энэ нь ном ёсоороо юм шиг ингэж тайлбарлахаа болиоч. Ямар ч Монгол айл олж байгаагаасаа илүү идэж уух нь тэр айл супер дампуурна гэсэн үг. Ямар ч Монгол айл. Тэгэхэд улсын бүх төсвийг барьж байгаа бид чинь ер нь алдагдалтай төсөв батлаад л, тэр нь тийм байх ёстой л гээд яриад байх юм. Яг

онолоороо бол бид өнөөдөр ирээдүйгээсээ зөвшөөрөл авахгүй дээрэм хийж байна шүү дээ. Энэ 1,3 их наядын чинь дараагийн 4 жил, 8 жил, 10 жилийн дараа бидний хойч үе хүүтэй төлнө. Тэрэн дээр ямар хариуцлага байгаа вэ? Өрнөөс би айх юм алга, энийг хэрэглээнд зарцуулбал бид энэ улсыг дампууруулж байна гэсэн үг. Ухаантай царайтай, гоё сайдын ажил хийгээд улсыг дампууруулж байна гэсэн үг. Харин өрийг мөнгө олдог, үржүүлдэг төсөл, хөтөлбөр лүү хэрэгжүүлж байгаа юу, хэдэн хувь байгаа вэ миний 1 дүгээр асуулт? 1,3 их наядын хэдэн хувь нь мөнгө үржүүлдэг, мөнгө өсгөдөг төсөл рүү орсон бэ? 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 76 төслийг 1,8 их наядаар санхүүжүүлж байгаа төсвийн хүрээний мэдэгдэл дээр байна. Нийт 126 төслийн 40 хувь нь ямар ч санхүүжилтийн эх үүсвэр байхгүй, бас энийг олон улсын зээл тусламжаар авах уу? Үндсэндээ гуйлга гуйж хөгжсөн орон хаана ч байхгүй шүү. Монгол энийг л нэг нээлт хийх гээд л зүтгээд байх шиг байна даа. 1 дүгээр асуулт их тодорхой байх гэж бодож байна.

2 дугаар асуулт. Та нар айлаас ирэхээр авдраа ух. Төрийн өмчийн компаниуд 22,8 их наядын өр төлбөртэй мөн их мөнгө шүү. Энэ Улаанбаатарын утааг байхгүй болгох орон сууцыг санхүүжүүлэх мөнгө шүү дээ. Төрийн өмчийн компаниудыг бүгдээрээ сонгуульд явсан найзуудыгаа даргаар нь тавьдаг, бүгдээрээ авлигын үүр уурхай гэж үзэж байна энэ 22,8. Ямар ч захын бизнесмен ядаж алдагдалгүй ажилладаг, ашигтай байдаггүй юм гэхэд. Тэгэхэд төрийн өмчийн компаниуд 22,8 их наядын алдагдал гадаад болон дотоод өр төлбөртэй. Энэ төсвийн хүрээн дотор хаана яваа вэ? Энэ дээр би гарцтай юм ярьа л даа. Тэгээд жил болгон нэг яншаад л тоо яриад л. Энэ тал дээр Монгол оронд хариуцаж энэ авлигын эх үүсвэрийг байхгүй болгодог улсууд байгаа юу? Улсын төсвөөс санхүүждэг АТГ энэ дээр ажилладаг уу? Нэг сургуулийн захирлыг нэг хөөцөлдөөд л, тоогоо гүйцээгээд л, дараа нь нэг ийм улс төрийн даалгавар маягаар нэг улс төрийн аллага шиг байгууллага болчихсон. Энэ тэнэглэлээ АТГ энэ үүрэг даалгавар чинь энэ төрийн өмчийн компаниудын 22,8 их наядын өр төлбөр дээр та нар хариуцлага тооцсон уу? Ямар гарц гаргалгаа байгаа вэ?

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье. Даваагийн Цогтбаатар гишүүний асуултад дутуу хариулсан байна лээ, тэрийг бас боломжоороо нэмээд хариулчхаарай.

Н.Учрал: Даваагийн Цогтбаатар гишүүний асуултад эхлээд хариулъя. Тэгээд энэ удаа Засгийн газар төсвийн хүрээ болон төсвийн төсөөллийн хуулийг боловсруулахдаа иргэдийн саналыг авсан, 240 гаруй мянган иргэн санал өгсөн. Цогтбаатар гишүүний хэлж байгаагаар тэр өндөр боловсролтой, эдийн засагч, мэргэжлийн эксперт олон залуучууд төсвийн талаар ойлголттой болсон юм байна. Эдийн засагчид өөрсдөө оролцсон. Тэгэхээр иргэдээс санал авна гэдэг буруу биш. Энэ нээлттэй, ил тод бодлого. Тэгээд иргэд өөрсдөө ирэх онд эдийн засгийн өсөлт ямар байх вэ гэдэг дээр өөрсдөө тооцооллоо хийгээд хүртэл над руу илгээсэн. Монголд олон эдийн засагч, мэргэжилтэн, экспертүүд байгаа юм байна. Тэгэхээр дарга нар өөрсдийгөө хамгийн ухаантай нь гэж бодлогоо болих хэрэгтэй. Тийм учраас би аливаа асуудал дээр дандаа мэргэжлийн холбоонуудтай уулзаж байгаа. Та бүхэнд ямар санал байна, ирэх онд эдийн засгийн өсөлт 5,7-д хүрэх үү, танд ямар бодол байна вэ? Ингээд оролцуулж байгаа. Оролцоод асуудлыг хамтдаа шийдвэрлэснээрээ татвар төлөгчид өөрсдийнх нь татвар төлөгдсөн мөнгөөр бий болж байгаа энэ төсвийн орлогыг зөв зүйлд зарцуулна. Энэ бол нээлттэй, ил тод бодлого байна гэдэгт эргэлзэхгүй байгаа.

Сая Ганбаатар гишүүн асууж байна. Тэгээд Ганбаатар гишүүн онолын хувьд гэж асуусан. Тэгээд онолын хувьд төсвийн тэнцэл бол эдийн засгийг тогтворжуулахад ашигладаг бодлогын, бодлогыг тохируулдаг үзүүлэлт мөн. Бид энэ үзүүлэлтийг зөв үедээ ашиглаж чадаагүйгээсээ болоод энэ алдагдал дээр өнөөдөр нэг ийм асуулт, хариултууд энд өрнөж байгаа. Энэ бол бидний буруу. Яагаад 33,4 их наядын орлого олдог үедээ яг түүнтэйгээ адилхан зарлага гаргаж байсан юм бэ л гэдэг асуултад л бид хариулах ёстой байхгүй юу. Яагаад эдийн засаг тэлж байх, халж байх үед бид хуримтлал үүсгэж чадаагүй юм бэ? Яагаад хумьж чадаагүй юм бэ? Хэрвээ тэгж чадсан байсан бол өнөөдөр ийм нөхцөл байдал байхгүй. Тийм учраас зүгээр Эдийн засаг, хөгжлийн сайдаар томилогдоод миний хувьд би иргэдийн оролцоог хангуулъя гэж хүссэн. Мэргэжлийн холбоонуудтай уулзсан, санал шүүмжийг нь сонссон.

Дээрээс нь энэ тоонуудаа хатуу барья л гэж үзсэн. Үнэнээ хэлье гэж үзсэн. Зах зээлд экспортын бараа, бүтээгдэхүүн тэр дундаа нүүрс нь яг хэд байгааг үнэнээр нь хэлье. Харин тоо хэмжээг нь шахаж өгье, гадаад нөхцөл байдалдаа үүсээд байгаа асуудал гарцуудыг нь эрэлхийлье, гацаа саадыг нь арилгая л гэж зорьсон. Дээрээс нь эцсийн үр дүнд тэр суурь тэнцэл чинь эерэг байх ёстой шүү, урсгал хэт нэмж болохгүй шүү, орлого, зарлагаа аль алиныг нь бууруулна шүү гэдэг энэ тоон дээрээ хатуу байсан. Гэхдээ ирэх онд 1,9 их наядын хөнгөлөлттэй зээл, тусламж хэрэгжих юм байна. Гэтэл энийг явуулахгүй байх нь өөрөө ард иргэдэд хүрэх олон төслүүдийг гацаах юм байна л гэж үзсэний үндсэн дээр эх үүсвэр нь тодорхой бус зүгээр баахан алдагдал тавьчхаад бондоор, үнэт цаасаар санхүүжүүлнэ гэж хэлчхээд түүгээрээ шаардлагагүй хөрөнгө оруулалт тавьдаг байдлаас татгалзах ёстой.

Тийм учраас Ганбаатар гишүүний хэлж байгаа маш зөв. 1,3 их наядын алдагдлаар газрын тосны үйлдвэр, тэр Эрдэнэбүрэнгийн УЦС, саяын 10 аймгийн дулааны станц гээд олон ажлууд мэдээж хэрэгжинэ. Тэгээд энэ ажлууд хэрэгжихээр эх үүсвэр нь заавал бичигдэх ёстой төсөв дээр. Тэрнээс хоосон нэг ийм бонд гаргана, үнэт цаас гаргана гээд эргээд төлж чаддаггүй ийм нөхцөлд орж болохгүй шүү дээ. Тэгээд өнгөрсөн энэ хугацаанд чинь бараг 12, 3 их наядын өр зээл авчхаад байна шүү дээ. Ашиглаж ч чаддаггүй, тэгээд хэрэглэж ч чаддаггүй, тэрийгээ эрэмбэлж ч чаддаггүй. Тэгэхээр сая Эдийн засаг, хөгжлийн яамнаас Засгийн газар дээр ерөөсөө энэ төслүүдээ яг олон улсын аргачлалаар нь үнэлээд дуусгасан. Энэ үнэлгээгээ барьж байгаад л жилийн төлөвлөгөө, 5 жилийн чиглэлээ явуулъя. Ингээд жоохон зохион.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Хотоо мануулах гэж нохой тэжээдэг. Уг нь ард түмнийхээ амьдралыг сайхан болгох гэж л төрийн өмчийн компани, сайдуудыг, Засгийн газрыг бид тэжээж байгаа юм шүү дээ. Тэгэхлээр нөгөө хотоо манах, ард түмнийг сайжруулах төрийн өмчийн компани ийм өртэй болчихсон байна. Энэ дээр АТГ юу ч хийхгүй байгаа энэ механизмыг яах вэ гэдгийг л ярьсан.

2 дугаарт толгойдоо малгайгаа тааруулдаг болохоос биш малгайндаа толгойгоо тааруулж зорж болохгүй, толгойгоо цавчиж болохгүй. Түүн шиг төсвийн хүрээний энэхүү хуульд хуулийг бид нэгэнт хэрэгжүүлэхгүй ингэж дандаа дээрэлхэх юм бол ерөөсөө хуульгүй байя. Ингэж худлаа жүжиглэхээ больё, энэ чинь хуульдаа бүүр заасан байгаа шүү дээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар

зүйлийн 7.3, 10.1, 10.1.2-ыг уландаа гишгэж бид төсвийн хуульгүй юм шиг орж ирж байгаа, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульгүй юм шиг орж ирж байгаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Энэ алдагдалтай төсөв гээд байгаа дээр бид олон талаас нь л тайлбарлаж байна. Би дахиад нэг талаас нь л төсөв талаас нь тайлбарлах гээд оролдъё. Алдагдлын бүтэц их чухал. Энэ юунд зориулж байна яг таны асуулт, юунд зориулж байна, ямар үр ашигтай төслүүд дээр явж байна вэ? Эсвэл цалин, тэтгэвэр, тэтгэмжээ авч тавьж чадахгүй алдагдалд орж байна уу, үгүй юү. Тэгэхээр бидний сонголт юу вэ гэхээр цалин, тэтгэвэр, тэтгэмжээ татварынхаа орлогоор бүрэн тавьчихаж байгаа юм. Бүүр дээрээс нь 2 хувийн ашигтай байгаа. Эдийн засгийн өсөлтөө хангахын тулд яг таны хэлж байгаа шиг яг мөнгөний үржүүлэгч төслүүд дээрээ энийг тавьж байгаа юм. 1,5 их наядаар нөгөө мега төслүүд дээрээ гадаадын зээл. тусламжаар санхүүжиж байгаа тэр төслүүд тэр хөрөнгийг тавьж байгаа юм 1,5. Хамгийн 1 дүгээрт нөгөө нефть боловсруулах үйлдвэр жилд тэрбум доллар авч үлдэх энэ төсөл, Эрдэнэбүрэнгийн УЦС, Улаанбаатарын.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тийм. Тэгэхээр Ганбаатар гишүүнээ тэгээд таны санаа зовж байгаатай би ажил байна. Тэгэхээр алдагдал маань цэвэр мөнгө үржүүлэгч хамгийн үр ашигтай ийм төслүүд рүү явж байгаа шүү гэдгийг хэлье.

Дээрээс нь Улсын Их Хурлын даргаа Арцсуурийн төсөл хойтон үргэлжилнэ шүү дээ, 13 тэрбум төгрөгийн санхүүжилт тавигдсан байгаа. Тэгээд хойтон үргэлжлээд 27 онд дуусна. Энэ Арцсуурь маань өөрөө 159 км зам төсөл, бүтэн дүнгээр нь бид чадахгүй, төсөв хэзээ ч чадахгүй. Тийм учраас 20 км-ээр нь эхний төсөл болгож тасалсан байгаа. Дараа нь үргэлжлэхдээ дахиад тендер зарлагдана. Арвайхээр-Мандалговь-Чойрын зам ч гэсэн адилхан. Энэ чинь нийтдээ 474 км-ийн зам байхгүй юу. 474 км замыг Монгол Улс өнөөдөр нэг дор бид барьж арай чадахгүй. Нийт төсөв нь 875. Тийм учраас эхний төсөл 40 км-ээр 3 талаас нь эхэлсэн юм. Тэр төсөл энэ жил дуусна, 25 онд дуусна. 26 онд эхлүүлье гэтэл 430 км дээрээ зураг нь 22 оных байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гүйцэтгэлийг нь үр дүнтэй харьцуулсан харьцуулалт хангалтгүй байна гээд илтгэл дээрээ танилцуулсан. Тэгээд энэ байгууллагынхаа зөвлөмж, дүгнэлтийг ингээд чихнийхээ хажуугаар зүгээр өнгөрөөдөг ийм Засгийн газартай. Энэ байгууллагын хуулийг 21 удаа өөрчилчихсөн, Төсвийн тухай хуульдаа 71 удаа өөрчилчихсөн, хамгийн тогтвортой байгууллага нь хамгийн тогтворгүй болж хуульд хамгийн их өөрчлөлт ордог ийм болчихсон.

Аудитын байгууллага нь төсөв үр дүнгүй байна, үр дүнд чиглээгүй байна гээд дүгнэлтийг Их Хуралд гаргаад өгчихсөн. Тэгээд энэ бас яг хэвээрээ. Яг бодитоор ярихад 2016 оноос эхлээд буюу МАН засгийн эрх авсан жилээсээ эхлээд эдийн засаг дахь төрийн оролцоог багасгана гээд яг 10 жил энийгээ давтаж бичсэн. Тэгсэн мөртөө бодит үйлдэл хийгдээгүй. Бизнесийн орон зайг тэлэх, татвар төлөгчдийн

тоог нэмэх, бизнес эрхэлж байгаа хүмүүс чөлөөтэйгөөр аж ахуйгаа эрхлэх ийм боломжийг өнөөдөр хүртэл бий болгоогүй ингээд 10 жил зүгээр цаасан дээр бичиж байна ганцхан өгүүлбэрээр. Цаашаа үр дүн, гүйцэтгэл харьцуулсан үзүүлэлтээр нь юу ч байхгүй байгаад байна. Ингээд бид худлаа яриад бие биеэ хуураад байвал энэ байдал хэзээ ч өөрчлөгдөхгүй, ирэх жил дахиад л төсвийн эдийн засаг дахь төрийн оролцоог багасгана гээд бичээд л ороод ирнэ.

Их Хурлын гишүүдэд тараасан Төсвийн тухай номын 136 дугаар хуудас дээр бахархалтай нь аргагүй нэг юм бичсэн байна лээ. ТӨК-уд ДНБ-ний 74 хувийг үйлдвэрлэж байна гээд. Тэгээд энэ юугаараа та нар төрийн оролцоог багасгаад байгаа юм бэ Засгийн газрынхан, сайдуудаа? Энэ чинь улам нэмэгдээд байна шүү дээ. Ингээд бид алт, зэс, нүүрс гээд гуравхан зүйлээс ихэнх орлогоо олдог. Тэгтэл энэ тооцоолол бол хөөс, хийсвэрээр хөөсрүүлээд бодчихсон. Ковидын үед хил хаалттай байх үед 2020 онд 23 тонн, 2019 онд 21 тонн алт олборлож байсан юм. Өнөөдрийн байдлаар 8 тонн хүрэхгүй байна. Хил нээлттэй болчихсон. Энэ юу гэсэн үг вэ гэхээр алт олборлолт нэмэгдсэн, олборлож байгаа ААН хэвээрээ, илүү олон болсон ч тушаалт нь багассан гэсэн үг. Дэлхийн түүхэн дээр, түүхэн дэх хамгийн өндөр цэгтээ алт ирчихсэн байхад татвар төлөлт, үгүй ээ алт тушаалт нь багасаж байна гэдэг бол хууль бус алт хилээр гарч байна гэсэн үг. Үүн дээр Дамдинням сайд ямар бодолтой байгаа юм бэ?

2020 он, 26 оны улсын төсвийг бодохдоо алтыг 20 тонноор тушаана гээд, 20 тонн алт тушаана гэж улсын төсөв бодсон байна лээ энэ төсөв дээр. Энэ чинь биелэхгүй. Тэгээд эдийн засаг дахь төрийн оролцоо яагаад өндөр байгаад байна вэ гэхээр би та нарт өнөөдрийн байдлаар 54 мянган ААН татварын ямар нэгэн өртэй, нийт өр нь 3,5 их наяд байгаа юм. Тэгээд энэ ААН-үүдийг яаж хөл дээр нь бос гээд байгаа юм бэ? Яаж хүний цалинг тавиад байгаа юм бэ? Тийм учраас орлогын албан татвар чинь 1,8 их наядаар тасарч байна шүү дээ. Ингээд тооцооллоо зөв бодох хэрэгтэй байна. Төсвийн хүрээний мэдэгдлээ зөв бодож байж, бид зөв хийж байж энэ улсын төсөв боддог болох ёстой юм. Тэгэхгүй ингээд төсвийн хүрээний мэдэгдэл гээд ингээд сайхан, сайхан 10 жилд нэг цаасаа сору-доод тавьчихдаг, үр дүн нь яг 10 дахь жилдээ яг адилхан. Тэгээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Учрал сайд эхлээд хариулт өгье.

Н.Учрал: Тийм Шижир гишүүн ер нь бидний үеийнхэн үзэл бодол, итгэл үнэмшил ижилхэн л дээ. Энэ төрийн өмчийн оролцоог багасгах ёстой, тэгээд эдийн засаг дахь энэ хувийн хэвшлийн орон зайг бий болгох ёстой, хувийн хэвшил дэх ажлын байрыг хадгалах ёстой, эдийн засгийн эрх чөлөөний төлөө энэ цаг үед бид төрж өссөн л дөө. Тийм учраас би итгэл үнэмшлийн хувьд хамт. Тийм учраас Эдийн засаг, хөгжлийн сайд хийж байгаагийнхаа хувиар энэ удаа төсвийг, төсвийн бодлогыг оруулж ирэхдээ эхлээд бодлогын хувьд одоо ингээд харахаар жишээ нь манай энэ тэнцвэржүүлсэн орлого, тэнцвэржүүлсэн орлого нь нөгөө дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа 2 маань 37 хувь, аягүй өндөр. Энийг шат дараалалтай буулгаад, 20, энэ жил 30 хувь, 28 онд 28 хувь хүртэл бууруулъя л гэдэг 26, 27, 28 оны төсвийн төсөөлөл, 26 оны төсвийн хүрээг оруулж ирсэн. Энэ юу вэ гэхээр энэ 28, 37 хувийн орон зайд тэр татварын шинэчлэл хийгдэх ёстой, хувийн хэвшлийн орон зайг хадгалах ёстой. Одоо энэ Сангийн яамнаас энэ татварын багц хуулийг барьж байгаа тэр 4 их наядын ачаалал үүрээд байгаа хууль чинь энэ орон зайд хадгалагдах ёстой гээд.

2-т Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг төсөв дагуулж барьсан. Нэг ёсондоо тэр олон төслийг төсвөөс санхүүжүүлэхээ болих хэрэгтэй, өөр санхүүжилтийн механизм олох хэрэгтэй.

2-т тэр алдагдлыг зөвхөн хувийн хэвслээр ажил гүйцэтгэх зарчмаар шинэ ажлын байрыг бий болгох руу, шинэ технологи нэвтрүүлэх рүү зарахын тулд нэгэнт гадаадын зээлээр хийгдэх ажлуудыг илүү хувийн хэвслээр ажил гүйцэтгэх зарчмаар хийхийн тулд нөгөө эдийн засгийн эрэлтийг дэмжих бодлогоор оруулж ирсэн. 2-т төсвийн орлого багасна гэдэг бол цаанаа татвар төлөгчдийн мөнгөө татвараа багасгах бодлоготойгоо уялдуулж байгаа. Дээрээс нь тэр НӨАТ-ын 2.5 ч гэсэн цаанаа өөрөө бүртгэлжүүлэх механизм л яваад байгаа. Далд эдийн засгийг сэргээх.

3-д Эдийн засгийн эрх чөлөөний хуулийг 3 хоногийн өмнө legalinfo дээр тавилаа. Ингээд Эдийн засгийн эрх чөлөөний хуулийг дагалдуулаад хөрөнгө оруулалт, бизнесийн орчинд саад тотгор учруулж байгаа, үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхлоос бусад тохиолдолд хувийн хэвшлийн эрх зүйн байдлыг дордуулсан, үйл ажиллагааг нь хориглосон ямар ч хууль, дүрэм журам, захиргааны хэм хэмжээний акт гаргахыг хуулиар бүхэлд нь хориглож байгаа.

Тэгээд энэ Хэвлэлийн эрх чөлөөний хууль хэвлэл мэдээллийн салбарыг энэ олон жил зохицуулж хамгаалж ирсэн шиг бид Эдийн засгийн эрх чөлөөний хуулийг бий болгож, энэ баялаг бүтээгчдийг дэмжих ёстой. Үүний хүрээнд AI дээр энэ эдийн засгийн эрх чөлөөг хөндөөд байгаа бүх хуулиудын шүүлт хийхэд 200 орчим хууль гарч байна. Ингээд энэ Эдийн засгийн эрх чөлөөний хуулийг дагалдуулаад Хөрөнгө оруулалтын хууль олон жил бид ярилаа, одоо баталж гаргая. Хөрөнгө оруулалтын хууль, түүнийг дагасан 10 гаруй хуулийн өөрчлөлт, дээрээс нь Зөвшөөрөл, мэдэгдлийн хууль гээд нийтдээ Эдийн засгийн эрх чөлөөний хууль, түүнийг дагасан 110 хуулийн өөрчлөлтийг legalinfo дээр тавьсан. Тэгээд энэ бол аль нам засаглахаас үл хамаараад энэ хуулийг хийгээд авах нь бидний хувьд чухал юм байна лээ. Тэгээд АН-ын бүлгийн дарга ийм хуулийн концепц боловсруулсан гээд ярьж байсан. Тэгээд бид энийг улс төржихгүйгээр хамтдаа энэ эдийн засгийн эрх чөлөөний хуулийг гаргаад, төрийн оролцоог хумих хэрэгтэй. Тэгээд өмнө нь тэр ТӨК-ийн бүтээмж, засаглал ил тод байдлыг сайжруулах хуулийг Их Хуралд оруулчихсан байгаа юм. Тэр хуулийг батлах хэрэгтэй. Ингээд түүний дараа Засгийн газраас баримтлах чиглэлийг Засгийн газрыг шахаад Их Хурлын гишүүд мэдээж хуулийнхаа хүрээнд шахаад, бид хурдан хугацаанд ажиллаад оруулж ирээд, татан буулгахыг нь татан буулгаж, нэгтгэхийг нь нэгтгэж, өөрчлөхийг нь өөрчилж, листэд болгохыг нь болгож, нэг мөр нэг талдаа гарах хэрэгтэй л гэж ийм байр суурьтай байгаа.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт Дамдинням сайд.

Г.Дамдинням: Алт тушаалтын өнөөгийн нөхцөл байдал бол Шижир гишүүнтэй энэ төрийн өмчийн оролцоотой холбоотой асуудал дээр байна. Хамаг сайн том лицензүүдийг нь төрийн өмчийн компаниудаар тогтоол гаргаж байгаад өгүүлээд ингээд, тэгээд л олборлолт явдаг, тэгээд хувийн хэвшлийнхэндээ өгмөөр байгаа юм. Тэгээд зардалтай холбоотой асуудлууд дээр нь бөөн хэл ам болоод л ингээд л яваад байгаа. Одоо ч гэсэн надаас лиценз нэхээд л явж байна. Би өмнө нь авсан лицензүүд дээр хийсэн хайгуул, судалгааныхаа ажлын үр дүн, хөрөнгө оруулалт та нар ер нь яаж хийх гээд байгаа юм бэ гэдгээ харуул, сорчилж олборлоод яваад байна энэ буруу. Уулын ажлын төлөвлөгөөгөө дагахгүй байна,

байгаа үедээ төсвийн орлого мундаг сайн хийсэн нэр зүүгээд байхаа болиоч гэдэг ийм байр суурьтай л явж байгаа. Алтан дээр одоогийн байдлаар 49 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ дээр гол асуудал сая би энэ Алт тогтоол оруулж ирсэн Алт аяныг дэмжих тухай тогтоол өнгөрсөн хаврын чуулганаар Улсын Их Хуралд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Үдээс өмнөх чуулганы, тодруулах юм уу? Тодруулж асууя, доошоо харж сууж байгаад тэгээд араас ингэж орилдгоо болимоор байх юм, харахаар доошоо хараад суучих юм. Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Нөгөө эдийн засаг дахь төрийн оролцоог багасгая гээд яриад байдаг. Гэтэл бодитоор энэ чинь төрийн өмчит компани, төр чинь өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүний 74 хувийг үйлдвэрлээд байна шүү дээ. Энэ тоо ингээд жил болгон нэмэгдээд байгаа, энэ чинь багасахгүй байгаад байгаа юм. Тэгэхээр та нарын яриад байгаа чинь нөгөө тийшээ нөгөө урвуу хамааралтай буюу худлаа яриад байна гэсэн үг ер нь бол. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар чинь 28 хувиар буурчихсан. Энэ юу вэ гэхээр татвар төлөгчийг хэлээ унжуулж байна гэсэн үг. Арай гэж хөл дээрээ тогтож байна гэсэн үг. Тэгээд энэ зузаан ном дээр чинь эдийн засаг дахь төрийн оролцоог багасгана гэсэн ганцхан өгүүлбэр байгаа болохоос өөр ямар ч бодлогын баримт бичиг цаас алга гэж хэлээд байгаа юм. Ганцхан өгүүлбэр, Төсвийн хүрээний мэдэгдлийн 3 дугаар хуудсан дээр ганцхан өгүүлбэрээр байгаа. Сүүлийн 10 жилд ер нь хувийн аж ахуйн нэгжүүдээс авч болох бүх татварыг авсан, 9 төрлийн татвар нэмсэн 2016 оноос хойш. Одоо нэг татвар хойшлохоор шууд дансыг нь хаадаг болсон. Тэгээд энэ бид төрийн оролцоог улам өндөр байлгаад байна гэсэн үг. Татвар төлөгч аж ахуйн нэгжүүд чинь төрийн хяналт шалгалтаас үхтлээ айдаг болчихлоо. Энэ чинь төрийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Тамгын газар анхаараарай. Өнгөрсөн долоо хоногт Даргын дэргэдэх зөвлөл дээр яригдсан. Ирэх долоо хоногийн баасан гарагт Улсын Их Хурлын асуулгын цаг, Улсын Их Хурлын тухай хуульд орсон өөрчлөлтөөр анхны асуулгын цаг явагдана. Уг асуулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд Ерөнхий сайдаас асуух асуултаа долоо хоногийн өмнө цаасаар өгсөн байх зохицуулалт байгаа, тийм ээ. Намын бүлгүүд болон намуудад өнөөдөр албан ёсоор мэдэгдээрэй. Тэгэхгүй бол хугацаа өнгөрсөн, урьдчилж мэдэгдээгүй гэдэг асуудал дандаа яригдаж хөндөгдөнө. Мэдээлсэн үү Ариунхур дарга? Албан ёсоор мэдээлээрэй. Тэгээд гишүүдэд энийг зарын групп дээр мэдээлэл өгч, ажил эхлэх ёстой гэдгийг хэлье.

Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөлөө. 14 цагаас чуулганы хуралдаан үргэлжилнэ.

12.56 цаг

2025 оны 9 дүгээр сарын 17, Лхагва гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 05 минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа үдээс хойших хуралдааныг даргалав.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы үдээс хойших хуралдаан эхэлж байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг өрнөж байгаа. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж байгаа. Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин.

Б.Түвшин: Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг эрье. Тэгэхлээр бид төсвийн хүрээний мэдэгдэл буюу нэг ёсондоо Монгол улсын 2026 онд барих төсвийн малгай, дээл, гадуур арьс бүрээсийг нь хэлэлцэж байна л даа. Тэгээд энэ төсвийн хүрээний мэдэгдэл өөрөө төсвөөсөө илүү чухал. Ирэх 3-аас 5 жилийн эдийн засгийн прогнозыг гаргадаг. Тэгэхээр ийм чухал асуудлыг хэлэлцэхдээ нөгөө төсөвтөө, тэр тусмаа орон нутгийн төсөвтэй цуг хэлэлцчихлээр ихэнх хүмүүс ерөөсөө л нөгөө орон нутгийн төсөв, мөнгө таваарын тухай яриад эхэлдэг. Тэгэхлээр хөдөөгийн сонгогч ч гэсэн асууж л байна лээ. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл болон энэ төсвийнхөө том бодлогуудыг төсөв мөнгөтэй холбоотой асуудлаасаа тусдаа хэлэлцэж болох уу гэж асуулгасныг энэ дээр 1 дүгээрт асууя?

2 дугаарт энэ төсвийн хүрээний мэдэгдлийг ер нь төсвөөс нь тусдаа хэлэлцэж, ач холбогдол гаргаж тавихгүй бол төсвийн хүрээний мэдэгдэл чинь өөрөө бидний ирэх 3 жилийн эдийн засгийн хөгжлийн гол, гол бодлогууд байгаа шүү дээ. Энэ төсвийн хүрээний мэдэгдэлд ордог 9 үзүүлэлт буюу энэ Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ гэх мэтээр энэ 9 үзүүлэлт өөрөө ирээдүйн 3 жилийг гаргана.

Тэгэхээр 3 дахь асуулт болохлоороо энэ өндөр хөгжилтэй орнуудад төсвийн хүрээний мэдэгдлийг гаргахдаа 15-аас 20 ийм үзүүлэлтүүдээр тал талаас нь хайрцаглаад гаргадаг. Бид өнөөдөр яг энэ 9 үзүүлэлтээрээ гаргаад ингээд нөгөө яг төсөвтөө тааруулаад баталдаг. Тэр ч утгаараа сүүлийн хэдэн жилүүдэд төсвийн хүрээний мэдэгдлээ яг төсөв хэлэлцэх болгондоо өөрчилдөг гэж яригдаад байгаа. Тэгэхлээр энэ чинь дунд хугацааны зорилго, чиглэлгүй болохоор төсөв өөрөө үр ашиггүй байх ийм үндэслэл болоод байгаа юм. Тэгэхлээр яг энэ төсвийг Эдийн засгийн хөгжлийн яамнаас ер нь цаашдаа энэ 15-аас 20 үзүүлэлтүүдээр гаргах, ялангуяа зарим нэг ийм чухал үзүүлэлтүүд байна л даа. Эдийн засгийн мөчлөгийн нөлөөг арилгасан төсвийн орлого, зарлагын тэнцэл гэж үзүүлэлт байна. Мэдрэмжийн шинжилгээний үр дүн, санхүүгийн эрсдэл, татварын бүтэц, улсын салбарын хөрөнгө оруулалтын дундаж өгөөж, нийгмийн салбаруудын зардлын хуваарилалт мэт ийм гол, гол чухал үзүүлэлтүүдийг оруулж төсвийн хүрээний мэдэгдэл буюу энэ ирэх 3, 5 жилээ, ирэх 3-аас 5 жилийнхээ эдийн засгийн үйл ажиллагааг төлөвлөх боломжтой байна уу? Одоо бол бид хөгжлийн болон эдийн засаг, санхүүгийн урт хугацааны, дунд төлөвлөлтийн бичиг баримт ч дутуу. Тэгээд ийм 9 үзүүлэлтэд дотор энэ төсвөө, төсвийн хүрээний мэдэгдлээ ярилцаад байна. Цаашдаа ер нь энэ чиглэлээр юу хийх вэ, ямархуу судалгаа хийж байна вэ гэдэг нэг асуулт байна?

4 дэх асуулт болохоор дотоодын нийт бүтээгдэхүүнийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 5,4 хувь, Засгийн газраас 5,7 хувь гэж оруулж ирсэн. Хэдийгээр 0,4

хувьтай бага, 0,3 хувьтай маш бага дүн юм шиг боловч энэ эдийн засагт нөлөөлөх.../минут дуусав/

Х.Булгантуяа: Түвшин гишүүн нэмээд нэг минут.

Б.Түвшин: Энэ Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн 0,3 хувь чинь 1 дүгээрт нэрлэсэн дүнгээрээ хэд болж байна, энэ зөрөөний учир шалтгаан нь юу вэ гэдгийг 1 дүгээрт тайлбарлаж өгөөч?

5 дугаарт мөчлөгийн нөлөөг салгасан тийм Дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцож гаргасан уу? Ер нь мөчлөгийн нөлөөгүйгээр ингэж цэвэрлэсэн байдлаар эдийн засгаа юу гэж харж байгаа вэ?

6 дугаарт мөчлөгийг, мөчлөг болж байна гээд байгаа эдийн засгийн мөчлөг. Тэгвэл энийг ямар шалгуур үзүүлэлтүүд, юугаар хэмжиж, ямар үр дүн гаргах вэ, ямар мөчлөгийн үр нөлөө гарна гэж хэн тодорхойлж гаргаад ингээд мөчлөгийн асуудал яриад байгаа вэ?

6 дугаарт ер нь энэ төлөвлөлтийг иргэдээсээ болон олон нийтээс санал авах нь зөв л дөө. Доороосоо санал авч байна. Гэхдээ яг энэ эдийн засгийг тодорхой хөгжлийн хөтөлбөр лүү, тодорхой чиглэл рүү чиглүүлэхийн тулд дээрээс төлөвлөж явахгүй бол доороос цуглуулсан мөнгөө тааруулж төсвийнхөө орлого, зарлага тэгээд энэ төсвийн.../минут дуусав/

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Түвшин гишүүний асуултад хариулъя.

Н.Учрал: Түвшин гишүүн яг бодит нөхцөл байдалтай холбоотой чухал асуултыг асуулаа. Тэр төсвийн хүрээний мэдэгдлийг хуулиараа хавар хэлэлцдэг. Ингээд төсвийг намар хэлэлцэх ийм хуультай. Ирэх жилээс хавар бид төсвийн хүрээний мэдэгдлийг батална. Энэ удаа нөгөө хавар батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэл дээр энэ 9 тоог оруулж ирэхдээ нөгөө голлох экспортын бүтээгдэхүүний үнийг өндөр тооцчихсон байсан, 80 доллараар гээд тооцчихсон. Тэгэхээр орлого буурч байгаагаар тоонууд дагаад өөрчлөгдөөд байгаа. Тэгэхээр тухайн үед Төсвийн тогтвортой байдлын хууль дээр хэрвээ бид ийм тооцож болшгүй, болзошгүй ийм асуудлууд үүсэх тохиолдолд буюу орлого, зарлагыг нэгэн зэрэг бууруулсан тохиолдолд төсвийн хүрээний мэдэгдэл дээр нөгөө 7.5 дахь заалтыг ашиглахгүй, хамаарахгүй гэдэг хуулийг хийсэн учраас энэ удаа төсвийн хүрээний мэдэгдэл төсөвтэй хамт орж ирж байгаа юм.

Тэрнээс биш ер нь хавар төсвийн хүрээний мэдэгдлээ батлаад, тэгээд түүндээ тохирсон төсвийг боловсруулаад 9 сарын 1-нд өргөн мэдүүлэх ийм хуультай. Тэгэхээр бид ирэх жилээс хавар төсвийн хүрээний мэдэгдлийг батлаад явна. Төсвийн тогтвортой байдлын хууль бол сайн хууль. Төсвийн тогтвортой байдлын хуулийг чанд мөрдөж явбал энэ мөчлөг сөрсөн бодлого яг тэр цаг хугацаандаа өөрөө хэрэгжээд л явна. Тийм учраас энэ Төсвийн тогтвортой байдлын хуулийг яг чанд барихгүй тохиолдлууд байснаас болоод яг энэ эдийн засаг тэлж байх үед бид хумьж хуримтлуулж чадаагүй. Тийм учраас одоо ингээд мөчлөг сөрсөн бодлого зөвхөн агшсан үед л хэрэгждэг, тэлсэн үед хэрэгждэггүй ийм байдлууд байна.

Ер нь үзүүлэлтүүдийг нэмж болно яг таны хэлж байгаагаар. Тэгэхээр гаднын олон улсуудад нөгөө зарлагаа салбараар нь гаргаад явдаг жишгүүд байдаг юм байна. Тэгэхээр хэрвээ хууль дээр бид энэ үзүүлэлтүүдийгээ нэмье, дээрээс нь энэ зарлагуудаа салбар салбараар нь гаргаад явъя гэдэг хуулийн өөрчлөлт хийвэл ер нь болно. Тийм учраас бид үүн дээр судалгаа хийлгэж байна. Дээрээс нь ер нь цаашдаа зарлагын реформ хийх чиглэл рүү явах ёстой. Тэгээд энэ одоогоор 9 үзүүлэлт байгаа ч гэсэн энэ 9 үзүүлэлт яг бариад явбал, дээрээс нь төсвийн тусгай шаардлагуудыг баримтлан явбал төсвийн сахилга бат, хариуцлага улам л нэмэгдэнэ гэж үзэж байгаа юм. Тэгэхээр бид чанд барих л хэрэгтэй.

Эдийн засгийн өсөлтийг 5,7 хувь болгож бууруулсан буюу үүн дээр яагаад ийм өөрчлөлтүүдийг хийв гэхээр, яаж хэмжив гэхээр Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг гаргахдаа уул уурхай, уул уурхайн бус гэж ангилаад нэгж хувиудаар нь тооцоолсон. Жишээ нь 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл дээр уул уурхай хэдэн нэгж хувь байх юм, уул уурхайн бус нь хэдэн нэгж хувь байх юм, дотор нь жишээ нь ХАА 9.4, уул уурхай 11.9, боловсруулах 6.7, цахилгаан, ус 8 гээд салбар болгоноор нь өсөлтөд үзүүлж байгаа нөлөөллөөр нь хэмжсэн. Түрүүн яагаад мөчлөг сөрсөн бодлого хэрэгжих гээд байна вэ гэж ярьж байна вэ гэхээр түрүүн хэлж байсан. Ер нь нийт ДНБ орлогын харьцаа бол 37 хувь болчихоод байгааг шатлалтай бууруулах ёстой. Дээрээс нь мөчлөг сөрсөн бодлого явуулна хэрэгжүүлнэ гэдэг өөрөө потенциал түвшин, өнөөдрийн гүйцэтгэл 2-ын харьцаа нөгөө хасах руугаа ороод эхлэх буюу одоогийн байдлаар нөгөө потенциал түвшин гүйцэтгэл 2 бараг тэг болох ийм хэмжээнд оччихсон дээрээ ингээд хэмжилт хийгээд үзэхээр ийм байдал руу шилжсэн. Тийм учраас бид энэ нь өөрөө тэгээс доошлоод эхэлбэл маш муу болно. Тэгээд ирэх жил сөрөг тал руугаа явах магадлал өндөр байгаа учраас энэ үед илүү.../минут дуусав/

Х.Булгантуяа: Түвшин гишүүн нэмж тодруулъя.

Б.Түвшин: Ер нь яах вэ мөчлөгийн гээд л бүгд л ярьж байгаа. Тэгэхлээр мөчлөггүй үеийн ДНБ хэд байх юм, мөчлөг яаж нөлөөлөөд тэгээд тэрийг бид яаж сөрөх юм гэдэг энэ эдийн засгийн бодлогууд гарах ёстой. Тэгэхлээр ер нь цаашдаа энэ төсвийн хүрээний мэдэгдэл чинь өөрөө ирэх 3-аас 5 жилийн бидний эдийн засгийн загвар үзүүлэлт мөн юм бол яалт ч үгүй энэ 15-аас 20 үзүүлэлтүүдийг оруулж ирэх хэрэгтэй. Энэ дээр судалгаа хийж байгаа юм байна. Би хавраас энэ тухай ярья. Энэ төсвийн хүрээний мэдэгдлээ бид тогтворгүй ингээд байнга өөрчлөөд байгаа нь өөрөө тэр судалгаа шинжилгээ дутагдсаных. Хэрвээ энэ 15-аас 20 үзүүлэлтээр гаргачихвал цаашдаа энэ хөдөлж байгаа буюу ямар нэгэн алдаа гаргаж байгаа дээрээ хариуцлага тооцох үндэслэл болно гэж ингэж үзэж байгаа учраас би Эдийн засгийн хөгжлийн сайдаас энийг асуугаад байгаа юм.

Тэнцвэржүүлсэн үнийг 133 доллароор тооцсон юм байна. Ер нь зах зээлийн үнэ 70 орчим доллар гэж харж байгаа. Тэгэхлээр энэ тэнцвэржүүлэлтийн үнийн орлогыг тооцсон энэ зөрөө хаанаас гарах вэ? Ер нь Тогтворжуулалтын санд мөнгө байгаа юу? Энэ орлогын.../минут дуусав/

Х.Булгантуяа: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Тэнцвэржүүлсэн үнэ нүүрсийг 133 гээд тооцоод илүү 133-аас давбал Тогтворжуулалтын санд орох ёстой. Гэсэн хэдий ч өнөөдөр яг бодит үнэ 70

доллар. Тэгээд тэнцвэржүүлсэн үнийг гаргах аргачлал нөгөө Валютын сангийн нөгөө түүхий эдийн статистикийн тухайн төсвийн жилийн өмнөх дараалсан 20, 19, 18 гээд жилүүдийг харьцуулаад ингээд гаргадаг дундаж үнэ. Тэгэхээр нөгөө ковидын үед нөгөө нүүрсний үнэ их өсчихсөн. Тэгэхээр энэ аргачлалынх нь дагуу л гаргаж байна гэсэн үг. Тэгээд энэ аргачлалаар нь бодохоор ингээд 133 гарч ирчхээд байгаа учраас Тогтворжуулалтын санд бараг эндээс хуримтлал үүснэ гэж бараг байхгүй болчихоод байна л даа. Тэгэхээр тийм. Гэтэл зэс дээр харин тэнцвэржүүлсэн үнэ бага гарч байгаа. Тэгэхээр бид зэсээс Тогтворжуулалтын сан руу хуримтлал үүсгэх бололцоо байна гэж харж байгаа. Тэгээд ер нь эдийн засгийн идэвхжил суларч байгаа дээр энэ импортын, импортод эзэлж байгаа аж үйлдвэрийн орц, материалын импортууд буурч байна.../минут дуусав/

Х.Булгантуяа: Учрал сайд нэмж нэг минут.

Н.Учрал: Тэгэхээр энэ эдийн засгийн идэвхжил суларч байгаа дээр аж үйлдвэрийн орц, материалын импорт буурч байгааг юугаар жишээ нь хэлж болох вэ гэхээр Тяньжиний боомтод гэхэд энгийн үед 3-аас 4 мянган чингэлэг л байдаг байсан одоо чинь тэнд чинь бараг 250 орчим л байна гэсэн үг шүү дээ. Тэр зайлшгүй, яалт ч үгүй л ингээд бууж байна. Тэгэхээр дээрээс нь энэ нийт эрэлтийнх нь 60 хувийг бүрдүүлдэг өрхийн хэрэглээ дагаад их хумигдсан. Тийм учраас бид энэ алдагдал тодорхой хэмжээнд тавьж, энэ мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж байгаа нь өсөлтийг дэмжсэн төслүүдээ дэмжинэ л гэсэн ийм санаа л даа. Жишээ нь газрын тосны боловсруулах үйлдвэр, тэр Эрдэнэбүрэн УЦС эд нар гээд илүү эрэлтийгээ дэмжиж байгаа. Тэгж байж л цаашдаа мөчлөг сөрсөн энэ бодлого эдийн засгийг тогтворжуулна л гэж ингэж харж байгаа. Тэгээд тэр зарлагын реформ, судалгаан дээр тантай хамтарч ажиллая.

Х.Булгантуяа: Түвшин гишүүний ярьж байгаа их чухал юм. Сая 2025 оны 7 сарын 5-нд Улсын Их Хурлаар 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсвийн төсөөллийг батлуулсан. Тэгээд 2 сарын дараагаар дахиад Улсын Их Хуралд ороод хэлэлцүүлээд явж байгаа. Өөрөөр хэлбэл уг нь бид Эдийн засаг, хөгжлийн яам тэр тусмаа байгуулагдаад эдийн засгийнхаа төлөвлөлтийг бид илүү сайн хийдэг болоод ингэж жилд 2 удаа төсвийн хүрээгээ дахин, дахин хэлэлцээд байдаггүйгээр хавар нь төсвийн хүрээг нь баталж өгөөд л, тэр орлоготой, тэр зарлагатай, тэр хэмжээндээ Засгийн газар нь төлөвлөөд л намар нь өргөн барьдаг байх зарчмыг нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа ягштал хэр хэрэгжүүлснээ гээд л ингээд уг нь байгуулсан. Тэгээд л хавар яг төсөвтэйгөө нийлүүлээд оруулаад ирэхээр зарим гишүүд нь тойргийнхоо сургууль, цэцэрлэг тулгамдсан асуудлуудаа ярилгүй яах вэ. Ингээд нийлүүлээд яриад ач холбогдол нь буурчхаад байгаа юм л даа. Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл.

О.Алтангэрэл: Өнөөдөр бид төсвийн хүрээ ярьж байна. Үндсэндээ сүүлийн 10 жил Монгол Улс энэ 2012-оос 2016 оны Зандаахүүгийн Энхболд даргатай парламентын Монгол Улсад авч үлдсэн энэ Тавантолгойн бүлэг ордоор, ордын орлогоор амьдарч байна. Энэ төсвийн хүрээний мэдэгдлийг харахаар төлбөрийн тэнцэл эхний 6 сард 462 сая ам.долларын алдагдалтай байгаа юм байна. Валютын нөөц 304 сая ам.доллараар багассан байна. Энэ чинь юу гэсэн үг вэ гэвэл доллар өснө, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өснө, ард түмний амьдрал хүндэрнэ гэсэн үг. Тэгэхлээр ирэх жил энэ төсвийн, энэ төлбөрийнхөө тэнцэлд ер нь яаж анхаарах гээд байгаа юм бэ? Тухайлбал дөнгөж сая би Тавантолгойн бүлэг

ордыг дурдлаа.Тавантолгойн бүлэг ордын лицензийн талбайн 4,1 хувийг эзэлдэг мөртөө хүрэн нүүрсний 8 хувь, коксжих нүүрсний 9 хувь, нийт баталгаатай А нөөцийн 32-оос 34 хувийн нөөцийг эзэмшиж байгаа Ухаа худгийн орд тэнд үйл ажиллагаа явуулж байгаа Энержи Ресурс компани. Энэ компанийн гадаадад зарж борлуулж байгаа нүүрсний орлого нь Монгол Улсын төлбөрийн тэнцэлд ер нь нөлөөлж байна уу, үгүй юү? Энэ төлбөрийн тэнцлээ эерэг болгох дээр өөр ямар нэг арга хэмжээ авах юм уу, үгүй юү 1 дүгээр асуулт?

2 дахь асуулт уржигдар Лондонд энэ Оюу толгойн Арбитрын шүүх хурал эхэллээ л дээ. Ковидын үед үндсэндээ 1 их наяд гаруй төгрөгийг нь аваад тараачихсан. Одоо ингээд шүүх хурал нь явж байна. Үндсэндээ шүүх хурлын явцад нотлогдсон цугларсан нотлох баримт бүх зүйлээс энэ гэрээ ерөөсөө Монгол Улсад асар их алдагдалтай болсон юм байна гэдэг тодорхой болчихсон. Манай Сайнхүүгийн Ганбаатар гишүүний 20 жил ярьсан зүйл үнэн болох нь нотлогдчихсон ийм байгаа. Тэгэхлээр хэрвээ энэ арбитрын шийдвэр Монголын талд ашиггүйгээр гарвал энэ төсөвт чинь яаж нөлөөлөх юм бэ, энэ талын тооцоолол байгаа юм уу? Манай Жавхлан сайд санаачилга гаргаад ажлын хэсэгт урьдчилаад энэ асуудлыг шийдвэрлэх тал дээр нэлээд олон алхам төлөвлөөд явж байсан. Харамсалтай нь энэ арбитрын хуралдаа тулаад маргаандаа тулчихлаа. Энэ асуудлыг урьдчилж ярьж байсан энэ арга хэмжээнүүдээ бидний үед ажлын хэсэг байгуулаад явж байсан арга хэмжээнүүдээ авч хэрэгжүүлж болохгүй байсан юм уу?

Ингээд нэгэнтээ арбитрын шүүхийн шийдвэр ингээд эсрэг талд Риогийн санаснаар Монголын татварын байгууллагын тавьсан тэр татварыг төлөх үндэслэлгүй гээд гарчихвал цаашдаа энэ төсөвт чинь ер нь яаж нөлөөлөх энэ тооцоо байна уу? Дээрээс нь Оюу толгойн мөнгийг Монголын банкаар дамжуулдаг больё гэж олон жил яриа хэлэлцээр.../минут дуусав/

Х.Булгантуяа: Алтангэрэл гишүүнд нэг минут.

О.Алтангэрэл: Энэ олон жил Оюу толгойн мөнгийг Монголын банкаар оруулъя гэдэг чинь ерөөсөө энэ төлбөрийн тэнцлийг л сайжруулах гээд байсан зүйл шүү дээ. Энэ зорилт маань мартагдсан уу, ерөөсөө ярихаа больчихсон уу, бид буугаад өгчихсөн үү? Ер нь цаашдаа энэ төлбөрийн тэнцлээ сайжруулахдаа ямар арга хэмжээ авах вэ гэсэн эдгээр асуултуудад хариулт өгнө үү?

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Төлбөрийн тэнцэл алдагдалтай байна гэдэг мэдээж валютын нөөц бууруулахыг л илэрхийлж байгаа. Тэгэхээр төлбөрийн тэнцлийн алдагдал мэдээж зөвхөн манайхаас гэлтгүй дэлхийн зах зээл дэх нүүрс, төмрийн үнэ буурсантай холбоотой болж байгаа мэдээлэл. Яах вэ хамгийн сүүлд авсан мэдээлэл буюу 25 оны 7 дугаар сарын байдлаар төлбөрийн тэнцэл 284 сая ам.долларын алдагдалтай байгаа. Тэгэхээр Засгийн газрын зүгээс энэ төлбөрийн тэнцлийг бууруулах үүднээс Алтангэрэл сайд бидний үед Сангийн сайдын ахалж байсан энэ экспортыг нэмэгдүүлэх ажлын хэсэг ажиллаж байгаа. Тэгэхээр энэ ажлын хэсгийг өнгөрсөн хугацаанд ажиллуулж энэ экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр зохих шийдвэрүүдийг гаргасан. Өнөөдөр урсгал тэнцэл 7 сарын байдлаар бараг 1,9 тэрбум долларын алдагдалд хүрчихсэн. Цаашдаа бид хэрхэн энэ валютын нөөцөө хадгалах вэ, энэ бууруулахаас сэргийлэх вэ гэдэг хамгийн их чухал.

Тэгээд үүнийг хийхийн тулд мэдээж нүүрсээ бид биржээр арилжаалах хэрэгтэй. Биржээ сайн дэмжих хэрэгтэй. Зэс, төмөр, алт гээд үнэ нь өсөж байгаа, хүлээлттэй байгаа энэ бүтээгдэхүүнүүдийг экспортлох чиглэл рүү хандуулна. Мэдээж бусад газрын ховрыг ашиглах чиглэлээр арга хэмжээнүүдийг авч байна. Тэгээд өмнөх Засгийн газрын үед хийж байсан, хэрэгжүүлж байсан ажил үргэлжилж байгаа. Ер нь Биржийн хуулийг бид ягштал мөрдөх л ёстой. Тийм учраас Биржийн хуулиа ягштал мөрдөнө, дээрээс нь мэдээж энэ валютын нөөцөө хадгалахын тулд зайлшгүй 2 дахь арга бол гадаадын хөрөнгө оруулалт. Тэгээд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг legal info дээр тавьсан. Үүнтэй холбогдуулаад Эдийн засгийн эрх чөлөөний хууль бас олон нийтээр хэлэлцүүлэг явуулж байна. Ингээд Их Хуралд оруулж ирээд гадаадын хөрөнгө оруулалтаа батлаад, арга механизмыг нь тодорхой болгоод, хөрөнгө оруулагчдаа хамгаалдаг, хөрөнгө оруулагчдынхаа эрх ашгийг зөрчихгүй байх чиглэлээр ажиллах ёстой. Ингэж байж л энэ цаашдаа энэ төлбөрийн тэнцлээ сайжруулж явах нь дамжиггүй. Тийм учраас бид их олон жил ярилаа Гадаадын хөрөнгө оруулалтын хуулиа гаргая гэж. Тэгэхээр энэ гадаадын хөрөнгө оруулалт дээр ямар нэгэн улс төржилтгүйгээр энэ хуулийг батлан гаргах ёстой, ингэж байж урагшилна.

Мэдээж энэ чинь экспорт дээр ч тэр, импорт дээр ч тэр Засгийн газрын зүгээс чөлөөт худалдаа хэлэлцээрүүдийг зөв явуулах чиглэлээр ажлуудыг өрнүүлж байна. Сая 200 сая хүнтэй зах зээл дээр бүтээгдэхүүнүүдээ гаргах, гаалийн тарифыг харилцан хөнгөлөх чиглэлээр Евроазитай гэрээнд гарын үсэг зурсан. Одоо 5 парламентаар орно. Дээрээс нь Японтой байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээрийг эргэж харж сайжруулах, зарим бүтээгдэхүүнүүдийг хасах, зарим бүтээгдэхүүнүүдийг нэмэх ийм шаардлагатай ажлууд биднийг хүлээж байна. Мөн боловсруулах үйлдвэрүүдээ дэмжихээс өөр арга зам байхгүй. Тийм учраас гангийн үйлдвэр, энэ зэс боловсруулах үйлдвэр, алт цэвэршүүлэх үйлдвэр гээд энэ боловсруулах үйлдвэрүүдээ дэмжих чиглэл рүү анхаарлаа хандуулаад ажлуудыг нь хариуцаад явж байна. Мөн энэ төлбөрийн тэнцэл сайжруулах дээр экспорт, импорт дээр шаардлагатай богино хугацаанд хийж хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг шатлалтай хийгээд явж байгаа. Баялгийн сан дээр өнгөрсөн хугацаанд хийгдэж байсан ажлууд үргэлжилж, Бямбацогт сайд энэ хэлэлцээрүүдийг ахлаад ажлуудыг явуулж байгаа. Тэр Ухаа худгийн асуудал дээр ч гэсэн хэлэлцээр эхэлж байгаа гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Алтангэрэл сайдын асуултад хариулъя. Оюу толгойн хувьд хангалттай манай төлбөрийн тэнцэл мөнгөний урсгал дээр орж ирдэггүй юм. Өмнө нь нэг удаа энэ чинь 2010, өмнөх энэ ОУВС-ийн хөтөлбөрийн үед шүү дээ 17 оны үед нэг удаа тогтоол ороод бүх мөнгөн урсгал нь Монголын банкнуудаар, санхүүгийн байгууллагуудаар явуулъя гэдэг ийм заалт орсон боловч Их Хурал дээр дэмжигдээгүй гарчихсан. Тэрнээс хойш яг энэ хэвээрээ л яваад байгаа. Зөвхөн дотоодын хэрэгцээнийхээ цалин хөлс, дотоодын худалдан авалтад шаардлагатай мөнгө нь улирлаар, сараар орж ирээд, тэр нь мэдээж төлбөрийн тэнцэл дээр тусгагдана. Тэгэхдээ уг нь шаардлагатай бүх борлуулалтын орлого нь манайхаар явдаг бол.../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайдад нэмж нэг минут өгье.

Б.Жавхлан: Мэдээж төлбөрийн тэнцэл дээр хангалттай бидэнд хэрэгтэй л юм орж ирнэ л дээ, харамсалтай нь тэгж явахгүй байгаа Оюу толгойн хувьд. Арбитрын шүүх маань нэлээн ойртчихлоо. Бид мэдээж муу scenario-аар тооцож байх ёстой. Тэгэхээр 1 их наяд 57 тэрбум төгрөгийн татварын өр нь, төлбөр нь орж ирээд манай төсөв дээр орж ирээд тэр нь төрийн сангаар дамжигдаад ингээд зарцуулагдаад явчихсан байгаа. Хэрвээ муугаар бодоод нөгөө талд гарвал энэ өр төлбөрийг бид буцааж төлөх ёстой, буцааж төлөх ёстой ийм л эрсдэл ирнэ. Ухаа худгийн хувьд тэр мөнгөн урсгал юмыг нь би сайн хэлж мэдэхгүй байна. Энэ дээр одоо хэлэлцээр хийж байгаа асуудлууд, Дамдинням сайд тэр талаар мэдэж байгаа зүйл байна уу?

Х.Булгантуяа: Дамдинням сайд, Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Стратегийн 2007 онд батлагдсан ордууд дээр төрийн эзэмшлийн хувь хэмжээ тогтоох, эсхүл түүнийг АМНАТ-өөр орлуулах асуудлыг шийдэх бүрэн эрх Их Хуралд байгаа. Засгийн газарт тодорхой чиглэл өгсөн. Үүний дагуу Засгийн газар ажиллаж байгаа. Энэ хүрээнд Орано майнинг компанитай Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдсан. Бусад ордууд дээр бид зэс, Эрдэнэтийн зэсийн овоолго дээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудтай хэлцэл хийх ажил эхэлсэн явж байгаа. Маргааш энэ нүүрсний Тавантолгойн бүлэг орд, Нарийн сухайтын бүлэг орд, үүнтэй холбоотой стратегийн орд эзэмшиж байгаа, ашиглаж байгаа компаниудтай хэлцэл хийх ажлыг маргааш бид хэлцэлд урьсан байгаа. Энэ ажил удахгүй эхэлнэ. Энэ хүрээндээ үндсэндээ бид 34 хувиа төр эзэмших үү, эсхүл Ашигт малтмалын.../минут дуусав/

Х.Булгантуяа: Бямбацогт сайд нэмж хариулъя.

С.Бямбацогт: Тэгэхээр стратегийн ордын 34 хувийг төрд авах, эсхүл ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах, ингэснээр Үндэсний баялгийн сан өсгөж арвижуулах, үүнтэй холбоотой ард иргэд маань байгалийн баялгийнхаа өгөөжийг хүртэх Үндсэн хуулийн заалтыг амилуулж хэрэгжүүлэх энэ бодлогыг өмнөх Засгийн газрын үед явуулж байсан. Одоо ч яг энэ бодлогыг үргэлжлүүлж байгаа. Нэлээн эрчимтэй ажиллахаар энэ ондоо багтаагаад тодорхой үр дүн гаргахаар бид ажиллаж байгаа. Тэгээд стратегийн ордуудын хил заагтай холбоотой асуудлаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг гарч ажиллаж байгаа. Энэ дээр Дамдинням сайд нэмэлт мэдээлэл өгөх.

Х.Булгантуяа: Дамдинням сайд нэмж хариулъя.

Г.Дамдинням: Би Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хамгийн сүүлд хийсэн 22 оны 6 дугаар сард хийсэн улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн буюу ТЭЗҮ-ийг Ухаа худаг уурхайн тухайд гаргаж өгье. Ухаа худгийн орд гэж байдаггүй, Тавантолгойн орд гэж байдаг. Нийт 34 жилийн хугацаанд ашиглагдах энэ уурхайгаас улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 10 их наяд 600 тэрбум төгрөг юм байна ТЭЗҮ-ээрээ тооцоолсон нь. Нийт борлуулалт нь 67 их наяд 626,7 тэрбум, ажлын байрны тоо 1900, жилд төсөвт оруулах орлого 313,5 тэрбум төгрөг тийм л. Тэгээд А зэрэглэлийн нөөц 479 сая тонн, Б зэрэглэлийнх 29,2 сая, Ц зэрэглэлийнх 68.5, А, Б, Ц гэдэг нь А нь хамгийн сайн судлагдаж баталгаажсан нөөц гэсэн үг.

Х.Булгантуяа: Алтангэрэл гишүүн нэмж тодруулъя.

О.Алтангэрэл: Энэ нөгөө төлбөрийн тэнцэл ярьж байгаа учраас би асуугаад байгаа юм л даа. Тэгээд түрүүнд нь Засгийн газраас байгуулагдсан ажлын хэсэг энэ Тавантолгойн орд газартай холбогдох бүх бичиг баримтуудыг цуглуулаад, шинжээчийн дүгнэлт гаргаад, холбогдох статистик тоо баримт мэдээллийг гаргаад гарын авлага хэвлүүлсэн бүх гишүүдэд тараасан. Мөн зарим нэг хэвлэл мэдээллийнхэнд өгсөн. Харамсалтай нь өнөөдөр энэ хүрээнд цугларсан баримтаар лицензийн талбай нь 4 хувь боловч хүрэн нүүрсний 8, коксжих нүүрсний 9 хувь, нийт баталгаажих сая Дамдинням сайдын хэлдэг А нөөцийн 32-оос 34 хувийг эзэмшдэг энэ талбай дээр үйл ажиллагаа явуулж байгаа компанийн орлого Монгол Улсын төлбөрийн тэнцэлд нөлөөлж байна уу, үгүй юу гэдгийг энэ танхимд хариулах хүн байхгүй байна шүү дээ. Тэгэхээр энэ асуудал дээр анхаармаар байна, энэ асуудлаа шийдвэрлэмээр байна шүү гэж захиж хэлье.

Х.Булгантуяа: Алтангэрэл гишүүн нэмж үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал.

Х.Баасанжаргал: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 3 асуулт байна. Тэгээд сайд нараас асуулт байна. 1 дүгээрт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн өгсөн дүгнэлт дээр 2 газар нийгмийн халамжийн зардлыг бууруулах талаар 2 газар дурдсан байгаа юм дүгнэлт хэсэгтээ. Энэ нийгмийн халамжийн зардлыг хэрхэн, ямар зарчмын хүрээнд бууруулах талаар тийм тодорхой санал байгаа юу? Ямар зүйлийг, ямар зарчмыг, ямар шалгуурыг санал болгож байгаа вэ гэсэн эхний асуулт байна?

2 дугаарт эдийн засгийн зах зээл дэх төрийн оролцоог бууруулах гэсэн байна. Гэхдээ яг аль салбар дээр мөн л адилхан ялгаа байхгүй ямар зарчим дээр, ямар бизнес дээр төр орох юм, ямар бизнес дээр төр орохгүй юм гэдэг хил хязгаар одоо болтол тодорхой болоогүй байгаа. Энэ дээр баримталж байгаа, баримтлах ёстой ямар нэгэн зарчим, баримтлах ёстой шалгуурууд гэж Засгийн газар санал болгож байгаа юу, тийм зүйл байгаа юу гэж асуух гэсэн юм. Энэ асуултыг мөн Эдийн засаг, хөгжлийн сайдаас мөн адилхан асуулт гэж ойлгоорой.

3 дугаарт төсвийн хөрөнгө оруулалтын хувьд төсвийн хөрөнгө оруулалтыг оновчтой байдлыг хангах гээд ийм чиглэлээр энэ дүгнэлт гарсан гэж байгаа юм. Гэхдээ харамсалтай нь би яг энэ хөрөнгө оруулалтын чиглэлээр оновчтой болгох тал дээр яг дүгнэлт хэсэг дээр олж харсангүй. Тэгэхээр яг энэ хэсэг дээр дүгнэлт хийв үү? Өнөөдөр Засгийн газраас барьж орж ирж байгаа төсвийн бодлогын яг энэ хөрөнгө оруулалтын хэсэг нь эдийн засаг болоод, нийгмийн үр өгөөжийг нь хэрхэн тооцсон юм бол? Түүнд үнэлэлт дүгнэлт өгч байгаа юу гэдэг ийм асуулт байна. Тэгээд эдийн засгийн үр өгөөжөөс гадна, нийгмийн үр өгөөж гэж асууж байгааг, зориуд онцолж асууж байгааг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн анхаараарай гэж хүсье.

4 дүгээрт боловсролын жил гэж зарласан ирэх жил. Гэхдээ төсөв дээр төсвийн хүрээний мэдэгдэл дээр энэ талаар ерөөсөө дурдаагүй байна. Тэгэхээр боловсролын төсөв дээр онцлох зүйл байна уу гэсэн ийм 4 асуулт Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асууя.

Сайд нараас түрүүн асуусан хөрөнгө оруулалтын бодлогоо энэ жил хэрхэн барьж орж ирж байгаа вэ? Ялангуяа дуусаагүй олон жил үргэлжилж байгаа барилга

байгууламж дээр ямар бодлого барьж байгаа вэ? Дуусах ёстой, 10 жил үргэлжилж байгаа, 7, 8 жил үргэлжилж байгаа ийм барилга байгууламжууд байгаа. Шинэ барилга байгууламжийг шийдвэрлэхдээ ямар шалгуурыг, ямар эрэмбийг гаргаж шийдсэн бэ гэдэг ийм хөрөнгө оруулалттай холбоотой нэг асуулт.

2 дугаарт боловсролын хөрөнгө оруулалттай холбоотой Наранбаяр сайд хариулах байх. Энэ жилийн онцлох бодлого юу вэ? Боловсролын жил гэж байгаа зарлаж байгаатай холбоотой. Зөвхөн сургууль барих тухай асуудлаас гадна боловсролын яг бодлого дээр гарч байгаа ямар ахиц байгаа вэ? Бодлогын ахиц гэж асуух гээд байгаа. Тэгээд яг үндсэндээ гадаадын зээл, тусламжаас зарцуулж байгаа хөрөнгө оруулалт, оруулж байгаа хөрөнгө оруулалтын дүнг гээд бидэнд танилцуулсан хувиар нь, нийт дүн хувиар нь харвал эрчим хүч, замыг хангах жил болсон юм биш үү?

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Нийгмийн халамжийн зардалд ДНБ-д эзлэх хувь хэмжээг жил бүр буулгах ийм зорилтыг тавьж байгаа, абсолют дүнг нь бууруулахгүй, зүгээр яг ковидын өмнө 2018, 2019 онуудад 2,1 хувь байсан халамжийн зардал 23 онд 3.7, 2024 онд 3 хувь болсон байдаг. Тэгэхээр 2026 онд бид энэ хувь хэмжээг 2.6, 2027-гоос 2020 оны төсвийн төсөөлөл дээр 2.4, 2028 онд 2,2 болгох ёстой ийм зорилт дэвшүүлсэн. Гэхдээ энэ халамжийн зардлыг бууруулж байгаа бол ажлын байрыг нэмэгдүүлэх ийм бодлогыг давхар хэрэгжүүлэх ёстой. Дээрээс нь энэ хувийн хэвшил дэх түрүүн би хэлсэн тэр тэнцвэржүүлсэн орлого, тэр GDP-ийн харьцаа өөрөө шат дараалалтай буураад 28 хувь руу очвол хувийн хэвшилд орон зай бий болно. Ингээд хувийн хэвшилд орон зай бий болгохын тулд салбаруудыг онцолж байгаа хөдөө аж ахуйн салбар, эрчим хүч, аялал жуулчлалын салбаруудыг илүү зах зээлийн зарчим руу шилжүүлнэ. Энэ бэлэн байдлын үнэлгээг нь хийж байгаад бид зах зээлийн шийд зарчим руу шилжүүлж чадвал энэ олон татааснуудыг буулгах ёстой.

Тэгээд түрүүн Сангийн сайдын мэдээлэлд гарч байгаа энэ төсвийг олон хуулиар хуваарилдаг байгаа асуудлуудыг шийдэхгүйгээр төсвийн хүрээг боловсруулаад, түүнд тохирсон төсөв боловсруулахад хуулиа барих зайлшгүй шаардлага үүсэж байгаа учраас төсөв оновчтой төлөвлөгдөхөд энэ их бэрхшээлтэй болж ирдэг. Ингээд хувийн хэвшилд орон зай бий болгох чиглэлээр Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хангаж ажиллана. Энэ хүрээнд өмнөх Засгийн газрын үед Хэрэг эрхлэхийн сайдын хувиар Төрийн өмчит компанийн хуулийг та бүхэнд орж хэлэлцэх эсэх талаар танилцуулга хийж байхдаа би дурдаж байсан. Төрийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулиар 8 дугаар зүйлд нь яг төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах 5-хан чиглэлийг л хуульчилж өгсөн. Энэнээс бусад тохиолдолд ТӨК байгуулахгүй. Үүнд нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулах бол ТӨК байгуулна. Үндэсний эдийн засгийн эрх ашиг сонирхлыг хангах зорилгоор стратегийн ач холбогдолтой салбарт, тодорхой салбарт зүй ёсны монопол үйл ажиллагаа явуулах үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой батлан хамгаалах, хил хамгаалах, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хууль болон олон улсын хувийн эрх зүйн гэрээнд заасны дагуу ТӨК байгуулахаас бусад тохиолдолд төрийн өмчийн компанийг байгуулахгүй гэдгийг хуулиар

хуульчилж өгсөн. Одоо энэ хууль анхны хэлэлцүүлэг явна. Батлагдсаны дараа энэ хуулийг манай улсад 21 аймагт бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Мөн төрийн өмчит компанийн асуудлыг Эдийн засгийн эрх чөлөөний хууль дээр агуулга концепцыг нь гаргаад, хувийн хэвшилтэй хэрхэн ажиллах, хувийн хэвшил дээр, хувийн хэвшлийн эрх зүйн байдлыг нь дордуулсан, баялаг бүтээгчдийн эрх зүйн байдлыг дордуулсан зохицуулалтуудыг хуулиар хийхгүй байх, no surprise гээд байгаа зарчим буюу тэр бизнесийн үйл ажиллагаанд гэнэтийн шийдвэр гаргадаг, хөрөнгө оруулагч нарыг үргээдэг энэ байдлыг таслан зогсоолгох чиглэлээр хэрвээ эрх зүйн байдалд нь халдсан зохицуулалт хийвэл жилийн өмнө заавал ашиг сонирхол нь зөрчигчид байгаа бүлгүүдийн саналуудыг тусгаж ингэж оруулдаг хуульд энэ саналуудыг тусгасан. Тэгэхээр Эдийн засгийн эрх чөлөөний хуулийн 110 хуулийн өөрчлөлт, Төрийн өмчит компанийн хууль батлагдсаны дараа бол хуулийн хуулиар хүлээсэн үүргээ улс орон даяар хэрэгжүүлнэ л гэж хэлье.

Х.Булгантуяа: Микрофон, ажлын хэсгийн 3 номерын микрофоноос индэр. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс.

Н.Ууганбаатар: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ууганбаатар байна. Тийм, манай дүгнэлт ерөнхийдөө жоохон товчхондуу гардаг. Тийм учраас түүн дээр их дэлгэрэнгүй тайлбар хийдэггүй. 2 дугаарт нь бодлогын шинжтэй зөвлөмжүүдийг энэ удаа нэг их тусгаагүй байгаа. Ерөнхийд нь тоймлоод хэлэхэд нийгмийн халамжийн зардлыг бууруулах гэдгийн цаана нь юу явж байгаа вэ гэхээр манай төсөв дотор байгаа урсгал зардал, түүн дотроо урсгал шилжүүлгийн өсөлт сүүлийн 5, 4, 5 жил маш эрчимтэй явсан байдаг. Энэ дээр энэ цаашаа үргэлжилбэл ер нь бид төсвийн тогтвортой байдалдаа эрсдэл учруулахуйц ийм дүр зураг харагдаж байна гэдэг иймэрхүү дүгнэлт явж байгаа. Манай нийгмийн халамжийн зардалтай холбоотойгоор хийсэн судалгаануудаас дүгнээд хэлэхэд ерөнхийд нь юу гэж хэлдэг вэ гэхээр бид өөрсдийнхөө орлогын түвшинтэй ижил түвшинтэй орнууд дотроо нийгмийн халамжаараа тэгш бус байдлыг арилгах, ядуурлыг арилгах тал дээр бараг лидер нь болчихсон байгаа. Тухайлбал энэ 2023 онд Дэлхийн банкнаас гаргасан нэг тайлан байгаа. Тэр тайлан дээр дунд орлоготой орнууд дотроо Монгол бол.../минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж микрофон өгье, 3 номер.

Н.Ууганбаатар: Жини коэффициентыг Монголын халамж, халамжийн систем 6 нэгж пойнтоор, 6 нэгжээр бууруулдаг орлогын тэгш байдлыг, ижил орлоготой орнуудын дундаж 3 орчим нэгж пойнт байдаг гэх мэтээр ингээд харьцуулалтуудыг хийчихсэн байгаа. Тэгэхээр ерөнхийдөө тэгш байдлыг хангах тал дээр нэлээн боломжийн ахиц дэвшил гарсан. Цааш нь яах ёстой вэ гэхээр энэ ахиц дэвшлийг хадгалж үлдээд, тэгээд үр ашгаа сайжруулах ёстой гэдэг иймэрхүү бодлогын чиглэл санал болгож байгаа юм. Тэгээд энэ чиглэлд ажиллавал зөв болов уу гэж бодож байна. Зах зээл дэх төрийн оролцоог хэрхэн бууруулах хил хязгаартай холбоотой асуудал нэлээн ерөнхий асуудал учраас товчхон хариулахад тун хэцүү. Төсвийн хөрөнгө оруулалтыг оновчтой байдлыг хэрхэн хангах тал дээр ОУВС-гаас гаргадаг аргачлал байгаа. Тэр аргачлалаар бид 16 онд нэг удаа, 22 онд байх бас нэг удаа аргачлалаар үнэлгээгээ хийлгэсэн. Тэгээд манай үнэлгээ юу гэж гардаг вэ гэхээр ерөнхийдөө дэд бүтцийн төслүүд дээр төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг 60 хувьтай гарч байна гэж хэлдэг. Тэгээд дүрэм журам.../минут дуусав/

Х.Булгантуяа: Боловсролын сайд Наранбаяр.

П.Наранбаяр: Баярлалаа. Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр боловсролын салбарыг дэмжих жил гэж зарлаад, энэ жилийн хүрээнд нийтдээ бид 117 сургууль, 73 цэцэрлэг, 32 дотуур байр, 220 орчим ийм төслийг санхүүжүүлж хөрөнгө оруулалт талаас нь дэмжиж байгаа юм. Энэ нь нэг, хэрвээ ингээд бид энийгээ бүрэн амжилттай хэрэгжүүлж чадвал ээлжийн коэффициентийг бууруулж, сургалтын чанарыг дээшлүүлэх ийм дорвитой алхам болох юм. 2 функтээр өснө гэсэн бидний тооцоо байгаа.

2 дугаарт нь та хэлж байна. Эрчим хүч, зам тавих энэ зардал чинь хамаагүй их хэвээрээ байна гээд. Энэ дээр бид хөрөнгө оруулалтыг энэ боловсролыг дэмжих жилийн хүрээнд Азийн хөгжлийн банкны зээлээр ингээд 540 орчим тэрбум төгрөгөөр ихэсгээгүй байсан энэ юу бол хөрөнгө оруулалт есөд байх байсан юм. Одоо бол яг энэ эрчим хүч, замын дараа 3 дугаарт орж ирж байгаа. Энэ нөгөө зам, эрчим хүч гэдэг өөрөө маш том, том төслүүд байдаг. Маш том.../минут дуусав/

Х.Булгантуяа: Наранбаяр сайдад нэмж микрофон өгье.

П.Наранбаяр: Маш том, том төслүүд, мөн томоохон ийм мега ийм юмнууд байдаг. Түүнийгээ дуусгахаар үргэлжлүүлэхээр тавихад л энэ төсөвт эзэлж байгаа хувь хэмжээ нь нэмэгдээд явчхаж байгаа гэдгийг та анзаарч байгаа байх. Ер нь бид энэ өмнөх онуудаасаа шилжээд удаашралтай байгаа барилгуудыг бүгдийг нь гүйцээх, хүүхдийн тооны өсөлт, газар зүйн их өгөгдөл, мэдээллийн системд суурилсан ийм хөрөнгө оруулалтын оновчтой төлөвлөлтийг л хэрэгжүүлж ингэж төлөвлөлтөө хийсэн байгаа.

Нөгөө талдаа энэ багшийнхаа цалин, хангамжийг дээшлүүлэх, нийгмийн хангамжийг дээшлүүлэхэд бид анхаарах ийм төсөв болох ёстой гэж үзэж байгаа. Энэ хүрээндээ 100 тэрбум төгрөгийг яг цалин, урсгал зардал дээр нь нэмүүлэхээр ингээд ярьсан байгаа. Гэхдээ энэ хангалтгүй. Цаашаа бид ярилцаад явахад төсвийн хүрээнд боломжууд яаж гарах нь вэ тэрийг харах ёстой гэж үзэж байгаа. Мөн энэ жилийнхээ хүрээнд бид сургалтын өмнөх, СӨБ-ынхоо хөтөлбөрийг дуусгасан. Одоо бага боловсролынхоо сургуулийн хөтөлбөрүүдийг гаргах энэ.../минут дуусав/

Х.Булгантуяа: Баасанжаргал гишүүн нэмж тодруулъя.

Х.Баасанжаргал: Учрал сайдаас энэ жил 2,6, дараа жил 2,4 функт болгож бууруулна гээд. Гол нь нөгөө энэ бууруулах бодлого нь өөрөө яг ямар зарчим барьж байгаа вэ л гэж, хэнийхийг бууруулах вэ, хэдэн хувиар бууруулъя гэж байгаа вэ л гэж илүү тодруулж асуугаад байгаа юм. Тэгэхгүй өмнө жилийнх шиг төрийн албан хаагчдыг нийтээр нь 9 хувь бууруул гээд тэгчихээр ингээд нөгөө салбар болгон харилцан адилгүй, ер нь маш их төвөгтэй, хүндрэлтэй байдал үүсгэж байгаа л даа. Тэгэхээр нийтээрээ 2,4 хувь гэдэг ч юм уу ийм нийтлэг бодлого барих нь өөрөө жаахан асуудал, алдаа гарах юм биш биз дээ гээд? Тэгээд бууруулахдаа яг ямар зарчим, ямар шалгуур, бодлого барих вэ л гэж асуугаад байгаа гэсэн үг.

Боловсролын сайдаас тодруулахад нөгөө сургууль, цэцэрлэг барихаас гадна бодлогын ямар өөрчлөлт гарах вэ л гэж тодруулаад байгаа юм. Мэдээж багшийн цалин хөлсний асуудлыг угаасаа шийдэх ёстой тодорхой хэмжээнд. Гэхдээ яг боловсролын салбар дээр барьж байгаа бодлого, их, дээд сургууль дээр барьж

байгаа бодлого, ерөнхий боловсрол дээр, цэцэрлэг дээр барьж байгаа бодлого дээр ямар ахиц дэвшил гарах вэ Боловсролын жил?

Х.Булгантуяа: Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр боловсролыг дэмжих жилийн хүрээнд түрүүнд хөрөнгө оруулалт, цалингийн асуудлыг ярилаа. Түүнээс гадна СӨБ дээр бид СӨБ-ынхоо хөтөлбөрийг шинэчилж байгаа. Одоо ингээд сургалтуудаа хийгээд энэ жилээс шинэ хөтөлбөрөө заагаад эхэлж байна. Энэ дээр гол нь хүүхдийг нийгэмшүүлэх асуудал, энэ чиглэлээр зөв хүн болгож хүмүүжих асуудал дээр, зүрх сэтгэлийн боловсролыг олгох асуудал дээр бид онцгой анхаарч байгаа. Энэ бас бага боловсролын хөтөлбөрийг шинэчлэх ийм жил болно. Энэ бага боловсролын хөтөлбөрийг шинэчлэхдээ бид л энэ СӨБ дээр тулгуурласан энэ шинэчлэлийг хийнэ. Үүн дээрээ бид Монгол хүнийг бий болгох, Монгол хүн болгож төлөвшүүлэн хүмүүжүүлэхэд онцгой анхаарах юм. Мөн өнөөдөр дэлхийд шаардаад байгаа ийм бусад чадварыг эзэмшүүлэхэд энэ бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэл чиглэх учиртай. Цаашдаа дээд боловсрол дээр бид.../минут дуусав/

Х.Булгантуяа: Баасанжаргал гишүүн нэмж тодруулъя.

Х.Баасанжаргал: Наранбаяр сайдаас тодруулаад байгаа нь энэ байхгүй юу. Боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийг хийнэ гээд энэ бол угаасаа Энх-Амгалан сайд байхдаа Боловсролын ерөнхий хууль батлагдаад өмнөх парламентын үед батлагдаад төлөвлөгөөнд тусгасан ажил, угаасаа хийгдэж явж байсан ажил. Харин ч энэ жил бүх боловсролын салбарынхаа хөтөлбөрийн шинэчлэлийг хийчихсэн байх ёстой. Харамсалтай нь одоо дөнгөж бага, дунд, СӨБ дээрээ л явж байгаа ийм ажил байгаад байгаа. Би Боловсролын яамны бодлогын хувьд асуугаад байгаа байхгүй юу. Цаашид яг энэ хэвээрээ явах юм уу? Дараагийн 10 жил энэ боловсрол дээрээ бид ямар ахиц дэвшил гаргах юм бэ, ямар үр дүн рүү чиглэх юм бэ? Их, дээд сургууль төгссөн хүүхдүүдийн ажилгүйдлийн түвшин өндөр хэвээрээ байгаад байна, мэргэжлээрээ ажиллахгүй хэвээрээ байгаад байна гэх мэтээр яг бодлогын түвшиндээ ямар ахиц дэвшил гаргах юм бэ гээд, хөтөлбөрийн агуулга асуугаагүй. Хөтөлбөрийн агуулга дээр та хариулахаас илүү Боловсролын ерөнхий газрын хариулах хариулт энэ бол гүйцэтгэх байгууллагын хариулт. Тэгэхээр бодлогын хувьд гэж асуугаад байгаа шүү дээ?

Х.Булгантуяа: Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ хөтөлбөрийн шинэчлэл том шинэчлэл шүү. Энэ чинь ер нь 12 жилийнхээ циклээр явдаг ийм шинэчлэл байгаа. Энэ ажлууд яг л төлөвлөсөн ёсоороо явж байна. Энэ ажил нийтдээ ер нь 3 жилийн хугацаанд хэрэгжинэ гэж харж байгаа. Бид энэ хөдөлмөрийн зах зээлийг энэ төгсөж байгаа их, дээд сургуульд бэлтгэгдэж байгаа энэ боловсон хүчнийг уялдуулах тал дээр ялангуяа мэргэжлийн боловсролыг дэмжсэн ийм бодлогуудыг хүчтэй явуулна. Элсэлтийг нь нэмж байна. Бид энэ жил 20 мянгатай байсан элсэлтийг 26 мянга руу тооцож оруулж ирж байгаа, хувьсах зардлыг тэгж тооцож оруулж ирж байна. Мэргэжлийн боловсрол дээр хосмог сургалтыг нэмж оруулж ирж байна. Энэ дээр зах зээлд хэрэгтэй яг инженер, техникийн ажилтнуудыг бэлдэхэд онцгой анхаарна. Их, дээд сургууль дээр бид босго оноог дээшлүүлэх бодлогыг барьж байгаа. Мөн гаднын их, дээд сургуулийн хөрөнгө оруулалтуудыг татах асуудлыг ярьж байна. Их,

дээд сургууль дээр сайн ийм чадварлаг ийм боловсон хүчнийг урьж татаж авч ажиллуулах ийм асуудлуудыг, ийм бодлогуудыг оруулж ирж байгаа.

Х.Булгантуяа: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Халамж хэт өндөр байх нь хөдөлмөр эрхлэлтэд сөрөг нөлөө үзүүлдэг. Тэгэхээр ер нь сая би хэлсэн үе шаттай энэ харьцааг ДНБ-д эзлэх хувь хэмжээг бууруулах ёстой. Яах вэ ковидын өмнө 2 хувьтай GDP-ийн 2 хувьтай байсан байна. Ковидын үед энэ халамжууд нэмэгдсэн. Энэнээс хойш бүтэн ингээд бууруулж чадахгүй яваад байгаа юм. Тийм учраас бид яг танд хэлснээр ингээд үе шаттай бууруулах бодлогуудыг барьж байгаа. Тэгээд тэр зорилгынхоо хүрээнд энэ Төрийн өмчит компанийн хууль, Эдийн засгийн эрх чөлөөний хуулиар төрийн оролцох салбар, оролцохгүй салбаруудыг ангилсан. Хөдөө аж ахуй, эрчим хүч, аялал жуулчлал гэдэг салбарыг зах зээлийн зарчим руу нь үе шаттайгаар шилжүүлнэ гэж зорьж байгаа. Зүгээр бид Эдийн засаг, хөгжлийн яам энэ төсвийн хүрээ хязгаараа гаргаад, үүндээ төлөвлөлт хийж байгаа шүү дээ. Тэгэхээр Хөдөлмөрийн яам энэ гол бодлогоо оруулж ирнэ.

Х.Булгантуяа: Учрал сайд танай яаман дээр Хүн амын хөгжлийн газар гэж бүүр тусгайлсан газартай. Танай яамны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тухай хууль дээр эрхлэх асуудлын хүрээнд байгаа. Өөрөөр хэлбэл Монголын хүн ам 6 настай, хэзээ, хэдэн хүүхэд 6 нас хүрч сургуульд орох нь вэ, хөдөлмөрийн насанд хэчнээн хүн хэдийд хүрэх нь вэ, хэдэн хүн тэтгэврийн насанд хүрэх нь вэ энэ бүх тооцооллуудыг уг нь нэгдсэн журмаар танай яам салбарын яамнуудынхаа уялдаа холбоог хангаж хийж байх чиг үүрэг байгаа шүү. Энэ ганцхан Наранбаяр сайдын ч буруу гэж хэлэхэд хэцүү. Нэг жилийн дотор энэ хүн хэдэн мянган сургууль, 100 сургууль барина гэж байхгүй шүү дээ угаасаа ойлгомжтой. Эрх биш 2, 3 жилийн өмнө бид хэчнээн хүүхэд 1 дүгээр ангид орох вэ гэдгийг нь тооцоолоод сууж байх ёстой. Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин.

Х.Тэмүүжин: Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотойгоор Дамдинням сайдаас нэг асуулт асуумаар байна. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл болон ирж байгаа төсөл, төсөв Монгол Улсын ирээдүйн 5 жилийн үйл явцыг ингээд төлөвлөх гэж оролдож байгаа. Бид нэг алдаан дээрээсээ сургамж аваад тэр алдаагаа зоригтой засчихдаг баймаар байгаа юм. Дамдинням сайд аа. Бид 2007 онд стратегийн орд гэдэг нэр томъёо ашиглаад буруу хаалга татаад, мухар гудамж руу орчихсон. Ер нь стратегийн бүтээгдэхүүнийхээ тухай одоо жоохон зоригтой яриад, энэ стратегийн орд гэдэг юмнаасаа болоод эдийн засаг дээр ямар үр дагавар гаргаад байгаа вэ гэхээр жоохон даацтай хөрөнгө оруулалт томтойгоор хариуцлагатай уул уурхай эрхлэх зорьж байгаа том ААН-үүд дээрээ бид үл ойлгогдох маш популизм дарамт гээд олон зүйлийг бий болгочоод яг адилхан бүтээгдэхүүн гаргаж байгаа боловч жижиг ордууд дээр хариуцлагагүй уул уурхай, татвар болон янз бүрийн зүйлээс займчдаг тийм дээрмийн маягийн бизнесийг ингээд өдөөчихсөн. Тэгэхээр энийгээ бид нэг зоригтой шийдээд, энэ нэг стратегийн орд гэж бараг дэлхийд байхгүй энэ нэр томъёонуудаа нэг болиод, Монгол Улсын хувьд стратегийн бүтээгдэхүүн гэж яг юу юм, юу байх ёстой юм гэдгээ нэг тодорхой гаргаж өгмөөр байна.

Тэгвэл дараагийн төрийн оролцоог ч гэсэн ярихад илүү цэгцтэй болох гээд байна. Тухайлбал уул уурхайн бүтээгдэхүүн тэр дундаа стратегийн бүтээгдэхүүнээс бусад энэ бизнес эрхлэгчдээ татварын дарамтаас гаргамаар байна. Энэ Засгийн

газар НӨАТ-ын 10 хувийг буцаан олголтыг 5 хувь болгоё гэж санал гаргаж байх шиг байна лээ. Яг бизнес эрхэлж байгаа хүмүүс дээрх татварын дарамт болон энэ ачаалал чинь хэтэрхий их байгаа. Ажлын байр нэмж чадахгүй байгаа, эдийн засгийг тэлж чадахгүй байгаа. Тэгэхээр энэ НӨАТ-аа 5 хувь руугаа оруулчхаж болдоггүй юм уу? Буцаан олголт нь 2 хувиараа л байж байдаг юм байгаа биз. Энэ Пүрэвдорж гишүүний болон бусад гишүүний санаачилсан нэг хууль энд гацаад л зогсоод байх юм. Засгийн газар энэ дээр нэг зоригтой шийдвэр хийж болдоггүй юм уу? Түвшин гишүүн болон бусад гишүүний өргөн барьсан нийгмийн даатгалтай холбоотой, даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал байна. Яг үндсэндээ бизнес эрхлэгчдийг сөхрүүлж байгаа энэ 2 юм чинь энэ шүү дээ. Хувь хүнийх нь төлөх төлбөртэй холбоотой асуудлыг яаж шийдэх юм, ААН-үүд ийм дарамт дотор байх юм уу, үгүй юм уу гэдэг дээр зоригтой шийдэл гаргамаар байна.

3-д нь ер нь шинэ Ерөнхий сайд ч гэсэн хэлээд л байсан. Хувийн хэвшилтэй өрсөлддөг төрийн бизнес эрхэлдэг ийм, төр өөрөө хувийн хэвшилтэй өрсөлдөгч байдаг энийг зогсооно л гэж хэлсэн. Одоо энэ ТӨК-уд тэр дундаа бизнес эрхлэгчдийн хийж чадаж байгаа ажил дээр бөөн мөнгө, хүн, үйл ажиллагаа ингээд овоолчихсон байгаа, энийгээ татан буулгаад эндээс орох.../минут дуусав/

Х.Булгантуяа: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Тэмүүжин гишүүнтэй 100-аас дээш хувийн хувь байдаг санал нэг байна. Улс орнууд стратегийн бүтээгдэхүүн гэж зарладаг Европын холбоо, АНУ, БНХАУ гээд томоохон улс орнууд стратегийн бүтээгдэхүүнүүдээ зарлаж байгаа. Стратегийн бүтээгдэхүүн гэдэг зөвхөн газрын ховор элементийг тооцдоггүй. Тухайн улс орны эдийн засагт том хэмжээний хувь нэмэр оруулж байгаа бүтээгдэхүүнүүдээр нь зарлаж явдаг. Манай улс стратегийн орд гээд Үндсэн хууль руугаа ингээд хийгээд, тэрийгээ ингээд бид гацаалтад оруулчихсан. Яаж гацаалтад оруулчхаад байгаа вэ гэвэл стратегийн орд гэдэг нэр өгчихөөр одоо хайгуул, судалгааны ажлыг хувийн хэвслүүд явуулж чадахаа байчихсан айгаад. Жоохон хайгуул, судалгааны ажил хийгээд дараачийн Оюу толгойн, Тавантолгойг бий болгоно гээд явахаараа улс дээрэмдэнэ чинь 51 хувийг нь авчихна, 34 хувийг нь авчихна гэдэг айдастай байгаа учраас хайгуул, судалгааныхаа тайланг өгөхөө больчихоод байгаа юм.

Ийм учраас том хэмжээний хөрөнгө оруулалт орж ирэхээ больчихоод байгаа юм. Яг одоогийн байгаа байдлаараа бид харж чадвал, одоогийн байгаа байдлаараа үргэлжилбэл бидэнд дараачийн Оюу толгой, Тавантолгой гарч ирэхгүй. Яагаад гэвэл компаниуд тайлангуудаа өгөхгүй гэсэн үг. Тэгэхээр энэ Тэмүүжин гишүүнтэй санал нэг байна. Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг удахгүй Засгийн газраас оруулж ирнэ, манай яаман дээр бэлтгэгдэж байна, олон нийтийн хэлэлцүүлгийг удахгүй эхлүүлнэ. Энд стратегийн орд, стратегийн бүтээгдэхүүн гэдэг юмаа нэг ойлгомжтойгоор тодорхойлоод, тэгээд том биетэй бол чамаас авна гэж дайраад байхаасаа илүүтэй бүгдээрээ л байгалийн заяагдмал нөөц ашиглаж байгаа учраас, бүгдээрээ заяагдмал нөөцөө ашиглаж байгаа учраас тэр заяагдмал нөөцөөсөө Баялгийн сангийн тусгай Амнат авъя. Ингэвэл том, жижиггүй бүгдээрээ Баялгийн сангийн хувь нэмэр оруулагч болж хувирна.

Одоо хууль юу байгаа вэ гэхээр чи том биетэй учраас чамаас татвар илүү авна, чи жижиг биетэй учраас чамаас татвар авахгүй гэдэг ийм л бодлого явж байгаа. Тэгэхээр одоо бол бид том, жижиггүй нэгэнт энэ байгалийн заяагдмал

нөөцөөсөө баялгийн сангийн Амнат авдаг больё, ингэвэл Амнатын хэмжээ буюу баялгийн сангийн хэмжээ хэд дахин том болно. Энэнээсээ ард иргэддээ шууд олгодог энэ зохицуулалт руугаа явъя гэдэг ийм л концепцыг бид бариад явж байна.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Би хариулах нь. Тэмүүжин гишүүний асуултад хариулъя. Тэмүүжин гишүүний зарчмын суурь асуудал дээр мэдээж бүгдээрээ л санал нийлж байна. Ер нь татварын дарамтыг аль болох бууруулъя, хамгийн оновчтой байдлаар явуулъя. Гэхдээ бид харин ямар хувилбараар, ямар арга замаар явах вэ гэдгийг энэ их зөв сонголтоо л хийх хэрэгтэй. Нөгөө нүдийг нь ухаж байгаад ингээд сохолчих вий. Тэгэхээр энэ НӨАТ дээр ийм юм байгаа юм 10-ыг 5 болгох уу, эсвэл 2-ыг 5 болгох уу гэдэг дээр бид 2-ыг 5 болгоё. Тэгэхдээ прогрессив шинжтэй сая төгрөг хүртэлх гэдэг ийм замаа сонгосон. Яагаад 10-ыг 5 болгоогүй вэ гэдэг дээр би нэг товчхон 3 үндэслэл хэлье. 1 дүгээрт, НӨАТ өөрөө ийм регрессив шинжтэй ийм татвар байдаг. Өөрөөр хэлбэл Сайнзориг гишүүнээ, би Тэмүүжин гишүүний асуултад хариулаад байгаа юм. НӨАТ-ыг, НӨАТ-ын орлого 8 их наяд болж ирж байгаа. 10-ыг 5 болгочихоор шууд 4 их наяд болно гэсэн үг. 4 их наяд.../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайдын микрофоныг нэмж өгье.

Б.Жавхлан: Тэгэхээр энэ 4 их наяд ингээд иргэдийн гар дээр үлдэхээр ерөөсөө нийт иргэдийн НӨАТ бичүүлж байгаа иргэдийн 25 хувь дээр 3 их наяд нь очно. 1 их наяд нь 75 хувь дээр очно. Тэгэхээр нөгөө орлогын тэгш бус байдлыг улам гааруулна гэсэн үг 1 дүгээр тайлбар нь энэ.

2 дугаарт, НӨАТ маань өөрөө 8 их наяд, 30 их наядын 8 их наяд гэдэг бол энэ аль хэдийн төсвийн орлогын дархлаа болсон, хамгийн тогтвортой орлого байдаг. Бид ковидын үед хүнд үед НӨАТ-ын орлого л нэмэгдэж байсан, төлөвлөгөө нь биелэгдэж байсан, хамгийн тогтвортой орлого болж чаддаг. Ийм бүтэц болчихсон байгаа. Тэгэхээр энэ орлогыг бид огцом бууруулах нь өөрөө энэ төсөв талдаа маш эрсдэлтэй, маш өртөгтэй үнэтэй гэсэн үг.

3 дугаарт, И баримт дээр жишээ нь буцаалт нь 2 хувь, татвар нь өөрөө 5 хувь болчихоор нөгөө бүртгэлийн шинж чанар нь байхгүй болчихно. Нөгөө нэг И баримт бүртгүүлдэг хүмүүс чинь бүүр байхгүй болоод эхэлнэ. Арай хийж нөгөө 48 хувь дээр байсан.../минут дуусав/

Х.Булгантуяа: Тэмүүжин гишүүн нэмж тодруулъя.

Х.Тэмүүжин: Жавхлан сайдын хэлж байгаа 3 үндэслэл яг төрд биш, иргэнд ашигтай байж болох 3 үндэслэл байхгүй юу. Хамгийн тогтвортой төрийн орлого гэж. Энэ чинь иргэдийн халаасанд байгаа хамгийн найдвартай орлого нь байхгүй юу. Иргэдийнхээ халаасанд тэр мөнгийг үлдээчихвэл улс төрчийн төрийн гар харж дээшээ харж биш амьдралаа өөрсдөө шийдэх гэж оролдоно шүү дээ.

2-т нь дахиад энэ НӨАТ-тай холбоотой асуудлыг чинь дагаад хүний мөнгийг аваад дарга гар дээрээ шажигнуулах юм уу, эсхүл иргэд дараа дараагийнх нь бизнес рүү, хөрөнгө оруулалт руу, хүүхдийнхээ боловсрол руу, эрүүл мэнд рүүгээ мөнгөө хийх юм уу гэдэг сонголт. Тэгээд бид нэг ийм дарга тэдний өмнөөс сонгож

байх ёстой гэдэг философиосоо салмаар байгаа юм. Иргэд нэг сонголт хийх хэрэгтэй шүү дээ. Иргэд илүү хариуцлагатай тэр сонголтыг хийж чадна шүү дээ. Тийм учраас шударгаар ялгамжтай болж байгаа орлогыг бид засаж өгнө гэж ингэж.../минут дуусав/

Х.Булгантуяа: Тэмүүжин гишүүн үг хэллээ тийм ээ? Тийм, асуултаа арай амжсангүй. Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал.

О.Батнайрамдал: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Надад Дамдинням сайд, Жавхлан сайд, Бямбацогт сайдад асуулт байна. 2026 оны төсвийн хүрээ 27, 28 оны төсвийн төсөөллөө бид ямар ч байсан эдийн засгийн өсөлт 5,7-гоос 6,5 хувь байх нь гээд нэлээн өөдрөг төсөөлсөн байна. Энэ өөдрөг төсөөллийн ашигласан яг үндсэн таамаглалын нэг нь би Засгийн газрын танилцуулсан презентац дээрээс эш татаж байгаа шүү. Оюу толгой гүний уурхайн зэс, алтны агуулга сайжирна гэсэн байна. Оюу толгойн гүний уурхайн зэс, алтны агуулга сайжирна. Зэс, алтны Оюу толгойн зэс, алтны агуулга цэвэр зэсээр 22-оос 31 хувь хүртэл нэлээн огцом сайжирна гэсэн таамаглал дээр үндэслэж бид эдийн засгийн өсөлтөө 6,5 хувь гэж тооцоолсон байна. Оюу толгойн одоо явж байгаа далд уурхай болон ил уурхайн дундаж агуулга бол Онтрэ-г оруулахгүйгээр сайжрахгүй байгаа шүү.

Харин ч эсрэгээрээ буулттай. Тэгэхээр энэ дээр ямар таамаг дээрээ юу оруулсан байна гэхээрээ Онтрэ-гийн талбай руу олборлолт орно гэсэн агуулгаар нэг ёсондоо энэ таамаглал гарсан гэсэн үг. Онтрэ-гийн талбай одоо явж байгаа Оюу толгойн талбай 2-ын алт, зэсийн агуулга нь хоорондоо ялгаатай байхгүй юу. Алт, зэсийн агуулга Онтрэ-гийн талбай дээр ойролцоогоор 65-аас 76 хувиар илүү байдаг зэс, алтан дээр. Тэгэхээр энэ эдийн засгийн үндсэн таамаглалын нэг нь болохоор тэгэхээр бид Онтрэ-гийн талбай руу 2026 оноос олборлолт орж байж бид зэс, алтны агуулгаа сайжруулна гэсэн таамаг дээр бид эдийн засгийн тооцооллоо хийсэн байна. Тэгэхээр Дамдиннямаас, Дамдинням сайдаас асуумаар байгаа юм л даа. Одоо тэгэхээр бид Онтрэ дээр хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна гээд та ажлын хэсгийг ахалж байгаа. Тэгэхээр энэ асуудал хэрхэн явж байгаа вэ? Тэгэхээр бид Онтрэ дээр шинэ хөрөнгө оруулалтын гэрээ байгуулаад, олборлолт оруулж байж бид энэ төсвийн хүрээ дээрээ орсон эдийн засгийн өсөлтдөө хүрэх таамаглал нь бодитоор биелнэ гэсэн үг юм. Тэгэхээр хэрвээ энэ хөрөнгө оруулалтын гэрээг бид байгуулж чадахгүй бол тэгвэл төсвийн хүрээний таамаглал буруу болох гээд байна л даа.

2 дугаарт Жавхлан сайдаас асуух асуулт байгаа юм л даа. Өнөөдөр бид хэдэн ахмадын тэтгэвэр 6 хувиар нэмэгдүүлнэ гэж ярьж байна, тэгээд инфляцдаа ч яг хүрэхгүй л байгаа юм байна л даа. Тэгээд энэ дээр олон ахмадууд мессеж бичиж байна, уулзаад байна л даа. Ойролцоогоор 378 тэрбум төгрөг нэг ёсондоо бид тэтгэврээ 6 хувиар нэмэгдүүлэхэд зарцуулахаар тооцоололтой юм байна. 12 тэрбум долларын Оюу толгой дээр байгаа зээлийн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүд нь бид 11 хувиар хүү төлж байгаа тийм ээ, жил болгон хүү төлж байгаа гэсэн үг. Ойролцоогоор 1,3 тэрбум долларын хүү төлж байгаа.

Х.Булгантуяа: Батнайрамдал гишүүн үргэлжлээд нэг минут.

О.Батнайрамдал: Тэгэхээр бид цаашдаа энэ ахмадын тэтгэврээ хэрхэн нэмэх, тэгээд багш нарын цалин яригдана, эмч, ажилчдынхаа цалинг нэмэгдүүлэх, тэгэхээр бид төсвөөс гадуур бас төрийн өмчит компанийн ашигт ажиллагааг давхар

ярих хэрэгтэй. Тэд нарын ноогдол ашгийг бид хэрхэн наашлуулж авч энэ асуудлуудаа шийдэх вэ? Төсвийн бялуу томроход өөрөө орон зай багатайг ойлгож байна. Гэхдээ Оюу толгой дээр байгаа 12 тэрбум долларын хувь нийлүүлэгчдийн зээлийн 11 хувийн зээлийн хүүг 3 хувиар бууруулахад 1,4 их наяд төгрөг буюу ахмадын тэтгэврийг 22 хувиар нэмэх хэмжээний мөнгө яригдаж байгаа байхгүй юу. Өнөөдөр Засгийн газар 6,6 хувийн хүүтэй гаднаас зээл авах боломжтой, чадвартай мөртөө бид Оюу толгой Рио Тинто компанид 2 оронтой тоогоор 11 хувиар хүү төлж байгаа нь асуудалтай байгаад байна л даа. Энэ дээр өөрт гэрээгээр олгосон эрхээ хэрэгжүүлж бид энэ дээр зээлийн хүүг хугацаанд нь бууруулах уу?

Х.Булгантуяа: Сайдууд асуултад хамгийн эхний хүн 3 минут хариулаад, араас нь 1, 1 минут хариулаад байгаа байхгүй юу. Тэгэхээр эхний хүн их сайн хариулах хэрэгтэй байгаад байна шүү. Тэгэхгүй бол амжихгүй. Их олон хүмүүс ар араасаа богинохон, богинохон хариулах болчихоод байна. Дамдинням сайд.

Г.Дамдинням: Онтрэ-тэй холбоотой асуудлыг ажлын хэсгийг нь би ахлаад ажиллаж байна. Онтрэ компанийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлүүд дээр нийтдээ үйлдвэрлэлийн нөөц нь 812 сая тонн ба түүнд агуулагдах зэс нь 4,7 сая тонн, алт нь 275 тонн, мөнгө нь 1334 тонн, молибден нь 46 мянган тонн байна. Одоогийн үнийн жишгээр харьцуулж харвал борлуулалтын орлого 54 тэрбум ам.долларын тогтоогдсон нөөц, үйлдвэрлэлийн нөөц бидэнд байна гэсэн үг. Онтрэ-н эзэмшиж байгаа энэ талбайг Оюу толгой төслийн хүрээнд олборлолт хийвэл ашигтай. Оюу толгой төслийн хүрээнд олборлолт хийхгүй бол ашиггүй. Яагаад вэ гэвэл ийм орд газар байлаа гэхэд энэ гол агуулгатай бул нь энэ газрынхаа гүнд байгаад байгаа юм.

Манай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хувьд ОТ болон Онтрэ компанийн ТЭЗҮ-ийг шинэчилж хүлээж аваагүй байгаа. Тэгэхээр уулын ажлын төлөвлөлт хийгдээгүй гэсэн үг яг Онтрэ дээр. ОТ компани Онтрэ-тай гэрээ хийсэн гэдэг сураг байдаг 80:20-ийн харьцаатай. Би энэнд зарчмын хатуу байр суурьтай байгаа. Бид бизнес хийж байгаа хүмүүс оролцогч талуудаа хүндэтгэж, хамтарсан бизнес хийх ёстой. Монгол Улсын оролцоо заавал байх ёстой. Түүн дээрээ тулбал бид Монгол Улсыг хүндэтгэхгүй байгаа хүмүүстэй бизнес хийх ч зайлшгүй шаардлага байхгүй. Тэгэхээр энд шинэ хөрөнгө оруулалтын гэрээ Онтрэ-гийн хариуцаж байгаа талбайнууд дээр хийх үү, эсвэл яах вэ гэдгээ бид судлаад ярилцаж байна.

Улсын Их Хурал дээр байгуулагдчихсан сонсголын ажлын хэсгийг манай Батнайрамдал гишүүн ахалж байгаа. Батнайрамдал гишүүний сонсголын ажлын хэсгээс гарсан дүгнэлт тодорхой Байнгын хороогоор орж, эсвэл Их Хурлаар орж манай ажлын хэсэгт чиглэл өгвөл бид тэр хүрээнд нь ажиллаад явна гэж байгаа. Чиглэл өгөхгүй гэвэл бид хөрөнгө оруулалтын гэрээний хувилбаруудыг боловсруулж ажиллана гэсэн ийм бодолтой байна. Ний нуугүй хэлэхэд бид хэлэлцээр хийх зохион байгуулалтын ажлуудтай байгаа учраас нарийн тодорхой мэдээллүүдийг Их Хурал дээр нээлттэй ярих яг боломжгүй байна. Ер нь би зарчмын сая байр сууриа хэлчихлээ.

Х.Булгантуяа: Жавхлан сайд. Дараа нь Бямбацогт сайд хариулъя.

Б.Жавхлан: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Төрийн өмчийн компаниудын ноогдол ашиг болон бусад өгөөжүүдийг нэмэгдүүлэх нь номер нэг асуудал зөв. Гэхдээ энэ маань өөрөө хэд хэдэн ялгаатай сувгаар өгөөж нь төсөв

дээр ордог гэдгийг та сайн мэдэх байх гэж бодож байна. Ноогдол ашиг шууд баялгийн сан руу ордог, тэнцвэржүүлсэн тэнцэл рүү орохгүй, хуримтлалын сан руу шууд орно. Тэгэхээр тэтгэвэр нэмэх тийм эх үүсвэр болж чадахгүй гэсэн үг 1 дүгээрт. 2 дугаарт тэр Оюу толгойн доторх хувь нийлүүлэгчийн зээл тэр хүүгийн асуудлуудыг компани дээр буюу Бямбацогт сайд хариулах уу тийм ээ? Тэгье.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд нэмж хариулъя.

С.Бямбацогт: Энэ Оюу толгойтой холбоотой асуудал олон жил Монголчуудыг талцуулж хуваагдуулж, нэлээн л асуудалтай байж байгаа. Одоо ч гэсэн асуудалтай. Тэгээд ер нь Монголын Улсын Засгийн газар, Их Хурал нэг талдаа хамтарсан нэгдмэл байр суурьтай байж, энэ компанийг байранд нь тавих ёстой байх. Өнөөдөр ерөөсөө ингээд үйл ажиллагаа явуулж байгаа ТУЗ-ийн 9 гишүүнтэй, 9 гишүүнээс гуравхан нь Монголынх, зургаа нь Рио Тинто талаас байдаг. ТУЗ дээр ерөөсөө бүх асуудлаа олонхын саналаар хүч түрээд явчихдаг, Монгол Улсын эрх ашиг, Монголын ТУЗ-ийн Засгийн газрын байр суурийг сонсдоггүй. Үүнээсээ болоод үндсэндээ менежментийн баг нь хүртэл үндсэндээ Монгол Улсын Засгийн газар, ТУЗ-ийг сонсдоггүй ийм байдалтай үйл ажиллагаа явуулж байгаа. Тийм болохоор энэ ОТ төслийн хувьд, засаглалын хувьд шинэчлэл хийх энэ ТУЗ-ийн 3 гишүүнийг яаж хүчтэй болгох юм, энэ Засгийн газрын байр суурийг яаж ойлгодог болгох юм энэ талд бид анхаарах.../минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж нэг минут өгье.

С.Бямбацогт: Тэгээд энэ жил ч гэсэн нөгөө гэрээнд өөрчлөлт оруулах, 7 жилд нэг удаа гэрээнд өөрчлөлт оруулах ёстой, энэ хугацаа нь болсон. Энэ хугацаандаа багтааж гэрээнд өөрчлөлт оруулах талаар Улсын Их Хурлаас байгуулсан түр хороо, Засгийн газраас байгуулагдсан ажлын хэсэг идэвхтэй хамтарч ажиллаж, маш тодорхой үр дүн гаргах талаар анхаарахгүй бол ингээд үндсэндээ жил дуусах гэж байдаг. Гэтэл ахисан урагшилсан зүйл байхгүй байгаад байдаг. Энэ талаар нэг бүгдээрээ нэг байр суурьтай байж, тодорхой үр дүн гаргах хэрэгтэй байгаа юм. Тэгээд энэ тал дээр хамтарч ажиллахыг Их Хурлын гишүүн, манай Батнайрамдал гишүүн бол түр хорооны дарга хийж байгаа, Хянан шалгах түр хорооны дарга хийж байгаа. Энэ дээр бидэнтэй хамтарч ажиллах байх. Тэгээд хамтарч ажиллаж байж, хурдан хугацаанд, бодитой үр дүн гаргая. Олон жил ужгирсан энэ асуудал маргаанд цэг тавих цаг нь болсон гэж хэлье.

Х.Булгантуяа: Батнайрамдал гишүүн нэмж тодруулъя.

О.Батнайрамдал: Хянан шалгах түр хорооны хүрээнд 2 үндсэн л асуудал байгаа юм л даа. Нэгэнтээ бид Үндсэн хууль дээрээ стратегийн орд гэдэг концепц байгаа бол бид Үндсэн хуулийг хэрэгжүүлэх ёстой юм. Дургүй юм чинь хэрэгжүүлэхгүй гэж юм байхгүй шүү дээ. Онтрэ-гийн талбай стратегийн ач холбогдолтой ордын ОТ бүлэг ордын хил заагт албан ёсоор орсон л бол ОТ дээр тавьсан зарчим Онтрэ дээр үйлчлэх ёстой юм. Энэ гэрээг Монгол Улсын Засгийн газар ард түмнийг төлөөлж гүйцэтгэх засаглалын хувьд хийх ёстой. Энэ дээр Хянан шалгах түр хорооноос чиглэл өгнө гэсэн Хянан шалгах хуулийн гаргалгаа байхгүй шүү Дамдинням сайд аа. Та тэгэхээр биднийг хүлээхгүй шууд хэлэлцээртээ орох ёстой, цаг хугацаа байхгүй. Бид 12 сарын 31-нээр зээлийн хүү өөрсдийн гэрээгээр олгосон эрхээ хэрэгжүүлэх тэр хугацаа одоо дуусахад бидэнд 105 хоног л үлдээд байна л даа. Тийм учраас Сангийн сайд аа, би танаас асуугаад байгаа юм, 105

хоногийн дараа бидний энэ гэрээгээр олгосон эрх дуусах гээд байна. Энэ эрхээ Монгол Улсын эрх ашгийн төлөө.../минут дуусав/

Х.Булгантуяа: Батнайрамдал гишүүн үг хэллээ дээ. Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа.

А.Ариунзаяа: 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсвийн төсөөллийн тухай хуультай холбоотойгоор надад нэг асуулт байгаад байгаа юм. Энэ юу вэ гэхлээр уржигдар Улсын Их Хурлын чуулганы нээлтийн өдөр маш олон сэтгүүлчид Улсын Их Хурлын гишүүдээс энэ Монгол Хятадын Засгийн газрын хооронд байгуулсан хэлэлцээр Гашуунсухайт-Ганцмод боомтын асуудалтай холбоотойгоор маш олон асуултуудыг асуулаа. Энэ юутай холбоотой юм бэ гэхлээр энэ Улсын Их Хурлын гишүүд чинь улс орноо зарчихсан юм уу, 10 тэрбум долларын ашиг унагаасан ийм асуудал байна, нүүрсээ хэдэн төгрөгөөр, хэнд, хаана, яаж борлуулаад байгаа юм бэ гэдэг ийм асуудлыг ярьсан. Та нар ер нь мэдсэн юм уу Улсын Их Хурлын гишүүд ээ гэж. Тэгээд энэ юу болоод өнгөрчхөв гэхлээр Монгол Улсын 3 дахь Ерөнхийлөгч нийгэмд мэдээлэл хийгээд, энэхүү асуудлыг ярьж байгаа нь Засгийн газар хоорондын байгуулсан энэ гэрээн дээр Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүн ийм ойлголттой байхад албан ёсны байр суурь илэрхийлээгүй маш удлаа. Намбарын Энхбаяр гэдэг хүнийг нь хүндлэхгүй байж болно. Ядаж албан тушаалыг нь хүндлээд, Засгийн газрын энэ хэлэлцээрийг зөв ойлгуулах тал дээр нь Засгийн газар өөрөө дуугарч ажиллах ёстой.

Эцэс сүүлдээ энэ асуудлыг бүүр улс төржүүлээд гишүүд нь би ч мэдээгүй болоод л, эргээд л нөгөө өмнөх Засаг руугаа ч оруулаад л, сүүлдээ АН-ыг ч гэсэн буруутгаад байна гээд Пүрэвдорж Улсын Их Хурлын дэд дарга өглөө асуусан шүү дээ. Эцэс сүүлдээ Амарбаясгалан даргын зургийг нь тавьж байгаад улс орноо худалдсан хүн гээд л энэ гэрээтэй холбоод бичих юм. Ямар учир байна вэ? Үнэхээрийн тийм алдагдалтай гэрээ байгуулчихсан юм уу? 2024 оны 12 сард энэхүү гэрээг хэлэлцээрийг байгуулахад баримтлах чиглэлийн тогтоолыг бид баталсан. 25 оны 3 сард хэлэлцээрийг соёрхон баталсан. Хэдхэн сарын өмнөх л асуудал шүү дээ. Бүгдээрээ гэнэт мэдэхээ байчихлаа. Засгийн газар энэ дээрээ албан ёсны байр суурь илэрхийлж, ард иргэддээ үнэн зөв мэдээлэл өгсөн нь зөв байх. Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүний амнаас гарч байгаа үг чинь арай ч нэг худлаа улс төржилт баймааргүй юм. Ийм учраас үүн дээр Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн өөрийнхөө баталсан хуульдаа эзэн байж, Засгийн газар ч гэсэн оруулж ирсэн энэ хэлэлцээртээ эзэн байж, албан ёсны байр суурь хариуг нь өгөх хэрэгтэй шүү дээ. Иргэд Ерөнхийлөгчийнхөө, Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүний үгэнд итгэхгүй өөр яах юм бэ? Тэгээд үнэн яриад байна уу, худал яриад байна уу? Үүн дээр хэн байр сууриа илэрхийлэх вэ? Оюун-Эрдэнэ хамтарсан засгийн байгуулсан гэрээ Занданшатарын.../минут дуусав/

Х.Булгантуяа: Бямбацогт сайд хариулах уу? ЗГХЭГ-ын дарга. Энхбаяр даргаар ахлуулсан ажлын хэсэг гарсан гэсэн. Тэгээд тийм. Одоо Улсын Их хурал Засгийн газраас оруулж ирсэн зүйлийг баталсныхаа төлөө Улсын Их Хурлын гишүүд хулгайч болж болохгүй байх. Тэгэхээр үүн дээрээ Засгийн газар та бүхэн маань өөрснөө албан ёсныхоо ер нь байр суурийг илэрхийлсэн нь зүйтэй байх. Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Тэр ажлын хэсэг гараад энийг тийм үү шалгаад үнэн зөв гэдэг юм уу, буруу хулгай байсан гэдгийг тогтоосон зүйл ерөөсөө байхгүй. Тэгээд Монгол

Улсын Ерөнхийлөгч асан Энхбаяр гуай өөрийнхөө л хувь хүний бодол, хувь хүнийхээ байр суурийг л илэрхийлсэн гэж ойлгож байгаа. Энэ Засгийн газрын байр суурь биш. Үүнийг юу гэдэг юм Их Хурлын танхим руу оруулж ирээд, Засгийн газар Их Хурлын хоорондох асуудал болгоод байх шаардлагагүй, шаардлагагүй. Улсын Их Хурал хамтын шийдвэр гаргадаг. Тэгээд Улсын Их Хурлын буруутгахлаар хэнийг буруутгах юм. Бид бүгдээрээ л кнопдоод шийдвэр гаргасан. Хэрэв үнэхээр алдаатай байсан бол Улсын Их Хурал л засна, үүнийг Засгийн газар засахгүй. Алдаатай байсан эсэхийг холбогдох хууль хяналтын байгууллага, тэр мэргэжлийн байгууллагууд нь шаардлагатай бол дүгнэлтээ гаргах байх. Одоогоор гэхдээ энэ тал дээр Засгийн газар дээр ямар нэгэн бодлого шийдвэр гарч, ярьж байгаа зүйл байхгүй байгаа, байхгүй байгаа. Тийм болохоор гэрээ хүчин төгөлдөр, гэрээний дагуу үйл ажиллагаанууд нь 2 тал хүлээсэн үүргээ биелүүлээд л явж байгаа. Энийг л хэлье.

Х.Булгантуяа: Ариунзаяа гишүүн нэмж тодруулъя.

А.Ариунзаяа: Улсын Их Хуралд эрх нь байгаа гээд Засгийн газраас оруулж ирсэн хэлэлцээрийг бид хэлэлцэж, соёрхон баталсан үнэн. Үнэхээрийн алдагдалтай, ийм хулгай зэлгээний асуудал байгаа гэж үзвэл Засгийн газар эргээд энэ хэлэлцээрээ цуцлах эрх нь байгаа. Хэрэвзээ цуцлахаар орж ирвэл төсөөлөлд ямар өөрчлөлт орох вэ гэдэг ийм асуудлыг би асуугаад байгаа юм. Тэгээд Намбарын Энхбаяр гуайд мэдээллийг нь маш сайтар өгөх л хэрэгтэй л дээ. Би түрүүн хэллээ шүү дээ зүгээр энэ Намбарын Энхбаяр гэдэг хүн биш энэ чинь Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүн шүү. Ард иргэд энэ хүний үгэнд итгэдэг юм шүү. Зүгээр нэг хаячхаж болохгүй. Ийм учраас энэ чинь иргэдийн санаа зовнилд нь ороод байгаа байхгүй юу. Улсын Их Хурлыг хулгайч мэтээр ярьж байгаа нь өөрөө буруу шүү дээ. Засгийн газар өөрийнхөө хэлэлцээртээ зөв мэдээллийг нь өгөх үүрэгтэй. Ийм учраас энэ мэдээллийг залруулж ард иргэдээ тайвшруулах хэрэгтэй.

Х.Булгантуяа: Ариунзаяа гишүүн үг хэллээ. Засгийн газраас оруулж ирсэн хэрвээ аливаа бичиг цаас алдаатай энэ тэр байвал Засгийн газар ч гэсэн өөрөө үүнийгээ сайжруулах, засах давхар үүрэгтэй, энийг ганцхан Улсын Их Хурал ч хийх албатай биш. Тийм учраас салбарын сайдууд, салбарын яамд бол хамгийн нарийн мэдээлэл, хамгийн сайн тооцоолол Улсын Их Хурлын гишүүдэд биш, тэр хүмүүст ганц туслах, ганц зөвлөх 2-той байгаа. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүдэд биш, салбарын сайдууд салбар салбарын нарийн бодлого тооцооллуудаа өөрснөө хариуцаж оруулж ирдэг, хуулийн дагуу өөрснөө үүний хуулийн хариуцлагыг хүлээдэг байгаа. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн. Мөнхбат гишүүн байхгүй байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Гишүүдийн өдрийн мэндийг эрье. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт дээр болохоор энэ ДНБ-д эзлэх нийгмийн халамжийн зардлыг бууруулахыг зөвлөсөн байгаа. Тэгэхээр 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон 2027-гоос 2028 оны төсвийн төсөөлөл дээр энэ талаар ямар томоохон өөрчлөлт хийхээр тооцож байна вэ 1 дүгээр асуулт?

2 дугаар асуулт болохоор энэ 2028 онд Засгийн газрын өрийн нийт хэмжээ 59,5 их наяд төгрөг болж өмнөх жилээсээ 7,7 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцсон байна. Тэгэхээр үүний цаана томоохон хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэхээр тооцсон байх гэж ойлгож байгаа. Тэгэхээр ямар хөрөнгө оруулалт төслүүдийг санхүүжүүлэхээр тооцсон бэ?

3 дугаар асуулт болохоор энэ Монгол Улсад Засгийн газар батлагдсан гадаад зээлийн ашиглалт нэлээд муу байгаад байгаа. Яагаад муу байгаад байгаа вэ гэхээр төсвийн алдагдал нэмнэ гэдэг хязгаарлалтаас болоод батлагдсан зээлдээ хий шимтгэл төлдөг ийм байдалтай байж байгаа. Тэгэхээр ингээд 2026 оны төсвийн хүрээний мэдэгдлийг харахаар ойролцоогоор 3,4 их наяд төгрөгийн зээл нэмж авах юм байна гэж харагдаж байгаа юм. Тэгэхээр бид ярихдаа үр ашигтай хөрөнгө оруулалтын төслүүдээ явуулна гэж яриад байдаг. Тэгэхээр энэ үр ашигтай гэж тооцож байгаа хөрөнгө оруулалтын төслийн ажлын төлөвлөгөөг 2026 онд бүрэн санхүүжүүлж байгаа юу, эсвэл төсвийн алдагдлын хязгаарт ороод дутуу ашиглахаар байгаа юу зээлээ гэсэн нэг ийм асуултууд байна?

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: 2018, 2019 онуудад 2.1, 2 хувьтай байсан халамжийн зардал нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа боол 2023 онд 3,7 болсон. Тэгэхээр бид 2026 оноос энэ ДНБ-тэй харьцах хувийг багасгана, 2026 онд 2,6, 2027 онд 2,4, 2028 онд 2,2 хувь болгож ирэх ийм зорилтын хүрээнд үе шаттай бууруулахаар төсвийн төсөөллийг боловсруулсан. Тэгэхээр цаашдаа нийгмийн халамжийг бууруулах бодлого барина. Бууруулах бодлого барьсан хэдий ч үүн дээр арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн тулд энэ хувийн хэвшил дэх ажлын байрыг хадгалах зорилтуудын хүрээнд энэ гадаадын зээл, тусламжаар санхүүжих төслүүдийг эрэмбэлэхдээ буюу 149 төслийг эрэмбэлэхдээ илүүтэйгээр ач холбогдол өндөртэй боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих, шинэ ажлын байрыг бий болгох, ажлын байрыг хадгалах, шинэ технологи нэвтрүүлэх төслүүдийг тэргүүн ээлжид хэрэгжүүлж гэдэг зорилгоор сая Засгийн газар дээр 149 төслийг эрэмбэлэхээр яамнуудаас санал авч байна.

14 мега төслийг эрэмбэлсэн. 4 бүлэг, 15 зүйлээр эрэмбэлсэн байгаа гэдгийг хэлэх ёстой. 4 бүлэг түрүүн хэлсэн тэр макро эдийн засгийн байдлын үнэлгээ, санхүүжилтийн хэлбэр, нийгмийн сошиал импакт гээд олон аргачлалуудаар 1-ээс 5 оноогоор үнэлсэн. Тэгэхээр энэ үнэлэх ажил хийгдэж байна. 10 дугаар сарын 31-нээс өмнө 5 жилийн үндсэн чиглэлийг дагуулаад хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг оруулж ирнэ. Эдийн засгийн хөгжлийн яам юу вэ гэхээр төсвийн хүрээ буюу хязгаарыг тогтоож байгаа гэдэг утгаараа, дээрээс нь жилийн төлөвлөгөө, 5 жилийн чиглэл, зорилтот хөтөлбөр боловсруулдаг ийм бүрэн эрхийнхээ хүрээнд ирэх оноос 5 дугаар сард төсвийн хүрээ орж ирэхэд бид жилийн төлөвлөгөөнд тусгачихсан төслүүдийг л оруулна. Төсөв дээр ч гэсэн жилийн төлөвлөгөөнд туссан байгаа дээрээ л эрэмбэлэх ажлуудыг зохион байгуулна гэж хэлэх ёстой.

Монголд ажиллах хүчний оролцооны түвшин 62 хувь байна. Тэгэхээр ажил хийх боломжтой 100 хүн тутмын 62 нь л ажил хийж байна гэсэн үг. Тэгэхээр ажил эрхлэлтийг нь нэмэгдүүлэх, халамжаас хөдөлмөрт гэдэг энэ бодлого хэрэгжүүлэх бол төсвийн бодлоготойгоо уялдаж явдаг. Төсвийн бодлоготой уялдаж явдаг учраас энэ гадаадын хөнгөлөлттэй зээлүүдийг эрэмбэлэх ажлуудыг хийгээд, энэ эх үүсвэр тодорхой төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор хэдийгээр суурь тэнцэл нөгөө эерэг буюу татвараас бүрдэж байгаа орлогоороо цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, багш нарын цалин хөлсөө тавиад, нэмээд 2 хувийн ашигтай буюу энэ тусгай шаардлагаа бариад, гэхдээ тэр 1,3 их наядаар илүү ажлын байр нэмэгдүүлэх төслүүдээ санхүүжүүлэх нь энэ халамжаас хөдөлмөр эрхлэлт гэдэг бодлогыг амилуулахад хамгийн их дөхөмтэй гэж үзэж байгаа юм.

Ирэх жил гадаадын зээл, тусламжийн 1,9 их наядын ашиглалт хийгдэнэ. Үүн дээр зам тээврийн салбар 17 хувийг эзэлж байна, Улаанбаатар хотын дэд бүтэц 15 хувийг эзэлж байна, газрын тосны үйлдвэр 11 хувь, эрчим хүч 16 хувь гээд нөгөө 10 аймагт баригдах станцууд, тэгээд усан хангамж буюу нөгөө цэвэрлэх байгууламжтай холбоотой зардал, эрүүл мэнд, боомт, онцгой байдалд гээд бусад зардлууд гэж байгаа. Тэгэхээр томоохон төслүүд газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл, нийслэлийн нийтийн тээвэр, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх дэд төвүүдийн бүтээн байгуулалт, тээврийн холболт логистик, засвар арчлалт, бүтээн байгуулалт гэсэн гол төслүүд эзэлж байна. Энэ төслүүд дандаа ажлын байр нэмэгдүүлэх зорилготой гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Соронзонболд гишүүн нэмж тодруулъя.

Л.Соронзонболд: Энэ тэр Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төсөл, тэр газрын тосны үйлдвэрийн төсөл 2026 онд хийх гэж байгаа ажлаа яг бүрэн санхүүжүүлж байгаа юу л гэж асуугаад байгаа байхгүй юу? Тэгэхгүй болохоор чинь одоо яг бүрэн санхүүжүүлэхгүй, миний ойлгоод байгаагаар зээлийг нь ингээд дутуу ашиглаад байдаг л гэж ойлгоод байгаа шүү дээ.

Х.Булгантуяа: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Тийм ер нь би түрүүн тайлбарласан. Ер нь энэ гадаадын зээл, тусламжууд бид ашиглаж чаддаггүй юм байна лээ. Яагаад вэ гэхээр нэгд Төсвийн тогтвортой байдлын хуулиа барьдаг. 2-т манай Их Хурлын гишүүд санаачлаад байсан энэ гадаадын зээл, тусламжууд чинь зарлага талд нь төсөв дээр бичигдчихээд, орлого талд нь бичигддэггүй. Тэгэхээр орон зай байдаггүй. Тэгэхээр цаад тал маань гадаадын тал маань зээл, тусламж өгье гээд ингээд санхүүжилт нь бэлэн байгаад байхад төсөв дээр тавья гэхээр зарлага дээр бичигдчихээд байдаг. Тэгэхээр гаднын нэлээн олон сайн жишгүүд байна л даа. Энэ зарлага дээр ингээд бичигддэггүйгээр зарим төслүүдийг төсвөөс гадуур санхүүжүүлэх ийм бололцоог нээдэг. Газрын тос боловсруулах үйлдвэр нийт төсөв чинь бараг 2 тэрбум доллар шүү дээ, 26 онд энэний 207 тэрбум 745 сая төгрөгийг санхүүжүүлнэ л гэж ингэж тооцож байгаа.

Х.Булгантуяа: Гадаадын зээл, тусламж орлого талдаа бичигдэх ямар ч үндэслэлгүй л дээ. Зүгээр энэ бол эдийн засгийн өөрөө үр өгөөжтэй төсөл учраас заавал буцаад татвар төлөгчдийн мөнгөөр буцааж төлөгдөх албагүй. Жишээлбэл цэвэрлэх байгууламж өөрөө үүнийгээ аж ахуйн тооцоот байгаад өөрөө өөрөө төлөх ийм бүрэн боломжтой. Энэ эрх зүйн орчноо бий болгох Засгийн газраас өргөн бариад үүнийгээ бий болгох бүрэн боломжтой байгаа шүү. Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга.

Б.Уянга: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Сая Соронзонболд гишүүний асуусан тэр гадаадын зээл, тусламжтай холбоотой л асуултыг үргэлжлүүлээд асуух хэрэгтэй байгаа юм. 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсвийн төсөөллийн тухай хууль дээр Засгийн газрын өрийн нийт хэмжээ одоо 26 он дээр төсвийн хүрээний мэдэгдэл дээр 51,2 их наяд гээд дотоодын нийт бүтээгдэхүүний 50 хувьтай тэнцэхээрээ гээд бичигдсэн байна. Яах вэ энэ нь болохоороо 27, 28 онд 45 Дотоодын нийт бүтээгдэхүүний 45 хувь руу тэнцэнэ гээд явсан байна л даа. Яг

энэ төсвийн энэ гишүүдэд тараагдсан дэлгэрэнгүй Засгийн газрын өртэй холбоотой мэдээллийг уншихаар Засгийн газрын нийт өр 26 оны яг төсөв дээр тусах нь 44,8 их наяд байна гээд яг энэ хүснэгт дээр харагдаж байгаа юм. Тэгвэл яагаад энэ хүрээний мэдэгдэл дээр 8 тэрбум, 7, 8 их наядаар ингэж нэмж 50 хувьд нь хүргээд 51,2 их наяд гээд бичсэн юм бол? Магадгүй 26 хувьд нэмээд гадаадаас зээл авах гэж байгаа юм болов уу? Одоо энэ удахгүй зүрх судасны энэ эмнэлэг баригдах гэж байгаа энэ зээл нь орох гэж байгаа юм болов уу гээд харахаар аль хэдийн энэ Зүрх судасны үндэсний төвийг 182,9 тэрбум төгрөгөөр энэ гаднын зээлээр барина гээд энэ төсөвт 26 оны төсөвт хөрөнгө оруулалт талдаа ингээд орчихсон байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг л асуумаар байгаа юм. Яагаад хүрээний мэдэгдэл дээр, төсвийн хүрээний мэдэгдэл дээр 51,2 их наяд гээд одоо байгаа 44,8 их наяд гаднын Засгийн газрын өр гэж бичигдсэн байгаа тэр дүнгээрээ бичихгүйгээр 51,2 их наяд гэж бичсэн бэ?

Яг манай хууль дээр 60, дотоодын нийт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр болохоороо Дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх ёстой гэсэн заалт нь байсаар байтал одоо байгаа дүнгээрээ л яг мэдэгдэж байгаа дүнгээрээ бичих ёстой байсан биш үү гэсэн энэ асуултыг асуумаар байгаа юм? Тэгээд ер нь Засгийн газрын энэ гадаад зээлийн энэ хөрөнгө баталгаажуулалтын шимтгэл гээд л нөгөө авна гээд баталгаажуулчихсан, тэгээд аваагүй байгаа тэр зээлдээ бид 26 онд 59 тэрбум төгрөг төлөх юм байна. Ер нь зээлээ ашиглаагүйнхээ төлөө ингээд байнга төсвөөс мөнгө төлж, төлбөр төлж явдаг юм байна. Тэгэхээр энэ зээл ашиглалттай холбоотой ямар нэгэн ажил хийгдэж байна уу? Энэ дээр хариулт хэлээд өгөөрэй.

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Засгийн газрын нийт өрийн хэмжээ 2 дугаар улирлын байдлаар 35,5 их наяд төгрөг буюу нийт GDP-ийн 39,5 хувьтай тэнцэж байгаа. Хуулийн төсөл дээр Засгийн газрын өрийн дээд хязгаар тавьж байгаа шүү дээ. Төсвийн хүрээ чинь хязгаар. Тэгэхээр энэ хязгааруудыг л тавьж байгаа гэсэн үг. Тэгэхээр Эдийн засгийн хөгжлийн яам бол Засгийн газрын нийт өрийн хязгаараа тавиад, Сангийн яамны тооцоолол бол илүү гүйцэтгэлд тулгуурлаад хийгддэг ийм өрийн хэмжээ. Тэгэхээр 2026 онд бид энэ хязгааруудыг Дотоодын нийт бүтээгдэхүүний 50 хувь, 27-гоос 28 онд 45 хувь гээд хязгаарыг ингээд бууруулж байгаа гэж хэлж болно. Тэгэхээр өрийн хэмжээ гэхээсээ энэ бол зүгээр нөгөө хүрээ бол дээд хязгаар юм гэж ойлгох хэрэгтэй.

Шинэ магадгүй гадаадын зээл, тусламжийн төсөл эхлүүлээд тэр нь шууд нэмэгдээд явна гэсэн үг огт биш. Тэгэхээр бид энэ зээлийнхээ ашиглалттай холбоотойгоор цаашдаа ажлуудыг хийх шаардлагатай. Тэгэхээр цаашдаа бид мэдээж өр энэ гадаадын зээл, тусламжийн ашиглалтаа сайжруулах чиглэл рүү анхаарах ёстой учраас энэ Их Хурлын гишүүдийн ч гэсэн өргөн бариад байсан хууль, ийм реформын шинжтэй ажлуудыг зайлшгүй хийж байж л цаашаа энэ зээлийн ашиглалт нэмэгдэх юм байна лээ. Тэрнээс биш түрүүн гишүүдийн асуултад гараад байгаа. Жишээ нь Эрдэнэбүрэн дээр гэхэд л Хятадын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл нь 1,2 их наяд байгаад байдаг. Гэтэл 2026 онд бид энэ чинь бүгдийг нь санхүүжүүлж чадахгүй шүү дээ. 25 онд жишээ нь 79,9 сая долларыг л санхүүжүүлсэн. Тэгэхээр нэг талаасаа төсвийн сахилга бат, хариуцлагын асуудал учраас бид ингээд тавиад явж байгаа. Зүрх судасны төв дээр гэхэд л 26 онд 182 тэрбум тавина ч гэдэг юм уу, энэ бол дээд хязгаараа тавиад, тэр жилдээ

гүйцэтгэлээрээ санхүүжүүлээд явж байгаа. Мэдээж гадаадын зээл, тусламжууд цаашаа энэ төлбөрийн тэнцэлд ч гэсэн нөлөө үзүүлнэ. Тэгээд ер нь мэдээж сая Булгантуяа даргын хэлж байгаагаар бид энэ төсөвтэй холбогдуулаад реформын шинжтэй өөрчлөлтүүдийг хийж байж цаашаа энэ зээл, тусламжуудыг ашиглалтыг сайжруулах юм байна гэж хэлмээр байна. Тэгээд Сангийн яамны зүгээс яг нөгөө өрийн ашиглалтын талаар, гадаадын зээл, тусламжийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх байх. Ажлын хэсэг 4 номер.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон ажлын хэсэг.

С.Тулга: Тулга Сангийн яам. Гишүүний асуултад хариулъя. Хагас жилийн байдлаар өрийн харьцаа GDP-ийн 39,5 хувьтай байгаа. Бид оны сүүлээр энийг 44,5 хувьд хүрнэ гэж байгаа. Энэ нөхцөл хэзээ биелэх вэ гэхлээр бид 25 он дээр 1 тэрбум хүртэлх ам.доллар хүртэлх баталгаа гаргана гэж тооцсон байгаа. Энэ баталгаа бүрэн гарч байж 44,5 хувьд хүрнэ. Баталгаа гараагүй тохиолдолд Дотоодын нийт бүтээгдэхүүний 40,6 хувьтай тэнцүү байна. Ирэх онд дотоодын нийт бүтээгдэхүүний 43,8 хувь гэж тооцож байгаа. Энэ нөхцөл маань хэзээ биелэх вэ гэхлээр энэ жилийн 1 тэрбум долларын баталгаа, 26 онд 1 тэрбум хүртэлх ам.долларын баталгааны хүсэлт бас гаргасан байгаа. Энэ нь гараад хүрвэл 43 хувьтай байна гэж байгаа.

Тэгээд Засгийн газрын өр бол 3 хэрэгслээр нэмэгдэж байгаа ирэх жилийн хувьд. Гадаад зээлийн ашиглалт 1,5 их наяд, дотоод бонд 561 тэрбум, тэгээд Засгийн газрын баталгаа 1 тэрбум хүртэлх ам.доллартой тэнцэх хэмжээгээр гарч байж үүгээр Засгийн газрын өр нэмэгдэж байгаа. Нөгөө талдаа бид эргүүлээд 2,6 их наяд төгрөгийн зээл.../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн, Уянга гишүүн нэмж тодруулъя.

Б.Уянга: Энэ төсвийн мэдээлэлтэй танилцаад асуух асуултаа Сангийн яамнаас тухай бүрд нь асууж явсан. Тэгээд яг мэдээллүүдийг дэлгэрэнгүй, цаг тухайд нь өгч байсанд талархаж байгаа. Энэ хүснэгтийг бүгдийг нь ойлгож байгаа юм. Учрал сайд аа, энэ Төсвийн тогтвортой байдлын хууль дээр гадаадын зээл, тусламжийн ДНБ-д эзлэх тааз нь 60 хувь байхгүй юу. Тэгтэл одоо энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр яагаад 50 хувиар гээд 51,2 их наяд гээд тавьчихсан юм бэ гэсэн асуулт юм байгаа юм? Тэгээд нэмээд зээл 7, 8 их наядаар нь нэмж 26 онд авах гээд байгаа юм уу гэсэн асуулт байхгүй юу?

Х.Булгантуяа: 4 номер ажлын хэсгийн микрофон. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

И.Батхүү: Уянга гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Гадаад зээлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ яг зээлжих чадвар, олон улсад Монгол Улсын макро эдийн засгийн тогтвортой байдлыг харуулахад чухал нөлөөтэй. Хэдийгээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар 60 хувийн хязгаар гэж тавьж өгсөн байгаа ч гэсэн бид хөгжлийн бодлогын баримт бичиг, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахдаа илүү төсвийн хатуу зарчим баримтлаад, энэ шаардлагыг нь доошоо буулгаж өгсөн байгаа. Тэгэхээр ирэх онд 50 хувь, дараагийн жилүүд 45 хувиас ямар ч тохиолдолд, ямар ч эрсдэл гарч байсан гадаад зээл, бондын санхүүжилт, бусад төрлийн өр үүсгэх юун дээр дээд хязгаарыг нь тавьж өгч байгаа гэсэн үг.

Яагаад яг хатуу тоогоор тавьж болдоггүй юм бэ гэвэл гадаад зээлийн ашиглалт нь өөрөө гадаад валютаар авдаг учраас өрийн хэмжээ нь өөрөө хэлбэлзэж байдаг валютын ханш, бусад тооцооллоороо. Тэгэхээр яг одоо энэ төсвийн хүрээний 3 жилийн хугацаатай тооцоолол дээр тэдэн тэрбум, тэдэн их наяд байна гээд хатуу тоо тавьж болохгүй. Дээд хязгаарыг нь тавьж.../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Уянга гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Тэгэхээр энэ гадаад өрийн удирдлагын тухай энэ ойлголт дээр 3 тоо байгаа шүү Уянга гишүүн ээ. Тогтвортой байдлын хуулиар хязгаар 60 хувь, хүрэн дээр энийгээ бид арай эрсдэлийг нь бууруулаад өөрөөр хэлбэл бодлогоо нэлээн чангалаад 50-аас, 60 биш шүү, энэнээс бүүр доошоогоо 50-аас илүү гаргаж болохгүй шүү гээд нэг ийм тоо оруулаад ирсэн, батлуулчхаж байгаа юм. Гүйцэтгэл гэдэг, гүйцэтгэлийн 3 дахь тоо маань жишээ нь энэ жилийнх 42 орчим гарна, 50-аар хязгаарласан мөртөө гүйцэтгэл маань 42-оор гарч ирнэ гэсэн үг. Хойтон 44, 43 орчим гарна. 50-аар хязгаарлана, тэгэхдээ 43. Цаашаагаа 45 гээд, 45-аас доош буулгахгүй, 45 дээр бариад явна. Тийм. Тэр нь нэлээн урт хугацаанд явах байх. Олон улсын байгууллагуудаас ч гэсэн ер нь 45 байхад танайхыг.../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Номин.

Ч.Номин: Сайн байцгаана уу, би Уянга гишүүний асуусан асуулт дээр нэмээд асуучихъя. Өнгөрсөн нэг дэх өдөр Ерөнхий сайд гадаад өрийн бодлогоо чангатгаж, илүү энэ зээлжих зэрэглэлээ хадгалахын тулд цаашдаа энэ гадаад өрөө багасгаж явна гэдэг мэдэгдэл хийсэн. Тэгээд багасгаж явна гэхээр өрийн таазаа нэмэгдүүл, төсвийн хүрээний мэдэгдэл дээр өрийн таазаа дээд хязгаараа 50 хувь болгоод нэмэгдүүлээд цаашаа явж байна. Жавхлан сайд дөнгөж сая бид бууруулаад явна гэж ярьж байгаагийнхаа эсрэг ер нь 45 хувь руугаа явуулна гээд ярьж байна. Гэтэл бид олон улсын зах зээл хүндрэлтэй байна, дээрээс нь орлого бүрдэхгүй байх нөхцөл үүсэж байна гэдгийг аудитын дүгнэлтээр, мөн үүнээс гадна Төсвийн тогтвортой байдлын дүгнэлтээр гарчхаад байхад энэ төсвийн таазаа нэмэгдүүлж байгаа чинь ямар бодлогоор ингэж нэмэгдүүлж байгаа юм бэ, ямар баталгаатай гэж үзэж байгаа юм бэ гэдэг 1 дүгээрт асуулт байна?

2 дугаарт Учрал сайд Эдийн засаг, хөгжлийн сайдаас асууя. Та энэ төсвийн хүрээний мэдэгдлээ тооцохдоо юу гэж тооцсон бэ гэхээр биет хэмжээгээ нүүрсийг 90 сая тонныг гаргана, үүнээс гадна үнэ 70 долларын үнэтэй байна гэж тооцсон байна. Яг өнөөдрийн байдлаар дунджаар та бүхэн 6 мянга, 6 сая тонныг биет хэмжээгээр гаргаж байгаа, дундаж үнэ 56 доллар байгаа гэж Монголбанкнаас мэдээлж байна. Тэгэхээр энэ жил хүртэл одоо яг энэ 8 сард гаргаж байгаа 8 сая тонноороо гаргалаа гэхэд 75 сая тонноос нэмэгдэхгүй. Тэгвэл Олон улсын эрчим хүчний агентлагийн мэдээлснээр Хятад улсын нийт нүүрсний эрэлт 25 онд бол 24 оноос 13 хувь, мөн цаашлаад 26 онд бүүр үүнээсээ 3 хувь унана гэж байгаа. Ингээд 3 хувиар унаж байгаагаар үзэхэд бид 2026 онд 70 сая тонноос дээшээгээ тонн ийм нүүрс гаргахгүй ийм тооцоолол гарч байна. Ингээд үзэхэд орлогын төсөөлөл чинь төсөв дээрээ ч, төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ ч арай өндөр байгаа юм биш үү? Хамгийн сайнаар бодоход 400 орчим тэрбум төгрөгийн бууралттай, муу талаас нь үзвэл 1 их наядын бууралттай орлого бүрдэх нөхцөл үүсэж байна. Тэгэхээр үүнийг хэр бодитой гэж үзэж байгаа юм бэ гээд 1 дүгээр асуулт байна?

2 дугаарт болохоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн даргаас асуулт байна. Ийм дүгнэлт гаргасан байна. Монгол Улсын төсвийн төсөөлөл ерөнхийдөө сайжирчихсан, бүрдэл хангасан, дээрээс нь төсвийн зардлын өсөлт хязгаарлагдсан байна, ер нь эерэг хандлагатай байна гэдэг ийм дүгнэлт гаргаж өглөө. Өнгөрсөн онууд, өнгөрсөн оны төсвийн хүрээний, төсвийн төсөл дээр шал өөр дүгнэлт гарч байсан. Тэгэхээр өнгөрсөн оноос юу өөрчлөгдсөн гээд өнөөдөр бид 1,4 их наяд төгрөгийн алдагдалтай төсвийг батлахыг зөвшөөрч байгаа юм бэ? Үүнийгээ тайлбарлаж өгөөч.

Сангийн сайдаас асуух асуулт байна. Орлогыг нэмэгдүүлэх тал дээр гарсан байна. Орлого нэмэгдүүлэхдээ.../минут дуусав/

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Түрүүн Уянгаа гишүүн хөндөөд байсан, яг үүнтэй адилхан асуулт байна. Бидний баталсан Төсвийн хүрээний мэдэгдэл дээр ямар байсан бэ гэхээр дээд хязгаар чинь 50 хувь байсан. Тэгэхдээ Төсвийн тогтвортой байдлын хуулиар өрийн дээд хязгаар чинь 60 хувь байж болно гээд хуулиар зөвшөөрчихсөн. Гэхдээ илүү төсвийн сахилга бат барих үүднээсээ 50 хувь дээр л барьж байгаа гэсэн үг. Тэгэхээр Дотоодын нийт бүтээгдэхүүний 50 хувь чинь тэр 51 их наяд байхгүй юу. Тэгэхээр бид одоо жишээ нь ийм байгаа юм. Төсвийн тогтвортой байдлын хуулиар урсгал зардал чинь 30 хувь биз дээ, 30 хувь шүү дээ урсгал зардал. Гэтэл жилийн төлөвлөгөө дээр 24 хувь байхгүй юу. Тэгэхээр илүү төсвийн сахилга батаа барихын тулд бид энэ төсвийн хүрээг оруулж ирэхдээ урсгалыг хуулийн хүрээнд нь биш бүүр багасгаад 24 хувиар, дээрээс нь хууль дээр 60 хувийн өр хязгаар байж болохыг нь харин багасгаад 50 хувь бууруулсан байхгүй юу. Та болохоор сая нэмсэн гэж яриад, та бидний баталсан төсвийн хүрээний мэдэгдэл угаасаа 50 хувь байсан. Одоо баталж байгаа энэ төсвийн хүрээний мэдэгдэл чинь дахиад 50-иараа. 60 болгож болох байсан хуулиараа. Гэхдээ энэ хязгаарт хүргэхгүйгээр, харин Ерөнхий сайдын бодлогын дагуу бид өрөө, өрийн хязгаараа буулгасан. Ерөнхий сайдын зарласны дагуу.

Дээрээс нь ирэх онд энэ чинь 45 хувь хүртэл буурна. Тэрнээс зөвхөн хуулийн хязгаараа бариад л, Төсвийн тогтвортой байдлын хуулиар чинь 60 хувь гэсэн юм чинь гээд 60-аас дээш их наядын өр гээд ингээд бичиж болох л тийм хуулийн боломжтой байхгүй юу. Гэтэл харин энийг нь аль алиныг нь бууруулсан, nominal тоо өөрөө буурсан гэдгийг би хэлье. Тэгэхгүй бол буруу ойлголт төрчих вий. Аль алиныг нь бууруулсан шүү. Сая өсгөсөн гэж буруу ярьж байх шиг байна.

Нүүрс дээр юу юм бэ гэхээр 25 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл бол биет тоон хэмжээ 85 сая тонн, одоо эндээс 58 сая тонн гарчихсан. Тэгэхээр ирэх жил 90 сая тонныг гаргана л гэдэг ийм зорилтыг тавьж байна. Энэ тоог зүгээр нэг өглөө ирээд гаргаж болохгүй л дээ. Энийг чинь тоог нь яг хэдий хэмжээний биет тоо хэмжээ гаргах вэ гэдгийг нэгд энэ маш сайн хийгдсэн нэг ажил байдаг юм байна лээ. Засгийн газар дээр энэ нөгөө биржийн гэрээнүүд чинь бүртгэгдчихдэг юм байна. 40 сая тонны нүүрсний гэрээнүүд чинь бүртгэгдсэн, энэ бол тодорхой асуудал, гэрээ хийгдчихсэн гэсэн үг. Нэмэлтээр хэдий хэмжээний нүүрс гарах вэ гэдгийг шийдэхийн тулд хувийн хэвшлүүдтэй уулзалт хийдэг. Ингээд энэ тоон хэмжээ болоод үнэ дээр бид тэр Блүүмбергийн терминал дээр байгаа байгууллагуудын төсөөллүүдийг авдаг, ингээд харьцуулж байгаад шийддэг. Ингээд биет тоон хэмжээгээ нэмэгдүүлэх үүргийг хүлээхийн тулд энэ салбар чинь өөрөө нөгөө тээврийнхээ салбартай уялдаж

явах гэдэг утгаараа тээврийн салбар дээр байгаа гацаа хүндрэлүүдийг арилгах чиглэлээр экспортын тэр ажлын хэсэг дээр арга хэмжээнүүдийг аваад явж байгаа.

Тийм учраас цаг алдахгүй ажил аваад Хятадад очоод Ерөнхий сайдтай нь уулзалт хийсэн. Энэ төлөвлөгөөндөө энэ асуудлыг тусгаач. Энэ Гашуунсухайт-Ганцмодны хил холболтын ажил хийгдсэний дараа тэр Шивээхүрэн, Сэхээ, тэр Хангимандал, Бичигт, Зүүнхатавч тэр боомтуудыг холбох ажлыг энд суулгаж өгөөч. Дээрээс нь энэ 2 улсын хил хамгаалах, гааль, гадаадын иргэн, харьяат, тэр боомт гээд энэ олон байгууллагуудын мэдээллийг хурдан, шуурхай шийдвэрлэдэг болооч. Гааль дээр байгаа хилээр бараа нэвтрүүлэхэд нөгөө тавиад байгаа журмууд дээрээ хүний оролцоог багасгаач гээд, хүний оролцоо шингэсэн 55 зүйл, заалтыг өөрчлөөд, журам нь хэрэгжээд эхэлчихсэн. Ингээд жолоочгүй тээврийн терминал дээр зөвхөн биржийнхээ тээврийг дэмжье гээд шийдвэр гаргачихсан. Тэгэхээр 90 сая тоннд хүргэнэ л гэж зорьж байгаа. Хүргэхийн тулд салбарын сайдуудыгаа шахаж.../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд аа өрийн, Учрал сайд аа, өрийн nominal хэмжээ нэмэгдсэн байгаа шүү дээ. 25 оны хүлээгдэж байгаа чинь 40 их наяд гэж байна Засгийн газрын энэ төсвийн ном дээр. 26 онд төсөв дээр оруулж ирж байгаа нь 45 их наяд. Тэгэхээр nominal дүнгээрээ нэмэгдэж байгаа, ДНБ-тэй харьцуулсан харьцааг нь. Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Булгантуяа дарга бас нэмж асуугаад, асууж байх шиг байна. Тэр nominal дүн нэмэгдэж байгаа чинь 3 янзын эх үүсвэр байгаа, 3 шалтгаанаар байгаа юм. 1 дүгээрт, энэ чинь манай өрийн ер нь бараг 98 хувь нь гадаад валютаар илэрхийдэгддэггүй учраас ханшийн зөрөөнөөс нэмэгдэж байгаа. Мөн нэмж авч байгаа зээлүүдээс нэмэгдэж байгаа, мөн дотоодын бондоор нэмэгдэж байгаа ийм nominal дүнгийн зөрөө шүү. Хэн, Номин гишүүний асуултад хариулъя. Орлого өслөө гэж хэлэх гэж байсан уу тийм ээ? Тэгсэн чинь микрофон хаагдчих шиг боллоо.

Тийм орлого ийм юм байгаа шүү. Орлого тодотголын дүнгээс 1,4 их наядаар өндөр байгаа, тодотголын дараах дүнгээс. Тэгэхээр тодотгол жилийн дундуур хийгдсэн. Өөрөөр хэлбэл 7 сараас хойших орлого, 7 сараас өмнөх орлого гээд энэ 2, энэ 2 -ын нийлбэр дүнгээс хойтонгийн бүтэн жилийн орлого чинь бол 1,4 их наядаар өндөр байгаа. Гэхдээ 5 сард та бид 2 цуг.../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя. Тэгээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 3 номерын микрофон дээр хариулахад бэлдэж байгаарай.

Б.Жавхлан: 5 сард батлуулсан хойтонгийн жилийн төлөвлөгөө, төсвийн хүрээнээс энэ орлого маань муудаж байгаа 1,9, ноднин 25 оны төсөв батлуулж байхад анхны тооноос 2,3, 1,9 гээд нийлбэр гэхээр чинь бүүр 4,2 их наядаар ингээд орлогыг бууруулж төлөвлөсөн байгаа шүү. Тийм.

Х.Булгантуяа: Энхбаяр дарга, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Энхбаяр дарга нэмж хариулъя. Энэ дээр ийм байгаад байх юм. Төсвийн хүрээн дээр бүүр ингэж байна шүү дээ одоо өргөн барьсан дээр чинь. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр нийт өр бүүр 51,2 их наяд. Энэ нь энэ төсвийн ном дээр байгаагаас ч их байна. Тэгвэл энэ 2 зөрөөтэй байна. Төсвийн ном дээр бол Засгийн газрын нийт өрийг 2026 онд, эсхүл надад та нар өөр ном өгнө гэж баймааргүй юм. Засгийн газрын нийт өр, үгүй ээ 2026 оны төсөв гэсэн байна. 2026 оны төсөв гэсэн байна. 2026 оны

гүйцэтгэл чинь гараагүй шүү дээ. Энэ болохоороо Номин сайдын асуугаад байгаа нь 51,2 их наяд болоод Дотоодын нийт бүтээгдэхүүний 50 хувьд хүрч байгаа юм байна шүү гэж асуугаад байгаа. Тэгээд энэ яагаад өсөж байгаа юм бэ, өсөх нь зөв юм уу гэж. 3 номерын микрофон, ажлын хэсгийн микрофон дээрээс хариулъя.

Н.Энхбаяр: Номин гишүүний асуултад хариулъя. Цаг бага байгаа учраас би товчхон 2 тоо л хэлье гэж бодож байна. Өнгөрсөн онд бид төсвийн 2025 оны төсөв дээр дүгнэлт өгөх үед нөхцөл байдал нь ямар байсан бэ гэхлээр 24 онд Улсын Их Хурлаас 25 оны төсвийг батлахдаа 27 их наядаар баталсан. 8 сард төсвийн тодотгол хийгээд 30 их наяд, 25 оны өргөн барьсан төсөв нь 35 их наяд. Нэг жилийн дотор үндсэндээ төсвийн зарлагыг 30 хувь өсгөсөн ийм өөрчлөлт байсан учраас мэдээж бид энэ дээр хурдтай өсөлт байна гэсэн дүгнэлтийг өгч байсан. Одоо тэрнээс хойш ямар өөрчлөлт оров гэхлээр өнгөрсөн оны сүүлд дахин тодотгон баталсан 33,7 их наядын төсвийг сая тодотгол хийгээд эргэж буурсан байгаа. Тэгээд тэр буурсан дүнтэй харьцуулахад харьцангуй одоогийн ирэх оны өргөн барьж байгаа 2026 оны 32,9 их наяд гэдэг харьцангуй бага хурдтай өсөлт байна гэсэн үг.

2 дугаарт бидний төсөөллийн хувьд хараат бус байгаагийн нэг тодорхой нотолгоо бол өнгөрсөн оны 3 сард бидний өгсөн макро эдийн засгийн төсөөлөлд 2026 оны зарлагын хязгаарыг бид.../минут дуусав/

Х.Булгантуяа: 3 номерын микрофоныг нэмж өгье. Энхбаяр дарга хариулчхаарай.

Н.Энхбаяр: 30,9 их наяд гэж өгч байсан. Гэтэл энэ хугацаанд өнгөрсөн оны төсөв дээр Засгийн газраас өргөн барьсан төсөв дээр төсвийн хязгаарыг, 26 оны төсвийн хязгаарыг 37,3 их наяд гэж байсан байхгүй юу. Тэгэхээр илүү бидний 3 сард боловсруулсан төсөл бодит байдалтай илүү ойрхон байна гэсэн үг, 26 оны төсөв.

Х.Булгантуяа: Номин гишүүн нэмж тодруулъя.

Ч.Номин: Би ингэж асуугаад байгаа байхгүй юу. Та бүхэн яагаад 1,4 их наядын алдагдалтай төсөв батлахыг энэ онд болно гэж үзэж байгаа юм бэ гэдгээ тайлбарлаад өгөөч гэж асууж байгаа юм.

Би дахиад нэг юм тодотгоод асуучихъя. Энэ өргөн барьж байгаа төсвийн хүрээний мэдэгдэл, дээрээс нь төсөв маань 2026 оны хөгжлийн төлөвлөгөөтэй, дээрээс нь төлөвлөлтийн шаардлагуудтай бүрэн нийцэж байгаа хөрөнгө оруулалтын төслүүд орж ирж байгаа юу, энэ 100 хувь нийцэлтэй байгаа юу гэдгийг Учрал сайд хариулаад өгөөч?

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Ямар ч байсан төсвийн хүрээний мэдэгдлийн тоо батлагдсан Засгийн газрын өр 52,7 их наяд байсныг 51,2 болгож бууруулж байгаа. Тэгээд Булгантуяа даргын сая уншаад байгаа зүйл гүйцэтгэлийн төсөөлөлтэй нь холбоод ингээд байх шиг байна. Бид төсвийн хүрээнийхээ хязгаарыг ярьж байгаа юм шүү гэдгийг хэлье. Жилийн төлөвлөгөөтэй нийцэж байгаа. Нийцүүлэхийн тулд 126 тэр төслөөс 50-ийг нь явуулахад төсвөөс санхүүжих бололцоогүй болсон байсан. Тийм учраас ямар нэгэн байдлаар санхүүжүүлэхийн тулд санхүүжилтийн арга хэрэгслийг олохын тулд бид Төр, хувийн хэвшлийн түншлэлийнхээ хуулийг нэмэлт,

өөрчлөлтөөр дагуулж оруулж ирж байгаа. Ингээд тэр 50 төслийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиараа аймаг, орон нутгууд бие даан хэрэгжүүлэх, Засгийн газрын зүгээс бодлогоор дэмжих ажлуудыг шат дараатай хийх зорилгоор оруулж ирсэн. Ингээд энэ бол улсын жилийн төлөвлөгөөтэй нийцэж байгаа юм. 5 жилийн үндсэн чиглэл батлагдаагүй байгаа 31-ний өмнө оруулж ирнэ.

Х.Булгантуяа: Жавхлан сайд. Дээрээс нь нэмээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хариулахад бэлдэж байгаарай.

Б.Жавхлан: Гишүүдийн яг давхардаж байгаа нийтлэг асуултад хариулъя. Төсвийн тоо болгон хүлээгдэж буй гүйцэтгэлийн тоо ирэх жил. Хязгаар энэ физикал framework шүү дээ энэ чинь хязгаар байхгүй юу, энэнээс давж болохгүй гэж байгаа л ийм 2 ялгаатай 2 тоо. Төлөвлөгөө болон ирэх жилийн төсөв 2 зөрнө. Төлөвлөгөө дээр 3,6 их наяд гэж байгаа, 3,6 их наяд. Төсвийн боломжит хязгаар маань 3,2 их наяд. Тэгэхээр төлөвлөгөө талаасаа харвал мөнгө нь дутчихсан төсвийн. Төсөв талаасаа харвал байгаа бүх мөнгөө төлөвлөгөөндөө нийцүүлж тавьсан ийм л зүйл байгаа юм.

Х.Булгантуяа: Алдагдалтай төсвийн тухай хэн хариулах вэ? Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Жавхлан сайд ч гэсэн хариулмаар байна.

Н.Энхбаяр: Өнгөрсөн онд төсвийг алдагдалгүй болгох тухайд манай улсын нөгөө түүхий эдийн үнэ ханш маш сайн байсан тийм ээ, гишүүд маань сайн мэдэж байгаа өнгөрсөн онд өргөн барьсан. Тэгэхээр яагаад буурсан шалтгааныг Засгийн газраас хаврын чуулганаар өргөн барьсан төсвийн тодотгол дээр тодорхой биччихсэн байгаа тайлбарыг нь. Энэ 14 дүгээр хуудсан дээр. Түүхий эдийн үнэ унасан, төсвийн орлого бүрдэх боломжгүй байна, тасарч байгаа учраас төсвийн тодотгол хийж байна гээд. Тэгэхээр энэ нөхцөл байдал одоо ч гэсэн хэвээр үргэлжилж байгаа. Өнөөдөр ҮСХ-ноос танилцуулсан Монгол Улсын эдийн засгийн 8 сарын, эхний 8 сарын үзүүлэлтээр ч гэсэн тодорхой байна. Өнгөрсөн оны мөн үеэс экспорт 1,4 тэрбум доллароор буурсан. Энэ хэмжээгээр төсвийн орлого бараг 1 их наядаар тасраад явж байна. Энэ нь өөрөө төсвийн орлого бүрдэхгүй байна гэдгийг маш тодорхой харуулж байгаа учраас энэ хэмжээний алдагдалтай төсөв нь эрүүл үзэгдэл гэсэн үг.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Булгантуяа дарга Сангийн дэд сайд байсны хувьд энэ зовлонг хамгийн сайн ойлгох хүний нэг гэж бодож байна. Энэ удаа орлого дутаж байгаа юм. Дутсан орлогынхоо хэмжээгээр зардлаа бууруулаад, хөрөнгө оруулалтуудаа буурна гэх юм эдийн засгийн өсөлт ирэх жил байхгүй, юун 5,7. Ингээд төлбөрийн тэнцлийн алдагдал, энэ дахиад энэ эдийн засгийн энэ бууралт 2 чинь нийлээд энэ бүр хямрал руу чирч явна. Тэгвэл алдагдал тэр зөрөө маань яг юунд ашиглагдаж, юунд чиглэж байна вэ гэдгээрээ л хамгийн чухал хариулт тэнд байх ёстой. Бид өнөөдөр хүрээн дээрээ суурь тэнцэл, тэнцвэржүүлсэн тэнцэл гэдэг 2 дүн батлах гэж байгаа. Суурь тэнцлээр бүх татварынхаа орлогоороо бүх урсгал зардлаа бид бүгдийг нь санхүүжээд, цаана нь 2 хувийн ашигтай, цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө бүгдийг нь бүүр ашигтайгаар санхүүжүүлнэ. Ганцхан бидний хамгийн чухал гэж байгаа энэ мега төслүүдийг санхүүжүүлэх зээлийн ашиглалтаар л энэ 1,3 хувийн.../минут дуусав/

Х.Булгантуяа: Номин гишүүн нэмж тодруулъя.

Ч.Номин: Жавхлан сайд аа, бас яг тийм биш байна. Хөрөнгө оруулалт нь 1 их наяд 585 тэрбум төгрөгийг бол та урсгал зардалдаа алдагдлаараа санхүүжүүлнэ гээд энийгээ буцаад шинэ өр зээл гаргана гээд энэ та нарын өгсөн мэдээлэл дээр чинь байгаа. Нөгөө талдаа би Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг энэ хэлж байгаа 1,4 их наядыг алдагдалтай байх нь асуудалгүй юм байна гэж хэлж байна гэж ойлгож байгаа. Яагаад би энийг дахин, дахин асуугаад байна вэ гэхээр түрүүн би Учрал сайдаас асуусан буруу ойлгосон бололтой байна. Би цаашдаа дахиад орлого дахиад 1 их наядаар дутагдах магадлал өндөр байна. Яагаад гэхээр нүүрсний үнэ энэ хэмжээгээрээ буурна, дахиад бодит хэмжээ чинь 90 сая тоондоо хүрэхгүй. Тэгэхээр 1,4 их наядын алдагдал биш, бүүр энэнээс өндөр алдагдал гарах магадлалтай байна. Энийг юу гэж харж байгаа вэ гэж асууж байгаа юм.

Х.Булгантуяа: Учрал сайд хариулах уу? Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Тодорхой бус байдлын үнэ, тодорхой бус байдлын индекс түүхэн дээд түвшиндээ хүрчихсэн байна. Бид төсвийн хүрээг өмнө хавар баталж байхад нүүрсний үнэ 80-аас нэмэх байсан шүү дээ. Тэгээд 80-аар хамгийн багаар бодоод оруулж ирсэн. Сарын дотор ч 70, 70-аас доош орсон шүү дээ. Тэгэхээр энэ чинь нөгөө биднээс шууд хамааралтай асуудал биш байхгүй юу. Тэгэхээр Засгийн газар мэдээж эрсдэлийг тооцно, эрсдэлийг тооцож байгаа. Тийм учраас хамгийн боломжийн юм байна. Яагаад гэвэл хувийн компаниудтайгаа ч уулзлаа, биржийн гэрээнүүдээ ч харлаа, олон улсын тэр Блүүмбергийн терминал дахь байгууллагуудын үзүүлэлтүүдийг ч харлаа. Тэгээд 70-аар тооцъё, бодитоороо л ярья. Тэгээд тоо хэмжээг 90-д хүргэх бололцоотой юм байна. Одоо зүгээр гүйцэтгэлээ харлаа л гэж, ингэж тооцож оруулж ирсэн. Тэгээд үүнийхээ төлөө.../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Номин гишүүн ээ, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.12 дээр нэгдсэн төсвийн суурь зарлага гэж нийт зарлагаас үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжих зардлыг хасаж тооцно гэж байгаа юм. 4.1.13 дээр энэ нэгдсэн төсвийн суурь тэнцэл гэж нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос зарлагыг хассан дүн гээд. Ингээд суурь тэнцлийг өнөөдөр бид төсвийн хүрээн дотор батлах гэж байгаа юм. Тэнцвэржүүлсэн тэнцэл, суурь тэнцэл гээд. Тэгэхээр түрүүний таны хэлж байсан, миний хэлж байсан 2 ялгаа чинь эндээ байгаа байхгүй юу. Тэгэхээр суурь тэнцэл гэхээр зөвхөн гадаад зээлийн ашиглалт, бондын дүнг, үнэт цаасны дүнг оруулсан дүнг хэлээд байгаа юм. Тэр дүнгээр энэ удаагийн 1,3 их наядын алдагдал чинь тайлбарлагдах байхгүй юу. Түүн дотор чинь нефть боловсруулах үйлдвэр байж байна, Эрдэнэбүрэнгийн УЦС байж байна, нийслэлийн 2 том цэвэр усны төслүүд байж байна гэх мэт хамгийн шаардлагатай нэн тэргүүний ирэх жилийн 5,7 хувийн эдийн засгийн өсөлтийг boost хийх ийм мега.../минут дуусав/

Х.Булгантуяа: 2026 оны төсвийн хүрээний мэдэгдлийг 2025 оны 5 сарын 30-нд баталсан юм байна Улсын Их Хурал. Ингэхэд аль хэдийн жишээлбэл Дэлхийн Банкны commodity markets outlook 2025 оны 4 сард гарчээ. Түүн дээр энэ бүгдийг нь уг нь зөндөө л биччихсэн байна лээ. Хятадын эдийн засаг саарах төлөвтэй байна, эрэлт буурахаар байна, үнэ буурахаар байна. Ялангуяа Хятад руу нийлүүлдэг гээд 3 улсын нэр дотор манай Монгол Улсын нэр бас байна лээ. 22 дугаар хуудсан дээр

байх шиг байна. Түүн дээр бүгдээрэнг нь бичсэн байна лээ. Тэгээд яах вэ тэр үед оруулж ирж байхад Улсын Их Хурлын гишүүд хэлж байсан юм л даа. Арай өөдрөгөөр оруулж ирээд байгаа юм биш биз дээ гэхэд бид эдийн засгийнхаа төлөвийг, төлөвлөгөөг мэдэж байна гэж л тухайн үед батлуулж байсан. Тэгээд яг төсөвтэйгөө нийлүүлээд ахиад л өөрчлөлт хийх нь төсвийн тогтвортой байдлыг хангахад тааруухан байна гэж уг нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Улсын Их Хуралд бүүр үүрэг чиглэл уг нь өгч байсан, Засгийн газарт ч гэсэндээ. Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаяр.

Д.Батбаяр: Ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд бид сая хэлж байна. Нөгөө 5 сарын 30-нд бид энэ төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг бид уг нь батлаад, тэрний дагуу 3 сарын хугацаанд мэргэжлийн зохих холбогдох байгууллагууд нь уг нь ажиллаад, судалгаагаа хийгээд, төсвөө багцлаад Улсын Их Хуралд өргөн барьдаг. Нэг ёсондоо хүрээний дагуу төсвөө уг нь өргөн барьдаг жамтай шүү дээ. Тэгтэл эсрэгээрээ болчихоод төсвөө багцалчихаад, тэрэндээ тааруулаад ахиад хүрээнийхээ асуудлыг ахиад өөрчилж гээд ороод ирдэг нэг ийм байдалтай болчихоод байна л даа. Тэгэхээр хүрээний хэрэг байгаа ч юм уу, байхгүй ч юм уу гээд хүн болгон гайхаж байгаа байх.

Энэ Эдийн засгийн хөгжлийн яамнаас тараасан нэг танилцуулга байна. 2025 он, 2024 он болон 2026 оны эдийн засгийн нөхцөл байдлууд гэсэн. Тэгээд энэ дээр тийм сайн зүйл ер нь харагдахгүй байгаад байна л даа. Ер нь салбар болгон дээр л саармагжилт, салбар болгон дээр зогсолт бий болохоор харагдаж байна. Тэгээд уул уурхай болон үйлчилгээний салбаруудын энэ өсөлт ерөнхийдөө зогсчихсон. Мөн уул уурхай, худалдаа, санхүү, уул уурхай биш шүү, санхүү, худалдаа үйлчилгээний салбарын ажилгүйдэл нь нэмэгдчихсэн. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь 945 сая доллар буюу 40 орчим хувиар эрс багасчихсан зөвхөн нэг жилийн дотор шүү дээ. Тэгээд нүүрсний үнэ буучихсан, одоо хил дээрх үнэ нь 67 доллар болчихсон яваа юм байна. Аман дээрх үнэ бүүр багасчихсан гэсэн үг шүү дээ. Сая 5 сард 80 доллар байсан бол одоо 3 сарын хугацаанд 67 доллар болоод бүүр буурчихсан. Өмнөх онтойгоо харьцуулбал нөгөө төсвийн орлого гэдэг зүйл маань бүүр 6 хувиар багасаад, нөгөө татвар төлдөг байгууллагуудын төлсөн татвар нь 10 хувиар багасчихсан. Нэг ёсондоо ажил хийж, орлого олж байгаа байгууллагууд нь 10 хувиар ингээд агшчихсан, Монгол Улсын эдийн засаг агшчихсан байна гэсэн үг байхгүй юу.

Тэгж байхад нөгөө талд нь эргээд дахиад энэ төсвийн зарлага нь болохоор бүүр 11 орчим хувиар ингээд нэмэгдээд ороод ирж байгаа байхгүй юу. Тэгээд гаднын нөхцөл байдал ч гэсэн ялгаа байхгүй энэ дээр л байгаа. 2026 онд Хятадын эдийн засаг ахиад үргэлжлээд буурна, 0,4 хувиар буюу, 0,5 хувиар буюу нийтдээ 4 хувийн өсөлттэй байх юм байна гэсэн таамаг гарчихсан Дэлхийн банкин дээрээс. Тэгээд энэ 0,5 хувийн бууралт гэдэг маань ойролцоогоор 14, 15 орчим сая тонн нүүрсээр буурч байгаа байхгүй юу. Нэг ёсондоо нүүрсний эрэлт ингэж буурч байна гэсэн үг. Тэгэхээр юу гэж асуух гээд.../минут дуусав/

Х.Булгантуяа: Батбаяр гишүүний микрофон нэг минут нэмж өгье.

Д.Батбаяр: Тэгэхээр яг юу гэж асуух гээд байна гэхээр сая Учрал сайд угаасаа хэлж байна шүү дээ. 5 сарын 30-нд энэ хүрээний мэдэгдлийг баталж байх үед байсан үнэ сарын дотор уначихсан, энэ тодорхойгүй байдал маш их байна гэж яриад байна. Тэгэхээр бид ерөөсөө ирэх оныхоо төсвийг ахиад батлах гэж байгаа

юм чинь энийг арай жоохон өөдрөгөөр, бодитойгоор, бодит үнэнтэйгээр, олон улсын дүнтэйгээр ингээд хүрээгээ оруулаад ирж болдоггүй юм уу? Энийг хүрээгээ, биш ээ доош нь буулгаад, илүү бодитой болгоод, саяын энэ яриад байгаа нүүрснийхээ үнийг бүүр доош нь буулгаад ингээд оруулаад ирж болдоггүй юм уу? Яагаад ингээд ихээр аваад байдаг юм бэ гэдэг асуулт асуумаар байна.

2 дугаарт нь энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуучихмаар байна. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бол энэ төсөв маань өөрөө тогтвортой, алдагдалгүй, үр дүнтэй байх тал дээр нь ер нь хариуцаж ажиллаж байдаг ийм байгууллага, өөрийн гэсэн.../минут дуусав/

Х.Булгантуяа: Батбаяр гишүүн нэмээд дараа нь тодруулчих тэгэх үү? Хариулт нь эхний шатаас, Учрал сайдаас хариултыг нь авчхаад, тэгээд Тогтвортой байдлын зөвлөлийнхөөс нэмээд тодруулчихъя. Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Тэгээд би Батбаяр гишүүнтэй юун дээр санал нэг байна вэ гэхээр үнэнээ бид ярих ёстой. 5 дугаар сарын 30-нд төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад яг хуулиар олгогдсон эрхийн хүрээнд юу байдаг вэ гэхээр Төсвийн тогтвортой байдлын хуульд Төсвийн зөвлөлийн ирүүлсэн макро тоонд үндэслээд, төсвийн хүрээгээ хийнэ гээд заасан байдаг. Тэгээд тухайн үед өмнөх Засгийн газрын үед Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нүүрс нь нэг ийм 88 доллар байх юм байна гэж ирүүлсэн юм байна л даа. Тэгэхэд нь багаар нь 80 доллар гээд тухайн үед баталчихсан. Тэгээд шинэ Засгийн газар байгуулагдах тэр цаг үед энэ эдийн засгийн байдал, энэ олон улсын геополитикийн асуудал, энэ худалдааны дайн, Ойрх Дорнодын мөргөлдөөн, энэ Хятадын эдийн засгийн өөрчлөлтүүд бол ингээд зарим бүсээрээ идэвхтэй, зарим бүсээрээ идэвхгүй ийм, ийм болчихсон байсан.

Тэгээд би өөрөө Эдийн засаг, хөгжлийн сайдаар томилогдоод энэ төсвийн хүрээ боловсруулах үүрэг надад ирсэн. Тухайн үед би батлагдсан төсвийн хүрээгээрээ явъя, 80 доллароор нүүрсээ бодъё, орлого, зарлагаа яг ингээд батлагдсанаараа явъя гээд Сангийн яам руу явуулсан бол Сангийн яам түүнд тохирсон төсөв боловсруулна. Тэгэхээр төсвийн орлого тасраад дахиад тодотгол руу явах байхгүй юу. Тийм учраас хуулиа харсан чинь Төсвийн тогтвортой байдлын хууль дээр төсвийн хүрээг ирэх намар оруулах бололцоо байхгүй болохоор нь орлого, зарлагыг нэгэн зэрэг буурсан тохиолдолд нэг удаагийн өөрчлөлтөөр Төсвийн тогтвортой байдлын хуулиа өөрчлөх бололцоог хуулиар та бүхэнд нээж өгсөн. Энэ хүрээндээ энэ шинэ төсвийн хүрээг боловсруулсан. Боловсруулахдаа нүүрсийг 70 доллароор л тооцож байгаа юм. Яах вэ энэ бол түрүүн хэлсэн би нөгөө хувийн хэвшлийнхэнтэй ч уулзалт хийлээ, тэр биржийн гэрээнүүдээ ч харлаа, тэр Блүүмбергийн терминал дахь байгууллагуудын үнийг ч гэсэн харьцууллаа. Яг ингээд энэ аргачлалынхаа дагуу ер нь 70 доллар гээд оруулах нь зүйтэй гэдэг байдлаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс саналыг нь аваад, энэ тоог боловсруулсан.

Дээрээс нь орлого, зарлагын аль алиныг нь бууруулсан. 31,6 болчихоод байгаа одоо бол орлого, багаар төлөвлөсөн. Зарлагыг бол энэ чинь 33,4 гэж батлагдсан зарлага шүү дээ. Түүнийг дахиад бууруулсан. Тэгээд урсгалаа хатуу барьчихсан, тэгээд суурь тэнцлээ 2 дээр нэмэх байлгахын тулд, эерэг гаргахын тулд бид яг энэ хатуу шаардлагуудаа бариад л Сангийн яаманд явуулаад, Сангийн яам энэнийх нь дагуу төсвөө ингээд боловсруулсан. Тийм учраас энэ бол тийм хэт өөдрөг биш, бас хэт гутранги биш ийм төсөөлөл гэж ингэж үзэж байгаа. Тэгэхгүй хэт их багаар орлого

төлөвлөөд, тэгээд Засгийн газраас ажил шаардах бол эрсдэлтэй. Ер нь Засгийн газар бол ажлаа хийх үүрэгтэй шүү дээ. Тийм учраас одоо ингээд л энэ биет тоо хэмжээг нэмэгдүүлэх, үүсээд байгаа асуудлуудыг цаг хугацаанд нь шийдэх, арилжаагаа нэмэгдүүлэх чиглэлээр олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа.

Жишээ нь ингээд л биржийн үнэ дунджаар 30 хувиар уурхайн ам нөхцөлтэй гэрээний үнээс өндөр байдаг. Биржээр арилжаалсан нүүрсний экспортыг тэргүүн ээлжид хийх зарчмаа бид баримтлаад ажиллаж байгаа. Гашуунсухайт боомтоор 1-ээс 6 сард өдөрт дунджаар 900 орчим тээврийн хэрэгсэл гарч байсан. Сүүлийн 2 сард 1400-аас 1600 болчихсон. Ингээд тэнд нөгөө менежментийн баг ажиллуулж байна. Яам болгон хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна. Ингэснээрээ 1,5-аас 1,7 дахин экспорт нэмэгдсэн. Биржийн бус жолоочтой тээврийн хэрэгсэл AGV терминалаар сард 10 рейс хийдэг болсон. Тэгээд жишээ нь Чайна Энержигийн нүүрс гэхэд л 8 вагон яваад эхэлчихсэн байна. Ингээд Хятадын талтай биржийн арилжааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээнүүдийг авч байна. Гаалийн журмаа шинэчиллээ, индексжүүлэх ажлуудыг цаг тухайд нь хийж байна гээд ингээд бид хийх ажлаа.../минут дуусав/

Х.Булгантуяа: Батбаяр гишүүн нэмж асууя.

Д.Батбаяр: Баярлалаа. Сая сайд хэлж байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн өгсөн дата дээр үндэслэж, төсвийн хүрээг хийж байгаа гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энэ эдийн засгийн байдлыг, олон улсын байдлыг ер нь юу гэж харж байгаа юм бэ? Нэг сайхан товч бөгөөд тодорхой яг энэ нэг минутад багтаагаад нэг хэлээч 1 дүгээрт нь? 2 дугаарт нь, Учрал сайдаас ахиад нэг нэмээд асууя. Энэ дээр нөгөө төсвийн орлого, зарлагатай холбоотой асуудал дээр нөгөө эдийн засгийн идэвхжил саатах эрсдэлтэй байгаа учраас төсвийн зардлыг нэмэгдүүлэх замаар эрэлтийг дэмжиж байна гэж. Энэ чухам ямархуу үр дүн гараад байгаа юм бэ? Тэгээд сая би түрүүнд нь нөгөө дурдсан татварын юу нь орлого нь бол 10 хувиар дутчихсан багадсан, зардал нь өөрөө 11 хувиар өсчихсөн байгаад байгаа юм. Тэгэхээр яг тэр зорилгодоо хүрч чадаж байна уу, үгүй юү? 10 хувиар зардлаа нэмэгдүүлээд байгаа боловч орж ирж байгаа татварын орлого, орж ирж байгаа.../минут дуусав/

Х.Булгантуяа: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хариулъя. Төсвийн хүрээний мэдэгдлийн тэгвэл их өндөр тоог Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн тооны хүрээнд. 3 номерын микрофон.

Н.Ууганбаатар: Батбаяр гишүүний асуултад хариулъя. Тогтвортой байдлын зөвлөл Ууганбаатар. Сая Учрал сайд тайлбарлаж байна. Ер нь бид нарын гаргасан таамаглал 3 сард буюу бид таамаглалыг хамгийн эрт гаргадаг байгууллага байгаа. Дэлхийн банк энэ тэр 4, 5 сард, тэгээд бусад нь үүнээс хойш Эдийн засаг, хөгжлийн яам бол 5 сард гаргадаг. Тэгэхээр 3 сарын нөхцөл байдал бол жоохон өөр байсан. Хуульд нэг ойлгомжгүй, тодорхойгүй зүйл байгаа нь төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах гэж байгаа тохиолдолд биднээр дахин таамаглал хийх, хийлгэх тухай асуудал байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ бол нэг хуулийн цоорхой байгаа гэж хэлж болно. Цаашид энийг нөхөх ёстой байх. Бид тэгвэл таамгаа update хийх шаардлагатай байгаа байхгүй юу. Тэгээд тэгвэл энэ процесс дахиад эхнээсээ явна. Ирэх жилүүдийн хувьд хамгийн магадгүй эргэлзээтэй тоо бол нэрлэсэн ДНБ-тэй холбоотой 102 их наяд арай жоохон өндөр байгаа болов уу бид бодож байгаа.

Энэ тухайлбал энэ оны хувьд эхний хагас жилийн гүйцэтгэлээр 40 их наядтай явж байгаа. Тэгээд бид уг нь хавартаа их эрчимтэй яваад, тэр эрчээрээ оноо.../минут дуусав/

Х.Булгантуяа: 3 номерын микрофоныг нэмж өгье.

Н.Ууганбаатар: Одоо бол намар жоохон эрчимжиж эхэлж байгаа. Тэгээд намрынхаа эрчээр намраа дуусгана. Тэгэхдээ хаврын эрчийг төдийлөн авч чадаагүй. Тэгээд тэр хуучин улирлын динамикаасаа жоохон энэ жил зөрчөөд байгаа. Тэгэхээр энэ жилдээ 90 гаруй их наядаар хаагаад, ирэх жил тэр нь 102 болтол цаашаа үргэлжилнэ гэхэд жоохон эргэлзээтэй байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатарын Ганбаатар.

А.Ганбаатар: 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28-ны төсвийн төсөл хэлэлцэж байгаа. Энэ хүрээндээ нэг асуулт байгаа юм. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ингээд тухайлбал гол орлого болох нүүрсний экспортыг 60-аас 70 сая тонн байна гээд Энхбаяр дарга өөрөө ч ярилцлага өгсөн байсан. Ингээд санал болгоод тавьчихдаг. Учрал сайд болохоор 90 саяд хүргэнэ гээд. Тэгээд заавал ингэж тулгах хэрэгтэй юм уу? Энэ зөвлөлийн чинь зөвлөмжийг авах ёстой. Энэ хүрээндээ ажиллах ёстой юм биш үү нэг?

Энхбаяр даргын энэ байгууллага чинь хэр хүчтэй байгууллага юм бэ? Зөвлөөд л орхичихдог юм уу? Зарим нэг хуулийн цоорхой байна гэж байна шүү дээ. Хэрвээ төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт хийвэл ахиад судалгаа шинжилгээ хийх боломжгүй гээд. Хэрвээ энэ байгууллагынхаа энэ зөвлөмжийг дагахгүй бол бид давсан төсөв, ихэдсэн төсөв гээд ингээд л байнга хэрүүлээ хийгээд л байх гээд байгаа байхгүй юу. Миний бодлоор нэг их хэмнэсэн төсвийг сайн төсөв гэж бодохгүй байна. Төсөв их байж болно, алдагдалтай ч байж болно. Хамгийн гол нь зарцуулалт, орлогоо зөв төлөвлөх ёстой гэж хараад байгаа юм. Тэгэхээр энэ дээр Учрал сайд хэр оновчтой төлөвлөж байгаа юм бэ? Энгийн жишээ гэхэд л саяын миний хэлдэг тэр 20 сая тонны зөрөөг яаж нөхөх юм бэ? Өөр салбараас орж ирэх боломж байхгүй харагдаж байгаа юм нэгд нь.

2-т нь Бямбацогт даргаас асууя гэж бодоод байгаа юм. Саяхан Эрчис Монголын захирал нэг мэдэгдэл гэх юм уу, ярилцлага өглөө л дөө. Уг нь Ерөнхий сайд цалинг нь хэмнэе, энэ төрийн өмчийн газруудыг багасгая, магадгүй заримыг нь хаая, уг нь хувьчлах ёстой шүү дээ, дуудлага худалдаанд оруулаад. Энэ чинь орлогын нэг үүсвэр гэж харж байгаа. Тэгээд 3 сая төгрөгийг юу гэнэ вэ, хэрвээ 3 саяар цалин авбал бид хулгай хийнэ гэдгээ шууд зарлалаа шүү дээ. Та энэ хүн дээрээ ямар арга хэмжээ авах юм бэ? Нэг ийм л 2 асуудал байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Эхлээд Учрал сайд хариулъя. Тэгээд Бямбацогт сайд хариулах уу?

Н.Учрал: Мэдээж энэ тоонуудыг гаргахад бид хамгийн боломжийн хувилбараар л тооцож байгаа л даа, тэрнээс биш зөвхөн нэг яамны ажилчид бид суугаад хийчхэж байгаа юм биш. Тэгэхээр яг тэр үнэ тооцохдоо, тоо хэмжээ тооцохдоо би бол өнгөрсөн хугацаанд тэр нэг биржийн гэрээнүүд бүртгэгдээд, энэ Гааль татварын санхүүгийн мэдээллийн технологийн төв дээр энэ big датанууд төвлөрөөд, энэ big дата дээр их анализ хийдэг болсон нь бол энэ тоо биет хэмжээг

төлөвлөхөд их дөхөм боллоо гэж харсан. Дээрээс нь тэр биржийн гэрээнүүдийг шууд ингээд цахим дээр бүртгээд авснаараа маш тийм анализ хийхэд их дөхөм болголоо гэж ойлгож байгаа. Тэгээд эдгээр дээр анализ хийсэн, тэр олон улсын байгууллагууд би өөрөө тэр Блүүмбергийн терминал дээр тэр 14, 5 байгууллагын яг тоонуудыг өөрөө ч гэсэн хэд, хэд харсан. Мэргэжлийн эксперт, шинжээчдийн санал бодлуудыг сонссон. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөнтэй ч гэсэн уулзалт хийсэн. Ер нь мэргэжлийн эдийн засагчид, санхүүчид, энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг бүрдүүлж байна.

Тэгээд бид энэ мэргэжлийн эрдэмтэн судлаачдын, салбарын экспертүүдийн үгийг сонсох ёстой. Тийм учраас би Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн байр суурийг бүрэн сонсож, түүн дээр ажиллаж байгаа. Тэр 70-аас 80 сая тонн байна байх гэдгийг би Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Энхбаярын ярилцлага дээр байсан юм болов уу гэж харсан. Тэрнээс биш бид яг энэ 9 тонн дээрээ ч гэдэг юм уу, тийм албан байдлаар ингэж тэр тоо хэмжээг бидэнд илгээсэн зүйл биш. Зүгээр нүүрсний үнэ дээрээ яг зөвшилцөөд, энэ хамгийн боломжийн үнэ юм гэж ойлголцолд бол хүрсэн. Тэгээд ер нь бид нэг зүйлийг ойлгох ёстой. Бид хаширлаад маш бага тоо хэлээд, орлогоо дахиад бууруулаад байж болно. Гэхдээ манай эдийн засаг өсөхгүй гээд л Засгийн газар нь яриад байвал гадаад, дотоод зах зээл хүлээж аваад юу гэж дүгнэх вэ гэдгийг бодох ёстой. Зээлжих зэрэглэлд ч нөлөөлнө.

Тэгэхээр энэ зээлжих зэрэглэлээ яаж хадгалж үлдэх вэ, энэ гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламж, нөгөө яриад байгаа энэ 1,3 их наядын тэр гадаадын зээлээр хийгдэх ажлууд чинь явж байж бид төгрөгийн ханшаа барих, энэ зээлжих зэрэглэлээ хадгалах, энэ эдийн засгийн өсөлтөө хадгалах, хамгаалахад энэ бол маш чухал үүрэгтэй юм билээ. Тэрнээс биш энд ингээд л нэг тийм гутранги байдлаар тэгээд оруулаад ирэх амархан л даа ер нь бол. Тэгэхдээ 1-д би шинэ ажил авсан, тэр хүрээндээ тоонуудаа мэргэжлийн хүмүүсийн саналд үндэслэе.

2-т энэ тусгай шаардлагуудыг нь хатуу барья, урсгал нэмэхгүй байя. Зарлагыг бид нөгөө тодотгосноосоо зарлагаа нэмсэн. Гэхдээ өмнө батлагдсан төсвөөс багасгасан шүү дээ адилхан. Тэгэхээр зарлага нэмнэ гэдэг бол цаанаа тэр чинь маш олон давуу талууд ажиглагдана шүү дээ. Цалин хөлс тавигдана, тэтгэвэр тавигдана, төсвийн бүтээн байгуулалт хийгдэнэ, дагаад эндээс чинь худалдан авалт нэмэгдэнэ. Тэгээд мэдээж энэ эрэлтийг дэмжинэ шүү дээ. Тэгэхээр ер нь цаашдаа ингээд л их агшаад л байхад нь хэмнэнэ, хэмнэнэ гээд байдаг, хариу арга хэмжээ авахгүй байж болохгүй. Тийм учраас энэ удаагийн төсөв дээр ч гэсэн геологийн салбар дахь нөгөө эрэл, хайгуулын зардлыг 2 дахин нэмэгдүүлээд, шинжлэх ухаанаа нэг жоохон дэмжээд, ингээд ороод ирж байгаа юм. Тэгэхгүй бол ийм үед зүгээр ингээд хумиад л байвал цаашаа эдийн засаг чинь цаашдаа тэр өсөлтөө хангаж явж чадах уу, үгүй юү гэдэг асуудал юм байна л гэж би ойлгож байгаа юм. Тийм.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд нэмж хариулъя.

С.Бямбацогт: 2014 онд уул уурхайн төрийн өмчит компаниудын удирдлага, менежментээр хангах чиг үүрэг бүхий Эрдэнэс Монгол компани байгуулж байсан юм байна лээ. Үүнд Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгой, Оюу толгой зэрэг компаниуд харьяалагддаг 16 компани. Яг үүнтэй адилхан бол уул уурхайн бус төрийн өмчит компаниудын удирдлага менежментийг хангах, менежментээр хангах үүрэг бүхий компанийг 2025 оны 1 дүгээр сард Эрчис Монгол компанийг байгуулсан. Үүнд МИАТ,

МТЗ энэ цахилгаан станцууд зэрэг компаниуд орж байгаа. Эрчис Монгол компани нь төрийн өмчит компаниудын удирдлагуудын цалинтай холбоотой асуудал дээр Засгийн газар бодлого барьж байгаа. ТӨК-удад дагасан шахаа, өндөр цалин авдаг, ажилчдаасаа хэд дахин илүү цалин авдаг гээд асуудал байнга гарч байдаг.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд нэмж хариулъя.

С.Бямбацогт: Энэ дээр бол Засгийн газраас төрийн өмчит компаниудын цалинг Улсын Их Хурлын гишүүд, сайд нарын цалинтай дүйцэхүйц цалинтай байя, улиралдаа хийсэн ажлынхаа үнэлгээгээр улиралдаа урамшуулал авдаг байя. Жилийн эцэстээ тийм үү KPI үнэлгээ хийлгээд төлөвлөгөө санхүү, орлого, ашиг, зардал энэ бүх үзүүлэлтийг дүгнээд жилийн эцэст давхар урамшуулал авдаг байя ийм зохицуулалтыг хийхээр судалгаа хийж ажиллаж байгаа. Энийг Эрчис Монгол компанийн захирал Амартүвшин ийм бага цалингаар ажиллаж чадахгүй, хулгай хийнэ гэдэг асуудал тийм агуулга бүхий ярилцлага өгсөн байсан. Үүн дээр сануулах арга хэмжээ авсан, сануулсан, 100 хоногийн хугацаатай үүрэг өгсөн байгаа. 100 хоногийн хугацаанд Амартүвшин захирал энэ харьяа компаниуд дээр тодорхой ажлууд хийж, менежмент санхүү, тодорхой маркетинг бүх чиглэлээр тодорхой ажлууд хийж, орлогыг нэмэгдүүлж, зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлсэн байх ёстой. Энэ ажлууд хийсэн үгүйтэй гүйцэтгэлийг нь харж байж дараа дараагийн арга хэмжээг авна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин.

Д.Энхтүвшин: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж 2 асуулт байна. 1 дүгээрт нь энэ төсвийн хүрээний мэдэгдлийг ойр ойрхон хэлэлцэж байгаатай холбоотой 15 жилийн дотор 21 удаа өөрчлөгдсөн ийм хууль байна. Ер нь Төсвийн тогтвортой байдлыг хангах ийм зориулалттай. Тэгээд үзэл баримтлал, үндэслэлүүд дээр болохоор зах зээлийн үнэ нь өөрчлөгдсөн, урьдчилан тооцох боломжгүй нөхцөлүүд бүрдсэн, экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ багассан гэдэг иймэрхүү шалтгаанууд явж байгаа. Тэгээд ингээд нэг удаагийн шинжтэй хуулиуд өөрчлөөд байхаар бусад хуулиуд дээр жишээлбэл зөрчилдөөнүүд гарч байгаа. Жишээлбэл өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа асуудал Дэгийн тухай хуулийг зөрччихсөн явж байгаа. Тэгэхээр бид өөрсдөө ингээд хуулиа зөрчөөд иймэрхүү байдлаар нэг удаагийн ийм аргацаасан байдлаар явмааргүй байна.

Тэгэхээр энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр өөрөө яг саяын нөхцөл байдлууд өөрөөр хэлбэл урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдал үүсвэл яах вэ, үнэ өөрчлөгдвөл яах вэ гэдэг заалтууд байгаа. Тэгэхээр энэ Төсвийн тогтворжуулалтын сан гээд 16 дээр 16.1 дээр ийм заалт байгаа юм. Тэгээд энэ дээр бүүр яг тодорхой заачихсан байгаа юм. Энэ санг юунд ашиглах вэ гэхээр саяын бидний яриад байгаа нөхцөл байдлууд дээр урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурвал зах зээлийн үнэ төсөвт тусгасан тэнцвэржүүлсэн үнээс буурсан бол, экспортын гол биет түүхий эдийн биет хэмжээ төсөвт туссан хэмжээнээс буурсан тохиолдолд гэх мэтчилэнгээр гээд ашиглах бололцоотой ийм Төсвийн тогтворжуулалтын сан гээд байгаа юм.

2025 оны 8 сарын байдлаар энэ сангийн хэмжээ 2 их наяд байгаа. Тэгэхээр энэ Төсвийн тогтворжуулалтын санг ашиглах ийм хувилбар луу заавал энэ төсвийн хүрээний мэдэгдлээ ингэж ойр ойрхон өөрчилдөг ийм байдал руу биш, өөр бусад хэрэгслүүдээ ашиглах талаар Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам ямаршуу

бодолтой байгаа вэ? Энэ санг ямар байдлаар өнгөрсөн хугацаанд ашиглаж ирсэн бэ гэдэг талаар мэдээлэл авмаар байна.

2 дугаарт, Татварын хуулийн төсөл иргэдээс санал авч байгаа, ААН-үүдээс санал авч байгаа. Тэгээд Сангийн яамны тооцоолсноор энэ нь төсөвт 4 их наядын нөлөө үзүүлэхээр гэсэн ийм тоо Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн мэдэгдэл ч бас, дүгнэлт дээр ч байна лээ. Тэгэхээр дүнг мэдээж энэ хууль он гараад өргөн баригдвал 2027 оноос хэрэгжиж эхлэх байх. Тэгэхээр 2027 оны төсвийн хүрээний төсвийн төсөөлөл дээр яг энэ үзүүлэлт туссан уу? Зүгээр яг одоо энэ өгсөн мэдээллээс харахаар тусаагүй шинжтэй харагдаж байгаа. Нэлээн том 4 их наяд гэдэг нэлээн том дүн учраас энэ өөрчлөлт ороогүй байгаа харагдаж байна.

Ерөнхий сайдын нэг ярилцлага дээр энэ дүн орчихсон, асуудал байхгүй гэсэн мэдээлэл өгсөн яриа байсан. Тэгэхээр энэ дээр яг энэ 4 их наяд орчмын энэ татварын энэ өөрчлөлтийг 2027 оны төсвийн төсөөлөл дээр ер нь энэ хаана орсон байгаа вэ гэдгийг асуумаар байна. Дээр нь зүгээр нэг тодотгож ийм 2 асуулт байгаа юм. Тодотгож нэг юм хэлэхэд сая Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт орсон. 21.30 дээр төсөв хэлэлцэх үед буруу мэдээлэл өгөх, нуун, санаатайгаар нуун дарагдуулах ийм асуудал нотлогдвол тухайн албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авахаар ийм заалт орсон байгаа шүү гэдгийг сануулж хэлээд саяын 2 асуултыг асууя.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулах уу? Жавхлан сайд.

Б.Жавхлан: Төсвийн хүрээний тоо асуулаа. Тэгэхдээ нөгөө татвартай холбоотой асуусан учраас би хариулчихъя. Бид Татварын багц хууль энэ маш том өөрчлөлт болж байгаа. 3 хууль дээрээ гурвуулан дээр нь. Тэгээд одоо хамгийн түрүүнд хамгийн их хүлээлттэй байгаа энэ НӨАТ-ын буцаан олголтыг 2-ыг 5 болгохыг 26 оны төсөв дээр тусгаж байгаа. Мөн 26 оны төсвийн хүрээн дээр ч хязгаар дээр туссан байгаа шүү, туссан байгаа. 27, 28 оны төсөөллийг бол одоо задалж ярих боломжгүй шүү дээ. Бид бол хязгаараа л ярьж байгаа. Хойтон 5 сард 27 оны хязгаарыг ярихад, батлахад төсвийн нөлөөллийг нь шууд оруулаад, татварын хууль хэрвээ энэ намартаа, хавартаа батлагдвал 27 оноос үйлчлэх тэр татварын параметруудийн өөрчлөлтийг төсөвт оруулаад явна гэсэн үг. Тийм. Тэр үед нь байхгүй юу. Энэ чинь ирэх нэг жилийн төсвийн хязгаар хүрээ, дараагийн 2 жилийнх нь төсөөлөл байхгүй юу. Төсөөлөл. Тийм, төсөөлөл чинь дараа жилийн яг бодит хязгаар болоод ирэх үед нь тэр төсвийн нөлөөллийг нь тэр жилийнх нь хязгаарт нь оруулна гэсэн үг. Ийм байна.

Х.Булгантуяа: Учрал сайд.

Н.Учрал: Төсвийн хүрээний мэдэгдлийг яагаад өөрчилж байгаа вэ гэхээр төсвийн хүрээний мэдэгдэл дээр орлогын доод хязгаараа баталдаг. Тэгэхээр орлогын доод хязгаар маань өөрөө хангагдахгүй болчихсон учраас төсвийн хүрээний мэдэгдэл өөрчлөгддөг. Тэгэхээр энэ зарлага дээр л тэр тогтворжуулалтын санг ашиглах болохоос орлого дээр нь ашиглах бололцоо байхгүй. Тийм учраас ер нь энэ Тогтворжуулалтын сан дээр хуримтлал үүснэ гэхээр чинь жишээ нь нүүрсний тэнцвэржүүлсэн үнэд 133 буюу 20, 19, 18 гээд жилүүдийн дунджийг гаргахад 133 болчихсон. Зэс дээр харин бага гарчихсан. Тэгэхээр зэсээс л нэг тогтворжуулалтын санд л орлого төвлөрнө гэхээс бусдаар нүүрснээс орлого төвлөрөх хүлээлт огт байхгүй байна. Тийм учраас Тогтворжуулалтын сан зөвхөн зарлага дээр. Тэгэхээр

төсвийн хүрээний мэдэгдэл ингээд орлогын доод хязгаар хангагдахгүй болсон учраас шинээр оруулж ирж батлуулж байгаа юм.

Х.Булгантуяа: Энхтүвшин гишүүн нэмж асуулт асууя.

Д.Энхтүвшин: Би нөгөө бүрдэл талаас нь биш, яг хуулиар 16.3 дээр болохоор энэ жишээлбэл өнөөдрийн үүсчихсэн байгаа 2 их наядыг ямар нөхцөлд зарах вэ гэдэг нь заавал энэ төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөхгүйгээр энэ сангаас ашиглах ийм тодорхой нөхцөлүүд байгаа байхгүй юу. Тэр нь саяын яриад байсан төсвийн орлого нь буурвал, экспортынх нь үнэ нь гэдэг тэрийг яаж ашиглах боломжууд байна, эсвэл шаардлага энийг ашиглах нөхцөл үүсэхгүй бол энэ хуулийн 16-гийн 3.1, 3.2-ыг өөрчлөөд ч юм уу, эсвэл энийг ашигладаг болговол бас нэг өөр арга хэрэгсэл байгаа юм. Тэгээд энийгээ яагаад ашиглахгүй байгаа юм бэ, энийг ашиглах юм уу гэдэг асуулт байсан.

2 дугаарт нь би Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс тэр 4 их наядын татварын өөрчлөлт орж ирэхээр байна. Энэ төсвийн нөлөөлөл хэрвээ ороод ирвэл тусгай шаардлагуудыг хангахгүй нөхцөл байдал үүсэж байна гэдэг ийм дүгнэлт гаргасан байсан. Энэ дээр та бүхнийг сая Сангийн сайд хэлэхэд бол арай жоохон өөр байдлаар хэллээ шүү дээ. Энэ нөхцөл байдал дээр та бүхэн нэг тайлбар хэлээч?

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Энхтүвшин гишүүн зөв юм асуугаад байна. Ер нь тогтворжуулалтын санг мөчлөг сөрж байх үедээ энэ алдагдалдаа ашиглаж болохгүй юм уу, алдагдлаа хааж болохгүй юм уу гээд байгаа юм. Тэгэхээр одоо тогтворжуулалт, Төсвийн тогтвортой байдлын хууль дээрээ тавьчихсан ашиглах шаардлагууд маань нэлээн босго өндөртэй. Тэр нөхцөл үүсээгүй байгаад байгаа учраас бид энийг ашиглаж болохгүй байгаад байгаа юм. Тэрийг та нөхцөлүүдийг нь харсан байх тийм ээ? Тийм. Тэгэхээр тэр нөхцөл одоохондоо үүсээгүй байгаад байгаа байхгүй юу. Одоо тэгэхээр тэрийг өөрчилнэ гэхээр дахиад л энэ сангаа яаж гэж байна гээд л бас бөөн улс төр болох байх. Та санаачлаад ороод ирвэл би дэмжээд өгье. Биднийг санаачлуулахгүй, бараг буцаачих байх. Тийм учраас энийг та гаргаад өгөөч.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай. Төсвийн тогтвортой байдлын, түр хүлээж байгаарай. 3 номерын индрийн микрофон Төсвийн тогтвортой байдлын зөвлөл.

Н.Ууганбаатар: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Тогтвортой байдлын зөвлөл Ууганбаатар. Тэр 4 их наяд 3-аас, 3,6-аас 4 их наядын шууд нөлөө үзүүлэхээр байгаа. Тэрний шууд бус нөлөөг давхар тооцох ёстой. Ер нь энэ удаагийн дүгнэлтэд бид нэг энэ төсвийн хүрээний мэдэгдэл маань өөрөө ирээдүй рүү чиглэсэн учраас ирээдүй рүү чиглэсэн зарим нэгэн дүгнэлтийг оруулахыг зорьсон. Энэнтэй холбоотойгоор нэг эрсдэл, бодит эрсдэл бол орлого тал дээр үүсэх 4 их наяд гэдэг маань тухайн жил хүлээгдэж байгаа Дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувьтай ойролцоогоор тэнцэхээр байгаа. 4 хувь гэдэг бидний тэнцвэржүүлсэн орлогын 2 хувийн алдагдалтай, хамгийн ихдээ 2 хувийн алдагдалтай байх, суурь тэнцлийн 2 хувийн ашигтай байх гээд 4 хувийн диффазоныг бүтнээр нь дүүргэхээр иймэрхүү дүр зураг харагдаж байгаа. Тэгээд

манай тэнцлийн 2 дүрэмд бол мөрдөгдөхгүй байх ийм нөхцөл байдал үүсэхээр байна гэсэн ийм анхааруулгыг сануулж байгаа. Цаад талын үндсэн санаа бол орлого талдаа реформ хийж байгаа бол зарлагын реформ зайлшгүй хэрэгтэй байна гэсэн ийм дүгнэлт байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай.

М.Мандхай: Энэ өдрийн мэндийг хүргэе. Би төсвийн энэ өсөлтийг олон улсын яах вэ жишээлбэл Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг харсан. Тэгээд дундаж өсөлт 5,4 хувьтай байсан. Тэгээд энэ нь өөрөө манай төсвийн өсөлтийн суурь 5,6 хувиас бага байгаа. Тэгэхээр би юу асуух гээд байна гэхлээр ер нь манайх өөрөө 5,6 гэж тавьсан нь 1 дүгээрт энэ төсвийн орлогыг илүү өөдрөгөөр тооцсон байна гэж дүгнэх гээд байгаа юм.

2 дугаарт магадгүй энэ өөрөө төсвийн зардлыг нэмэгдүүлэх ийм шалтгаан байсан юм болов уу? Үүнтэй холбоотойгоор асууя. Төсвийн өсөлтийн суурийг энэ олон улсын төсөөллөөс өндөр тавьж өгч байгаа нь ялангуяа бодит гүйцэтгэл 5-аас 5,4 орчимд хэлбэлзэж магадгүй байгаад байгаа. Тэгэхлээр ер нь энэ өсөлт нэг функтээр тасалдахад хэдий орчим тэрбум төгрөгийн, хэдий орчим төгрөгийн энэ орлогын тасалдал гарах вэ? Үүнтэй холбоотойгоор мэдрэмжийн тэр төлөвлөгөө хийсэн үү гэдгийг асуумаар байна. Мэдээж энэ түүхий эдийн үнэ гадаад эрэлт буурвал өсөлт угаасаа биелэхгүй нөхцөл байдал хүлээж байгаа. Тэгэхээр энэ дээр эхний асуултаа асууя.

2 дахь асуулт орлогын бүтцийг, орлогын бүтцийг харвал татварын энэ татварт хэт тулгуурласан орлогын бүтэц байгаад байгаа юм. Нийт 94 хувь нь үндсэндээ татвар дээр, татварын орлого дээр суурилчихсан байгаад байгаа. Тэгэхлээр хэрэв энэ татварын биелэлт тасалдвал ямар эх үүсвэрээр нөхнө гэж үзэж байгаа вэ? 2000-аас 2024 оны татварын бус орлого 15 хувьтай байсан, өнөөдрийн нөхцөл байдал 2024 он болон 25 оны, 26 оны татварын бус орлого 6 хувь болоод буурчихсан байгаад байгаа юм. Тэгэхээр бид ялангуяа энэ уул уурхайгаас хамааралтай ийм эмзэг улс 1 дүгээрт тасалдвал уул уурхайн орлого буурах, дээрээс нь татвараа авч чадахгүй ийм нөхцөл байдал үүсэх магадлал маш өндөр байгаа. Тийм учраас энэ татварын бус орлогын суурийг яагаад ийм хэт багасгасан юм бэ? Энэ дээр ингээд хариулж өгөөч.

3 дахь асуулт нь болохоор танилцуулга дээр төсвийн энэ 26 оны төсөв дээр төрийн хэмнэлтийн бодлого үргэлжилнэ гээд заачихсан байгаа юм. Төрийн байгууллагын үр ашиггүй зардлыг 5,7 хувиар бууруулж, хэмнэлтээр гарсан хөрөнгийг нийгмийн салбарт зарцуулна гээд, би нэгмөсөн 1 минутаа авчихъя тэгэх үү, гээд заачихсан байгаа юм. Тэгэхлээр энэ 5,7 хувийн хэмнэлт гэдэг чинь.../минут дуусав/

Х.Булгантуяа: 1 минут нэмж өгье.

М.Мандхай: Энэ 5,7 хувийн хэмнэлт чинь шинээр бий болж байгаа хэмнэлт үү, эсвэл юу гэдэг юм ийм шилжүүлэг юм уу, нэг хэсгээс нөгөөх рүү нь зардлыг шилжүүлж байгаа юм уу гэдгийг асуумаар байгаа. Ингээд 3 асуулт. Төрийн хэмнэлтийн бодлого үргэлжилнэ гээд 5,7 хувийн хэмнэлт, үр ашиггүй зардлыг 5,7 хувиар бууруулна гээд танилцуулга дээр байгаа. Тэгээд энэ нь хэдэн төгрөгийн

хэмнэлт юм бэ, хэрэв хэмнэлт нь өөрөө нэг байгууллагаас шилжүүлээд нөгөө байгууллага руу ийм хэмнэлтийг зарцуулах гэж байгаа бол аль байгууллагын ямар задаргаатай зардлаас гарсан юм бэ гэдэг дээр нэмэлтээр хариулаад өгөөрэй.

Х.Булгантуяа: Учрал сайд.

Н.Учрал: Эдийн засгийн өсөлтийг 2026 онд 5,7, 27 онд 6,3, 28 онд 6,5 хувь орчим байхаар тооцсон. Тэгээд таны хэлж байгаа нэр хүнд бүхий олон улсын байгууллагууд ч гэсэн энэ эдийн засгийн өсөлтийг ОУВС гэхэд 26 онд 5,5-тай байна, 27 онд 5,5, 28 онд 5,3 орчим байна гэж тооцсон. Дэлхийн банк мөн 26 оныг 6,5 гээд өөдрөгөөр, 27 онд 6,1 хувь гэж тооцсон. Азийн хөгжлийн банк бол 26 онд 6,6, 27 онд 5,9 хувь орчим байхаар тооцсон. Үүнд голлож нөлөөлөх зүйл юу вэ гэхээр уул уурхайн салбарт Оюу толгойн гүний уурхайн энэ нөлөөгөөр зэс, алтны агуулга нэмэгдэнэ. Тэгээд энэ бол том эерэг нөлөө үзүүлнэ. Дээрээс нь хөдөө аж ахуйн салбаруудад хэрэгжүүлж байгаа Атрын аян, Цагаан алт, Хүнсний хувьсгал аянууд нөлөөлнө гэж бид тооцож байгаа.

Түрүүн та нар орлогыг өндөр төлөвлөөд, зардал нэмэх гээд байгаа юм биш үү гэдэг байдлаар, тийм тэгж харж байх шиг байна. Төсвийн алдагдлын дээд хязгаар нь хуулиараа 2 хувь. Бид төсвийн алдагдлын дээд хязгаарт тулгаагүй, алдагдал 1,3 хувь дээр орж ирж байгаа. Тэгэхээр орлого өндрөөр төлөвлөөд зардал нэмнэ гэсэн ийм хардалт өгөх шаардлага байхгүй. Яагаад гэвэл алдагдлын орон зай байсан. Хэрвээ энэ 2 хувьд тулгаад орлого, зарлагаа аль алиныг нь өсгөөд, тэгсэн мөртөө алдагдалгүй төсөв байна гэж орж ирээд, хиймэл орлого төлөвлөчихвөл харин ингэж хардаж болох байх. Тэрнээс биш энэ өөрөө алдагдлынхаа орон зай байгаа учраас үүн дээр хардах шаардлага байхгүй гэж бодож байна.

Эдийн засаг мэдээж ирэх жилүүдэд саарах эрсдэл байгаатай холбогдуулаад мэдээж бид Засгийн газраас шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Жишээ нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг хялбар зохицуулалттай болгож, улсын жилийн төлөвлөгөөнд туссан төслүүдийг хэрэгжүүлнэ. Эдийн засгийн эрх чөлөөний хуулиа Их Хурлаас, Их хуралд оруулж ирж, 110 хуулийн өөрчлөлтөөр хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. Яг энэ эдийн засгийн мөчлөг сөрсөн бодлогын үед хувийн хэвшил дээр үүсгээд байгаа ачааг багасгах хэрэгтэй байдаг. Тийм учраас өнгөрсөн хугацаанд 58 журмыг, хууль давсан журмыг Хэрэг эрхлэх газрын дарга байхдаа тухайн үед цуцалж байсан. Үүнтэй холбогдуулаад энэ журмуудыг цуцлах ажил яригдаад, 90 хууль Зөвшөөрөл, мэдэгдлийн хуулиар орж ирснээрээ хүнд суртал буурна.

Төслүүдийг эрэмбэлсэн, түрүүн хэлсэн 149 төслийг 4 бүлэг, 15 зүйлээр эрэмбэлсэн. Засгийн газрын 14 мега төслийг төсөл хэрэгжээд эхэлчихсэн 5 төсөл, ач холбогдолтой 5 төсөл, ирэх жил биш, дараа жилээс нь хэрэгжүүлэх 4 төслүүдийг хойшлуулж байна. Энэ удаагийн төсөв дээр энэ эдийн засгийн 5,7 хувийн өсөлтийг хадгалахын тулд уул уурхай дээр хайгуулын салбарын хөрөнгө оруулалтыг 2 дахин нэмэгдүүлсэн. Хөдөө аж ахуйн салбарт зээл, тусламжаа нэмэгдүүлж байгаа. Эрчим хүчний салбарыг илүү зах зээл рүү шилжүүлнэ. Зах зээлийн зарчим руу, боловсруулах салбарт гангийн үйлдвэр, зэсийн үйлдвэр, Багануурыг түшиглэсэн хөх нүүрсний үйлдвэрүүдийг тэргүүн ээлжид урагшлуулна. Үүнийг бий болгохын тулд гадаадын хөрөнгө оруулалтын орчноо сайжруулах чиглэлээр хууль, эрх зүйн орчноо боловсронгуй болгоно. Ингээд 1,3-аар санхүүжүүлбэ, хөнгөлөлттэй зээлийн

хүрээнд тэр алдагдал дээр хийгдэх гэж байгаа хөнгөлөлттэй зээлийн хүрээнд ажлын байрыг шинээр нэмэгдүүлнэ гэдэг ийм зорилтуудтай байна.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Мандхай гишүүний асуултад хариулъя. Татварын орлого, татварын бус орлогын харьцааг ярилаа. Тэгэхээр татварын бус орлого гэдэг маань 4 төрлийн л орлого байдаг юм. Тусламжийн орлого, түрээсийн орлого, торгуулийн орлого, уул уурхайн бус төрийн компаниудын ногдол ашиг. Тэгэхээр ер нь манайтай ижил түвшний улсууд болон манайхаас дээш зээлжих зэрэглэлтэй улс гүрнүүд энэ татварын бус орлогоо аль болох багасгах чиглэл рүүгээ явдаг. Хөгжих тусмаа. Өөрөөр хэлбэл төр бизнест оролцохгүй, татвараа л авъя. Татвар нь буурвал дагуулаад л зардлаа бууруулах ёстой төрийн зардлаа.

Харин татварын бус орлого, таны, саяын миний хэлсэн түрээсийн орлогоо нэмэгдүүлье гэвэл баахан байшин барилга л төр түрээслээд байх нь байна. Тусламжийн орлогоо нэмэгдүүлье гадуур явж баахан тусламж гуйх хэрэгтэй болох нь. Торгуулийн орлого гэвэл энэ замын торгууль бүх торгуулиудаа л баахан нэмээд байх нь иргэд дээр ачаалал өгөх нь байна. Төрийн уул уурхайн бус компаниудын ноогдол ашгийг.../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж нэг минут.

Б.Жавхлан: Тийм учраас энэ татварын бус орлогын хувь хэмжээг цаашдаа ч гэсэн ер нь багасгах хэрэгтэй юм байгаа юм. 2015, 2016 онуудад энэ график харахаар тэр үед энэ татварын бус орлогын хувийн жин арай өндөр, тэгэхдээ 10-аас дээш гарч байгаагүй юм байна лээ. Тэр үед яах вэ эдийн засгийн уналттай байсан үе учраас ААНОАТ-уудын хувь хэмжээ буураад, татварын бус орлогуудынх нь хувь хэмжээ нь ингэж том ингэж харагдаж байсан ийм үеүд байна лээ. Тийм учраас цаашдаа энийг аль болох өсгөхгүй л байх хэрэгтэй.

Х.Булгантуяа: Мандхай гишүүн нэмж тодруулъя.

М.Мандхай: Миний асуусан тодорхой ерөөсөө асуултуудад хариулт өгсөнгүй. Бид хэд чинь Улсын Их Хурлын гишүүн болоод нэг жил нүүр үзчихсэн байгаа. Ер нь өөрсдийн чинь хариулдаг энэ тойруулж хариулдаг хариултыг бүүр залхтлаа сонсдог, ерөөсөө тодорхой хариулт авч чадсангүй гэж хэлмээр байна. Тэгээд би Сангийн сайдыг гайхаад байх юм. Татварын бус орлогыг буулгах нь илүү давуу тал гэж яриад байгааг би ерөөсөө ойлгохгүй байна. Үгүй ээ, харин эсрэгээрээ бид татварыг, аль болох л энэ татварын орлогуудаа л буулгах нь зөв юм шүү, ААН-үүдэд дарамт учруулахгүй, бусад орлогуудаа бид нэмэгдүүлэх нь ядаж манай эдийн засагт чинь таатай юм биш үү? Би бас ингээд асуултаа бэлдэхээсээ өмнө уншиж судалсан хүний хувьд хэлж байгаа юм л даа. Жишээлбэл зүгээр Япон улс гэхэд орлогын бүтэц, ялангуяа татвараас олж байгаа орлогыг хамгийн багадаа 62-оос 65 хувьтай барьж явдаг. Казакстан гэхэд дотоодын нийт, орлогыг ДНБ-тэй харьцуулахад 20-оос 22, манайх 30 байгаа шүү дээ. Тэгэхээр аль.../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Мандхай гишүүний асуултад дахиад хариулъя. Та бид хоёр 2 өөр хувь яриад байна. Нийт орлого дотроо эзлэх хувь, орлогоо татварын орлого,

татварын бус орлогоо ДНБ-д эзлэх хувийг та яриад байна. Би нийт орлого доторх татварын бус орлого, татварын орлого 2-ын харьцааг яриад байна. Тэгэхээр цаашдаа бид төсвөө ер нь хумьж байгаа учраас ДНБ-д эзлэх татварын орлого ч буурна, татварын бус орлого ч буурна. Төсвийн орлого доторх бүтцэдээ би хэлээд байна шүү дээ 4 төрлийн орлого байна. Тусламжийн орлого, түрээсийн орлого, торгуулийн орлого, уул уурхайн бус төрийн компаниудын ноогдол ашиг. Уул уурхайн компанийн ноогдол ашиг бол энэ чинь Баялгийн сан руугаа яваад орчихдог. Тэрийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Яг тэнцвэржүүлсэн тэнцэлд ордог энэ орлогын энэ 4 бүтцийг хэрвээ нэмэгдүүлье гэвэл төр баахан бизнес хийх гээд байна шүү дээ. Хувийн компанийнхаа ажлуудтай өрсөлдөж орох гээд байна шүү дээ. Тийм учраас төр энэ оролцоогоо багасгая гэж байгаа биз дээ. Энэнтэй та санал нийлж байгаа биз дээ?

Х.Булгантуяа: Мандхай гишүүн нэмж тодруулъя.

М.Мандхай: Та яах вэ нөгөө нэг төсвийн орлогыг ДНБ-тэй харьцуулсан арай нөгөө өөр талаас нь хараад үзэхгүй юу даа гэж би хэлмээр байна. Би нэг их өөр юм яриагүй байх, зүгээр өөр талаас нь л тайлбарласан юм.

2 дугаарт эдийн засаг, Учрал сайд маш буруу ойлголттой явж байгаа юм байна. Манай орлогыг өөдрөг төсөөлөөгүй, бид жишээлбэл хөдөө аж ахуй гээд, хөдөө аж ахуйн орлогыг таатай байна гэж үзэж байх шиг байна. Үгүй юм, энэ жил ялангуяа ган зудтай жил болсон. Одоогийн байдлаар улаан буудай 51,2 хувийн ургац алдчихсан, малын тэжээл 64,1 хувийн ургац алдчихсан, тосны ургамал 72,2 хувийн алдагдал хүлээчихсэн ингээд тариаланчид нийтдээ 20 тэрбум төгрөгийнхөө зээлийг төлж чадахгүй, хойшлуулаач гээд гуйгаад явж байгаа. Ер нь хөдөө аж ахуйгаас та нар хүлээгдэж байгаа орлогыг дахиад сайн наад мэдээллүүдээ сайн уншиж байж энэ.../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Мандхай гишүүнээ би дахиад хэлье. Та өөрөө яг буруу ойлгоод байна. Жишээ нь татварын багц хуулийг бид 4 их наядаар ингээд өртөгтэйгөөр хийлээ гэхэд татварын орлого буурна, бид энийг зориод байна шүү дээ. ДНБ-д эзлэх хувь хэмжээ чинь буурна. Харин тэр татварын бус орлогыг нийт орлого дотор байдаг тэр харьцааг бид өсгөж болохгүй. Ард түмнээ торгоод байж болохгүй, түрээсийн зах зээл дээр төр өрсөлдөөд байж болохгүй, уул уурхайн бус төрийн компаниуд баахан байгуулаад ноогдол ашгийг нэмээд байж болохгүй. Энэ чинь яг нөгөө хувийн хэвшилдээ орон зайг нь тавьж өгнө гэдгийнхээ эсрэг явах гээд байна шүү дээ. Харин ДНБ-д эзлэх хувь хэмжээг бууруулах нь гэдэг дээр санал нэг. Засгийн газар энийг чинь яг зориод ажиллаж байна. Татварын багц хуулийн өөрчлөлт чинь үүний эцсийн зорилго нь энэндээ хүрэх гээд байгаа юм.

Х.Булгантуяа: Та 2 нэг л юм яриад байх шиг байх юм уг нь. Харин тийм, сонсож байгаа бүх хүмүүс толгой дохиод л байх шиг байх юм. ДНБ-д татвараас, татварын орлогыг бууруулах нь зөв л гэж яриад байгаа юм биш үү та 2 чинь. Та 2 наадхаа тусдаа ярья. Тэгэхгүй бол бүүр нийгмийг бүгдээрэнг нь нэг юмыг 2 талаас нь яриад бүгдээрэнг нь юу яагаад байх юм. Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал гишүүн байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү.

Ц.Баатархүү: Эрхэм Монголчууддаа, Улсын Их Хурлын гишүүддээ намрын чуулганы энэ чуулганаар улсын төсөв хэлэлцэж байгаа, төсвийн хүрээ хэлэлцэж

байгаа энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Төсөв гэдэг бол тоогоор илэрхийлж байгаа хөгжлийн бодлого. Тэр дундаа өнөөдөр төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэнэ гэдэг цаашдаа ойрын жилүүдэд Монгол Улсын эдийн засгийн бодлого ямар байх юм бэ гэдгийг тойрч хэлэлцэж байна гэж бодож байгаа. Энэ салбар болгонд гарах зардлын хязгаар, ямар байдлаар улсын төсвийн орлого бүрдэх юм, эдийн засгийн төлөв байдал ямар байх юм бэ гэдгийг хэлэлцээд, энэ хүрээндээ маргааш төсвөө хэлэлцэнэ гэж ойлгож байгаа.

Би 3 зүйлийг тодруулъя гэж бодож байна. Энэ бодлогын асуудал гэж ойлгож байгаа. 1 дүгээрт, энэ манай энэ төсвийн хүрээний мэдэгдлээр бид ирэх жилийнхээ төсвийг батлахаар энэ ядуурал, ажлын байр, ажилгүйдэлд ер нь хэрхэн нөлөөлөх юм бэ? Ер нь бодлогын хувьд өнгөрсөн 30 жилийн энэ алдаа үргэлжлээд байна гэж би хараад байгаа. 1960 онд Солонгос улс эдийн засгийн чадвар багатай улс байсан, 90 он гэхэд эдийн засгийн хөгжилтэй улс болсон. Өнөөдөр бид 30 жил бүх салбарыг дэмжсэн зээлийн бодлого барьсан. Суурь эдийн засаг бүтээмжгүй байх шиг байгаа юм. Тэгэхээр жишээ нь жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээл гээд жил болгон 250-аас 300 тэрбум төгрөгийн зээл олгож байна. Энэний үр дүн яг ямар байдаг юм бэ гэдгийг асууя.

2 дугаарт нь энэ тэтгэврийн реформыг хэзээ оруулж ирэх юм бэ гэдгийг Учрал сайдаас асууя гэж бодож байна. Учир юу юм бэ гэхээр өнөөдөр ахмадууд тэтгэвэр нэмье гэж байгаа юм. Хэдүүлээ тоо харвал хөдөлмөрийн орлого буюу дундаж цалингийн 50-аас 70 хувьтай тэтгэврийн хэмжээ дэлхийн ихэнх оронд байна. Монгол Улсад тэтгэвэр авч байгаа хүмүүс 35-аас 45 хувьд хүрч байна хөдөлмөрийн орлогын. 2 дугаарт нь тэтгэвэр гэдэг бол хүмүүс ажил хөдөлмөр хийгээд хуримтлуулсан өөрсдийнх нь ирээдүйд хэрэглэх тэр төсөв юм. Энэ төрийн мөнгө биш. Тэгээд ингээд тэтгэврийг ингээд инфляцтай нийлүүлнэ, инфляцын хувь хэмжээтэй нийлүүлж тохируулж батална гэдэг хуультай, 6 хувиар нэмж оруулж ирж байна. Инфляцыг 8 хувьтай гэж байна. Тэгээд Жавхлан сайд нэмээд хариулаарай. Би жил болгон 10 хувиар нэмэхэд 4 дэх жил дээрээ тэтгэврийн хэмжээ 1 сая төгрөг болохоор байгаад байгаа юм. Тэгэхээр жил болгон 10 хувиар нэмээд явах энэ боломж бололцоо байгаа юм шиг харагдаж байгаа.

Дараагийн асуудал энэ тэтгэвэр дээр том реформ хиймээр байна. Дэлхийн зарим улс орон байна шүү дээ Учрал сайд аа, банкаар дамжуулж тэтгэврийн зээл авахаа больсон. Тэтгэврийн сан гэдэг институт өөрөө тодорхой эрүүл мэндийн зардал, барилга байгууламж, боловсролын чиглэлд урьдчилгаа мөнгийг тодорхой хувьтай, болзол.../минут дуусав/

Х.Булгантуяа: Баатархүү гишүүн нэмж нэг минут.

Ц.Баатархүү: Бид энэ оруулж ирж байгаа хүрээний мэдэгдэл, энэ төсөв энэ тэрээ ер нь нэг реформ хийж эргэж харахгүй бол өнгөрсөн жилүүдийн алдаа чинь яг адилхан байна. Би хэн нэгнийг онцолж шүүмжлэх гээгүй, 30 жил нэг ийм байдлаар л явсан. Нүүрсний үнэ өсвөл эдийн засаг нь өсдөг, нүүрсний борлуулалт унавал эдийн засаг нь тасалддаг. Валютын орлогын 42 хувь нь нүүрснээс хамааралтай. Байгаа баялгаа зарах тухай бид бүгдээрээ ярьдаг болсон. Тэгэхээр энэ тэтгэвэр гэхэд тэтгэвэр дээр ийм нэг реформ хийж болохгүй байгаа юм уу? Тэр хувийн тэтгэврийн санг хуульчлах, тэтгэврийн институт байгуулах, тэтгэврийн сангийн өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр анхаарч ажиллаад ингээд нэг тэтгэвэр энэ тэрээ нэмээд явахгүй бол зөвхөн ингээд нэг ийм төсвийн хүрээнд энийг яриад яваад

байхаар наад тэтгэврийн асуудал, бусад энэ хөрөнгө оруулалтын ажлууд чинь явагдахгүй юм байна гэдгийг хэлье. Ер нь энэ хөрөнгө оруулалтын ажил чинь 2 чиглэлд гарч байгаа юм байна лээ шүү.

Х.Булгантуяа: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Энэ нийгмийн даатгалын шинэчлэлтэй холбогдуулаад Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд хийгдэж байгаа ажлуудын талаар ярих нь зөв байх. Миний хувьд 2016 оноос хойш Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. Ингээд тухайн үед нийгмийн даатгалын шинэчлэл, тэтгэврийн реформыг хэрэгжүүлэх ажлын хэсгийг тухайн үеийн Их Хурлын дарга Занданшатар гаргаж, тухайн үед ажлын хэсгийг байгуулж, Хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг Их Хуралд өргөн мэдүүлсэн. Ингээд тэр чинь 10 дугаар сарын 2, ингээд тэр Хувийн нэмэлт тэтгэврийн хууль одоо хүртэл батлагдаагүй байна. Хувийн нэмэлт тэтгэврийн хууль бол цаанаа санхүүгийн салбарыг дэмжих хууль юм. Санхүүгийн зах зээлийг дэмжих хамгийн том механизм өөрөө хувийн тэтгэврийн шинэчлэл байсан. Тийм учраас тэр Хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам оруулж ирнэ гэдэгт би итгэж байна, тэгээд шахаж шаардана.

Миний эрхлэх асуудлын хүрээнд мэдээж 5 жилийн чиглэлээ 10 дугаар сарын 30-нд оруулж ирэхдээ энэ тэтгэврийн шинэчлэл буюу энэ хагас хуримтлалаас хуримтлалд шилжүүлэх, шимтгэлд суурилсан тэтгэврийн тогтолцоонд 95 оноос хойш шилжчихсэн мөртөө яг төлснийхөө хэрээр тэтгэвэр авдаггүй, энэ тэтгэврийн сангууддаа asset менежмент хийж чаддаггүй, ингээд энэ тэтгэврээрээ дамжуулаад эдийн засгаа 2 тулгууртай болгох арга замаа эрэлхийлж чадаагүй явж ирсэн. Тэгэхээр энэ тэтгэврийн шинэчлэлийг эдийн засгийн талаас нь харах ёстой гэж би ойлгож байгаа. Тийм учраас мэдээж Эдийн засаг, хөгжлийн сайдын хувиар энэ 5 жилийн чиглэлд зорилтот хөтөлбөр дотор 8 зорилтот хөтөлбөрийн энэ хүний хөгжил гэсэн энэ зорилтот хөтөлбөр дотор хувийн тэтгэврийн санг байгуулах, тэтгэврийн сангуудаа олон улсын энэ asset менежмент компаниудаар удирдуулах, нөгөө байгаа хөрөнгийг байгаа чигээр нь байлгаад байвал илжирдэг юм гээд нөгөө Тунгалаг тамир дээр гардаг шиг, нөгөө хөрөнгийн удирдлага хийх, зөв механизм руу явбал манай энэ эдийн засаг зөвхөн нэг тулгууртай, нэг банкны нэг ийм эдийн засагтай болчихсон. Тэгэхээр энэ чинь 2 тулгууртай болохын тулд санхүүгийн захаа дэмжихэд энэ тэтгэврийн реформ дэм болно. Тэгэхээр энийг би эдийн засгийн нүдээр харах ёстой гэдэг ийм бодолтой байгаа. Тэгэхээр би Баатархүү сайдын энэ санал санаачилгыг бүрэн дэмжиж байна. Тийм учраас энэ ажлыг манай парламент хийх ёстой гэдэг би ийм байр суурьтай байна. Ингээд үүн дээр Хөдөлмөрийн сайд нэмж хариулах байх гэж бодож байна.

Х.Булгантуяа: Хөдөлмөрийн сайд нь байхгүй байна. Учрал сайдыг бол энэ асуудлыг өнгөрсөн парламент ч гэсэн их ярьж байсан. Хувийн тэтгэврийн сангийн тухай хуулийг өргөн барьж байсан. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Баатархүү гишүүнийхээ асуултад хариулъя. Энэ нийгмийн даатгалын сан их том тогтолцоо юм байгаа юм. Тэтгэврийн реформ гэж хэлмээргүй байгаа юм. Энэ бол нийгмийн даатгалын тогтолцооны реформ байх ёстой. Тэгээд нийгмийн даатгалын санг төрийн мөнгө биш гэж хэлэхийн тулд төр өөрөө бүрэн оролцохоо болих хэрэгтэй, бие даалгаад явуулах хэрэгтэй. Гэтэл 2012-оос 16 онд энд нийгмийн даатгалын сангийн хамгийн том дампуурал, хамгийн том алдагдал тэр 5 их наяд төгрөг тэр үед бий болсон. Ингээд төр татаасаа нэмсэн, төр оролцоод

эхэлсэн, маш гүнзгий оролцсон. Тэгээд нийгмийн даатгал, тэтгэврийнхээ хэмжээг нэмэгдүүлэх аргачлал нь өөрөө инфляц байж болохгүй. Шаардлагатай нэмэгдэл хийвэл индексжүүлж л нэмэх хэрэгтэй юм байгаа юм. Нийгмийн даатгалын тогтолцоо, татварын гол философи нь юу байдаг вэ гэхээр тэтгэврийн хэмжээ бол шууд шимтгэлтэйгээ л холбоотой байх ёстой. Хэчнээн төгрөгийн шимтгэл төлсөн юм.../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулья.

Б.Жавхлан: Тэтгэврийн хэмжээ бол шимтгэлээрээ л тогтоно. Хэдэн төгрөгийн шимтгэл төлсөн юм, тэр хэмжээнийхээ тэтгэвэрт л тогтоолгоно. Харин нэгэнт тогтоолгосноос хойш инфляцад идүүлэхгүй байх, бодит өсөлтийг нь хангах нь төрийн үүрэг. Тийм учраас энэ хууль дотор нь тэгж орсон байгаа юм. Инфляцтай уялдуулж жил бүр нэмнэ гээд. Тэгэхдээ инфляцтай уялдуулахдаа хамгийн зөв аргачлал нь Төв банкныхаа мөнгөний бодлоготой уялдуулах хэрэгтэй. Мөнгөний бодлогын зорилтот түвшин хэд байна тэрүүгээр нь яг явах хэрэгтэй. Тэгэхгүй бид давуулж тавиад 8 хувь, 10 хувь гээд инфляцын маань зорилтот гол голч нь 6 гээд байхад нь аваачаад 10 хувиар нэмчихвэл энэ мөнгөний бодлого биелэхгүй. Харин ч бүүр инфляцаа нэмээд хаячихна. Ингээд нөгөө тэтгэврийн хэмжээ маань дахиад үнэгүйднэ, тэрний дараа жил нь дахиад өндрөөр нэмэх шаардлагатай болно. Энэ хооронд Төв банкны бодлогын хүү буурахгүй, улам нэмэгдээд, улам л мөнгөний өртөг нэмэгдээд. Тэгэхээр Төв банктайгаа зорилтот түвшинд.../минут дуусав/

Х.Булгантуяа: Сангийн сайд, Эдийн засгийн сайд 2, нэмж тодруулах уу? Баатархүү гишүүн нэмж тодруулья.

Ц.Баатархүү: Яах вэ хэдүүлээ ингээд бие биедээ эргүүлж тойруулж хариулаад байна л даа. Монгол Улсын суурь эдийн засаг бүтээмжгүй байгааг л илэрхийлээд байгаа юм. Маш энгийн дээ ажил хийж байгаа хүмүүсийн татвараар энэ орлого бүрдэж байна. Төрөлжүүлэх юм бол уул уурхай, нүүрс. Олон улсын зах зээл дээр нүүрсний үнэ унавал манай эдийн засаг тасардаг. Тэгэхээр эдийн засгаа төрөлжүүлэх чиглэлээр реформын шинжтэй бодлого орж ирэхгүй байна л гэдгийг хэлж байгаа юм. Энэ дээр хэдүүлээ анхааръя л гэж байгаа юм.

Хөрөнгө оруулалтын чинь зардал 27 хувь нь авто зам, дараагийнх нь барилга байшин. Энэ хөрөнгө оруулалт хийсний дараа Монголд юу үлдэх вэ, ямар өгөөж үлдэх вэ энэ дээр эдийн засгийн тооцооллууд байна уу? Ихэнх энэ зам барих, барилга барих түүхий эд гээд валют болоод гараад явчих юм биш биз дээ? Энэ барилга дотор ажиллах тэр урсгал зардлыг тооцож байгаа юм уу гэдэг дээрээ манай энэ төсөв.../минут дуусав/

Х.Булгантуяа: Баатархүү гишүүн үг хэллээ тийм ээ? Учрал сайд, Жавхлан сайд хоёр хоёулаа нийгмийн даатгалын тогтолцооны талаар маш сайн мэддэг, маш их ярьдаг хүмүүс. Тэгэхээр би ялангуяа Хувийн тэтгэврийн сангийн хуулийг Учрал сайд явуулах байх. Энэ бол өнгөрсөн хугацаанд ерөнхий хуулиар эрх зүйн орчин нь бий болчихсон, тусгайлсан хууль нь Улсын Их Хуралд өргөн баригдчихсан байж байгаад, хэлэлцэх асуудал, харин дууд л даа. Хэлэлцэх асуудалд байж байгаад, хэлэлцэгдэж амжаагүйгээр чуулган, өнгөрсөн парламент тарсан. Тэгэхээр үүнийг дахин оруулж ирж, Хувийн тэтгэврийн сангийн хуулийг оруулахдаа Учрал сайдыг онцгой анхаарч ажиллана гэдэгт итгэж байгаа шүү. Энэ манай тэтгэврийн реформын нэг том хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах.

Ж.Галбадрах: Гишүүддээ оройн мэнд хүргэе. 3 сайдаас 3 асуулт байна. 1 дүгээрт, төсвийн хүрээтэй танилцаад бидний баталсан жилийн хөгжлийн төлөвлөгөө маань биелэхээргүй төсөв болж байна гэж ингэж дүгнэж байна. Аудитын дүгнэлтэд хүртэл бичсэн байсан. 26 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан байсан 126 төсөл арга хэмжээ нь 76 болж багасжээ. 50 төсөл арга хэмжээ буюу 40 хувь хасагдсаны шалтгааныг санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байна гэж дүгнэсэн байсан. Тэгэхээр ер нь ийм бага тусгах байсан бол бид хөгжлийн төлөвлөгөө гаргаад л, тэр хөгжлийн төлөвлөгөөнд маш их олон санаануудыг бид ингээд тал талаас нь оруулж байсан. Тэгэхээр ингээд хөгжлийн төлөвлөгөө гаргаад, хөгжлийн төлөвлөгөөгөө бариад, төсвийн хүрээгээ гаргаад, тэгээд төсөв нь орох байтал бид өнөөдөр ингээд яг гишүүд ч гэсэн асууж байна. Энэ нь эсрэгээрээ төсөвтөө тохируулж, төсвийн хүрээгээ өөрчлөх ч юм уу, тэгээд хөгжлийн төлөвлөгөөгөө ингэж хасах ч гэдэг юм уу ийм зүйлүүд яваад байна гэж харж байна. Тэгэхээр эцэст нь энэ жилийн хөгжлийн төлөвлөгөө хэдэн хувиар биелэх бол 26 онд? 2-т, энийг би Учрал сайдаас асууя гэж бодсон юм.

2 дугаарт нь ер нь боловсролын салбарт хөрөнгө оруулалт 23 онд 526 тэрбум, 29 тэрбум байснаа 24 онд 723 тэрбум болж өссөн ч 25 онд мега төслүүдээ хөдөлгөх шаардлагатай учраас 40 орчим хувиар огцом бууруулж, 446 тэрбум болгосон. Өнгөрсөн 25 он, одоо энэ өнгөрч байгаа онд. Энэ нь боловсролын салбарт ихээхэн хүнд цохилт болоод байна. Ийм нөхцөлд бид боловсролын шинэчлэлийг хийе гээд нэлээн олон зүйлүүдийг, тооцооллуудыг гаргаж ирээд танилцуулаад явж байгаа. Сангийн яам, Боловсролын яам, Ерөнхий сайдын ажлын албанд танилцуулсан. Тэгээд энэ зүйл маань биелэхгүй юм биш үү? Бусад салбартай харьцуулаад үзэхэд 26 оны боловсролын салбарын хөрөнгө оруулалт нь зам, тээврийнхээс даруй 2 дахин бага байна. Өөрөөр хэлбэл ирэх жил боловсролын жил биш, зам тээврийн жил ч гэж зарлах ёстой юм шиг санагдаж байна л даа. Ийм байхад хүний хөгжлийн бодлого бол Засгийн газрын мега төсөл байна гэж гол зорилго болгосон маань хоосон лоозон болчих вий дээ гэж санаа зовж байна.

Тэгээд боловсролыг дэмжих жилд хүртээмжийг дээшлүүлэх зорилтоо бид биелүүлэх ёстой. Энэ жил 70 хүрлээ. Өнгөрсөн жил 60 давсан хүүхдүүдтэй байсан бол нэг ангийн хүүхэд 70 хүрсэн. Энэтэй холбогдоод ирэх жил хэрвээ энэ бидний төлөвлөж гаргасан тооцооллоор шинэ төсөл хөтөлбөрийг эхлүүлэхгүй бол 80 ч хүрч магадгүй байна шүү. Ийм учраас бид энэ боловсролын салбарыг жинхэнэ тэргүүлэх салбар гэж үзэж чадаж байна уу? Бид Сангийн яам, Боловсролын яамтай олон удаа уулзаж, нийслэлтэй ч олон удаа уулзаж, бүр гаргах байршлуудаа ч сургуулиудаа гаргаад явсан. Тэгээд энэ маань яасангүй, нэг минутаа үргэлжлүүлье дарга аа, энийг би.../үг тасрав/

Х.Булгантуяа: Галбадрах гишүүний нэмж нэг минут.

Ж.Галбадрах: Жавхлан сайдаас тодруулж асуух гэсэн юм. Дараагийн асуулт Наранбаяр сайдаас. Энэ жил олон шинэ төсөл хөтөлбөр оруулна, энийгээ АХБ-аас авсан, 130 сая долларын зээлээр хийнэ гэж ярьж байгаа. Тэгээд тэр зээлийг нь ингээд задлаад харахаар 26-аас 31 онд буюу 5 жилд тэгээд ердөө 41 төсөл хөтөлбөр л хийхээр ийм төлөвлөсөн байгаа. Тэгээд чуулганы нээлт дээр Амарбаясгалан дарга илтгэлдээ боловсролын хөрөнгө оруулалтаар онцгой анхаарахыг онцолсон. Мөн боловсролын салбарт жил бүр 36 сургууль, 32 цэцэрлэг барьж байж өөрөөр хэлбэл 68 юу буюу 28 он хүртэл 200 гаруй орчим шинэ төсөл,

хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэснээрээ бид нэг ангид байх хүүхдийн тоог 40-өөс бага барина, нэг сургуульд байх хүүхдийн тоог 1800-аас бага барина гэсэн тов тодорхой зүйлийг хэлсэн. Тэгээд энэ салбарын KPI буюу шалгуур үзүүлэлт нь энэ байгаа. Тийм учраас энэ зорилт Наранбаяр сайд биелэх үү, энэ хэзээ хэрэгжих вэ гэдгийг асуух гэсэн юм?

Х.Булгантуяа: Эхлээд Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Их Хурлаар батлагдсан Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл 126 байсан. Тэгээд сая ирэх оны төсөв дээр Эдийн засгийн хөгжлийн яам нөгөө жилийн төлөвлөгөөтэй энэ төсөв нийцэж байна уу эсэх дээр зөвшөөрөл өгөх ажил байдаг. Ингээд энэ хүрээнд харахад 126 төслөөс 60 хувь нь буюу 76 төсөл нь улсын төсвийн төсөлд тусгагдсан, үлдсэн 50 яах вэ, энэ 50-ийг хэрэгжүүлэх механизм нь төр, хувийн хэвшлийн түншлэл юм байна. Хэрэгжүүлэх гэхээр багадаа 1 жил 5 сар, зарим нь 2 жил болчихдог юм байна. Үе шатууд нь хэтэрхий их, том, гаднын хөрөнгө оруулалт татаад бариад, ашиглах, шилжүүлэх хэлбэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл хэрэгжүүлэхээр know how-ыг нь ашиглаж, ашиглаж баахан урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийлгэж хийлгэгчхээд хамгийн сүүлд нээлттэй сонгон шалгаруулалт гэж нэг юм зарлаад, тэгээд гаднын нэг компанид өгчихдөг. Тэгээд know how-аа ашиглуулсан хүмүүс яах вэ, оюуны өмч нь хаана хөндөгдөх вэ гээд. Тийм учраас бид энийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулж ирж үе шатыг бууруулж байгаа. Ингээд аймаг, орон нутаг бие дааж түншлэлийн төсөл хэрэгжүүлэх бололцоотой болж байгаа. Ингээд шийдсэн.

Улсын жилийн төлөвлөгөө Их Хурал дээр ажлын хэсэг гарахад Их Хурлын гишүүд тойргийнхоо олон бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг нэмсэн байсан. Ингээд тэр жилийн төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлэхийн тулд хөрөнгө мөнгө, тэгээд төслийн бэлэн байдлууд шаардлагатай. Дээрээс нь жилийн төлөвлөгөө бол зөвхөн төсөл, арга хэмжээнүүдийн жагсаалт биш. Энэ бол өөрөө салбаруудын бодлого. Тэгээд энэ утгаараа 5 жилийн чиглэл боловсруулах үүрэг шинэ Засгийн газарт ирлээ. 5 жилийн үндсэн чиглэл 8 зорилтот хөтөлбөр хуулийнхаа дагуу боловсруулах үүрэг ирсэн. Тэгэхээр энэ 5 жилийн чиглэлийг Шинжлэх ухааны академи, эрдэмтэн, судлаач нартай хамтарч боловсруулахаар ажлыг эхлүүлсэн. ШУА-ийн бага чуулганаар хэлэлцүүлгүүдийг 10 дугаар сарын 1-нээс эхлүүлнэ. Ингээд 31-ний дотор Их Хуралд өргөн мэдүүлнэ. 5 жилийн чиглэлээ цэгцтэй, хэмжиж болохуйц, нөгөө смарт гэж хэмжиж болохуйц, тодорхой, бодитой, цаг хугацаа нь тодорхой ийм ажлуудыг тусгах ёстой.

Тэгээд манай Галбадрах гишүүн, Мөнхсоёл гишүүн, манай Саранчулуун, тэгээд л манай Лувсанжамц энэ тэр бол энэ хөгжлийн бодлого дээр их анхаардаг гишүүд, ажлын хэсэг ч байгуулагдсан. Тэгээд Лувсанжамц гишүүний ярьж байгаа саналыг би бүрэн дэмжиж байгаа. Ер нь энэ индикаторуудыг л бий болгохгүй бол жишээ нь боловсролын салбарт гэхэд уншлага, уншлагын түвшнийг ахиулна гээд зорилго тавьчихдаг. Тэгээд дарга нар, төрийн албан хаагчид, байгууллагууд ажлаа үнэлүүлэхдээ яадаг вэ гэхээр уншлагыг сайжруулах чиглэлээр 2 эсээ уралдаан зарлалаа, 2 удаа форум хийлээ гээд хэдэн зураг явуулаад, тэгээд тэрийг нь 100 хувь хангагдсан гээд ингээд дүгнэчихдэг. Энэ индикатор өгч чадахгүй байгаатай холбоотой шүү дээ.

Тэгэхээр бид төлөвлөөд, төсөвлөөд, хянаад мониторинг хийх эрх Эдийн засаг, хөгжлийн яаман дээр байна. Тэгэхээр одоо яах вэ гэвэл индикаторуудыг өгнө. Жишээ нь уншлагын түвшнийг ахиулна гэж байгаа бол индикатор нь юу юм бэ гэхээр тестийн дундаж оноо нэмэгдэх ёстой байхгүй юу хүүхдүүдийн. Тэгээд дундаж оноо нэмэгдсэнийг нь үнэлбэл тэр индикатор. Тэгээд дундаж оноо нь хэд гарснаас шалтгаалаад оноог нь өгдөг, ингэж явдаг KPI үнэлгээ гэж байгаа энэ бол. Тэгэхээр индикаторуудыгаа зөв өгч чадахгүй болохоор хэмжиж чадахгүй байна. Тийм учраас энэ санал санаачилгыг бүрэн дэмжиж байгаа. Ер нь Хөгжлийн бодлогын хуульдаа ч гэсэн манай Их Хурлын ажлын хэсэг анхаараад, энэ жилийн төлөвлөгөө, энэ олон баримт бичиг, энэ ажлуудыг нэг ийм цэгцлэх, маш ойлгомжтой болгоход анхаарч өгөөч гэж би хүсэж байна.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя. Тэгээд Наранбаяр сайд.

Б.Жавхлан: Галбадрах гишүүний асуултад хариулъя. Эхлээд би Галбадрах гишүүнд талархал илэрхийлэхээр байгаа юм. Бид 2026 оны төсөв төлөвлөлт хийхдээ ер нь анх удаа Big data, яах вэ биднийхээ түвшинд л хиймэл оюун ухаан юм даа. Big dataаг программчлаад, боловсролын байгууллагын энэ салбарын хэрэгцээтэй сургууль, цэцэрлэг, дотуур байрыг эрэмбэлж гаргасан юм. Ингээд 108 сургууль, 95 цэцэрлэг, 61 дотуур байр нийт төсөвт өртөг нь 2,2 их наяд. Тэгэхээр 1 салбар дээр бид 2,2 их наяд нэг жилийн дотор төсөвт суулгах ямар ч боломж байхгүй. Энэ бодит үнэнтэйгээ эвлэрэх ёстой. Тэр бүү хэл одоо яг Боловсролын яамнаас яг бэлэн магадлал хийгдчихсэн зураг, төсөв бүх шаардлага хангаж байгаа хэдэн төсөл байна вэ гэхээр энэ чинь 5 төсөл л гарч ирж байгаа шүү дээ. Гуравхан сургууль, хоёрхон цэцэрлэг, тавхан төсөл бэлэн байгаа юм. Ингээд цаашаагаа бэлэн биш, гэхдээ хэрэгцээтэй энэ 108 сургууль.../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайдын микрофоныг нэмж өгье.

Б.Жавхлан: Юугаар санхүүжүүлэх вэ, ямар нэг байдлаар хөдлөх хэрэгтэй боловсролын жил дээрээ. Ингээд хамгийн боломжтой бэлэн байгаа эх үүсвэр маань Азийн хөгжлийн банкны 130 биш шүү, 150 сая доллар юм байгаа юм. Эндээ багтсан, энэ чинь Азийн хөгжлийн банкны зээл авахаар тэднийх өөрсдийнхөө стандартыг тавина, аягүй өндөр стандарттай, аягүй өөрсдийнхөө өндөр стандартын зураг, ийм ногоон байшин гэж яриад байгаа юм. Энэ зураг, энэ нөхцөлүүдээ тавина. Тэгээд зураг, төслүүд нь хийгдээд, магадлал нь эцэслэгдэж гараад ингээд ирэх жилээс төслүүд эхэлнэ. 41 төсөл гэдэг чамлахаар тоо биш шүү Галбадрах гишүүнээ, чамлахаар тоо биш. 41 цэцэрлэг, сургуулийг бид ирэх 3 жил цувууллаа, цувууллаа гэхэд бэлэн байдлыг нь хангаад хийж чадахгүйдээ төсөв дээрээс. Тэгэхээр Азийн хөгжлийн банкны шаардлагыг нь нийцүүлээд, ингээд нэлээн хурдтайгаар нэг дор ингээд шийдэж байгаа нь түрүүн Наранбаяр сайд хэлсэн. Яамнуудыг хөрөнгө оруулалтаар нь эрэмбэлэхэд Боловсролын яам хэрвээ энэ Азийн хөгжлийн банкны санхүүжилт ороогүй бол 9, энэ орсноор бүр 3 руу ороод ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр.../минут дуусав/

Х.Булгантуяа: Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Галбадрах гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ боловсролыг дэмжих жилийн хүрээнд таны оруулсан их хувь нэмэр өндөр байгаа. Энийг Боловсролын яамны зүгээс бид танд талархалтай хандаж байгаа. Энэ АХБ-тай бид зээлийн гэрээгээ ер нь 4 аравны, хагас жилээр байгуулна. Үүнээс

960-аас дээш суудалтай, 960 болон, 960 суудалтай ийм барилга яахын аргагүй 3 жилд хэрэгжихээр, бусад нь 1-ээс 2 жилд хэрэгжихээр ингээд байж байгаа. Түрүүнд 41 сургууль, цэцэрлэгийн барилга байгаа. Энэ нийтдээ 593,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй. 32 сургууль, 9 цэцэрлэг гэсэн ийм байдалтай байгаа. Энийг барьснаараа 1100 хүүхэд стандартын шаардлага хангасан орчин нөхцөлд СӨБ-д хамрагдана. 18880 хүүхдийн хүчин чадал бүхий 32 сургуулийн барилгууд орно. Энэ дээр яг бидний хувьд энэ газар зүйн мэдээлэл.../минут дуусав/

Х.Булгантуяа: Галбадрах гишүүн нэмж тодруулъя.

Ж.Галбадрах: Баярлалаа. Тэгээд бид ирэх жилийг боловсролыг дэмжих жил болгочхоод байгаа. Дээрээс нь яг тодорхой бүүр хөгжлийн төлөвлөгөөнд 45 сургууль, 45 цэцэрлэг гэж ингэж бүүр орж ирсэн байснаа явсаар байгаад ингээд багасаад сая би Жавхлан сайдын юунаас төсөвт яг нөхцөлөө хангачихсан байсан нь ердөө 3 сургууль, 2 цэцэрлэг. Би бас энийг улсын төсвөөр ахиухан шинэ төслүүдийг оруулаасай гэж бодож байсан юм. Тэгээд тэрнийхээ учрыг оллоо.

Нөгөө талаас Наранбаяр сайд энэ салбарын сайдад хэлэхэд бид КРІ буюу тэр 40-өөс доош оруулах гэдэг зорилгоо барьж л энэ шинэ төсөл хөтөлбөр оруулах гээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид бүх талаасаа энэ төсөв хэлэлцэх хугацаанд маш сайн тал талаасаа ярилцаж, энэ боловсролын салбарт оруулах өөрөөр хэлбэл тэр АХБ-аас авч байгаа нийт зээл дотроос нь ахиад тэр зээлээс ахиад тэр 130 биш, 150 байсан, тэрийг 250 руу, 200 руу дөхүүлэх энэ тэр тийм боломж нь байдаг юм уу дотор нь? Нийт.../минут дуусав/

Х.Булгантуяа: Наранбаяр сайд нэмж хариулах уу?

Д.Наранбаяр: Энэ дээр бид энэ 198 төсөл арга, хэмжээг ер нь энэ жил дуусгаж ашиглалтад бүрэн оруулна гэж байгаа юм. Нэг маягийн зургаар явах ийм тооцоотойгоор явсан боловч энэ холболтын зураг гээд их хэцүү ийм асуудал үүсдэг. Тэгээд холболтын зургаасаа болоод энэ барилгын үнэ нь өөрөө их савладаг. Энэнээс болоод бид бэлэн зураг төсөвгүй ийм төсвүүдийг оруулж ирж чадахгүй ийм байдал нөхцөл үүссэн. Ер нь ийм бэлэн зураг төсөвгүй байхаараа юу болж байна гэхээр төсөв дээр ерөөсөө ашиглалтад орж өгөхгүй 7, 8 жил барилга чинь бүгд ийм байдлаар орж ирээд л, эхний жил амсуулж өгөөд л, дараа жил нь ингээд, ингээд бага багаар явсаар байгаад юу ч биш болчихсон ийм барилгууд байгаа. Тийм. Тэгээд тендерээ зарлаж амжихгүй ийм нөхцөл байдал үүсчхээд байгаа юм. Ийм учраас бид энэ 198 төсөл дээрээ нэмэх нь энэ 41 барилгуудаа ингээд гүйцээгээд явахад нэг тодорхой хэмжээнд асуудлаа шийдэж чадна гэж харж байгаа. Цаашдаа энийг яг энэ хэлсэн энэ байдлаараа.../минут дуусав/

Х.Булгантуяа: Түрүүн Баатархүү гишүүн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас асуулт асуусан, ахмадын төлөөлөлтэй уулзаж байгаад сая хоцроод ороод ирэх шиг боллоо. Нэмээд хариулчхаач. Энэ нэлээн чухал асуудал хөндсөн. Аубакир гишүүний микрофоныг өгье.

Т.Аубакир: Уучлаарай, сая нөгөө ахмадын төлөөлөлтэй санал солилцож байгаад орж ирээд Баатархүү гишүүний асуултад яасангүй. Ер нь нийгэм, эдийн засгийн байдал, хүн амын насны бүтэц, дундаж наслалт, хөдөлмөрийн харилцааны хэв шинжийн өөрчлөлттэй холбоотойгоор тэтгэврийн даатгалын харилцаа нь удаан хугацаанд нэг хэв маягаар үргэлжлэх ер нь боломжгүй л дээ. Одоо энэ ахмадуудын

тавьж байгаа шаардлага үнийн өсөлт, инфляцтай холбоотой тодорхой хэмжээнд тэтгэврээ өсгөөд явах зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, ахмад настан санхүүгийн олон эх үүсвэрээс тэтгэврээ авах нөхцөлийг бүрдүүлэх, олон давхаргатай энэ тэтгэврийн тогтолцоонд шилжиж, даатгуулагчийн олон жил шимтгэл төлөхийг урамшуулах, тэтгэврийн доод хэмжээг аажмаар халах, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний тэтгэврээ олгох зорилго бүхий суурь тэтгэврийг нэвтрүүлэх хуулийн төслийг боловсруулаад үндсэндээ бэлэн болж байгаа юм. Тэтгэврийн тогтолцооны 3 дахь давхаргыг нэвтрүүлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр хамрагдах хувийн нэмэлт тэтгэврийн.../минут дуусав/

Х.Булгантуяа: Аубакир сайдын микрофоныг нэг минут.

Т.Аубакир: Нэмэлт тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэх хүрээнд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг судлаачид,, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчдын оролцуулсан ажлын хэсгийн хүрээнд боловсруулаад бэлэн болгочихсон байгаа Баатархүү гишүүн ээ. Тэгээд мөн Түвшин нарын өргөн барьсан хуультай уялдуулах, эргээд энэ төсөв дээр ирэх ачаалал энэ тэрийг нь тоолоод, тооцоод ажиллаад явж байгаа. Мөн манай яаман дээрээс бэлэн болчихсон хуулийн төсөл байж байгаа. Хувийн тэтгэврийн сантай болох, мөн олон давхаргат, олон эх үүсвэрээс тэтгэврээ авах бололцоог судалж үзээд үндсэндээ хуулийн төсөл бэлэн болсон энэ намрын чуулган чуулганаар хэлэлцүүлнэ. Энэ дээр мөн Түвшин нарын гишүүдтэй бид санал солилцох ёстой. Хуулиудаа зарим зүйлүүдийг нийлүүлээд явъя гэдэг дээр тогтсон байгаа шүү Баатархүү гишүүн ээ. Тийм.

Х.Булгантуяа: 2024 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн Нийгмийн даатгалын багц хуулиар жил болгон инфляцтай уялдуулж тэтгэврээ нэмэхээр болсон. Үүн дээр манай Жавхлан сайд сайн мэдэж байгаа. Жил болгон үүнээс хойш бид инфляцтай уялдуулж тэтгэврээ нэмж байгаа. Түүний өмнө зарим жилүүдэд ингээд өнжчихдөг байсан тэтгэврээ авагчдын хувьд, ахмадуудын хувьд их бухимддаг байсан асуудал нь тэр. Заримдаа 2, 3 жил өнжиж байж нэг нэмдэг, эсхүл сонгууль дөхүүлж байж нэмж нэмж байна гэж бухимддаг байсныг хуульчлаад одоо манай ахмадуудын хувьд жил болгон тэтгэврээ нэмэгдэх ямар ч байсан хууль, эрх зүйн орчин нь бий болсон. Аубакир сайд үүнийг онцолж хэлж байна. Нэгэнт ахмадууд, иргэдээс одоо 1,2 сая орчим нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид байгаа. Ажил хөдөлмөр эрхэлж байхад нь таныг ахмад насанд хүрэхээр өгнө гээд шимтгэлийг нь авчихсан учраас түүнийг жил болгон инфляцтай уялдуулж нэмэгдүүлэх үүргийг Засгийн газар хуулиараа хүлээсэн байгаа учраас сая 25 оны төсөвт ч, 24 оны төсөвт ч, 26 оны төсөвт ч орж ирж байгаа. Тэгээд Улсын Их Хурлаар ийм том хэмжээний хуулиудыг баталж гаргахын үр дүн энэ байгаа юм. Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа.

Э.Болормаа: Өнөөдөр хэлэлцэж байгаа төсвийн хүрээний мэдэгдэл дээр үндсэндээ яг 2 гол асуудал байгаа. Эхнийх нь орлогоо бид зөв тооцоолсон уу, 2 дахь нь төсөв алдагдалтай байх нь зөв үү л гэдэг ийм 2 үндсэн асуудал байгаа. Түрүүн сайдууд маань хариултдаа хэлэхдээ ер нь энэ томоохон төслүүдээс болж энэ алдагдалтай байгаа Эрдэнэбүрэнгийн УЦС, газрын тосны үйлдвэр гэх мэтчилэн зүйлүүдийг хэлж байна л даа. Гэхдээ өнгөрсөн жилийн алдагдалгүй төсөв дээр энэ мега төслүүд бүгд хэрэгжиж байсан. Тэгэхээр энэ жил яг л адилхан төслүүд

хэрэгжиж байна, эдгээрийн аль нь ч шинэ төсөл яг биш л дээ. Дөрөвхөн сарын өмнө бид төсвийн хүрээг дахин баталж байхад мөн л алдагдалгүй гэдэг байр суурийг энэ Улсын Их Хурал баталсан. Яг адилхан 126 гишүүн энд байна, дийлэнх сайдууд яг хэвээрээ байна. Монгол Улсын урт хугацааны, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд ерөөсөө өөрчлөгдсөн зүйл байхгүй байна.

Тэгэхээр яагаад бид ингэж байр сууриа томоохон өөрчлөх шаардлага үүсэв л гэдэг ийм асуудал байна л даа. Сая сайдын хэлээд байгаа шиг тийм түүхэн дээд хэмжээний тогтворгүй байдал үнэхээр үүссэн бол харин бид зардлаа танах ёстой юм биш үү улам бүүр? Дуусгаж чадахгүй барилгууд эхлүүлж бид яах юм бэ? Сая Наранбаяр сайд тодорхой хэллээ шүү дээ. Ингээд л амсуулаад л жил болгон дуусгаж чаддаггүй олон барилгууд байдаг. Яах вэ онолын хувьд алдагдал өөрөө буруу биш гэдгийг би ойлгож байна. Өнгөрсөн жил ч гэсэн энийг хэлж байсан. Гэтэл аудитын байгууллагын дүгнэлтээр ийм үр ашиггүй, үр өгөөжгүй төсөв байгаа цаг дээр алдагдалтай төсвийг дэмжихгүй. Тогтвортой байдлын зөвлөлийн хэлснээр ер нь төрийн байгууллагуудын мөрөөдлийн жагсаалтын нийлбэр болсон байна гэж энэ төсвийг дүгнэж хэлсэн байна. Тэгэхээр зардлаа нэг мөсөн танаад, алдагдалгүй төсөв өргөн бариач гэж байр сууриа хэлмээр байна.

Өчигдөр Ерөнхий сайд төсвийн танилцуулгадаа хэлсэн байгаа. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийе гэж маш чухал үг хэлсэн. Гэтэл бид энэ алдагдал оруулж ирнэ гэдэг чинь хөнжлөө даваад 1,3 их наядаар хөлөө жийж байна гэсэн үг шүү дээ. Үүнээс гадна 2 дахь том асуудал нь хөнжлөө өөрөө зөв хэмжээгүй байна. Орлогоо зөв тооцоолоогүй байна гэдэг чинь хөнжлөө бид буруу хэмжсэн байна гэсэн үг. Тэгэхээр би энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн даргаас асууя гэж бодож байна л даа Энхбаяр даргаас. Өчигдөр та бидний тооцооллоор бидний голлох бүтээгдэхүүн болох нүүрсний экспортыг ирэх жил 60-аас 70 сая тонн байна гэж тооцоолсон гэж байгаа. Засгийн газрын оруулж ирж байгаа төсөв дээр 90 сая тонн гэж өөдрөгөөр төсөөлсөн байна гэж хэлж байгаа юм. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тооцооллоор хэрвээ ирэх жилийн эцэст буюу 2026 оны эцэст 70 сая тоннын нүүрсний экспорт байвал энэ эдийн засагт яг.../минут дуусав/

Х.Булгантуяа: Учрал сайд нэмээд хариулъя. Дараа нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хариулахад бэлдэж байгаарай.

Н.Учрал: Өмнө нь батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдэл, хүрээнд төсөв батлагдсан. Тэгээд тухайн үед алдагдалгүй төсөв батлагдсан. Тэгэхдээ тэр чинь орлого, зарлага нь аль аль нь өндөр, тэр чинь 33,4 биз дээ, орлого, зарлага. Тэгэхээр нэг ёсондоо одоо бид орлого, зарлагаа аль алиныг нь бууруулж байгаа л гэсэн үг байхгүй юу үнэнтэйгээ нүүр тулж байна шүү дээ. 31,6 их наядын орлого олно, 1,9-өөр бууруулж байна, зарлагаа дахиад бууруулж байна 32 их наяд 980 юм зарлагаа. Зүгээр орлогоосоо зарлага нь өндөр байгаа буюу тэр дунд байгаа төсвийн тэнцлийн алдагдал нь өөрөө тэр гадаадын нэгэнт авчихсан байгаа хөнгөлөлттэй зээлүүдээ ашиглахад чиглэгдэж байгаа юм.

Гэхдээ Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагын дагуу 2 хувьд хүргэх буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьд хүргэх төсвийн тэнцлийн алдагдлыг тооцоогүй, 1,3 хувь байх гэдэг байдлаар оруулсан л гэж хэлж байгаа юм. Яагаад гэхээр түрүүн би хэлсэн. Энэ бол мөчлөг сөрсөн бодлого. Тэгэхээр одоо ийм үед тэр ажлын байр, хувийн хэвшлээ дэмжих, энэ хөнгөлөлттэй зээлүүд ч гэсэн дандаа л энд чинь томоохон төслүүд байна. Энэний чинь цаана шинэ ажлын

байрнууд нэмэгдэнэ, дотоодын туслан гүйцэтгэгч компаниуд ажилтай, орлоготой болно гээд ийм эдийн засгийнхаа эрэлтээ дэмжих, эдийн засгаа тогтворжуулахад хэрэглэдэг ийм тохируулга юм энэ чинь. Энэ тохируулга хэлбэрээр нь ашиглая, өнгөрсөн хугацаанд бид ерөөсөө тохируулга хэлбэрээр нь ашиглаж чадсангүй гэдэг байдлаар тайлбарлаж байгаа юм.

Тэгээд Болормаа гишүүний асуултад нэмээд хэлэхэд ер нь нэгэнт авчирсан зээлээ мэдээж ашиглаад явахаас өөр бидэнд зам байхгүй. Тийм учраас нэгэнт авсан зээлээ ашиглаад явна. Эрдэнэбүрэнгийн сая жишээг авч байна. Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц энэ жил эхлэх гэж байгаа, газрын тосны үйлдвэр Их Хурлаар нэмэлт санхүүжилтийг нь та бид баталсан. Тэгэхээр энэ юу вэ гэвэл нөгөө ЕРС 4 буюу мэргэжлийн байгууламжийн санхүүжилт одоо гарч эхлэх ёстой, удах тусмаа мэдээж энэ төсөл ач холбогдлын хувьд ч бай, цаг хугацаандаа эхлэх асуудал дээр ч бай зогсох магадлалтай учраас ингээд цаг хугацаандаа ашиглалтаа сайжруулаад явъя гэж ингэж тооцож байгаа. Тэгээд тэр 70 сая тонн гэдэг дээр Энхбаяр дарга өөрөө хариулах байх. Ер нь нөгөө одоогийн гүйцэтгэлийг би та бүхэнд хэлсэн. Тэгэхээр энэ жилийн гүйцэтгэлийг 85 сая тоннд хүрнэ гэж тооцож байгаа. Тийм байхад ирэх жил бид хувийн хэвшилтэйгээ ч уулзлаа, биржийн гэрээнүүдээ ч харлаа, энэ дээр хэрэгжүүлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээ ч ярилцлаа. Тээвэр ч нэмэгдэж байна, экспорт ч сүүлийн 2 сар нэмэгдлээ. Тэгээд ийм байхад бид өнөөдөр тэгээд нүүрсээ 90 сая тонн гэж төлөвлөөд, салбаруудаа, салбарын яамнуудаа шахаад шаардаад ингээд араас нь зохих арга хэмжээнүүдийг аваад явах нь буруу зүйл биш байх гэж бодож байгаа.

Тэгэхээр үнийг хэтэрхий хөөргөж байгаа зүйл биш. Биет хэмжээ нэмэгдүүлэх асуудал цэвэр гүйцэтгэх засаглалын ажил шүү дээ. Тэр урд хөрштэйгөө ярилцах, тэгээд л тэр хил гааль дээр үүсээд байгаа асуудлуудаа шийдэх. Тэгээд л одоо 2 сар гаруй хугацаанд гэхэд л юутай ч энэ менежментийн баг үр дүнтэй ажиллалаа. Тэгээд л экспорт нэмэгдэж байна. Тэгээд 9 сарын 28-нд Ганцмод дээр Өвөр Монголын удирдлагууд ирж ажиллана, хүлээгдэж байгаа 3 асуудлыг хамт шийдвэрлэнэ. Тэгээд ингээд үүний төлөө бүх боломжоороо л хичээж ажиллах ийм л байдалтай байна.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Болормаа гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. 2024 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд орсон өөрчлөлтөөр 4.1.13, 4.1.12 гээд ийм 2 өөрчлөлт орсон байгаа байх. Та амжвал энийг нэг эргээд хараадхаарай. Түүн дээр энэ цаашдаа ер нь төсвийн алдагдал гэж ер нь ямар ойлголт байх юм гэдгээ аягүй тодорхой болгочихсон байгаа. Цаашдаа төсвийн алдагдал гэдэг нь гадаад эх үүсвэрээс санхүүжигдэх зарлагыг л алдагдалд тооцно гээд маш тодорхой заачихсан байгаа. Бусад орлого, зарлага нэмэх 2 хувь байна, бүүр заавал нэмэх 2 хувь байх ёстой. Нийт татварын орлогоороо нийт цалин, тэтгэвэр тэтгэмж, хүүхдийн мөнгөө бүрэн санхүүжүүлээд цаана нь 2 хувийн давсан ашигтай байх ёстой шүү гэдгийг заачихсан байгаа юм. Тэрнээс энийг бид зохиож юм уу, эдийн засгийн агуулгаар нь ухаж яриад байгаа зүйл ерөөсөө биш. Хуульд ингээд заачихсан байгаа юм. Ноднин яасан бэ гэхээр алдагдалтай төсөв байж байгаад орлого гэнэт цөмрөхөөр бид төлбөрийн тэнцлээ хамгаалах шаардлагатай болж ирсэн. Ингээд 2.../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тэгээд ноднин анх өргөн барьсан төсөв дотор 2,3 их наядын зээлийн санхүүжилт байсан юм. Энийг бид дахиж тодотгол хийгээд 800-гаар бууруулаад, 1,5 дээр аваачиж байсан байхгүй юу. Одоо энэ түвшиндээ л нэг арайхийж авч орж байгаа ийм л асуудал. Тэгэхээр гадаад зээлээр санхүүжиж байгаа яг энэ хэсгээрээ л алдагдал болгож байгаа. Энэ нь өөрөөр хэлбэл хуулиар зөвшөөрсөн ийм гадаад эх үүсвэрээр санхүүжигдэх зарлага буюу алдагдал байгаа юм гэдгийг тодруулж хэлье. Энэ дотор байгаа төслүүд нь дандаа мега төслүүд байгаа. Эрдэнэбүрэнгийн УЦС, нефть боловсруулах үйлдвэр гээд. Хэрвээ ноднин 800 тэрбумаар багасаагүй байсан бол энэ жил эдгээр төслүүд нэлээн урагшлах байсан. Тэгэхээр энэ ашиглалтад орох хугацаанд нь тодорхой хэмжээний энэ санхүүжилтээс болж эрсдэл үүснэ. Иймэрхүү асуудлууд байна. Тийм учраас зайлшгүй энэ алдагдлаар эдийн засгийнхаа өсөлтийг санхүүжүүлнэ. Дээрээс.../минут дуусав/

Х.Булгантуяа: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 3 номерын микрофон.

Н.Энхбаяр: Болормаа гишүүний тавьсан асуултад хариулъя. Тэгэхээр цаг бага байгаа учраас би товчхон, товчхон хариулахыг хичээе. Монгол Улс 2018 онд төсвийн тэнцэл маань яг нэмэх, гүйцэтгэлээр нэмэх гарсан, эерэг гарсан байдаг.

Х.Булгантуяа: 3 номерын индрийн микрофоныг жоохон чангалах уу. Энхбаяр дарга жоохон өндөрдөөд байх шиг байна та.

Н.Энхбаяр: Тэгэхээр Монгол Улсын төсөв 2 удаа өнгөрсөн 15 жил 2 удаа нэмэх тэнцэлтэй гарсан байгаа 18, 23 онд. Тэгэхээр 18 онд Олон улсын валютын сангийн хөтөлбөрийг хэрэгжүүлээд нэлээн чамбай төлөвлөлттэй байсан байгаа. Тэгэхээр үндсэндээ бид энэ чиглэлээр төсвийн хариуцлагатай байх ёстой гэдгийг дэмжиж байгаа юм.

2 дугаарт тэр 70 сая тонн гэдэг дээр яг бидний өгсөн албан ёсны нөгөө дүгнэлт дээр энэ тоо байхгүй. Хэвлэлд өгсөн ярилцлага дээр байгаа. Тэгэхээр энэ дээр гишүүддээ тайлбарлах нэг зүйл байгаа. 2024 онд Монгол Улс нийтдээ 83,7 сая тонн нүүрс экспортод гаргасан байгаа дундаж үнэ 103 ам.доллар гаалийнхаар. Гэтэл энийг худалдан авч байгаа тал маань ангилал нь өөр байдаг. Бид гаалийн статистик дээр чулуун нүүрс ба хүрэн нүүрс гэсэн 2.../минут дуусав/

Х.Булгантуяа: 3 номерын микрофон нэмж минут өгье.

Н.Энхбаяр: Худалдан авч байгаа талд нүүрсний ангилал өөр учраас энэнээс 53,9 сая тонныг нь металлургийн буюу коксжих нүүрс гэж ангилсан байна. Бид нарын нөгөө 90, 100 доллар гэж. Тэгэхээр ийм ангиллын зөрөө байгаа учраас бидний цаашдаа экспортлох нүүрсний маань бүгдээрээ коксжих нүүрс байж чадахгүй. Энэ дотор эрчим хүчний нүүрс байна. Тэгэхдээ бидний зорих ёстой зүйл бол цаашдаа энэ яг Хятад улсын хэрэгцээтэй байгаа коксжих нүүрсний зах зээлийн 60-аас 70 сая тонноо тууштай хамгаалах ёстой гэдэг байр суурийг хэлж байгаа юм. Цаана нь үлдэж байгаа 20-оос 30 сая тонн бол эрчим хүчний нүүрс буюу Хятад улсын баримталж байгаа бодлогоос хамаараад хэлбэлзэх магадлал маш өндөртэй, эрсдэлтэй гэдгийг л хэлээд байгаа юм. Энэ талаар дараа Байнгын хороодын хурал дээр илүү тайлбар өгч болно. Ирэх жил батлах Хятад улсын ӨМӨЗО-ы хөгжлийн бодлогоос яг энэ биелэгдэх үү, үгүй юү гэдэг нь их зүйл хамаарах гээд байгаа юм.

Х.Булгантуяа: Болормаа гишүүн нэмж тодруулъя.

Э.Болормаа: Би яг аягүй тодорхой тоон асуулт асуугаад байна л даа. Монголбанкны судалгааны үр дүнгээс төсвийн алдагдал нь өөрөө Дотоодын нийт бүтээгдэхүүний 27 хувийг, инфляцын 28 хувийг, төгрөгийн ханшийн 21 хувийг дангаараа тайлбарлаж байна гэх юм. Тэгэхээр энэ буруу тооцоолно гэдэг чинь аягүй аюултай зүйл байхгүй юу. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийнэ гэтэл бид хөнжлөө даваад 1,3 их наядаар алдагдалтай, нэмээд хөнжлөө буруу тооцоолоод 70 сая биш, 90 сая гээд тооцчихсон. Тэгэхээр жилийн эцэст наад алдагдал чинь нэмэгдэхээр хэн хариуцлага тооцох юм бэ? Сайдууд сайндаа л огцорно. Энэ чинь яг иргэдийн бодит үнийн өсөлтөөр төлөөс нь төлөгдөнө. Тэгэхээр энэ тоондоо хариуцлагатай хандаач. Тэгэхээр нэмэлтээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хэвлэлээр хэлсэн байна уу, бичгээр хэлсэн байна уу энэ 70 сая болсноор яг ямар тоон нөлөө үзүүлэх вэ тооцоогоо гаргана уу гэж хүсмээр байна.

Х.Булгантуяа: Болормаа гишүүн үг хэллээ, тийм ээ. Улсын Их Хурлын гишүүн Загджавын Мэндсайхан.

3.Мэндсайхан: 26 оны төсвийн хүрээний мэдэгдлийг харж байхад Хөдөө аж ахуйн салбар яг 23 хувийн өсөлттэй гарсан байна гэсэн ийм танилцуулга байна л даа. Тэгээд би задаргааг нь харлаа. Тэгээд Хөдөө аж ахуйн сайд байхгүй байна. Хөдөө аж ахуйн салбарын өсөлт гэхээр экспортынх нь бүтцээ аваад үзэхээр өмнө нь сүүлийн 10 жилийн голлох бүтээгдэхүүн ноолуур байсан, нийт экспортын хөдөө аж ахуйн салбарын 95 хувийг эзэлдэг. Энэ тоо хэмжээ маань хэвээрээ байна. Гэтэл энэ салбар маань 23 хувийн өсөлттэй гарлаа гэж байна. Өнөөдрийн байдлаар энэ Хүнсний хувьсгал хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Монгол Улс дотоодын хүнсний хэрэглээгээ 50 хувийг нь хангадаг байсан бол өнгөрсөн жилийн байдлаар 85 хувийг нь хангадаг болсон, үр тариагаа дотоодоосоо 100 хувь хангадаг асуудлыг дэвшүүлсэн.

Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд бид арьс шир, ноос ноолуурыг, ялангуяа тэр дундаа арьс шир, ноос, дайвар бүтээгдэхүүнийг боловсруулъя. Энэ чиглэлээр хөнгөлөлттэй зээлийг гаргая гээд энэ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлээд явж байгаа. Бодит байдал дээр хөдөө аж ахуйн салбар өнөөдөр ургацаа алдчихсан. Үр тарианы асуудлыг тэр гурилын импортын хууль руу чихээд өнгөрч болно. Үгүй ээ, тэгээд хүнсний ногоогоо бид 85 хувь хангаж байсан бол энэ жил бид 50 хувийг нь дотоодоосоо хангах боломжгүй боллоо. Энэ бол бодлогын алдаа. Тэгээд хаана энэ 23 хувийн өсөлт явчхав эдийн засаг дээр?

Ноос, арьс шир, дайвар бүтээгдэхүүн, малын дайвар бүтээгдэхүүн жалгандаа хэвтэж байна. Энийг боловсруулах нэг ч үйлдвэр бий болсонгүй. Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд гарч байгаа зээлийн задаргааг үзэхээр өмнө нь явж байсан ноолуурын хөнгөлөлт, эргэлтийн хөнгөлөлтийн зээл болоод гараад явчихсан байгаа юм. Тэгэхээр энэ дээр хөдөө аж ахуйн салбарын бодлого маш буруу явж байна. Энэ тооцоолол худлаа байна. Би Жавхлан сайдаас хүсэлт байгаа нь юу вэ гэхээр зэрэг энэ баруун бүсийн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах гээд Үйлдвэр, технологийн паркийг Ховд аймагт байгуулаад барьж байгаа. Энэ дээр энэ оны төсөв дээр тодорхой төсөв тавигдсан байна. Гэхдээ энийг бүрэн тавьж өгөөч. Он дамжуулаад ингээд тавиад байхаар түрүүн сайдууд өөрсдөө зовлонгоо ярьж байна шүү дээ. Жил дамжаад явахаар, бага багаар амсуулаад явахаар тэрийг дагаад инфляц өсдөг, төсөвт өртөг өсдөг ингээд дуусдаггүй ажил байна. Тэгэхээр

энэ бага төсвийг та нэг шийдээд, энэ үйлдвэр технологийн паркаа бид ирэх жил ашиглалтад оруулаад оруулаад, энэ баруун талд энэ малчдын маань өмнө тулгараад байгаа энэ арьс шир, ноос ноолуурын асуудлаа шийдмээр байна. Боловсруулах үйлдвэрүүдээ барих боломжийг нь бүрдүүлж өгөөч гэж хүсэлт байна.

Нөгөө талдаа Учрал сайдаас энэ том bankable төслүүдээ хэрэгжүүлээд явахгүй бол одоо нэгэнт бид төсөвт хөрөнгө оруулалтын энэ орон зай бага байгааг ойлгож байна. Энэ Хөгжлийн банк чинь ер нь яах юм бэ? Энэ нөгөө найдваргүй зээлийн асуудлууд нь юу болж байгаа вэ? Тэгээд улсын төсөв хөрөнгө оруулалтын орон зай бага байна гэдэг тэр боломжийг нь олгож байгаа Хөгжлийн банк маань ингээд ажлаа хийж чадахгүй юм бол, энэ үндсэн чиглэлдээ ажиллахгүй юм бол энэ банк байх шаардлага байгаа юм уу? Энэ найдваргүй авлагын хэмжээ тэр өмнөх активын өсөлт нь ер нь ямар түвшинд байгаа юм бэ, энийг нь та нэг мэдээлэл өгөөч гэж асууя? Тэгээд тодруулъя.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Мэндсайхан гишүүнийхээ асуултад хариулъя. Харин тийм ээ, хэрвээ болдог, боломж нь байдаг ерөөсөө бүгдийг нь бүтэн, бүтэн тавиад л явчихмаар байгаа юм. Ингээд бид төсвийнхөө хязгаарынхаа хэмжээнд, төсвийн хүрээнийхээ хэмжээнд саяын хэлснээр нөгөө хөнжлийнхөө уртынхаа хэмжээнд ингээд оруулаад тавьчихсан байгаа юм шүү. Тэр хойшдоо боломжууд гардаг бол хэдүүлээ арай илүү ахиу, ахиу дээш тавиад явцгаана байх гэж бодож байна.

Х.Булгантуяа: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Хөгжлийн банк Их Хуралд Хөгжлийн банкны хуулиа боловсруулаад өргөн мэдүүлэхэд бэлэн болсон юм байна лээ. Тэгэхдээ дахин ажиллах хэрэгтэй. Тэгээд импортыг орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх ёстой банк сүүлдээ уулзвар зам санхүүжүүлсээр байгаад буруу замаар будаа тээсэн. Одоо зээлийн үлдэгдэл бараг 2,3 их наяд, хэвийн зээл нь 919, анхаарал хандуулах зээл нь 74 юм байна. Тэгэхээр энэ асуудлуудыг чанаргүй зээлүүдийг төлүүлэх тал дээр анхаарч байна. Тийм учраас хуулиа өргөн мэдүүлнэ, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлнэ, ТӨХК-удын хоорондоо үүссэн өр, авлага байна. Энийг нэг талд нь гаргана. Ингээд хамтраад шийдвэрлээд явна гэдэг ийм зорилготой байгаа. Тэгээд Хөгжлийн банкныг хуулийг нь оруулж ирнэ гэж хэлье.

Х.Булгантуяа: Мэндсайхан гишүүн нэмж тодруулъя.

З.Мэндсайхан: Жавхлан сайд энэ үйлдвэр технологийн паркийн асуудал дээр нэг онцгой анхаарч өгөөч, ирэх онд дуусах тал дээр нь анхаарч өгөөч гэдэг хүсэлтийг дахин тавимаар байна. Ер нь зүгээр хөдөө аж ахуйн энэ 23 хувийн өсөлт гэдгийг та бүхэн маань энэ тооцооллоо хийхдээ эргэж хараарай. Би хэлээд байгаа шүү. Тэр ноос, экспортын маань өөрөө 95 хувийг нь ноолуур бүрдүүлдэг хөдөө аж ахуйн салбарын. Энэ тоо зүгээр л самнасан шатлал буюу технологийн шатлал нь нэмэгдсэн болохоос биш ямар ч дэвшил гараагүй. Тэгээд 23 хувийн өсөлт гээд харахаар өнгөрсөн жил цаг уурын таатай нөхцөлөөс болоод мал өсчихсөн, тэр хуц ухнын хийсэн ажил бол Энхбаяр сайдын хийсэн ажил биш шүү дээ. Тэгээд тэрийгээ 23 хувийн өсөлт би мундаг юм хийчихлээ гээд байгаа. Яг талбар дээр нүүгээд очвол энэ салбар мундаг болно гээд яамаа нүүлгээд явсан, нүүж очсон газраа ургацаа алдчихсан иймэрхүү байдалтай байж болохгүй. Энэ дээр энэ бодлогын алдаа гарч

байна шүү Хөдөө аж ахуйн салбар дээр. Энийг Засгийн газар онцгой анхаармаар байна.

Х.Булгантуяа: Жавхлан сайд эхлээд хариулъя, тэгээд нэмж ажлын хэсэг хариулъя.

Б.Жавхлан: Тэр яг өсөлт Хөдөө аж ахуйн яамны бүтцийн өсөлтийнх нь тэр задаргааг судлаачид ажлын хэсгээс мэргэжлийн улсууд судалгаан дээр үндэслэж хариулах нь зөв шүү. Мэндсайхан сайд аа, энэ яах вэ тантай зүгээр нэг талаар санал нийлж байна. Энд тайвшрах өсөлт бол биш юм байгаа юм шүү хөдөө аж ахуйн өсөлт чинь. Яагаад вэ гэхээр бид ноднин айхтар хүнд зуд болоод, ургац алдаад үндсэндээ 40, 30 гаруй хувь уначихсан байхгүй юу салбар нь өөрөө. Тэгээд тэр суурин дээрээс өссөн өсөлт нь энэ жилийн эдийн засаг дотор өсөлт болж гарч ирж байгаа юм. Тэрнээс биш энэ жилийн өсөлт нь ноднингийнхыгоо нөхөөд, тэрний өмнөх жил дээр оччихсон зүйл биш. Тэрэн дээрээ хүрээгүй байгаа. Тийм. Тэгэхээр тэрийг тайлбарлаж хэлэх хэрэгтэй.

Х.Булгантуяа: Ажлын хэсэг 4 номерын микрофоноос нэмж хариулъя.

Л.Энх-Амгалан: Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яам гишүүний асуултад хариулъя. Хөдөө аж ахуйн салбарын өсөлт эхний хагас жилийн байдлаар 35 хувьтай байна. Энэ ҮСХ-ноос гаргадаг статистик. 35 хувьтай өсөхөд сая Жавхлан сайдын хэлснээр өмнөх 2 жил хөдөө аж ахуйн салбар нэлээд уначихсан байсан. Тэгэхээр тэр бага суурин дээрээс өвөлжилт, хаваржилт харьцангуй таатай байсантай холбоотойгоор зүй бус хорогдол бага байсан. Төл хүлээн авалт сайн байсантай холбоотойгоор ийм өндөр өсөлт үзүүлээд байгаа. Бидний хувьд энэ жил зуншлага, ялангуяа ган ихтэй байгаа учраас энэ өсөлт бага зэрэг саарах төлөвтэй байна. Оны төгсгөлд 23 орчим хувьтай болж саарах болов уу гэсэн ийм төсөөлөлтэй. Тэгээд нийт энэ жилийн тухайд нийт 5,5 хувийн өсөлтийн 2 хувь нь энэ Хөдөө аж ахуйн салбараас бүрдүүлж байгаа. Дараа жил харьцангуй саарна. Нийт 5,7 хувийн өсөлтийн 1 орчим хувь нь хөдөө аж ахуйн салбар.../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн, Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тэгэхээр энэ хөдөө аж ахуйн салбар дээр ноднингоос хойш Засгийн газар нэлээн олон арга хэмжээнүүд авсан. Хөдөө аж ахуйн салбараа уламжлалтын том салбараа хамгийн их ажлын байрыг шингээдэг салбар шүү дээ. Энийгээ сэргээхийн тулд маш олон үндэсний томоохон хөтөлбөрүүдийг бүрэн санхүүжүүлсэн, ноднингоос хойш Шинэ хоршоо, Хүнсний хувьсгал, Цагаан алт энэ урамшууллын бүх хөтөлбөрүүд маань тултал, тултал явлаа. Ингэсний үр дүнд Хөдөө аж ахуйн яамныхан салбарынхан ч, тариаланчид, малчид бүгдээрээ л хичээсэн. Тэгээд хөдөө аж ахуйн салбарт гарч байгаа энэ сэргэлтийг бас голж болохгүй шүү. Голж болохгүй. Энэ жилийн 5,7 хувийн өсөлт дотор байгаа ихэнх нь бараг 60 хувь нь энэ хөдөө аж ахуйн салбарын ноднингоо унасан тэр суурин дээрээсээ сэргэж байгаа энэ сэргэлтийн л үр дүн юм байгаа юм. Магадгүй 23 оныхоо тэр өсөлт өсөж байсан тэр хэмжээндээ арай хараахан хүрээгүй байгаа. Гэхдээ сэргэж байгаа юу гэвэл сэргэж байгаа. Энэ сэргэлт бол энэ жилийн эдийн засгийн өсөлтөд маш эергээр нөлөөлж байгаа гэдгийг бүүр тодруулж хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат.

Д.Ганбат: Бид нэг төсвийн хүрээний мэдэгдэл, төсвөө ярьж байна л даа. Тэгэхээр энэ бүтэн жилдээ бодлого ямар байх вэ гэдэг нь ингээд харагдаад явах байх. Ер нь ямар бодлого байгаа юм бэ энэ жилийн төсвийн хүрээ, төсвийн мэдэгдлийн цаана, юугаар гийгүүлэх юм бэ ард олноо? Энэ дампуураагүй салбар байгаа юм уу манай улс оронд, бүгд л дампуурчихсан юм шиг байна шүү дээ. Зүгээр жишээ татаад л ганц, хоёрыг нь хэлж болж байна би, минут хугацаатай юм чинь.

Манай Ардын намынхан маань өдрөөс өдөрт л хөрөнгөтний нам шиг л харагдаад байна л даа. Хэдэн дарга нь улам л баяжих юм. Нөгөө Ардын намын гишүүд ард түмэн маань улам л ядуураад байх юм. Авлига ихсээд л байх юм. Энэ маань ямар учиртай юм бэ? Энэ чинь багасах шинж алга энэ төсвийн байдлаар бол. Та нарын нөгөө мөрийн хөтөлбөрт чинь дотоодын нийт бүтээгдэхүүний 20 хувь нь улсын төсөв байна гэж та нар чинь зарлаад л яваад байсан шүү дээ. Тэгээд энэ чинь залилан болж байна уу? Ард түмнийг залилсан. Та нарын наад төсөв чинь өнөөдөр ярьж байгаа нь 30 хувьтай байна. Бүх яамны сайдууд хариулаарай. Ямар гэрэл гэгээтэй баян юм болох юм, яах юм гэдгээ? Одоо хар Боловсролын яам нэг сандал дээр гурвуулаа сууж байна хүүхдүүд, нэг ангид далуулаа байна. Үгүй ээ яахаараа ийм байдаг юм бэ? Бид чинь 2021 онд 17 наядын л төсөв ярьдаг байсан шүү дээ. Одоо бид 33 наядын төсөв ярьж байна. Тэгээд хар л даа энэ яамны тоо 18, та нар тэгээд дангаараа засаг барьж байгаа юм бол наадхаа 9 болгочхож болдоггүй юм уу 9 яамтай байж гэх мэтчилний ийм асуултууд байна.

Сүүлийн арваад жилд хурал цуглааныг маш их хийсэн шүү дээ. Дандаа л худлаа ярьдаг, бас энэ юмаа тэгээд л дандаа л яриад явах юм байна л даа. Тэгээд л 126 гишүүнтэй боллоо гээд л байсан. Хаана байгаа юм, юм сайжирна гээд байсан, улам л дордоод байх шиг байх юм. Тэр харж байхад энэ хил холболтын гэрээ энэ тэр гээд юмнууд яриад байна л даа. Үгүй ээ бид яахаараа 200 сая тонн нүүрс гаргадаггүй юм бэ? Зориуд л энэний эсрэг ажиллаад байх юм. Яаж ядуу байлгах вэ, яаж Монголчуудыг гэртээ байлгахгүй, эх орондоо амьдрах тийм юмыг нь хааж боосон, хувийн хэвшлүүд хийхгүй юм алга л байна шүү дээ. Тэр эрчим хүчний станцыг чинь хамгийн том турбинтэй 150 мвт-ын турбинтэй тийм юмыг хийж чадаж л байна шүү дээ. Тэгээд төр хамаг юмыг сайхан хийнэ, бид хийчихнэ гээд байдаг. Үндсэндээ 1 төгрөгөөр хийх юмыг 2 төгрөгөөр хийж байна. Тэгээд их луйвар их байна шүү дээ. ХЗБХ-ны даргаар ажиллаж байх үед би.../минут дуусав/

Х.Булгантуяа: Одоо тэгээд Ганбат гишүүн сайд болгон хариулах уу? Салбар болгондоо 26 он болох гэж байгаа гэрэл гэгээтэй зүйлийг дурдана уу гэнэ? Учрал сайд. Дамдинням сайд. Бүгдэд нь 1, 1 минут өгдөг юм уу, тэгэхдээ тийм дэг байхгүй шүү дээ. Эхний сайд нь, харин тийм, тийм дэг байхгүй. Үгүй ээ, эхний хүн нь нэлээн ихийг нь ярих юм шиг байна шүү. Дэг нь тийм байхгүй байхгүй юу. Тийм, дэг нь тийм байхгүй, тийм шүү дээ. Хэрэг эрхлэхийн дарга эхлээд нэгтгэж эхний 4 минут дээр нь та явах нь зүйтэй байх. Эсхүл Учрал сайд Эдийн засаг, хөгжлийн сайд төсвийн хүрээ оруулж байгаа юм чинь. Ямар хэцүү юм бэ, би бүүр хуваарилалт хийгээд. Учрал сайд хариулъя. Та хамгийн сүүлд, та тэгээд үгээ хэлье.

Н.Учрал: Ганбат гишүүний асуултад хариулъя. Тэгээд та энэ хувийн хэвшилд маш олон компаниуд, чадварлаг компаниуд олон байна гэж хэлсэн. Би үүнтэй санал нэг байна. Үнэхээр хувийн хэвшлийг бүрэн дэмжиж чадвал цаашдаа маш олон бүтээн байгуулалтын ард гарч чадна. Тийм учраас энэ хувийн хэвшлийг дэмжсэн, төрийн оролцоог бууруулсан ийм төсвийн хүрээ, төсвийн төсөөллийг оруулж ирсэн. Энэ удаагийн төсөв ч гэсэн төрийн оролцоог бууруулснаараа олон тоонуудаараа

илэрхийлж байгаа. Тэгээд энэ юу вэ гэхээр түрүүн энэ төсвийн хүрээний үед танилцуулаад байгаа орлого, зарлагаа аль алиныг нь бууруулсан. Түүнийхээ цаана бид нийт дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ болоод тэнцвэржүүлсэн орлогынхоо харьцааг 28 он гэхэд 28 хувь бууруулах буюу одоогийн 37, 28 он хүртэлх 28 хувийн тэр орон зайд энэ 4 их наяд төгрөгийн ачаалал үүрэх гээд байгаа энэ татварын шинэчлэлийг хийх орон зайг авч үлдсэнээрээ бид хувийн хэвшил бизнес хийх бололцоог олгож байгаа.

Энэ хүрээндээ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг энэ төсвийн хуулийг дагалдуулаад өөрчилж байна. Ингэснээрээ аймаг, орон нутаг, нутгийн өөрөө удирдах байгууллагаараа дамжуулаад бие дааж гаднын хөрөнгө оруулалтуудыг татах, бариад ашиглах шилжүүлэх хэлбэрээр нийтийн үйлчилгээний зориулалттай дэд бүтцийнхээ төслүүдийг 100 тэрбум төгрөгөөс доош төслүүдийг заавал Засгийн газраас зөвшөөрөл, дүрэм журам, бичиг цаас олон нэхүүлж шаардуулахгүйгээр бие дааж аймаг, орон нутгууд түншлэлийн төслөө хэрэгжүүлэх гарцыг нээж байна.

Мөн ингээд dparliament дээр тавигдсан энэ Татварын багц хуулийн шинэчлэлийг Их Хурлаар хэлэлцүүлж эхэлнэ. Мөн legal info дээр тавигдсан Эдийн засгийн эрх чөлөөний хуулийг бид хувийн хэвшлээ дэмжих бодлогын хүрээнд оруулж ирнэ. Эдийн засгийн эрх чөлөөний хуулиар үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхлыг хөндөөгүй л бол хувийн хэвшил бизнесийн үйл ажиллагаанд төр хөндлөнгөөс оролцох, нэмэлт зохицуулалт, нэмэлт хяналт, нэмэлт давхар хяналт шалгалт хийхийг хуулиар бүрэн хориглож байгаа. Ингээд эрх зүйн байдлыг нь дордуулсан ямар нэгэн өөрчлөлтийг төрөөс үзүүлэхгүй байх буюу гэнэтийн шийдвэр гаргахгүй байхад хязгаарлах Эдийн засгийн эрх чөлөөний хуулийг боловсруулсан. Үүнийг анх удаа 400 хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиуд дээр шүүлтийг AI дээр хийгээд, 200 хууль гараад эндээс нь 110 хуулийн өөрчлөлтийг дагалдуулж байна. Ингэснээр хувийн хэвшлийн бизнес эрхлэх боломж, бололцоог хуулиар бүрэн олгоно.

Мөн Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг батална гэж их олон жил ярилаа. Тэгэхээр хөрөнгө оруулалтын хуулиа баталж, хөрөнгө оруулагч нараа хамгаалахгүйгээр бид цаашаа эдийн засгийн өсөлтийн энэ 5,7 хувийг хангахгүй. Бид цаашдаа энэ төлбөрийн тэнцлийг эерэг болгож чадахгүй. Тийм учраас Хөрөнгө оруулалтын хуулийг олон жил ярьсан бол одоо энэ Хөрөнгө оруулалтын хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Эдийн засгийн эрх чөлөөний хуулийг дагалдуулаад өргөн мэдүүлж байна.

Мөн энэ олон дүрэм журам, хүнд суртал, тээгийг арилгах чиглэлээр өнгөрсөн хугацаанд Засгийн газар дээр хууль давсан журмуудыг цэгцлэх ажил явагдаад, 56 журам цэгцэлсэн. Сая шинэ Засгийн газар байгуулагдаад 20 компанийг нэгтгэж, нийлүүлж өөрчлөн зохион байгуулсан. 2 их наядын хэмнэлт хийсэн. Одоо энэ хэмнэлт үргэлжилнэ, хэрэглээгээ хумина, ингээд Зөвшөөрөл, мэдэгдлийн хууль гэж 90 хуулийн өөрчлөлтийг оруулж ирснээрээ компаниуд зөвшөөрөл энгийн зөвшөөрөл, тусгай зөвшөөрөлд заагдаагүй л бол бусад төрлийн үйл ажиллагааг төрөөс заавал асуухгүйгээр хийх энэ эрх зүйн боломжийг олгоно. Тэгэхээр төр илүү дэмжлэг туслалцаа үзүүлдэг энэ орчин нөхцөл рүү бүрэн орно гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Энэ ер нь ирэх жилд өнөөдөр энэ бүлэг дүүргэлт тийм олон хүүхэд байгаа нь энэ ялангуяа энэ нийслэл дээр байгаад байгаа юм, аймгийн төвүүд дээр байна. Энэ ингээд олон жилийн хуримтлагдсан асуудал л даа. Шууд нэг жилийн дотор шийдэхэд хүнд. Гэхдээ бид энэ хөрөнгө оруулалтыг ноднин жилтэйгээ харьцуулахад 2 дахин, 2,3 дахин их нэмж энэ хүртээмжийн асуудлыг нэмэгдүүлэхээр баригдаж байгаа цэцэрлэг, сургуулийг нэмэхээр ингэж оруулж ирж байгаа энэ удаагийн төсөв. Ер нь нэг ангид бүлэг дүүргэлтийн стандартыг 35 суралцагч байхаар ер нь 2007 онд 3 сайдын хамтарсан тушаал байдаг. Гэхдээ өнөөдөр энэ хуулийг шууд барихад ялангуяа нийслэлд боломжгүй байгаад байна. Ер нь бүлэг дүүргэлтийг 44 хүүхдээр тооцоход нийт 18792 ийм бүлэг шаардлагатай байгаад байгаа юм. Тэгэхээр энийг бууруулахын тулд бид явж байгаа. Энэ жил гэхэд л ерөнхий боловсролд 29 мянган хүүхэд.../минут дуусав/

Х.Булгантуяа: Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: 26 оны төсөвт гэрэл гэгээтэй зүйл эрүүл мэндийн салбарт байна. Ялангуяа хөрөнгө оруулалт 5,5 дахин нэмэгдсэн. Энэ дотор зүрх судасны тусгайлсан төв барих энэ ажил эхэлнэ. Үүний соёрхон батлах нь харин таны дэмжлэгтэй батлах ёстой байгаа. Ер нь 800 гаруй тэрбум төгрөгөөр ирэх 2 жилийн хугацаанд түргэн тусламж, харвалт, шигдээс, гэмтэл, осол аваар осол яаралтай тусламжийг Улаанбаатар луу зөөдөггүй болох энэ тогтолцоог хийхээр энэ том хөрөнгө оруулалт 800 гаруй тэрбум төгрөг 21 аймагт жигд хүртээхээр ажил явж байгаа. Та санаж байгаа Баянхонгор аймгаас харвалттай хүнээ наашаа зөөж байгаад эмч, сувилагч нь осолдож амь насаа эндсэн тохиолдлыг та санаж байгаа байх. Тэгвэл одоо тэгэхгүй байх энэ тогтолцоог хийхэд бидэнд энэ том тогтолцоог хэрэгжүүлэх энэ төсөв та бүхэнд дахин баригдана. Та бүхэн соёрхон баталбал энэ зээлээр бид 2 жилийн хугацаанд Монгол Улс даяараа түргэн тусламж түргэн хүрдэг болгоно.

Х.Булгантуяа: Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Ганбат гишүүний асуултад хариулъя. Манай зам тээврийн салбарт таны саяын асуусан гэрэл гэгээтэй юм юу вэ гэхлээр 1 дүгээрт хил холболтын асуудал байна. Хил холболтын төмөр замын асуудал ажил нь 6 сарын 15-ны өдөр эхэлсэн. Өнөөдрийн байдлаар 2341 баганан суурь босгохоос 140 баганан суурь босчихоод байна. Мөн бусад газар шорооны ажлууд зогсолтгүй явж байгаа. Ер нь бид аль болох хурдан, богино хугацаанд хил холболтуудаа хийх энэ асуудлыг ярилцаж байгаа. Эхний ээлжид Ганцмод-Гашуунсухайтын хил холболтын барилгын ажил эхэлсний дараа 2 дахь, 3 дахь хил холболтыг ярина гэдэг ийм протоколыг тухайн үед хамт зурсан Их Хурлаас өгсөн чиглэлийн дагуу. Тэгээд энэ дагуу Сэхээ Шивээхүрэн боомтыг сая Ерөнхийлөгчийн айлчлалаар урд хөрштэй ярьж ингээд эхлүүлэхээр болсон гэдгийг хэлье. Дээрээс нь.../минут дуусав/

Х.Булгантуяа: Дамдинням сайд, тэгээд Бат-Амгалан сайд, Батшугар сайд.

Г.Дамдинням: Манай салбар түрүүн Туваан сайд маань салбартаа сэтгэлтэй хүн. Морин тэрэгний морь нь байгаад байдаг, тэргэн дээр нь бүгдээрээ гараад суучихсан ийм л салбар хөөрхий. Тэгээд энэ салбарт эрэл, судалгааны ажил гэдэг үндсэн зардал зайлшгүй гарах ёстой байдаг. Ирэх оны төсөв дээрээ харин гэрэл гэгээтэй мэдээ 2 дахин зардал нь нэмэгдэж байгаа. 2 дахин эрэл, судалгааны ажил нэмэгдэнэ гэсэн үг. Ирээдүйн үр хүүхдүүдийнхээ идэх хоол, эдийн засгаа тогтвортой

байлгах орд газрууд, газар тариалангийн газрууд, барилга байгууламжийн суурь байх ёстой газрууд, онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн төлөвлөлтийг гаргахад зайлшгүй шаардлагатай энэ ажлууд хийгдэнэ. Мөн металлургийн салбарт том мэдээ дуулгаж байгаа. Энэ бол Эрдэнэтийн зэс хайлуулах үйлдвэрийн ТЭЗҮ хийгдэж дууссан. Энэ ондоо багтаад тендерийг нь зарлаад, тэгээд сонгон шалгаруулаад гүйцэтгэл нь эхэлнэ гэсэн ийм мэдээтэй байна.

Х.Булгантуяа: Бат-Амгалан сайд.

Э.Бат-Амгалан: Ганбат гишүүний асуултад хариулъя. Тэгээд Монгол хүн амныхаа бэлгээр гэдэг манай Ганбат гишүүн маань дандаа л гэрэл гэгээтэй их сайхан юмнууд ярьдаг. Нэг минутад салбарын гэрэл гэгээтэй асуудлуудыг яривал нэлээн мэдээж багтахгүй байх. Гэхдээ барилгын салбарт ер нь гишүүддээ, ер нь ард иргэддээ, энэ аж ахуйн нэгжүүддээ хэлэхэд хамгийн түрүүнд энэ барилгын тусгай зөвшөөрлүүдийг бүтэн сарын хугацаанд хүндрэл учирч авлигын асуудал маш л олон асуудал ярьдаг энэ асуудлыг өнгөрсөн 9 сарын 5-наас энэ тусгай зөвшөөрлийг Имонголиа цахим сайт дээр 3 хоногийн дотор авдаг ийм хурдан шуурхай, иргэдэд хүндрэл учруулахгүй иймэрхүү маягаар ажиллаад эхэлж байна. Ер нь цаашдаа энэ барилгын салбарт тулгамдаад байгаа энэ олон норм дүрэм, стандартын асуудлуудыг Барилгын тухай хуулийг энэ намрын чуулганаар Улсын Их Хурлаар оруулж батлуулж ажиллахаар ийм ажлуудыг хийж байгааг хэлье.

Х.Булгантуяа: Батшугар сайд.

Э.Батшугар: Ганбат гишүүний асуултад хариулъя. Мэдээлэл технологийн салбар 21 дүгээр зуунд бидний салшгүй нэг хэсэг болсон. Үүнтэй холбоотойгоор Монгол Улс ч гэсэн салбараа дэмжих ёстой. Энэнтэй холбоотойгоор өнөөдөр Засгийн газраар Мэдээлэл, технологийн үйлдвэржилтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтэд анхаарал тавьж, 2 журам баталсан. Журам нь ямар учиртай юм бэ гэвэл энэ виртуал бүсэд бүртгүүлсэн компаниуд татварын болон татварын бус хөнгөлөлт эдлэх бололцоо нээгдэж байгаа юм. Ингэснээр салбараа дэмжиж, Start-уруудаа, залуучуудаа дэмжих бүрэн бололцоо бүрдэж байгаа гэж хэлмээр байна.

2-т нь Монгол Улс анх удаа GPU авч байгаа юм. Энэ хиймэл оюуны үндсэн чип, тооллого хүчин чадлыг нь бүрдүүлж чадна. Өнөөдөр Монгол Улсад дөрөвхөн 2023 оны GPU байгаа. Үүнийг салбарын компаниуд бүгдээрээ түрээсэлдэг. Харин хамгийн сүүлийн үеийн GPU авснаар салбарынхаа компаниудаа дэмжих, дээрээс нь эрдэм шинжилгээний ажилтан сургалт.../минут дуусав/

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайд хариулаад тэгээд. Ганбат гишүүн бүх гишүүдээс 26 онд салбарт нь ямар гэрэлтэй гэгээтэй ахиц дэвшил гарах вэ гэдэг асуулт асуусан Ганбат сайд, гишүүн.

Б.Чойжилсүрэн: Ганбат гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний салбар 2026 онд хөгжил урагшаа явдгаараа явна, хөгждөгөөрөө хөгжих ёстой гэсэн ийм найдлагатай байгаа нэг. 2026 онд хэд хэдэн төслүүд маань үргэлжлээд явна, ажиллана. Эхний ээлжид 2026 онд энэ Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төсөл энэ жил 2 дахь блок нь ашиглалтад оруулна энэ ондоо. 26, 27, 28 онуудад 3, 4 дүгээр блокоо ашиглалтад оруулахаар ийм төлөвлөгөөтэй явж байгаа. Баян-Өлгийн цахилгаан станц мөн ялгаагүй 2026 онд барилга угсралтын ажил үргэлжлээд 27 оны

эхний хагаст 1 дүгээр блок, 28 оны эхний хагаст 2 дугаар блок ашиглалтад орохоор ийм төлөвлөгөөтэй. 3 дугаарт энэ Шивээ-Овоо дээр 660 мвт-ын станцууд ингээд ажлаа эхлэх гэж байна. 2026 онд үргэлжлээд явна, 28 онд ашиглалтад орохоор эх үүсвэр талдаа ийм ажлууд хийгдэж байгаа.

Х.Булгантуяа: Төсвийн тэгэхдээ хүрээ ярьж байгаа шүү дээ Ганбат гишүүн ээ уг нь бол. Ганбат гишүүн.

Д.Ганбат: Тэгээд гэрэл гэгээтэй ямар, ямар юм байгааг нь тэгээд ард түмэн хараад шүүх юм байгаа биз дээ 1 жилийн дараа. Нөгөө талаараа уг нь бид 200-аад сая тонн нүүрс гаргаад байх боломжтой энэ бүх юмнууд ингээд гацаад байдаг юм уу, яагаад байдаг юм бэ? 2015 онд авлигаараа бид 70 хэдэд байсан юм. Одоо бид чинь Балбын дараа орчхоод байна шүү дээ. Ийм л байдалтай байгаа шүү дээ. Тэрийг та мэдэж байгаа биз дээ юу болоод байгаа гадуур, дотуур. Нөгөө талаар сая тэр Ерөнхийлөгч нь ард түмнээс болж сонгогдож байсан улсууд болохоор нэг юм хэлээд байдаг болчихжээ. 10 тэрбумын алдагдалтай гэрээ байгуулсан гээд байна шүү дээ. Үгүй ээ тийм их мөнгөтэй юм уу бид нар? Би асуулт асуугаад байхад та нар хариулахгүй байсан. Тэгээд л яарч байгаад л баталсан. Энэ 126 бүгдээрээ сайн сайхан болчихсон гээд байсан. Тэгээд тэнд чинь энэ дарга нарын, гишүүдийн хэд хэдэн нөхдүүд орчихсон.../минут дуусав/

Х.Булгантуяа: Ганбат гишүүн үг хэллээ. Одоо хэнээс асуух вэ? Бямбацогт сайд хариулах уу? Тийм, Бямбацогт сайд хариулъя. Энэ асуудлаар Улсын Их Хурлын гишүүдээс хэвлэл мэдээлэл, олон нийт асуугаад байгаа юм. Тэгэхээр та бүхэн өөрснөө яг энэ, яг үнэнийг хэлэхэд гэрээ хэлэлцээрт орж байсан хүмүүс энд байхгүй шүү дээ. Тэгэхээр та бүхэн өөрснөө үүнд нь Засгийн газрын хувьд үүн дээрээ хариултаа албан ёсоор өгөх нь зүйтэй байх.

Х.Булгантуяа: Ганбат гишүүний асуултад хариулъя.

С.Бямбацогт: Их Хурал дээр бүгдээрээ хэлэлцээд л, бүгдээрээ хамт баталсан. Засгийн газрын холбогдох сайдууд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд гээд сайдууд нь гарын үсгээ зураад ажлын хэсэг нь ажилласан. Тэгээд энэ юмыг эргээд юу гэдэг юм Их Хурал дээр бие биеэ байцаагаад, бие биеэсээ асуугаад байх энэ хэр зохимжтой юм бол. Иргэд, олон нийт тэгээд л өөр өөрсдийнхөө байр суурь, үзэл бодлоо илэрхийлж байдаг, шүүмжлэх асуудлаа шүүмжилдэг. Заримдаа худлаа, үнэн мэдээлэл тарааж байдаг. Тэр болгоныг Их Хурлын танхим дээр оруулж ирээд нэг их асуудал болгоод хэрүүл хийгээд байх шаардлагатай юм болов уу. Шаардлагатай бол Улсын Их Хурлаас ажлын хэсэг байгуулах, Засгийн газраас ажлын хэсэг байгуулаад үнэхээр асуудал байж уу, алдаа байж уу, мэдээлэл бодитой үнэн үү, худлаа юу гэдгийг шүүгээд үзэх бололцоо боломж байгаа байх. Тийм болохоор энэ талд нь шаардлагатай бол анхаарч ажиллах талд нь анхааръя.

Х.Булгантуяа: Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Би Ганбат гишүүний асуултад хариулъя. Ер нь хил холболтын төмөр замын тухайд 1 дүгээрт Монгол Улс төрийн худалдан авалтын газар тендер зарласан. Хятадын компани, өөрөөр хэлбэл урд хөршийн гүүрэн байгууламжийг барих тэр компанийг энэ тендерт оруулсан Хятадын 2 компани орж ирсэн. Манайд одоохондоо ийм төвөгшил ихтэй барилгын байгууламжийг барих

компани одоохондоо байхгүй. Яагаад вэ гэхлээр энэ 18,3 км ийм гүүрэн байгууламжтай хил холболт байгаа Ганбат гишүүн ээ. Хамгийн өндөр нь 30 метр, хамгийн нам газартаа 20 метр ийм өндөршилтэй, дандаа гүүрэн дээгүүр явах нарийн болон өргөн царигийн зам төмөр зам явах ийм байгууламж байгаа. Тэгээд энийг худалдан авах Төрийн худалдан авах газар шалгаруулаад Хятадын CRC.../минут дуусав/

Х.Булгантуяа: Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Хятадын CRC буюу Хятадын зам гүүрний компани шалгарсан хамгийн бага үнээр 848 тэрбум буюу доллароор 235 сая доллароор шалгарсан. Тэр гэрээ баталж байх үед 290 саяын, 290 сая долларын санал өгч байсан. Их Хурал дээр яригдаж байхад гишүүд та гэрээ хийх гэж байгаа хамгийн бага үнээр хийхийг бодоорой гэдэг ийм захиа даалгавар өгсөн. Энийг биелүүлсэн. Тэр утгаараа энэ ажил ингээд 1 дүгээрт явагдаж байгаа.

2 дугаарт энийг ямар нэгэн оффтейк байхгүй, Монгол тал өөрийнхөө тендерт шалгарсан компани өөрөө Тавантолгойгоос шууд бэлэн мөнгөөр нь төлөх юм энэ байгууламжийн мөнгийг өртгийг, Монгол талынхаа байгууламжийн мөнгийг бид өөрсдөө төлнө. Хятад тал өөрсдийнхөө байгууламжийн мөнгийг өөрсдөө төлж байгаа. Тийм учраас бид урьдчилгаа мөнгөө төлөөд барилга байгууламжийн ажил эхэлсэн. 2 дахь заалтад аль болохоор Монгол компаниудыг энэ туслан.../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү? Минийх орохгүй юм. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж.

Б.Пүрэвдорж: 2024 оны 6 сарын 5-ны өдөр Малчны тухай хуулийг Тэмүүлэн нарын гишүүд, Батжаргал гишүүн өргөн бариад энэ хуулийг хэлэлцүүлээд батлуулсан. Тэгээд 7 сарын 1-нээс энэ хуульд байгаа 4.2.9-д байгаа хуульд заасан өндөр настны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлнэ гэж ийм заалт орсон. Тэгээд энийгээ 7 сарын 1-нээс хэрэгжүүлээд, энэ 2026 оны 1 сарын 1 хүртэл хэрэгжүүлэх ёстой. Гэвч түрүүчийн сайд, түрүүчийн Засгийн газар, энэ Засгийн газар нь энэ журмаа оруулж ирэхгүй байсаар байгаад энийг өнгөрүүлж байгаа, өнгөрүүлсэн. Өнөөдрийн Засгийн газар бас энэ дээрээ тодорхой хэмжээгээр шийдвэр гаргахгүй, хууль хэрэгжүүлэхгүй өөрөөр хэлбэл Улсын Их Хурлаас баталсан хуулийг өнөөдрийг хүртэл хэрэгжүүлэхгүй ингээд явж байгаа. Тэгээд энэ нь юуг илэрхийлж байна вэ гэвэл яг 6 сарын 5-нд буюу 5, 6-хан хоногийн дараа сонгууль эхэлж байсан энэ сонгуульд зориулсан зүйл биш байгаа даа, арай Батжаргал гуай, таныг тэгж арай хуураагүй байлгүй. Энэ дээд талын нөхдүүд чинь Засгийн газарт байгаа нөхдүүд л ингэж завааруулж байх шиг байна.

Тийм учраас энэ Аубакир сайдыг энэ яаралтай энэ журмаа оруулаад, энэ Засгийн газраар батлуулаад, тэгээд энэ 9 сард чинь, 10 сард, 11 сард нэг хэдэн малаа нядалж нэг хэдэн төгрөгтэй болдог үе байгаа манай малчид. Тэгээд богинохон ч гэсэн энэ хугацаа байгаа, энэ хугацаандаа маш яаралтай энэ ажлаа хийж хэрэгжүүлээч. Аубакир сайдыг энэ хөдөө орон нутаг, тэр Баян-Өлгийд явж байхад нь хүмүүс нь асуудаггүй юм уу хаашаа юм бэ? Энэ малчдад хэлэхээр тухайн үед Энх-Амгалан сайдаасаа огт асуудаггүй байсан юм байна лээ. Тэгсэн мөртөө над

руу ингээд янз янзаар бичээд, энэ асуудлыг хэлж өгөөч, ярьж өгөөч гээд ингээд байх юм. Аубакир сайдыг энэ асуудлаа оруулж ирэхгүй бол тэр Баян-Өлгийн малчид нь жоохон хариуцлага тооцох хэрэгтэй шүү дээ. Хууль хэрэгжүүлэх ёстой шүү та нар. Ингэж энийг хэрэгжүүлэхгүй энэ оныг дуусгавал энэ зөвхөн малчдын саналыг авахын тулд 24 онд ийм л заваан арга хэрэглэсэн байна гэж бид тооцох болчихоод байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд ээ, Даргын дэргэдэх зөвлөл дээр бид хэлэлцэх асуудлаа батлахдаа, дээрээс нь ер нь энэ төсвийн хэлэлцүүлгийг иргэд, олон нийт маш их ач холбогдол өгч, анхааралтай сонсож байна. Тийм учраас орой үдшийн цагаар хуралдаж, хэдэн их наядын төсөв, санхүү ярих зохимжгүй юм. Бидний ярьж байгаа төсөв бол өнөөдөр төсвийн хүрээг хэлэлцэж байна. Төсөв, төсвийн хүрээ бол татвар төлөгчид Монголын ард түмний төлсөн мөнгийг бид 2026 онд хэрхэн, яаж зарцуулах вэ гэдэг асуудлыг ярьж байгаа. Тэгэхээр олон нийтийн зүгээс төсвийн хэлэлцүүлэгт онцгой ач холбогдол өгдөг болсон ийм цаг үед уртасгасан цагаар шөнө, өдрийн цагаар хэлэлцэх биш, ажлын цагуудад ач холбогдол өгч, олон нийтийн ийм хэлэлцүүлэг анхаарлын дунд төсвийн хэлэлцүүлгийг явуулах нь зүйтэй. Төсвийн хүрээгээ бас хэлэлцэж явуулах нь зүйтэй гэж үзсэн юм. Ингээд өнөөдөр 18 цаг болж байна. Төсвийн хүрээтэй холбогдуулан 2026 оны төсвийн хүрээ, 27, 28 оны төсвийн төсөөлөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууссан. Өнөөдөр ахиад цаана нь 14 гишүүн үг хэлэхээр нэрээ өгсөн байна. Тэгээд маргааш өглөө чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдрийн яг энэ ирцээрээ гишүүд асуулт, үг хэлээд, үүний дараагаар 2026 оныхоо төсвийн төсөл рүү оръё.

17.59 цаг

Өнөөдрийн нэгдсэн чуулган дууслаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА